



Амар
амгалант
ОЛОХ НЬ

Тусламж шаардлагатай
хүмүүст зориулав...

АМАР АМГАЛАНГ ОЛОХ НЬ

ЭЛЕН Г. УАЙТ

All rights reserved
© 2003 by Inspiration Books East, Inc.

Зураг, дизайн

**К. Vreeland / Н. Armstrong Roberts
К. Врийланд / Х. Армстронг Робертс
Cover layout and design by IBE, INC.**

IBE INC. • PO Box 352 • Jemison • AL 35085 • USA
www.inbookseast.org

Гарчиг

1- дүгээр хэсэг: Христэд хүрэх зам**Бүлгүүд:**

Өмнөтгөл	6
1 Бурханы хайр энэрэл	8
2 Нүгэлт хүнд Аврагч хэрэгтэй	15
3 Гэмшихүй	21
4 Буруугаа хүлээхүй	35
5 Бурханд бүхнээ зориулахуй	40
6 Бурханд итгэж Түүнийг хүлээн авах	46
7 Христэд харь-алагдахуй	53
8 Христийн дотор өсөх нь	62
9 Бидний амьдрал ба ажил үйлс	71
10 Бурханыг танин мэдэхүй	78
11 Мөргөлийн давуу тал	85
12 Эргэлзэхүй	97
13 Их Эзэн доторх ба-р ба-сгалан	105

2- дугаар хэсэг: Христэд итгэгчдийн замнах зам

Библийн хичээл

1 Библид итгэж найдаж болох уу?	118
2 Бурхан гэж хэн бэ?	122
3 Гэм ба зовлон бэрхшээл хаанаас бий болов?	125
4 Гэм нүгэл гэр бүлд шургалсан нь	130
5 Есүс бол хүн дүртэй Бурхан	135
6 Мөнхийн амьдралд хүрэх зам	139
7 Диваажин бол бодит газар	144
8 Есүс дахин ирнэ!	149
9 Цаг хугацаа бага үлдлээ	155
10 Бурханы Хуулийн талаар	159
11 Хууль ба Нигүүлсэл	165
12 Санан дурсах өдөр	168
13 Яагаад н-м гариг олны анхаарлыг татах болов	177
14 Яагаад усан баталгаа хийлгэдэг вэ?	187
15 Үхсэний дараа юу тохиолддог вэ?	191
16 1000 жилийн амар тайван	197
17 Там гэж юу болох хаана байдаг тухай	205
18 Библи болон Эрүүл мэнд	212
19 Библид мөнгөний талаар юу сургадаг вэ?	220
20 Христэд итгэгчдийн амжилт	225

ДҮГЭЭР ХЭСЭГ

ХРИСТЭД ХҮРЭХ ЗАМ

Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар
дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.

Иохан 14: 6

ӨМНӨТГӨЛ

Хүн төрөлхтөн Христ рүү алхам алхмаар ойртоход зүйрлэшгүй их тус дэм өгч, сая сая уншигчдын хүртээл болох хувь заяа цөөн хэдэн номонд л заяах бүлгээ.

Өдгөөг хүртэл хэвлэгдсэн тоо томшгүй олон ном зохиолуудын дундаас энэхүү бэсрэг бүтээл оройлон цойлж, 70 гаруй хэл дээр орчуулагдан, дэлхий ертөнцийн өнцөг булан бүрт уншигдсаар байна. 1892 онд анх хэвлэгдсэн уг номыг уншигчдын тоо он жил улирах тусам улам өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд угшигчдын хэрэгцээ шаардлагын үүднээс олон зуун удаа ахин дахин хэвлэгджээ. Өнөөдөр бүх дэлхийн соёлт хүн төрөлхтөнтэй хамт Та энэ номыг эх хэл дээрээ уншиж, “Христэд хүрэх зам”-аар замнах боломжтой боллоо.

Энэхүү номын зохиогч Елен Ж.Уайт (1827-1915) АНУ-д төрж өссөн нэгэн бөгөөд хожим нь Христ болоод Ертөнцийн Эзэний тухай, Тэдний сургаал номлолыг гурван тивийн ард түмний дунд түгээн дэлгэрүүлж явжээ. АНУ-аас гадна Баруун Европ, Шинэ Зеланд, Австралийн улс орнуудад олон жил ажиллаж амьдрахдаа Тэрбээр боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, шашин судлал зэрэг өргөн цар хүрээг хамруулан 45 боть ном зохиол туурвисан байна.

“Христэд хүрэх зам”. Уг номын агуулга нь нэрнээсээ тодорхой юм. Христ бол хүний хамгийн итгэлт Анд найз, Туслагч хийгээд цорын ганц Аврагч мөн болохыг, хэрхэн Түүний ивээлд орж, мөнхийн амьдралд хүрч чадахыг та энэ номноос унших болно.

Иаков гэм нүглээсээ болж Бурханаас хагацах вий хэмээн айхдаа газар дэрлэн, хөсөр хэвтжээ. Тэгээд тэр зүүдлэхдээ, хөрст газраас эхлэн бүр дээшлэн дээшилсээр тэнгэрт хүрсэн сүрлэг сайхан гэрэлт шат байхыг олж

харжээ. Тэрхүү гэрэлт шатны оргилд зогсогч Нэгэн түүнд итгэл найдвар хийгээд тайтгарлын үгсийг айлдан байлаа...

Иаковын зүүдэндээ үзсэн тэр л гайхамшигт үзэгдэл нь “зам, үнэн, амь” болсон Христийг мэдэхийг хүсэгч хүн бүхэнд үзэгдэх болно. Энэ утга төгс санаа бол эл номын “амь” бөлгөө.

Эрхлэн нийтлэгчид

БУРХАНЫ ХАЙР ЭНЭРЭЛ

Байгаль хийгээд илчлэлт бүхэн Бурханы хайр ивээлийг эн тэнцүү гэрчилж байдаг билээ. Тиймээс ч бидний аж амьдрал, баяр хөөр, цэцэн мэргэн ой ухаан бүгд Тэнгэрийн Эцэгээс эх сурвалжтай юм.

Байгаль дэлхийн гайхамшигт сайхан бүтээл туурвилыг харцгаагтун!

Зөвхөн хүний төдийгүй, хамаг амьтны ашиг тус, аз жаргалын төлөөнөө бүхнийг хичнээн гайхамшигтай зохируулсныг бодоод үзэцгээ. Газар дэлхийг гийгүүлэн сэргээгч нарны гэрэл, хур бороо, уул нуруу, дов толгод, далай тэнгис, тал хөндий энэ бүгд цөм Их Бүтээгчийн энэрэл хайрыг өгүүлсээр буй. Тэр Өөрийнхөө бүхий л бүтээл туурвилын өдөр тутмын хэрэгцээг хангаж байдаг. Энэ тухай “Дуулал” номд, “Бүхний нүд Тан руу хардаг бөгөөд Та товлосон цагт тэдний хоол хүнсийг өгдөг билээ. Та мутраа дэлгэн, бүх амьтны хүслийг хангадаг” (Дуулал 145:15,16) хэмээн яруу сайхнаар дүрсэлжээ.

Бурхан хүнийг маш ариун, аз жаргалтай байхаар бүтээжээ. Ертөнцийг Бүтээгчийн мутраар бий болсон газар дэлхий үзэсгэлэнтэй сайхан байлаа. Газар дэлхийд ялзрал өгөршлийн ул мөр, хараалын бараан сүүдэр огт байсангүй ээ. Харин Бурханы мөн чанар болох хайр энэрлийн хуулийг зөрчсөн нь дэлхийд үхэл зовлон тарьжээ. Гэвч нүгэл хилэнцийн уршгаар бий болсон зовлон гамшиг уруу ч Бурханы хайр энэрэл чиглэдэг билээ. Бурхан хүний тусын тулд газрыг хараасан тухай өгүүлсэн нь буй. (Эхлэл 3:17) Аж төрөл, ахуйн явдлаар дүүрэн хүний амьдралд тохиолдох бэрхшээл, сорилтууд нь зөвхөн хүний төлөө, түүнийг хүмүүжүүлж сэнхрүүлэхийн тулд бөгөөд энэ нь хүн төрөлхтнийг доройтуулан мөхөөгч нүглийн үр дагавараас чөлөөлөх Бурханы төлөвлөгөөнд урьдчилан тусгагдсан болой.

Цөвтөж доройтсон хэдий ч, дэлхий дээр ганцхан уй гашуу, гуниг зовлон ноёрхож байдаг юм биш ээ. Эх байгалд найдлага хийгээд тайтгарлын аялгуу дуурьсаж байдаг. Өчүүхэн бутнаас цэцэг нахиалж, өргөстэй мөчирт сарнай цэцэг дэлбээгээ задлан байдаг.

Дэлбээлж буй нахиа, газраас цухуйж буй өвсний ширхэг бүхэн “Бурхан бол хайр юм” хэмээн шивнэж байдаг билээ. Агаар мандалд баяр баясгалант дуу хоолойгоо цууриатуулан байгаа үзэсгэлэнт шувууд, өнгө өнгийн булбарайхан анхилам цэцэгс, сүр хүчит ногоон ой мод—энэ бүхэн Бурханы Эцэг ёсны халамж, энхрийлэл, Өөрийн хүүхдүүдээ жаргалтай байлгах гэсэн Түүний чин хүслийг гэрчилдэг билээ.

Бурханы Үгэнд Түүний зан чанар илэрдэг. Эзэний хэлсэн бүхэн Түүний хэмжээлшгүй хайр, Түүний энэрлийг тунхагланам. Мосе “Өөрийнхөө цог жавхланг надад үзүүлээч” гэж залбиралын үеэр гуйсанд, Бурхан “Би Өөрийнхөө бүх сайн сайхныг чиний өмнүүр өнгөрүүлнэ” хэмээн хариулжээ. (Египетээс гарсан нь 33:18-19).

Энэ нь Түүний цог жавхлан бөлгөө.

Эзэн Мосегийн урдуур өнгөрч, “Эзэн, Эзэн, Бурхан өрөвч, нигүүлсэнгүй, уурлахдаа удаан ба энэрэл хайр, үнэнээр бялхам билээ. Тэр энэрэл хайрыг мянган үеийн турш хадгалж, гэмт хэрэг, гэм буруу, нүглийг уучилдаг” (Египетээс гарсан нь 34:6,7) гэж тунхаглав. Тэрээр “уурлахдаа удаан, хайр энэрлээр бялхам” тул “гэмийг уучилдаг” (Иона 4:2, Мика 7:18) ажээ.

Бурхан тэнгэр хийгээд газар дээрх тоо томшгүй олон бэлэг шинжээрээ биднийг Өөртөө хандуулсан билээ. Тэрбээр байгалийн үзэгдлүүдээр болон газар дэлхий дээр зөвхөн хүмүүс л мэдэрч чадах тийм ойр дөт, эмзэг харьцаагаар дамжуулан бидэнд Өөрийгөө таниулахыг эрмэлзсэн юм. Гэхдээ энэ нь ч Түүний хайрын тухай бүрэн гүйцэд төсөөллийг өгч чадаагүй билээ. Энэ бүх гэрчлэлийг үл хайхран «үнэний дайсан», Бурханаас аюун

ширвээтэж, Түүнийг догшин, хэрцгийг тооцох хүртэл хүний оюун ухааныг мунхруулсан байна. Сатан Бурханыг хүн төрөлхтний алдаа эндэгдлийг мөшгөн мөрдөж, ял оноох шүүгч, хатуу сэтгэлт мөнгө хүүлэгчийн адил гэж таниулсан. Тэрээр Ертөнцийг Бүтээгч Эзэн хүмүүсийг үргэлж хардаж сэрдэн, сүүлд нь шийтгэл оноохын тулд гэнэ алдаж, осолдохы нь хүлээж байдаг гэж ухуулдаг байжээ. Тиймээс ч Есүс дээрх харанхуй ойлголтыг няцааж, Бурханы хязгааргүй хайр энэрлийг илчлэхээр газар дэлхийд ирж, хүмүүсийн дунд амьдарсан билээ.

Бурханы хүү Эцэгээ мэдүүлэхээр тэнгэрээс ирэв. “Бурханыг хэн ч, хэзээ ч хараагүй бөгөөд Эцэгийн өвөр дэх цорын ганц Хүү болох Бурхан нь Түүнийг таниулсан юм” (Иохан 1:18). “Эцэг минь бүгдийг Надад өгсөн бөгөөд Эцэгээс өөр хэн ч Хүүг танихгүй. Хүү болон Хүүгийн Эцэгээ илчлэхээр хүссэн хүнээс өөр хэн ч Эцэгийг танихгүй” (Матай 11:27). Шавь нарынх нь нэг нь Түүнээс “Бидэнд Эцэгээ харуулаач” хэмээн гуйхад Есүс “Би та нартай ийм удаан хамт байхад, чи Намайг таньсангүй гэж үү? Намайг харсан хүн Эцэгийг харсан. Гэтэл ‘Бидэнд Эцэгээ харуулаач’ гэж чи яаж хэлнэ вэ?” (Иохан 14:8,9) хэмээн хариулжээ.

Есүс Өөрийнхөө газар дэлхий дээрх үүргийн тухай “Сайн мэдээг ядууст дэлгэрүүл гэж Тэр Намайг тосолсон юм. Тэр Намайг илгээсэн нь олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглах, сохруудад хараа оруулах, дарамтанд байгсдыг чөлөөлөхийн... тулд болой” (Лук 4:18) гэж хэлсэн байдаг. Энэ нь Түүний ажил үйлс нь байсан юм. Тэрээр Сатаны хорлолд өртөгдөгсөдийг анагааж, газар сайгүй сайн үйлийг бүтээж явав. Өвчинд шаналагсдын орь дуу нэг ч өрх бүлд сонсдох тийм тосгон суурин ч олон байв. Учир нь Тэрбээр дайран өнгөрөхдөө бүхнийг анагаасан нь тэр болой. Түүний бүхий л үйлс зорилго нь Түүний Бурханаар тослогдсон Нэгэн болохыг нотолж байв. Есүсийн амьдралын алхам бүр нь хайр энэрэл, нигүүлсэл байсан

бөгөөд зүрх сэтгэл нь хүмүүний үрсийг ивээн хайрлаж байв. Тэрээр хүмүүсийн гачигдал хэрэгцээг мэдэх гэж хүний язгуур шинж төрхийг олсон. Хамгийн ядуу болон энгийн хүмүүс ч Түүн рүү ойртохоосоо эмээж байсангүй. Бяцхан хүүхдүүд ч Түүнд эрхлэн нааддаг байв. Тэд нар Есүсийн хайр гэрэлтсэн харцыг ширтэж, Түүний өвөр дээр суух дуртай байв.

Есүс үнэнийг хэзээ ч нуун далдлаагүй бөгөөд үнэн үгсийг чин сэтгэлээсээ өгүүлдэг байв. Тэрбээр хүмүүстэй харьцахдаа туйлын зүй зохист хийгээд анхаарал халамжтайн зэрэгцээ хэзээ ч бүдүүлэг түрэмгий авирлаж, шаардлагагүй үед ширүүн үгсийг хэлж байсангүй. Эмзэг сэтгэлийг хөндөж, хүний сул дорой шинжийг буруушаан зэмлэж байсан нь нэгээхэн ч үгүй. Тэрбээр чин хайраар үнэнийг тунхаглаж хэлдэг байв. Бялдуучлах, үл итгэх, хууль ёсыг уландaa гишгэх явдлыг буруушаан, гашуун үгээ хэлж байхдаа, Түүний хоолойд нулимс зангирч байсан юм. “Зам, үнэн, амь” болсон Түүнийг хүлээн авахаас татгалзсан хайрт Иерусалим хотынхныхоо төлөө Тэр гашуудан уйлсан. Өөрийн Аврагчаа танихгүй байсан тэдэнд энхрий ялдам, энэрэнгүй хандаж байсан билээ. Түүний амьдрал нь бусдын төлөө зовнил, биеэ хайрлахгүй бүтээсэн гавъяат үйлс байлаа. Есүсийн хувьд сүнс бүхэн маш үнэ цэнэтэй байв. Тэнгэрлиг эрхэм чанарыг ямагт чандлан сахиж, Бурханы гэр бүлийн гишүүн бүрийг мэхийн хүндэтгэдэг байв. Тэрбээр хүн бүхэнд цөвтөж доройтсон оюун сэтгэл буйг олж харсан бөгөөд чухам тэднийг аврахын тулд л энэ ертөнцөд ирсэн билээ.

Энэ бүхэн Есүсийн газар дэлхий дээрх зан төрхийн илрэл бөгөөд Бурханы мөн чанар юм. Христийн амь амьдралаар илэрсэн Тэнгэрлиг нигүүлслийн давалгаа Эцэгийн зүрхнээс ундрэн хүний хөвгүүдэд цутган орсон нь тэр билээ. Элбэрэлт нигүүлсэнгүй Аврагч Есүс “мах биеэр илчлэгдсэн” Бурхан байсан бөлгөө. (1 Тимот 3:16)

Есүс биднийг аврах гэж амьдарч, зовж, шаналж, амь биеэ зориулсан юм. Бид бүхнийг мөнхийн баяр баясгалантай золгуулахаар Тэр Өөрийгөө «Зовлонг хүн» болгосон. Бурхан өгөөмөр буян бөгөөд үнэнээр бялхагч Өөрийнхөө хайрт Хүүгээ бичиглэхийн аргагүй суу алдарын ороноос хараал зүхлийн сүүдэрт харанхуйлж, нүгэлд автаж, зэрэмдэглэгдсэн энэ дэлхийд илгээжээ.

Басхүү Тэр Эцэгийн хайрын өлгий дотор оршигч Түүнд басамжлал, доромжлол, үзэн ядалт хийгээд үхлийг тэвчиж, Өөрийгөө болон Тэнгэр элч нарын мөргөл залбирлыг орхин одохыг зөвшөөрчээ. “Бидний амар амгалангийн төлөө Түүн дээр гэсгээлт бууж, Түүний шархаар бид эдгэрсэн” билээ. (Исаиа 53:5)

Элсэнцөлд, Гетсеманид болон загалмай дээрх Түүний шаналлыг харагтун! Бурханы Ариун Хүү Өөрөө нүгэл хилэнцийн дарамтыг үүрсэн. Бурхантай бүхэнээр нэгдмэл Тэрбээр Бурханыг хүнээс холдуулсан нүгэлт үйлийн бүхий л аймшиг зовлонг амсаж мэдэрсэн. Юуны учир Түүний амнаас “Бурхан минь, Бурхан минь, юунд Та Намайг орхив” гэсэн шаналантай дуун алдуурав? (Матай 27:46) Хүнийг Бурханаас тусгаарласан нүглийн аймшигт үр дагавар Бурханы Хүүгийн зүрхэнд тусчээ. Энэ агуу их өргөл нь хүнийг хайрлах хайрыг Эцэгийн зүрхэнд дотор ноцоож, Түүнд аврах сэтгэл төрүүлэхийн тулд байгаагүй юм. Огт тийм биш. “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн” (Иохан 3:16).

Аугаа их цагаатгалын өргөлийг авснаар Бурхан биднийг хайрлаагүй билээ! Харин эсрэгээр, Тэр бидэнд хайртай байсан учраас цагаатгалын өргөлийг урьдаас төлөвлөсөн байжээ. Есүс цөвтөж доройтсон дэлхий дээр Бурханы хязгааргүй хайрыг илэрхийлж чадах Бурханы Зууч байсан юм. “Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлсэн” (2 Коринт 5:19) юм. Бурхан Хүүтэйгээ хамт зовж шаналсан. Бидний нүгэл хилэнцийг цагаатгахын

төлөө өргөсөн мөнх хайрын төлөөс нь Гетсеманий цэцэрлэг дэх энэлэн, Голготын загалмай дээрх үхэл юм.

Есүс “Тиймээс Эцэг Намайг хайрладаг. Учир нь Би Өөрийн амийг буцаан авахыг тулд амиа өгнө. Мөн эргүүлж ч авах болно” (Иохан 10:17) гэж хэлсэн билээ. Өөрөөр хэлбэл, “Миний Эцэг та нарыг хайрладагийн учир Би Өөрийн амиа та нарын цагаатгалын тул өгч буй. Та нарын Төлөөний хүн буюу Батлан даагч болж, та нарын гэм нүгэл, үүргийг Өөртөө авч, Өөрийн амиа өгснөөр Би Эцэгтээ улам бүр эрхэмлэгдэнэ. Учир нь Миний өргөлийн ачаар Есүст итгэгчдэд Бурхан голч шударга, цагаатгагч болох юм” гэжээ.

Бурханы Хүүгээс өөр хэн ч биднийг цагаатгаж чадахгүй. Учир нь Эцэгийн дотор байгч Нэгэн л Бурханыг илчлэх бөлгөө. Бурханы хайрын гүн хийгээд өндрийг мэдэгч Түүнээс өөр Эцэгийн хайрыг дэлхийд нээгч нэгээхэн ч үгүй. Гэмт хүмүүсийн өмнөөс өргөсөн Христийн өргөл нь аугаа байгаад зогсохгүй зөвхөн энэ өргөлөөр л төөрөлдөн байгаа хүмүүст Их Эзэн хайраа илэрхийлэх билээ.

“Учир нь Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн”. Тэр Хүүгээ зөвхөн хүмүүсийн дунд байлгаж, тэдний нүгэл хилэнцийг үүрүүлэн, золиос болгон үхүүлэхийн тулд илгээгээгүй юм. Тэр Түүнийг цөвтөж доройтсон хүмүүн төрөлд “өгсөн” билээ. Христ тэдний аж төрөл, хэрэгцээн дунд амьдрах ёстой байв. Бурхантай нэгдмэл Тэрбээр Өөрийгөө хүний хүүхдүүдтэй салшгүй холбоогоор холбосон юм. Есүс “тэднийг ах дүүс гэж дуудахаас ичээгүй” (Еврей 2:11). Тэр бол бидний төлөө золиослогдсон Нэгэн, Эцэгийн хаан ширээний өмнө хүний төрхөөр залрагч бидний Хамгаалагч, Ах минь юм. Тэрээр бас Түүгээр цагаатгагдсан хүн төрөлхтөнтэй бүх үеүдэд үүрд холбогдсон Нэгэн мөн. Тэр Хүний Хүү бөлгөө. Энэ бүхэн хүнийг нүглийн хөнөөлт ангалаас гаргаж, Бурханыг биднийг хайрласных

нь хариуд хайрлаж, гэгээн амьдралын баяр баяслыг хуваалцахын тулд юм аа.

Бидний цагаатгалын үнэ цэнэ — Өөрийнхөө Хүүг бидний төлөө золиосолсон Тэнгэрийн Эцэгийн агуу их суу өргөл нь “Христийн ачаар бид ямар болж чадах билээ” гэсэн өөдрөг төсөөллийг төрүүлэх учиртай. Нэгэнтээ номлогч Иохан мөхөж доройтсон хүн төрөлхтнийг Тэнгэр Бурхан хичнээн өгөөмөр сэтгэлээр хайрладаг болохыг хараад, мөнхүү хайрын үлэмж хүч, сүр жавхланг үгээр илэрхийлж эс чадахдаа: “Бид Бурханы хүүхдүүд гэж дуудуулахаар ямар их хайрыг Эцэг бидэнд соёрхсоныг хараач!” гэж уулга алджээ. (1 Иохан 3:1) Бурхан хүнийг ямар их эрхэмлэнэ вэ!

Гэм нүгэл хийснээрээ хүний хөвгүүд сатаны харьяат болжээ. Адамын үр удам Христийн амиа зориулсан цагаатгал өргөлд итгэсний дараа л дахин Бурханы хүүхдүүд болох болно. Хүний язгуур чанарыг авснаар Христ хүн төрөлхтнийг өргөмжлөн дээдэлжээ. Одоо Христтэй холбогдсоноороо цөвтөж доройтсон хүмүүс үнэн хэрэгтээ “Бурханы хүүхдүүд” гэсэн өндөр хүндтэй нэрээр нэрлэгдэх боллоо.

Тийм хайрыг юутай ч зүйрлэшгүй билээ! Тэнгэрийн Хааны хөвгүүд! Ямар эрхэм хүслэн бэ! Энэ нь гүн гүнзгий сэтгэж, ургуулан бодох зүйл биш гэж үү?! Өөрөөс нь нүүр буруулсан хэдий ч ертөнцийг хайрлах Бурханы хайр юутай хосгүй вэ? Энэхүү бодол санаа сэтгэл булааж, Бурханы сургаалыг сүслэн дагах ухаан хайрланам.

Загалмайн гэрэл гэгээн дэхь Бурханы зан төрхийг хичнээн их судлах тусам элбэрэл хайр, өршөөл энэрэл лүгээ зөвт ёс, шударга шүүлт хэрхэн шүтэлцэсэнийг улам улмаар ойлгож, Бурханы хэмжээлшгүй хайр хийгээд төөрч будилсан хүүгээ энэрэх эхийн сэтгэлээс хавьгүй илүүтэй Түүний нигүүлсэнгүй их зан чанарын үй олон гэрчлэлүүд тов тодорхой болж ирдэг юм.

НҮГЭЛТ ХҮНД АВРАГЧ ХЭРЭГТЭЙ

Хийг анх бүтээхэд тэрээр ариун сайхан чанартай, төв төлөв оюун ухаантай байв. Хүн төгс төгөлдөр бүтээл байсан бөгөөд Бурхантай эв зүйтэй амьдарч байлаа. Түүний бодол санаа нь цэвэр ариун, хүсэл эрмэлзэл нь гэгээн саруул авай. Гэвч дуулгаваргүйгээсээ болж сэтгэл нь буруудаж, хувиа хичээх үзэл зүрхнээс нь хайрыг шахан гаргажээ. Гэм нүгэл хүнийг маш сулруулж, муу муухай юмыг бие даан эсэргүүцэх тэнхэлгүй болгов. Хүн Сатанд олзлогдож, хэрэв Бурхан онцгой аргаар оролцоогүйсэн бол үүрд нүгэлтэн хэвээр үлдэх байсан юм. Уруу татагч этгээд Бурхан хүнийг анх бүтээхдээ зохиосон төлөвлөгөөг нь нурааж, хорвоо дэлхийг гаслан зовлонгоор дүүргэх тооцоотой байжээ. Ингэснээрээ Сатан нүглийн бүхий л үүр уурхайг хүнийг бүтээгч Бурхан буй болгосон гэж зэмлэн буруушаах санаатай байсан юм.

Хүн гэм нүгэлгүй байх үедээ “мэргэн ухаан болоод мэдлэгийн бүх эрдэнэс нуугдсан” (Колоссай 2:3) Бүтээгч лүгээ баяр баясгалантай харьцаж байсан юм. Гэвч хүн нүгэлд унасныхаа дараа гэгээн амьдралд баярлаж хөөрөхөө ч бүр больж, Бурханаас нүүр буруулж далдрахыг эрмэлзэх болсон билээ. Шинэтгэгдээгүй хүмүүс одоо хүртэл иймэрхүү л байдалтай байна. Тэд Бурхантай нийцдэггүй, Түүнтэй харьцахдаа баяр жаргалыг эдэлж чаддаггүй байна. Нүгэлт хүн Бурханы дэргэд аз жаргалтай байж үл чадах ба ариун юмстай харилцахаас зайлсхийх билээ. Тийм хүн тэнгэрт илгээгдлээ ч баярлаж хөөрөхгүй байхсан бизээ. Зүрх сэтгэл бүхэн Бүтээгчийн хязгааргүй хайр энэрлийг уриалгахан хүлээж авдаг тэр газар ч гэсэн нүгэлт хүний

сэтгэл үл сэргэхсэн билээ. Тэнгэрт амьдрагсадын ариун дагшин хүсэл, сонирхол, бодол сэхээрэл түүнд маш хол хөндий байхсан. Нүгэлт хүн тэнгэрийн ая эгшгийг эвдэн гутаах бизээ. Тэнгэр дэх амьдрал түүнд шаналгаатай бөгөөд тэнгэрт оршин суугчдын гэрэл гэгээ, баяр баясгалангийн цогцлол болсон Бурханаас нүүр буруулан, далдрахыг л тэр хүсэх буй заа. Бурхан дур зоргоороо шийдэж, нүгэлтэн олныг тэнгэрт гаргахгүй байгаа хэрэг огт биш ээ. Тэд гэм нүглийнхээ улмаас тэнд амьдарч чадахгүй болохоор л аваачихгүй байгаа юм. Бурханы гэгээн алдар тэдний хувьд “Нүглийг хуйхлах гал дөл” байхсан билээ. Өөрсдийг нь аврахын төлөө амиа өгсөн Түүнээс нүүр буруулахын тулд тэд үхсэн нь дээр гэж бодох биз.

Бид өөрсдийнхөө буруугаас болж унасан нүглийн харанхуй ангалаас бие даан гарч чадахгүй. Бидний дотор муу юм оршиж, бид өөрсдийгөө өөрчилж чадахгүй байна. “Хэн бузраас цэврийг бий болгож чадах вэ? Хэн ч үгүй” (Иов 14:4), “Махан биеийн бодол санаа бол Бурханы эсрэг дайсагнал юм. Учир нь энэ нь Бурханы хуульд захирагддаггүй бөгөөд тэгж чадах ч үгүй” (Ром 8:7). Соёл, боловсрол, хүсэл зоригийн дасгал, хүний хүчин чармайлт тэр орчиндоо зохистой сайн боловч энд хүчин мөхөсдөнө. Тэдгээрийн тусламжтайгаар өнгөн дээрээ зөв зохистой байж болох боловч, сэтгэл санааг өөрчлөх юм уу эсвэл амьдралын эх сурвалжийг ариусгаж чадахгүй. Нүгэлтэн хүн ариун болохын тулд дотроос үйлчлэх хүч, дээрээс заяах шинэ амьдрал аргагүй чухал. Тэр хүч бол Христ. Гагцхүү Түүний ивээл сэтгэл санааны доройтлыг сэргээж, Бурхан хийгээд ариун ёсонд татаж чадна.

Аврагч айлдсан нь: “Хэн дээрээс эс төрнө”, өөрөөр хэлбэл хэрэв хүн шинэ амьдрал өөд хөтлөх шинэ сэтгэл, шинэ хүсэл, шинэ зорилго олж авахгүй юм бол “Бурханы хаанчлалыг олж харж чадахгүй.” (Иохан 3:3)

Хүнд байгалиас заяасан сайн сайхан зүйлийг л хөгжүүлэх хэрэгтэй мэтээр боддог хүмүүс гүнзгий төөрөлдөж байна. “Төрөлх хүн Бурханы сүнсний зүйлсийг хүлээн авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг”. “Чи дээрээс төрөх ёстой гэж хэлсэнд бүү гайх” (1 Коринт 2:14, Иохан 3:7). Христийн тухай “Түүнд амь байсан, тэр амь нь хүмүүсийн гэрэл гэгээ байв” “бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй” хэмээн өгүүлсэн байдаг. (Иохан 1:4; Үйлс 4:12) Хүн Бурханы нигүүлсэнгүй сэтгэл, Түүний сайхан чанар, эцэг ёсны энэрэл халамжийг ухамсарлаж, Түүний хуулийн цэцэн мэргэн, чигч шудрагыг олж харж, тэрхүү хууль нь хайр энэрлийн мөнхийн зарчимд үндэслэсэн гэдгийг ойлгож байгаа нь сайн хэрэг. Гэвч зөвхөн энэ нь хангалттай бус. Ном айлдагч Паул “Хуулийг сайн гэдгийг зөвшөөрч буй”, “Хууль бол ариун бөгөөд тушаал ч ариун, зөвт бөгөөд сайн юм” хэмээн дуу алдахдаа тэр бүхнийг мэдэж байсан юм. Чингэхдээ тэр сэтгэлээ өвтгөн, гасалж цөхрөн байж “Харин би махан биетэй бөгөөд нүглийн боолчлолд худалдагдсан” (Ром 7:16, 12, 14) гэж нэмж хэлжээ. Тэр өөрийн хүчээр хүрч чадахгүй тул ариун явдал, зөвт ёсыг туйлаас эрмэлзэн, “Би юутай хөөрхийлөлтэй хүн бэ! Хэн намайг үхлийн энэ биеэс ангижруулах вэ?” гэж халаглан асуусан юм. (Ром 7:24) Ийм харуусал цөхрөл нүгэл хилэнцэд дарагдсан сэтгэл зүрхний угаас гардаг бөгөөд газар сайгүй, цаг үргэлж сонсогдсоор иржээ. Тэр бүхэнд “Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун” гэсэн ганц л хариулт буй. (Иохан 1:29)

Бурханы сүнс гэм буруугийнхаа дарамтаас чөлөөгдөхийг эрмэлзэгч хүмүүст энэ үнэнийг таниулахын тулд олон тооны дүр зургийг ашигладаг.

Исавыг хуураад, нүгэл үйлдэж, эцгийнхээ гэрээс зугтахдаа Иаков гэм буруугаа ухамсарлаад уруу

царайлчихсан байсан билээ. Ганцаардмал, гэр оронгүй, үнэтэй цэнэтэй бүхнээсээ тусгаарлагдсан түүнийг үйлдсэн нүгэл нь Бурханаас салгаж, “Тэнгэрт хаягдсан” гэдэг бодол юу юунаас илүү шаналгаж байсан юм. Тэр уруу царайлан, гуниглан гутарч цулгуй газар дээр алжаалаа тайлахаар хэвтжээ. Түүний эргэн тойронд эзэнгүй зэлүүд дов толгод, дээр нь од мичид гялалзсан тэнгэр харагдаж байлаа. Тэгээд зүүрмэглэтэл хачин сонин гэрэл гэгээ цацарч, хэвтэж байсан газраас нь дээшлэн дээшилсээр бүр тэнгэрийн хаалга хүрсэн өргөн шатны бүдэгхэн дүр зураг зүүдэнд нь харагджээ. Энэ шатаар Бурханы Тэнгэр элч нар өгсөж уруудан ахуйн сацуу бүхний дээрээс Бурхан түүнийг тайтгаруулж, итгэл найдварын үгс айлдах нь сонсдож авай. Ийнхүү Иаков түүний хүслийг гүйцээж, харангалсан сэтгэлий нь дэвтээх Нэгэн болох Аврагч юугаа таньж мэдэх тавилантай байжээ. Нүгэлтэн Иаков Бурхантай холбоо тогтоох замаа тийм баяр талархалтайгаар олж харсан юм. Түүний зүүдэндээ үзсэн учир битүүлэг шат нь Бурхан хүн хоёрын хоорондох цорын ганц зуучлагч-Есүс Христийг бэлэгдэж байв.

Христ Нафанайлтай ярилцахдаа энэ бэлэг тэмдгийг дурьдаж байсан юм. “Тэнгэр нээгдэн, Бурханы тэнгэр элч нар хүний хүүгийн дээр өгсөх ба уруудахыг үзэх болно” (Иохан 1:51) гэж Тэрбээр айлдсан билээ. Хүн нүгэл үйлдээд Бурханаас цэрвэдэг болж, газар тэнгэрийн хоорондох холбоо тасарч, ангал үүсч Түүнтэй харилцаа тогтоох боломжгүй болжээ. Гэвч Христийн ачаар газар дэлхий тэнгэртэй дахин холбоо тогтоосон юм. Христ Өөрийн гавьяа зүтгэлээр нүгэл хилэнцийн ангал дээгүүр гүүр тавьж, Тэнгэр элч нар хүн зонтой харилцаж, тэдэнд хүчин зүтгэх боломжтой болжээ. Христ цөвтөж доройтсон хүнийг хүчин мөхөс, арчаагүй янзаар нь хязгааргүй хүчин чадлын Эх сурвалжтай холбож өгсөн байна.

Цөвтөж доройтсон хүн төрөлхтөнд найдвар төрүүлж, тусламж үзүүлэх цорын ганц Эх сурвалжийг хүн зон үл ойшоох юм бол, хөгжил дэвшлийг мөрөөдсөн бүхий л мөрөөдөл, хүн төрөлхтнийг оюун санааны хувьд өөд татах гэсэн аливаа оролдлого талаар өнгөрнө. “Аливаа сайн соёрхол ба аливаа төгс бэлэг нь дээрээс, Эцэгээс бууж ирдэг” (Иаков 1:17) Түүнгүйгээр зан байдлын жинхэнэ төгс төгөлдөр чанарыг сэтгэхийн арга байхгүй. Бурханд зөвхөн Христээр дамжиж л хүрч чадна. Тэрбээр “Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй” гэжээ. (Иохан 14:6)

Бурхан Өөрийнхөө газар дээрх хүүхдүүдтэй үхлээс хавьгүй хүчтэй хайраар холбогдсон байдаг юм. Өөрийнхөө Хүүг өгөхдөө, Тэр бидэнд тэнгэрийн бүх эрдэнэсийг нэгэн бэлэг болгон барьсан билээ. Аврагчийн амьдрал, үхэл болоод зуучлал, тэнгэр элч нарын хүчин зүтгэл, Ариун сүнсний уриа дуудлага, бүхнээр дамжуулан бүхний дээр үйлдэгч Эцэгийн халамж, тэнгэрт амьдрагсдын гандан бууршгүй хүсэл сонирхол-энэ бүхэн хүн төрөлхтнийг аврахын тулд билээ.

Бидний төлөө өргөсөн гайхамшигт Өргөлийн тухай байнга бодоцгоож, төөрөгсдийг аварч, тэднийг Эцэгийн гэрт эгүүлэн аваачих гэсэн Тэнгэрийн цуцалтгүй хүчин чармайлтын үнэлж цэгнэх гээд оролдоод үзье. Үйлс явдалд хамгийн хүчтэй сэхээрэл хийгээд юмс оролцжээ. Зөвт хэргийн төлөөх аугаа шагнал, тэнгэрийн баяр баясгалан, Тэнгэр элч нар хийгээд Эцэг болон Түүний Хүүтэй тогтоосон харилцаа, эцэс төгсгөлгүй үеүдийн туршид бидний чадварыг өөд татан хөгжүүлсэн явдал-энэ бүхэн биднийг Бүтээгч хийгээд Аврагчийн төлөө хамаг зүрх сэтгэлээсээ хүчин зүтгэхэд уриалан дуудахгүй байна гэж үү?

Нөгөөтэйгүүр, нүглийг шүүх Бурханы шүүлт, зайлбаргүй шийтгэл, ёс суртахууны доройтол, эцсийн мөхөл сүйрэл-энэ бүхэн Сатанд хүчин зүтгэхээс биднийг

сэргэмжлүүлэхийн тулд Бурханы айлдварт бичигдсэн байдаг юм.

Бид Бурханы энэрэнгүй уриа дуудлагыг сонсохгүй чихэн дүлий хэвээр үлдэх үү? Тэр бидний төлөө өөр юу хийж болох байсан бэ? Биднийг ийм гайхалтай хайраар энэрэн хайрласан Түүн лүгээ зөв зохистой харилцаа тогтооё л доо. Түүнтэй төст байдлыг олж, Эцэг, Хүү хийгээд хүн зонд хүчин зүтгэхээр илгээгдсэн Тэнгэр элч нартай эв зүй, харьцаанд эргэн орохын тулд бидэнд өгөгдсөн юмсыг ашиглацгаая.

ГЭМШИХҮЙ

Хүн Бурхантай хэрхэн зөв харьцаанд орж болох вэ? Нүгэлт хүн яаж зөвт үзэлтэн болж чадах вэ?

Зөвхөн Христээр дамжин бид Бурхан, Түүний ариун зам мөртэй зохирон оршиж чадна. Харин Христэд яаж хүрэх вэ?

Пентекост өдөр хүмүүсийн сэтгэлийг түгшээсэн нөгөө л асуултыг өдгөө олон хүн тавьсаар л байна. Тэр өдөр хүмүүс гэм нүглээ ухаарч мэдээд “Одоо яах вэ?” гэж асууж байсан гэдэг. Петрийн хариулсан анхны үг нь “Гэмшигтүн” (*Үйлс 2:37-38*) гэсэн үг байжээ. Үүний дараахан бас нэг өдөр Петр “Гэмшигцгээ, нүглээсээ салахын тулд эргэцгээ” гэж хэлжээ (*Үйлс 3:19*).

Гэмших гэдэг нь үйлдсэн нүглийнхээ төлөө энэлэн шаналж, түүнээ орхихыг тухайлан хэлж буй юм. Бид нүглийн хор хөнөөлийг ухаарахгүй юм бол нүглээс салж чадахгүй. Бид сэтгэл зүрхээрээ нүгэл хилэнцээс буруулж зайлахгүй юм бол бидний амьдралд жинхэнэ өөрчлөлт гарахгүй.

Гэмшихийн жинхэнэ утга учрыг олон хүн ойлгодоггүй. Хүмүүс буруу зөрүү хэрэг үйлдсэнээсээ болж зовж шанална гэж айдаг учраас нүгэл хийсэндээ харамсч, тэр ч байтугай өнгөн дээрээ зан байдлаа хувиргадаг. Гэвч Библийн утгаар бол энэ нь гэмшиж байгаа хэрэг биш. Тэд нүгэл хийсэндээ жинхэнээсээ харамсч байгаа бус харин нүгэл хилэнцийн уршиг гайд харамсан гашуудаж байгаа юм.

Исав өв залгамжлах эрхээ бүрмөсөн алдсанаа ойлгомогц ингэж гуниглаж байсан юм. Валаам зам дээр нь илд барьсан тэнгэр элч зогсож байхыг хараад айн цочиж, амиа авч гарахын тулд гэм буруугаа хүлээсэн юм. Гэвч тэр нүгэл үйлдсэндээ жинхэнэ ёсоор үл гэмшин,

муу муухайг жигшиж үзээгүйгээс гадна хүсэл зорилгоо ч өөрчлөөгүй юм.

Хариот хотын Иудас Их Эзэнээс урваад «Би гэм зэмгүй цуснаас урваснаараа нүгэл үйлдлээ» гэж дуу алджээ (*Матай 27:4*). Ирж буй шүүх цаазын өмнө мөхөх тавилантайгаа мэдэрч, сүнсээ гартал айж балмагдсаны улмаас тэр арга буюу ингэж буруугаа хүлээсэн юм. Үйлдсэн хэргийнх нь уршиг дагавар түүнийг айлгасан хэдий ч “Израилийн Ариун Нэгэнийг” няцааж, Бурханы ариун Хүүг барьж өгсөндөө чин сэтгэлээсээ харуусан шаналсангүй.

Фараон Бурханы шүүлт ирэхэд зовлонгоос зайлж гарахын тулд нүглээ хүлээн зөвшөөрсөн хэдий ч түүний уршиг дагавар нь мартагдмагц Тэнгэртэй дахиад ихэмсэг дээрэнгүй харьцаж эхэлсэн юм. Дээрх бүх хүмүүс нүгэл хилэнцийн хор уршигт харуусан гашуудсан боловч жинхэнээсээ гэмшиж байгаагүй билээ.

Зүрх нь Бурханы Сүнсний эрхшээлд орсон цагт нүгэлт хүний нинжин сэтгэл сэргэж, тэнгэр болоод газар дээрх Бурханлиг хаанчлалын үндэс болсон Бурханы хуулийн гүн хийгээд ариуныг ойлгож эхэлдэг юмсанжээ. “Ертөнцөд ирсэн хүн бүрийг гэгээрүүлдэг” (*Иохан 1:9*) тэрхүү Гэрэл сэтгэлийн бөглүүг гийгүүлж, харанхуйд автсан нууцыг илчлэхэд, нүгэлтэн сэтгэл оюунаараа өөрийнхөө гэм бурууг ойлгох болно. Тэр Иехува Эзэний зөвт санааг хүлээн авч, хүний сэтгэлийн бүхий л нууцыг мэдэгч Түүний дэргэд алдаа дутагдал, бузар булайтайгаа зууралдсаар байгаагаасаа айж эмээнэ. Тэрээр Бурханы хайр, ариун ёсны гоо үзэмж, цэвэр сайхны баяр баяслыг олж харна. Тэгээд Тэнгэр Бурхантай харьцахын тулд ариусч, хувирахыг туйлаас эрмэлзэнэ.

Нүгэл үйлдсэний дараах Давидын залбирал нь жинхэнэ ёсоор гэмшин харууссаны жишээ юм. Түүний гэмшил гүнзгий бөгөөд чин сэтгэлийнх байсан. Тэрээр

гэм буруугаа зөөллөх гэж оролдоогүй, өөртөө тулгарсан ял шийтгэлээс зайлсхийхийн тулд ч залбираагүй билээ.

Давид бузар муухай гэмт хэрэг үйлдсэнээ, хорон муу санаа өвөрлөж явснаа ухаарч, нүгэл хилэнцээ үнэнхүү жигшиж байсан. Тэр зөвхөн уучлал гуйх гэж залбираагүй бас сэтгэл зүрхээ ариусгах гэж залбирсан юм. Тэрээр ариун амьдралын баяр баясгаланг эдэлж, Бурхантай эв зохицол, харилцаа холбоогоо сэргээх гэж туйлаас эрмэлзсэн билээ. Давид туулж өнгөрүүлсэнээ санан, сэтгэл зүрхнийхээ угаас ямар үг хэлснийг сонсоцгоо:

“Алдаа зөрчил нь уучлагдсан бөгөөд
Нүгэл нь далдлагдсан нэгэн юутай ерөөлтэй вэ?
Эзэнд гэмтэн гэж үл тооцогддог бөгөөд
Сүнсэндээ заль мэхгүй хүн юутай ерөөлтэй вэ?”
(Дуулал 32:1-2)

“Бурхан, Өөрийн хайр энэрлийнхээ дагуу
намайг нигүүлсээч.
Өөрийн өршөөлийн агуу байдлын дагуу
миний алдаа зөрчлийг арилгаач...
Учир нь би алдаа зөрчлөө мэдэх бөгөөд
Миний нүгэл үргэлж миний өмнө байдаг...
Намайг хиссопоор цэвэршүүлээч,
тэгвэл би цэвэр болно.
Намайг угаагаач,
тэгвэл би цаснаас цагаан болно...
Бурхан, миний дотор цэвэр зүрхийг бүтээж,
Миний дотор зөв сүнсийг шинэчлээч.
Өөрийн оршихуйгаас намайг бүү холдуулаач.
Өөрийн Ариун Сүнсийг надаас бүү аваач.
Авралынхаа баясгаланг надад сэргээн өгч,
хүслэнт сүнсээр намайг тэтгээч...
Бурхан, миний авралын Бурхан,
намайг цусны буруугаас авраач.

Тэгвэл хэл минь Таны зөв шударгыг
баясгалантайгаар дуулна”.

(Дуулал 51:1-14)

Бид өөрийнхөө хүчээр ингэж нүглээ наминчилж чадахгүй юм. “Өндөрлөгт гарч, хүмүүст ивээл хүртээсэн” Христээс л ийм наминчлалыг хүртэж болно.

Чухамхүү энэ асуудлаар олон хүн төөрөлддөг. Иймээс ч Христийн тэдэнд үзүүлэх гэсэн тусламжийг хүлээн авч чаддаггүй юм. Тэд урьдаар гэмшихгүй бол Христэд хүрч чадахгүй, гэмшил наминчлал нь тэдний нүгэл хилэнцийг уучлах зам мөрийг засч бэлтгэдэг юм шиг санадаг байна. Үнэндээ нүглийг нь уучлахаас өмнө хүн гэмшдэг. Энэ бол аргагүй зөв. Учир нь гутарч, гэмшсэн сэтгэл зүрх л Аврагчийг үгүйлэн нэхдэг. Харин нүгэлтэн дараа нь Есүст очихын тулд гэмшитлээ хүлээх ёстой юу? Гэмшил нь нүгэлтнийг Аврагчаас тусгаарлах хориг саад болох учиртай гэж үү?

Нүгэлт хүн, Христийн “Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над руу ир. Би та нарт амралтыг өгье” (*Матай 11:28*) гэсэн урилгыг хүлээн авахаасаа өмнө нүглээ наминчлах ёстой гэж Библи сургаагүй билээ.

Жинхэнэ гэмшилд Христээс эх сурвалжтай хүч л хүргэдэг шүү дээ. Петр үүнийг Израильчуудад хандаж хэлсэн үгэндээ тайлбарласан юм: “Нүглүүдийг уучлах, Израильд гэмшлийг соёрхохын тулд Бурхан Түүнийг баруун гарынхаа Захирагч мөн Аврагчаар өргөмжилсөн” (*Үйлс 5:31*). Бид нинжин сэтгэлийг сэргээгч Христийн Сүнсгүйгээр гэмшиж чадахгүйн адил Христийн оролцоогүйгээр өршөөлийг мөн хүртэж чадахгүй.

Христ бол аливаа өлзий буянт оргил тэмүүллийн эх сурвалж мөн. Чухамхүү Христ л биднийг нүгэл хилэнцийг жигших сэтгэлтэй болгож чадна.

Үнэн хийгээд ариун ёсонд тэмүүлсэн аливаа тэмүүлэл нь нүгэлт байдлаа ухамсарлах ухамсар лугаа нэгэн адил

Түүний Ариун Сүнс бидний зүрх сэтгэлд нөлөөлж буйг гэрчлэн харуулж байна.

Есүс “Хэрэв Би газраас өргөгдвөл, бүх хүнийг Өөртөө татна” хэмээн айлдсан билээ (*Иохан 12:32*). Нүгэлт хүнд Христ хорвоогийн нүглийг цагаатгахын тулд нас барсан Аврагчийн дүрээр тодрон ойлгогдох ёстой. Бид Голготын загалмайд тэлүүлж хадагдсан Бурханы Хургыг хараад, гэм нүглээсээ чөлөөлөгдөн аврагдаж болох нууцыг улам сайн ойлгож эхэлнэ. Тэгээд Бурханы ивээл биднийг нүглээ наминчлан гэмшихэд хөтөлнө. Христ нүгэлтэн олныг аврахын тулд амь насаа золиослож, зүйрлэхийн аргагүй гүн их хайр энэрлээ илчилсэн билээ. Энэ хайр энэрлийг нүгэлт хүн ойлгомогц тольт зүрх нь уярч, ухаан бодол нь гэгээрч, түүнд гэмших сэтгэл төрдөг юм.

Христэд итгэхээсээ өмнө зарим хүмүүс нүгэлтэй амьдралаасаа ичиж, аль нэг булай муу дадал зуршлаа өөрсдөө орхих нь бий. Гэхдээ л улам сайн болох гэсэн аливаа оролдлого, сайн сайхныг хийх гэсэн тэдний чин хүсэл нь үнэн хэрэгтээ тэднийг Өөртөө татаж буй Христийн хүч чадлын илрэл юм. Тэдний мэдэрч ухамсарлахгүй байгаа энэ хүч нөлөө нь сэтгэл оюунд хүрч, нинжин сэтгэлийг сэргээн, амьдралыг мэдэгдэхүйц өөрчлөн сайжруулдаг байна.

Хүмүүсийн гэм нүглийн төлөө тэлүүлж хадагдсанаа ойлгуулахын тулд Христ Өөрийнхөө загалмайг хүлээн авах сэтгэлийг тэдэнд төрүүлдэг юм. Чингэхэд тэдний өмнө Түүний сургаал нээгдэж, урьдын бузар булай амьдрал нь илэрхий харагдан, гэм нүгэл сэтгэл зүрхэнд нь үндэс ёзоороо хичнээн гүнзгий шигтгэснийг тэд мэдэрч авдаг байна.

Тэд Христийн зөвт үзлийг зах зухаас нь ойлгож эхлээд: “Гэм нүгэлд өртсөн хүн бүхнийг цагаатгахад өчнөөн их үнэ цэнэ шаардагдсан юм бол, нүгэл гэдэг чухам юу юм бэ? Бид бүхнийг үхэлгүй мөнхөд амьдрах хувьтай болгохын тулд хичнээн их хайр энэрэл, шаналал,

доромжлол шаардагдав аа? Бурхан бидэнд ийм хайртай юм гэж үү?” хэмээн дуун алддаг аж.

Нүгэлт хүн энэ хайр энэрэл, Христ рүү татаж байгаа энэ хүчийг эсэргүүцэж болно. Гэвч хэрэв тэр эсэргүүцэхгүй бол Есүст заавал татагдана. Тэд авралын төлөвлөгөөг ойлгож, Бурханы хайрт Хүүд өчнөөн их гай зовлон учруулсан гэм нүглээ наминчлахаар загалмайн хөлд хүрч ирнэ.

Байгаль ертөнцийн хамаг юмыг маш уран эвлэг бүтээж өгсөн мөнөөх Тэнгэрлэг Ухаан хүн ардад хандан, тэдний сэтгэл зүрхэнд илэрхийлэхүйеэ бэрх хүсэл тэмүүллийг оргилуулж байна. Энэ дэлхий дээр юу ч тэр хүслэнг хангаж чадахгүй. Харин Бурханы Сүнс, амар амгалангийн эх сурвалж болсон Христийн ивээлийг эрж хайхыг тэдэнд уриалж байна. Бидний Аврагч үзэгдэх, үл үзэгдэх хүч нөлөөгөөр дамжуулан сэтгэлийг үл хангах нүгэлт зугаа цэнгэлээс хүмүүсийг холдуулж, анхаарлыг нь Түүн дотор олж болох үй олон давуу зүйлд хандуулахыг байнга оролдож байдаг юм. Энэ хорвоогийн хэмхэрхий усан сангаас ханатлаа уухыг дэмий л оролдож буй бүхэнд хандсан Бурханы мэдээнд: «Цангасан нэгэн нь ирэг. Хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй аваг» хэмээн өгүүлжээ (*Илчлэлт 22:17*).

Хэрэв та нар энэ хорвоод олдохгүй ямар нэг сайн сайхан юмны төлөө сэтгэл зүрхээрээ эрмэлзэн тэмүүлж буй аваас энэ хүслэн нь та бүхэнд хандсан Бурханы дуу хоолой мөн гэдгийг зөвшөөрөн хүлээцгээ. Түүнээс та нарын гэм нүглийг уучилж, Христийн хэмжээлшгүй хайр болон Түүний төгөлдөр ариун чанарыг нь нээн өгөхийг гуйцгаа. Бурхан болоод хүнийг хайрлах ёстой гэсэн Бурханы хуулийн зарчмууд Аврагчийн амьдралд төгс тусгалаа олжээ. Ариун хайр, сайн үйлсээр Түүний амьдрал дүүрэн байлаа. Түүнийг бид бишрэн харах, Аврагчаас сацрах гэгээ биднийг гэрэлтүүлэх үед л бид өөрсдийнхөө нүгэл хилэнц, гэм бурууг олж хардаг.

Никодемийн нэгэн адил, зөв амьдарч, ёс бус үйлдэл хийхгүй байна, тиймээс бидэнд бусад нүгэлтнүүд шиг Бурханы өмнө зүрхээ номхотгох хэрэг алга гэсэн бодлоор бид өөрснийгөө хуурч байж болох юм. Тэгвэл зөвхөн Христээс сацрах гэрэл гэгээнд л бид сэтгэл зүрхнийхээ хамаг гэм бурууг харж, бидний үйлдэл бүхэн хувиа хичээх, Бурханд тэрслэх явдлаар бузарлагдсан гэдгийг ойлгож чадна. Бидний ариун ёс үнэн хэрэг дээрээ хир даг болсон хувцастай адил, гагцхүү Христийн цус л нүглийн бузраас биднийг цэвэрлэж, бидний сэтгэл зүрхийг Түүний жишээгээр шинэчилж чадна гэдгийг бид ухамсарлах болно.

Хүмүүсийн зан байдлын хар толбо бүрийг тов тодоор илрүүлэн үзүүлэхэд Бурханы суу алдрын ганцхан туяа, Христийн сэтгэлд шингэсэн ариун чанарын ганцхан гялбаа л хангалттай бөгөөд нүгэлт хүнд өөрийнх нь муу хүсэл, атгаг санаа, бузар үг илхэн болдог байна. Тэр өөрийн тэрслүү үйлдлээрээ Бурханы хуулийг өдөөн дайрснаа олж хардаг. Түүний зүрх Бурханы Сүнсний нөлөөнд автаж, базлан өвдөх ажээ. Христийн ариун, сайхан зан төрхийг бодоход хүнд өөрөө өөрийгөө жигших сэтгэл төрдөг байна.

Зөнч мэргэн Даниел өөрт нь илгээсэн тэнгэрийн зарлагын сүр хүчийг хараад, өөрийнхөө сул дорой, төгс төгөлдөр бус байдлаа мэдэрч сэтгэлээр унажээ. Тэр гайхамшигт үзэгдлийг харах үед төрсөн сэтгэгдлээ илэрхийлж Даниел: “Миний дотор тамир тэнхээ алга болж, царай минь өнгө алдан зэвхийрч, надад хүч чадал үлдсэнгүй” гэжээ (*Даниел 10:8*). Ийм нөлөөнд орсон хүн хувиа бодох, хар амиа хичээх явдлыг үзэн ядаж, Христийн зөвт ёсыг даган Бурханы хууль болон Христийн зан чанарт нь тохирохоор сэтгэлээ ариусгахыг эрмэлзэх болно.

Номлогч Паул өөрийнхөө тухай хэлэхдээ: “хууль дахь зөвт байдлаар” тооцвол (зөвхөн гаднах үйлдлээр

авч үзэх юм бол) “гэм зэмгүй” байв гэжээ (*Филиппой 3:6*). Гэвч тэрээр уг хуулийн дотоод, сүнслэг утгыг нь ойлгоод ирэхлээрээ өөрийгөө нүгэлтэн гэдгийг олж харсан. Хүмүүсийн заншснаар хуулийн үг үсгийг зөвхөн илт үйлдэлд хамааруулах юм бол Паул нүглийг цээрэлдэг хүний тоонд орох байв. Харин тэр ариун сургаалийн гүн учрыг нь ойлгож, өөрийгөө Бурханы нүдээр харж арга буюу нүглээ хүлээн гэмших болсон юм. Паул энэ тухай: “Нэгэн цагт би хуульгүйгээр амьдарч байв. Харин Бурханы тушаал ирснээр нүгэл нь амьдарч, би үхсэн” хэмээн зүйрлэж хэлжээ (*Ром 7:9*). Тэрбээр Бурханы хуулийн оюунлиг чанарыг ойлгомгогц түүний гэм нүгэл нь жинхэнэ ой гутам жигшүүртэй байдлаараа тодорч, биеэ тоосон зан нь ор мөргүй алга болжээ.

Бурхан бүх нүглийг адилхан хэмжээтэй гэж үздэггүй. Бурхан хүмүүсийн адил гэм буруугийн зэрэг хэмжээг янз янзаар цэгнэдэг боловч Бурханы мэлмийд ямар ч нүгэл өчүүхэн төдий харагддаггүй. Хүний дүгнэлт сэтгэмж алаг цоог бөгөөд төгс төгөлдөр биш. Харин Бурхан юм бүхнийг жинхэнэ байгаагаар нь шүүн тунгаана. Архичинг жигшицгээж, нүгэл нь диваажинд очиход саад тотгор болно доо гэж түүнд хэлдэг мөртлөө бардам зан, харам сэтгэл, хувиа бодох явдлыг ихэнхдээ буруушааж зэмлэлгүй өнгөрөөдөг.

Гэтэл чухамхүү эдгээр нүгэл нь Бурханы энэрэнгүй сэтгэл болоод цөвтөж үл доройтох орчлон даяар ноёрхогч тэрхүү ариун хайр ивээлд эрс харшлах тул Түүний хувьд маш доромжлонгүй байдаг. Айхтар нүгэл үйлдсэн хүн ичиж зовж, өөрийнхөө арчаагүй доройг ухаарч, Христийн ивээлийг үгүйлж болох юм. Харин бардам зантай хүнд хэрэгцээтэй юм гэж юу ч байхгүй, тийм болохоор зүрх сэтгэл нь Христ болон Түүний тоо томшгүй ерөөл айлдлыг мэдрэх боломжгүй байдаг.

Өөрийгөө туйлын хүний мөсгүй нэгэн гэж боддог байсан хөөрхий татвар хураагч “Бурхан минь, нүгэлт

намайг өршөөгөөч” хэмээн залбирч байв (*Лук 18:13*). Ойр тойрныхон ч түүнд тийн ханддаг байжээ. Гэвч тэр өөрийн хэрэгцээ шаардлагыг мэдрэн, гэм буруу, ичгүүр сонжуурынхаа дарамтанд туйлдаж гүйцээд Бурханы өмнө очиж, Түүнээс өршөөл эржээ. Тэрээр нүглийн эрхшээлээс чөлөөлөгч Бурханы Сүнсний ивээлийг хүлээж авахад бэлэн байв. Тэгвэл фарисай хүний зөвт үзлээрээ гайхуулсан бардам залбирал нь түүний зүрх Ариун Сүнсний хүч нөлөөг хааж буйг гэрчилнэ. Тэрээр Бурханаас хол хөндий байсан учраас өөрийнх нь мөхөс байдал Бурханлиг ариун чанарт харшлахыг эс ухаарчээ. Тэр Бурханаас тусламж хүсээгүй бөгөөд аваагүй юм.

Нэгэнт та нар гэм нүглээ ойлгож ухаарваас сайн хүн болохоо битгий хүлээцгээ. Маш олон хүн Христэд хүрэхэд өөрсдийгөө учир дутагдалтай гэж үздэг. Та нар өөрсдийнхөө хүчин чармайлтаар засарч сайжирна гэж найдаж байна уу? “Етиоп хүн арьсаа, ирвэс толбоо өөрчилж чадах уу? Мууг үйлдэж зуршсан чи сайныг үйлдэж чадах уу?” (*Иеремиа 13:23*). Бидэнд ганцхан Бурхан л тусална. Илүү үнэмшилтэй баримт сэлт, илүү ариун ёс суртахуун, илүү тааламжтай боломж бий болохыг бид хүлээж суух ёсгүй. Бид өөрсдөө юу ч хийж чадахгүй. Бид ямар байна, тэр хэвээрээ л Христэд хүрэх ёстой.

Гэхдээ Бурхан Өөрийнхөө аугаа их хайр, энэрлээр Түүний ивээлийг огоордог хүмүүсийг ч аварна гэж хэн ч битгий хууртагдаасай. Нүглийн туйлын бузар булайг Голготын загалмай дээрх өргөлөөр л дамжин ойлгож болно. Хэрэв хэн нэгэн хүн, Бурхан нүгэлтэн бүрийг хэлтрүүлэх өрөвч сэтгэлтэй гэж бодож байгаа бол Голготыг харагтун.

Хүмүүнийг аврах өөр арга зам байгаагүй, ийм өргөл өргөхгүй бол хүн төрөлхтөн нүглийн гутамшигт хүчнээс ангижирч, ариун юмстай холбоо харилцаагаа сэргээж чадахгүй байсан учраас л Христ нүгэлтэн олны гэм бурууг

Өөртөө үүрч, хүмүүсийг сүнслэг амьдралаар дахин амьдарч эхлээсэй гэсэндээ тэдний төлөө зовлон эдэлсэн юм. Бурханы Хүүгийн хайр, зовлон болоод үхэл нь нүглийн аймшгийг илрүүлж, Христийг итгэн дагаж гэмээж нь л нүглийн эрхшээлээс ангижирч, илүү сүнслэг амьдарч болно гэдгийг гэрчилж байна.

Заримдаа нүглээ наминчлах хүсэлгүй хүмүүс, Христэд итгэгчдийг зааж “Би тэднээс доргүй. Амь биеэ үл хайрлах зүтгэл, ухаан овсгоо, эрхэмсэг сайхан чанараараа надаас дээрдээд байх юм тэдэнд алга. Тэд надтай л адилхан жаргаж, өөрсдийгөө цэнгүүлж явдаг” хэмээн ярих нь бий. Ийнхүү тэд бусдын дутагдлыг өөрсдийнхөө алмай амирангүйг зөвтгөхөд ашигладаг байна.

Гэвч Эзэн Тэнгэр бидэнд алдаж онодог, нөгчиж төгсдөг хүнийг биш, огт гэмгүй ариун Бурханы Хүүг үлгэр жишээ болгон үзүүлсэн учраас бусдын нүгэл хийгээд алдаа дутагдал бидэнд уучлал болж чадахгүй. Христэд итгэгчдийн зохисгүй байдлыг адлаад байгаа хүмүүс өөрсдийнхөө амьдралаар үлэмж сайн үлгэр дуурайл үзүүлэх ёстой. Хэрвээ тэд Христэд итгэгч ямар байх ёстойг тийм сайн ойлгодог гэж бодож байгаа бол энэ нь тэдний өөрсдийнх нь гэм бурууг зузаатгах юм биш биз? Тэд буяны цагаан мөрөөр хэрхэн амьдрахыг мэддэг мөртлөө тийнхүү амьдрахаас татгалздаг.

Алгуурлах осолтой. Бурханы өмнө гэмших явдлыг хойш бүү тавьцгаа! Мянга мянган хүн мөнхийн амийг үл хүртэх энэ алдааг гаргадаг. Христтэй холбоо тогтоож сэтгэлийн ариуслаа эрж олцгоо! Амьдрал богино бөгөөд тодорхойгүй байдгийг энд нуруших нь илүүц буй заа. Гэвч олон хүний дутуу дулимаг ойлгодог нэгэн аюулын тухай дуугүй өнгөрч болохгүй. Тэр нь нүгэл хилэнцээс ангижирцгаа гэсэн Бурханы Ариун Сүнсний уриаг нэн даруй дагахыг хүмүүс хүсдэгтүйд оршино. Нүгэл хичнээн өчүүхэн байлаа ч түүнийг өөгшүүлэгч үүрд балрах

аюултай. Бидэнд дийлдээгүй нь эцсийн дүнд биднийг ялж, хөнөөнө.

Адам, Ева хоёр хориотой жимс иднэ гэдэг тун ч ялимгүй хэрэг, үүнээс болж Бурханы анхааруулж хэлсэн тэр аймшигт үр дагавар гарахгүй байх гэж өөрсдөдөө итгүүлэхийг оролдсон. Гэтэл энэ ялимгүй хэрэг нь Бурханы хэлбэрэлтгүй ариун хуулийг зөрчсөн явдал байсан юм. Тэр хэрэг хүнийг Бурханаас салгаж, манай дэлхийд цутган орж ирсэн үхэл хагацал, цаглашгүй гаслан зовлонгийн үүдийг нээсэн юм. Газар дэлхийгээс зовж шаналагсдын орилоон чарлаан үеийн үед үргэлж цууриатсаар иржээ. Хүний дуулгаваргүй байсны гайгаар амьтан бүхэн ёлж гаслан байна. Тэнгэрт хүртэл Бурханд тэрсэлсний ул мөр үлджээ. Голготын загалмай Бурханы хуулийг зөрчигсөдийн нүглийг цагаатгахын төлөөх гайхамшигт өргөлийн дурсгал болон сүндэрлэсээр байна. Нүгэл хилэнцэд хөнгөмсөг хандахаа больцгооё!

Бурханы хуулийг зөрчсөн зөрчил бүр, Христийн ивээлийг үл ойшоох явдал бүхэн сэтгэл зүрхийг хахир хатуу болгож, хүсэл зоригийг мохоож, мэдрэмж хүртэмжийг сулруулан, бидэнд өөрсдөд маань муугаар нөлөөлж байна. Бид дуулгавартай байх дургүй болж байгаагаар үл барам Бурханы Ариун Сүнсний уриалгахан дуудлагыг сонсох чадвар мөхөс болж байна.

Муу явдлын зам мөрийг орхиё гэсэн цагтаа л орхиж чадна гэж олон хүн сэтгэлээ тайтгаруулж байна. Тэд Бурханы энэрэнгүй дуудлагыг үл ойшоолоо ч гэсэн тэр дуудлагыг ахин дахин хүлээн авч болох мэт санадаг ажээ. Тэд амьдрах хугацаандаа ивээлийн Сүнсийг гомдоож, Сатаны талд орсон ч туйлын аюултай үе дөхөхөд зам мөрөө өөрчилж болно гэж боддог юм. Гэвч ингэхэд тийм амар биш ээ. Нүгэлт амьдрал хүмүүсийн зан төрхийг буруу төлөвшүүлж чадах учраас хожим нь цөөн хэдэн хүнд л Христтэй ижилсэх хүсэл төрж болох юм.

Зан байдлын нэгээхэн дорой шинж, сэтгэл зүрхэндээ тээж явдаг нэгээхэн нүгэлт хүслэн ч эцсийн эцэст баярт мэдээний хүчийг үгүй хийдэг юм. Нүгэл хилэнцэд элдвээр тал засах явдал санаа сэтгэлийг Бурханаас холдуулна. Тэнгэрлиг үнэнд зориуд үл итгэн, хүйтэн цэвдэг, тоомсоргүй хандсан хүн эцсийн дүнд өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр унахыг үзнэ. Цэцэн Соломон, нүгэлт хүн «өөрийнхөө нүгэл хилэнцийн уяанд хүлээстэй байх аж» гэж хэлсэн байдаг (*Сургаалт үгс 5:22*). Библи сударт үүнээс илүү муу үйлст хөнгөмсөг хандах явдлаас ноцтой сэрэмжүүлсэн сургамж алга.

Христ биднийг нүглээс ангижруулахад бэлэн байдаг боловч Тэр хүслээ бидэнд хүчээр тулгадаггүй. Хэрэв бид нүгэлдээ шигдээд, булай муу явдалд бүрэн автаж, Бурханаас авралын ивээл хүртэхийг хүсэхгүй байвал Тэр яахсан билээ? Бид Бурханы энэрэл хайрыг зөрүүдлэн няцааснаараа өөрөө өөрсдийгөө баллаж байгаа юм. “Тэр тааламжтай цагт чамайг сонссон, авралын өдөрт чамд тусалсан” (*2 Коринт 6:2*). “Түүний дуу хоолойг сонсохдоо сэтгэл зүрхээ битгий хахир хатуу болгоцгоо!” (*Еврей 3:7-8*)

“Хүн гаднах төрхийг хардаг бол Эзэн зүрхийг нь хардаг” (*1 Самуэл 16:7*). Бурхан баяр гуниг эсэргэцсэн хувирамтгай, өжүүн хүний зүрхийг, бузар булай, худал хуурмагаар дүүрэн зүрхийг хардаг. Бидний санаа сэхээрэл хийгээд зорилго Бурханы өмнө илхэн буй. Та нарын сэтгэл хичнээн алдаа оноотой байлаа ч гэсэн Түүний зүг явцгаа! Дуулалч лугаа адил “Өө, Бурхан минь, намайг судлан, миний зүрхийг мэдээч. Намайг шалгаж, миний бодлыг мэдээч. Миний дотор ямар нэг хөнөөлт үйл буй эсэхийг харж, мөнхийн зам руу намайг залаач” хэмээн гуйж, сэтгэлийнхээ нандин бүгдийг Хамгийг тольдогч мэлмийн өмнө дэлгэцгээе (*Дуулал 139:23-24*).

Сэтгэл зүрх нь ариусаагүй тохиолдолд хүн зөвхөн оюун ухаанд тулгуурласан шашин буюу “ариун ёсны

дүрээр” л сэтгэл ханадаг байна. Тэгвэл “Бурхан, миний дотор цэвэр зүрхийг бүтээж, миний дотор зөв сүнсийг шинэчлээч” (*Дуулал 51:10*) хэмээн залбирцгаа! Та нар өөрөө өөрсөдтэйгээ чин шударга байцгаа! Та бүхний амьдралыг аюул занал нөмөрвөл ямар байх вэ, яг л тийм хичээл зүтгэлтэй, шургуу мэриймтгий байцгаа! Энэ бол Бурхан болон та нарын сэтгэлийн хооронд өнө мөнхийн төлөө шийдэгдэх ёстой асуудал юм. Та нарын найдах гэж оролдсон хоосон найдлага та бүхэнд осолтойгоор эргэж мэднэ.

Бурханы Үгийг залбиран байж судалцгаа! Энэ Үг танд Бурханы хууль бөгөөд Христийн амьдрал дахь ариун ёсны аугаа их зарчмуудыг нээж өгнө. Энэ зарчимгүйгээр “хэн ч Эзэнийг үзэхгүй болой” (*Еврей 12:14*). Тэрхүү Үг биднийг нүгэлтэн гэдэгт итгүүлж, авралын замыг тов тодорхой зааж өгч байна. Тэр Үгийг та нарын сэтгэл зүрхэнд хандсан Бурханы дуу хоолой хэмээн анхааран сонсох нь зайлшгүй чухал.

Нүглийн аймшиг, зүрх сэтгэлийнхээ үнэн байдлыг олж хараад цөхөрч бачимдахын хэрэггүй. Христ нүгэлтэн олныг аврахаар ирсэн шүү дээ. Бурханыг өөртөө татах гэхийн хэрэг бидэнд огт байхгүй. “Яагаад гэвэл Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, хүмүүсийн гэм бурууг үл харгалзсан билээ” (*2 Коринт 5:19*). Өөрийн элбэрэлт хайраар Тэр Өөрийнхөө төөрч будилсан хүүхдүүдийг Өөртөө татдаг юм. Бурхан аврахыг хүссэн хүмүүст ханддаг шиг, газар дэлхийн эцэг эхчүүдээс нэг нь ч алдаж эндсэн үр хүүхдэдээ тийм тэвчээртэй хандаж чадахгүй. Төөрөлдсөн хүнийг Түүнээс илүүтэйгээр хэн ч хайрлаж халамжилж үл чадна. Бурханы бүхий л амлалт, сэрэмжлүүлэг нь Түүний өгүүлшгүй их хайр энэрлийн илэрхийлэл юм.

Сатан та нарыг маш их нүгэлтэнгүүд гэж хэлбэл Өөрийнхөө Цагаатгагчийн зүг хараад Түүний гавъяа зүтгэлийн тухай яриарай. Чухам юу та бүхэнд тус болох

вэ гэвэл, Түүнээс сацарч буй гэрэл гэгээг итгэлтэйгээр ширтвээс болох нь тэр. Нүглээ наминчил, чингэхдээ “Христ Есүс нүгэлтэн олныг аврахаар ертөнцөд ирсэн” (1 Тимот 1:15), тиймээс бид Түүний үлэмжийн их хайр энэрлээр аврагдаж чадна гэж Сатанд хэлээрэй.

Нэг удаа Симонд Есүс өр тавьсан хоёр хүний тухай ярьжээ. Тэр хоёрын нэг нь эзэндээ бага шиг мөнгө, нөгөөдөх нь асар их мөнгөний өртэй байжээ. Эзэнтэн хоёуланг нь өрнөөс хэлтрүүлжээ. Христ “Тэгвэл тэдний хэн нь Эзэнээ илүү хайрлах бол?” гэж асуусанд Симон “Илүү өгөөмрөөр хэлтрүүлэгдсэн нь” гэж хариулсан гэдэг (Лук 7:43).

Бид маш их нүгэлтэн байсан, гэвч Христ бидэнд өршөөл уучлал хайрлахын тулд нас барсан. Түүний өргөл, Эцэгээс бидний авралын тухай асуухад дүйцэхүйц хангалттай аугаа билээ. Хичнээн их уучлал хүртсэн нь Бурханыг төдий чинээ их хайрлах болно. Эдгээр хүмүүс Түүний хаан ширээнд бусдаас ойрхон зогсож, Түүний үлэмжийн хайр, цаглашгүй өргөлийг алдаршуулах болно. Бид Бурханы хайр энэрлийг хэдий чинээ бүрэн дүүрэн ойлгох тусам нүгэл хилэнцийн хор уршгийг төдий чинээ сайтар ухамсарлах билээ. Бурханы бидэнд хүртээсэн өршөөл хичнээн өгөөмөрийг мэдэж, Христийн бидний төлөө өргөсөн өргөлийн суу ихийг ойлгож эхэлмэгц бидний зүрх сэтгэл хайр болон гэмшлийн давалгаанд хайлан уярдаг байна.

БУРУУГАА ХҮЛЭЭХҮЙ

Гэм нүглээ нуун далдлагч хэзээ ч амжилтанд хүрэхгүй. Харин гэм нүглээ хүлээн зөвшөөрч, тэдгээрийг мартдаг хүн хайр энэрлийг хүртэнэ” (*Сургаалт үгс 28:13*).

Бурханы өршөөл! Юутай энгийн, ухаалаг хийгээд шударга нөхцөлд түүнийг хүртэж болох билээ! Эзэн, нүглийн уучлалыг авахын тулд өөрсдийгөө зовоож зүдрээхийг биднээс шаардаагүй. Тэнгэрээс өршөөл хүртэж, өөрснийхөө хууль бус явдлыг цагаатгахын тулд бидэнд зовлон зүдгүүр амсан алс холын газар аялж мөргөл хийх эсвэл өөрийн махан биеэ тарчлаан зовоохын хэрэг байхгүй. Нүглээ ухаарч хүлээгээд дахин үйлдэлгүй орхисон хүн өршөөгдөнө.

Сургаал номлогч: “Тийм учраас бие биенийхээ өмнө нүглээ хүлээн зөвшөөрч, бие биенийхээ төлөө залбир. Ингэснээр та нар эдгээгдэх болой” хэмээжээ (*Иаков 5:16*). Өөрийн нүгэл хилэнцээ Бурханы өмнө хүлээцгээ, учир нь зөвхөн Тэр л түүнийг уучилж чадна. Өөрсдийн гэм бурууг нэг нэгнийхээ өмнө хүлээцгээ. Хэрэв та өөрийн анд буюу хөршийг гомдоосон бол буруугаа хүлээх ёстой, харин цаад хүний чинь үүрэг бол таныг уриалгахан уучлах.

Дараа нь та Бурханаас уучлал гуйх хэрэгтэй, яагаад гэвэл таны гомдоосон хүн мөн л Бурханд харьяалагддаг бөгөөд түүний сэтгэлийг эмзэглүүлснээрээ та бидний Бүтээгч хийгээд Цагаатгагчийн эсрэг нүгэл үйлдсэн байна. Ядарч туйлдахын цагт биднийг өрөвдөж, элдэв хар толбо, гэм нүглээс ариусгаж чадах цорын ганц Зуучлагч, “нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон” (*Еврей 4:15*) Тэргүүн Тахилчид та бүх үнэнээ яриарай.

Бурханы өмнө өөрсдийгөө хүлцэнгүй байлгаж, гэм буруутан гэдгээ хүлээгээгүй хүмүүс, Бурхан тэднийг

хүлээж авах гол болзлыг биелүүлэхгүй байна гэсэн үг юм. Хэрэв бид хожим харамсахааргүйгээр гэмшээгүй бол, хэрэв бид сэтгэл зүрхээрээ үнэнхүү даруу байж, оюун санаагаараа цөхөрч нүглээ наминчлаагүй бол, хууль бус үйлдлээ жигшин үзээгүй бол бид нүглээ уучлуулахын төлөө жинхэнэ ёсоор тэмүүлээгүй байгаа хэрэг. Үүнийг хийлгүйгээр бид Бурханы амар амгаланг олж чадахгүй билээ. Бид зүрхээ номхотгож, Бурханы Үгэнд заасан болзлуудыг биелүүлэхийг хүсэхгүй байгаа тэрхүү ганц шалтгаанаар л бидний урьдын нүгэл уучлагдалгүй үлдэнэ.

Энэ талаар бидэнд өгсөн илт бөгөөд тов тодорхой сургаал бий. Нүглээ яаж ч хүлээлээ гэсэн олны дунд ч, Бурхантай хоёулхнаа байхдаа ч үүнийг чин сэтгэлээсээ, зүрхнийхээ угаас хийх хэрэгтэй. Үүнд албадлага байж болохгүй, бас өөрийн бурууг хөнгөмсгөөр, хальт мөлт хүлээх явдал ч байж таарахгүй. Хэрэв хүн үйлдсэн нүгэл нь, ямар жигшүүртэй муухай вэ? гэдгийг ойлгоогүй бол түүнийг нүглээ наминчил гэж шахаж шаардаж болохгүй. Голт зүрхнийхээ угаас гэмшсэн тохиолдолд л биднийг өрөвч зөөлөн сэтгэлт Бурхан хүлээж авна. Дуулалч: “Эзэн эмтэрсэн зүрхтэй хүнд ойртон байдаг бөгөөд Сүнсээрээ гэмшигчдийг авардаг” гэжээ (*Дуулал 34:18*).

Өөрийн нүглийг жинхэнэ ёсоор ухамсарлах нь бодитой бөгөөд тов тодорхой байх учиртай. Зарим нүглийг зөвхөн Бурханы өмнө гэмшин хүлээж, нөгөө заримыг тэр нүглээс болж хэлмэгдсэн хүмүүсийн өмнө хүлээх ёстой болно. Харин нийгмийн өмнө үйлдсэн нүглүүдийг нийт олны өмнө гэмшин хүлээх ёстой ажээ. Гэхдээ аливаа нүглээ хүлээх явдал маш тодорхой, гэм буруугийнхаа голы нь олсон байх ёстой.

Самуелийн амьдарч байсан өдрүүдэд Израильчууд Бурханаас холдож, нүгэл хилэнцийнхээ төлөө зовж зүдэрсэн билээ. Тэд Бурханд итгэх итгэлээ алдаж, Бурханы мэргэн ухаан, хүчин чадал өөрсдийг нь удирдаж

байдгийг ойлгох сэхээгүй болсон юм. Тэд Өөрийнхөө үйл хэргийг хамгаалах Эзэний чадварт итгэхээ больжээ.

Тэд аугаа их Ертөнцийн Захирагчаас нүүр буруулж, хөрш улс түмэнтэйгээ адил төрийн байгууламжтай байхыг хүссэн юм. Энх амгаланг олохоосоо өмнө Израильчууд “Бид өөрсөддөө хааныг гуйснаараа өөрсдийн бүх нүгэл дээр энэ бузрыг нэмсэн” (1 Самуел 12:19) хэмээн буруугаа ил тодоор хүлээсэн билээ. Сэтгэл зүрх нь татагдаад байсан чухамхүү тэр л нүглээ тэд гэмшин хүлээх ёстой байлаа. Тэдний хуншгүй зан сэтгэл санаагий нь шаналгаж, тэднийг Бурханаас тусгаарласан юм.

Нүгэл үйлдсэндээ чин сэтгэлээсээ гэмшиж, түүнээ залруулахгүй аваас Бурхан хүлээж авахгүй. Амьдралд шийдвэрлэх өөрчлөлтүүд гарч, Бурханыг доромжлон дайрсан бүхий л оролдлого үгүй болох ёстой. Нүгэл үйлдсэндээ жинхэнэ ёсоор гэмшсэний үр дүн ийм л байх аж. “Биесээ угаагтун. Өөрсдийгөө цэвэрлэ. Миний хараанаас бузар муу үйлсээ зайлуул. Нүгэл хийхээ болигтун. Сайныг үйлдэхэд суралц. Шударга ёсыг эр. Хэрцгий догшиныг зэмлэ. Өвчтөнийг хамгаал. Бэлэвсэнг өмгөөлөгтүн” (Исаиа 1:16-17) хэмээн бидний юу хийх ёстойг тов тодорхой заажээ.

“Хэрвээ хорон муу үйлстэн барьцаалсан юмыг буцааж, тоносон юмсыг буцаан төлж, хууль бусыг үл үйлдэн, амийн баталсан журмыг дагаж явбаас тэр заавал амьдарна. Тэр үхэхгүй” (Езекиел 33:15).

“Энэхүү бурханлаг гашуудал нь та нарын дотор ямар хэрсүү байдал, зөвтгөл, эгдүүцэл, айдас, халуун хүсэл, зүтгэл, шийтгэл бий болгосныг харагтун. Та нар цэвэр гэдгээ энэ хэрэгт алив бүхнээр харууллаа” (2 Коринт 7:11) хэмээн номлогч Паул үнэнхүү гэмшлийн тухай бичжээ.

Нүгэл хилэнц ёс суртахууныг үгүй хийдэг, тийм учраас нүгэлт хүн зан байдлынхаа дутагдлыг анзаарахаа больж, үйлдсэн хорлонт хэргийнхээ аюумшигийг ойлгох

тэнхэлгүй болдог. Хэрэв тэр Ариун Сүнсний итгүүлэгч хүчин чадалд захирагдахгүй юм бол өөрийнхөө нүглийг бүрэн ухамсарлахгүй. Түүний гэмшил чин үнэн, буурь суурьтай болж чадахгүй. Тэр илчлэгдэхээсээ эмээж, гэм буруугаа хүлээвч сав л хийвэл тухайн нөхцөл байдлаар шалтаглан өөрийгөө зөвтгөхийг оролдох болно.

Хориотой жимс идсэний дараа Адам, Ева хоёр их айж ичсэн байв. Тэр хоёр нүглээ яаж цагаатгаж, үхлээс яаж зайлсхийх вэ гэж л бодож байсан. Их Эзэн тэр хоёрын үйлдсэн нүглийн тухай асуухад Адам хариулахдаа “Надтай хамт байлгахаар Таны надад өгсөн тэр эмэгтэй надад тэр модны жимснээс өгсөн, тэгээд би идсэн” хэмээн үйлдсэн нүглийнхээ заримыг Бурхан, Ева хоёр луу түлхжээ. Эхнэр нь болохоор могойг буруутгажээ: “Тэр могой намайг мэхэлсэнээс болоод би идсэн” (Эхлэл 3:12-13).

Та яагаад могойг бүтээсэн юм бэ? Та яагаад могойг Едэний цэцэрлэгт оруулсан юм? Евагийн хариултанд эдгээр асуултууд битүүдээ хөндөгдсөн нь өөрсдийн уруу татагдсаны хариуцлагыг Бурханд тохох гэсэн оролдлого байв. Өөрийгөө зөвтгөх үзэл санааг «худал хуурмагийн эцэг» анх гаргасан бөгөөд тэр нь Адамын бүх л хөвгүүд охидод илэрдэг ажээ.

Ийм байдлаар буруугаа хүлээхийг Ариун Сүнс дэмждэггүй, Бурхан хүлээж авдаггүй юм. Чин үнэнээсээ гэмшсэн хүн нүгэл үйлдсэн хамаг хариуцлагыг өөртөө үүрч, гэм буруугаа нэрэлхэж баашлалгүй шулуухан хүлээдэг. Тэнгэр өөд харах зүрхгүй болсон хөөрхий татвар хураагчтай адил тэрээр «Бурхан минь, нүгэлтэн намайг өршөөж үз» гэж залбирах болно. Гэм буруугаа хүлээгсэд цагаатгагдана, яагаад гэвэл Есүсийн цус, Түүний өмгөөллөөр тийм боломж буй болно.

Бурханы айлдварт үнэнхүү гэмшил, хүлцэнгүйн жишээг дурджээ. Библид өөрийгөө уучлуулах, эсвэл зөвтгөхийг оролдолгүй буруугаа хүлээсэн хүмүүсийн

тухай олонтаа өгүүлжээ. Номлогч Паул нүглээ нуугаагүй билээ. Тэрээр гэм буруугаа нимгэлэхийг өчүүхэн ч үл оролдон, аймшигт гэм нүглээ ил гаргаж тавьсан байв. Тэр «Би ахлах тахилч нараас эрх мэдэл аваад, ариун хүмүүсээс олныг шоронд хийснээр барахгүй тэднийг алж байхад нь ч тэдний эсрэг саналтай байлаа. Бүх синагогт би тэднийг дахин дахин залхаан байхдаа Бурханыг доромжлуулахыг хүчээр оролдон, тэдэнд хэрцгий хандаж, бүр харийн хотуудад ч хүртэл очиж, тэднийг мөшгөн мөрдөж байв» гэжээ (*Үйлс 26:10-11*). Паул өчүүхэн ч гуйвж дайвалгүй “Христ Есүс нүгэлтнүүдийг аврахаар ертөнцөд ирсэн. Тэдгээр нүгэлтнүүдийн эхнийх нь би байна” хэмээсэн билээ (*1 Тимот 1:15*).

Үнэнхүү гэмшилд автсан хүлцэнгүй хийгээд энэлэнт зүрх Бурханы хайр, Голготад өргөсөн өргөлийн нэгээхэн хэсгийг ч атугай хүртэж чадах бөлгөө. Хайрт эцгийнхээ өмнө хүү нь гэм буруугаа хүлээдэг шиг үнэнхүү гэмшсэн нүгэлт хүн хууль бус бүхий л хэргээ Бурханд нээж хэлдэг. “Бид нүглээ хүлээн зөвшөөрвөөс, Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ” хэмээн Библид сургадаг ажээ (*1 Иохан 1:9*).

БУРХАНД БҮХНЭЭ ЗОРИУЛАХУЙ

Та нар Намайг хайх бөгөөд бүхий л зүрхээрээ Намайг хайвал олно” хэмээн Бурханы амлалтанд өгүүлжээ (*Иеремиа 29:13*).

Бидний дотор Бурхантай төст байдал сэргээгдэхүйц өөрчлөлт гарахын тулд бид Түүнд бүрнээ автагдах учиртай. Бид уг чанараараа Бурханаас хөндийрөн холджээ.

“Та нар өөрсдийн нүгэл, хилэнц дотор үхсэн байв”, “Толгой нь бүхэлдээ өвчтэй, зүрх нь бүхэлдээ ядруу байна, эрүүл газар алга”, Сатан өөрийнхөө торонд чанга атгаж “өөрийн хүслээр тэднийг хөдөлгөхийн тулд тэднийг олзлон авсан байна” (*Эфэс 2:1; Исаиа 1:5-6; 2 Тимот 2:26*) хэмээн Ариун Сүнс бидний байдлыг дүрслэн өгүүлжээ. Бурхан биднийг анагааж, чөлөөлөхийг хүсч байна. Чингэхийн тулд бидний бүхий л төрөлх чанарыг язгуур үндсээр нь өөрчлөн шинэчлэх шаардлагатай учраас бид Түүнд бүрэн захирагдах ёстой.

Өөрийнхөө “би”-тэй тэмцэлдэх нь хүмүүсийн хэзээ нэгэн цагт хийхээс аргагүй хамгийн том тулалдаан мөн. Өөрийнхөө “би”-г номхотгож, Бурханы таалалд бүрэн нийцүүлэхийн тулд хүчин чармайлт хэрэгтэй. Бурханд өөрийгөө зориулахгүйгээр хүн ариун ёсны шинэ амьдралыг зохиох боломжгүй.

Бурханы засаглал нь Сатаны дүрсэлж үзүүлэхийг хүсдэгчлэн сохроор бишрэн дагах, өөрийн бодолгүй захирагдах явдал биш юм. Бурхан Өөрийнхөө бүтээлүүдийн саруул ухаан, нинжин сэтгэл өөд дуудаж, хүмүүст хандан: “Нааш ир. Хамт хэлэлцье” (*Исаиа 1:18*) хэмээн санал гаргаж байна. Тэрээр бидний хүсэл зоригийг хүчээр барьдаггүй, харин сайн дураараа ухаалгаар итгэх

итгэлийг хүлээж авдаг юм. Албадлагаар итгэх явдал, оюун ухаан болон ёс суртахууныг бүхий л талаар хөгжүүлэх бололцоог хааж, хүнийг оньсон хөдөлгүүр мэт болгон хувиргана. Энэ нь Бүтээгчийн хүсэл зоригт харшилна.

Тэр Өөрийнхөө бүтээлийн дээж болсон хүнийг дээд зэргээр хөгжөөсэй гэж хүсдэг юм. Бурхан эрхэм дээд аз жаргалыг бидэнд санал болгож, Өөрийнхөө өршөөл ивээлийн хүчээр биднийг тэр аз жаргалд умбуулахыг хүсэмжилдэг юм. Тэр Өөрийнхөө үзэл санааг бидний дотор хэрэгжүүлэхийн тулд биднийг Өөртөө урин дуудаж байна. Бурханы үр хүүхдүүдийн эрх чөлөөг эдлэхийн тулд гэм нүглийн боолчлолоос чөлөөлөгдөхийг бид хүснэ үү? Энэ бол бидний сонголт мэдсэн хэрэг.

Бид өөрсдийгөө Бурханд зориулахдаа биднийг Түүнээс тусгаарлаж байгаа юм бүхнээс зайлшгүй татгалзах ёстой. Тиймээс ч Аврагч “Та нарын хэн нь ч байгаа бүхнээсээ эс татгалзваас Миний шавь байж чадахгүй” (Лук 14:33) хэмээн айлджээ.

Зүрх сэтгэлийг Бурханаас холдуулагч бүхнийг орхих хэрэгтэй. Эд баялаг олон хүний шүтээн болж хувирсан. Мөнгө зоосонд шунаж, баяжих гэж улайран зүтгэх явдал бол тэднийг Сатантай холбож дөнгөлсөн гинж мөн. Бусад зарим нь юу юуны түрүүнд нэр алдар, өргөмжлөл хүндлэл рүү тэмүүлдэг. Зарим нь санаа амар, ямар ч хариуцлагагүй амьдрахыг эрхэмд үздэг. Гэвч боолчлолын эдгээр гав гинжийг тас цохих ёстой. Бид нэг хэсгээ Их Эзэний мэдэлд, нөгөө хэсгээ дэлхийн мэдэлд байлгаж таарахгүй. Хэрэв бид Түүнд бүрэн харъяалагдахгүй бол Бурханы хүүхдүүд болж үл чадна.

Зарим нь Бурханы хуулийг биелүүлэх, ариун зан байдлыг төлөвшүүлэх, аврагдахын тулд өөртөө л бүрэн найдлага тавьдаг мөртлөө Бурханд хүчин зүтгэж байна гэж ярьдаг. Эдгээр хүмүүс Христийн хайр энэрлийг хамаг зүрх сэтгэлээрээ мэдэрч чадаагүй авч Бурханы шаардлага

хэмээн Христэд итгэгчийн үүргээ сайн биелүүлж, улмаар мөнхийн амьдрал хүртэхийг эрмэлздэг. Тэгвэл ийм итгэл юунд ч хүргэхгүй.

Христ зүрхэнд минь бат оршиж байгаа цагт бидний сэтгэл Түүний хайр энэрэл, Түүнтэй харилцсаны баяр баясгалангаар бялхаж, Түүнгүйгээр цаашид байхын аргагүй болдог. Түүний тухай эргэцүүлэн бодохдоо бид өөрийнхөө “би”-г умартаж, Христийг хайрлах хайрын хүчээр хамаг бүхнээ хийдэг.

Бурханы хайр энэрлийн хүчийг мэдэрсэн хэн боловч Бурханы шаардлагыг өөрийн зүгээс яаж аль болох бага хохиролтойгоор хангая даа гэж огт боддоггүй. Тэд өөрсдийнхөө Цагаатгагчийн хүсэл зориг лугаа бүрэн нийцтэй аж төрөхийг эрмэлзэн, хамаг юмаа дуртайяа орхиж, сонгосон зорилгодоо хүрэхийн төлөө өөрийгөө бүрэн дайчлахад бэлэн байдаг. Хэрэв Христэд итгэгчийн сэтгэл зүрхэнд энэ гүн хайр байхгүй бол түүний итгэл хоосон үг, худал хуурмаг зүйл, хүнд дарамт болно.

Та нар Христэд бүхнээ зориулахдаа хэтэрхий их юм золиослож хохирч байна гэж бодож байж болох юм. Тэгвэл өөрсдөөсөө “Христ миний төлөө юугаараа хохирсон билээ?” гэж асуугтун. Бурханы Хүү биднийг аврахын төлөө амгалан тайван байдал, халуун амь бүхнээрээ хохирсон. Тэр бидэнд хамаг зүрх сэтгэл, хайр энэрлээ зориулсан. Тэгэхэд бид, тийм л хайр энэрэл үгүй хүмүүс, Түүний төлөө зүрхээ нээхгүй байх гэж үү?

Бид агшин бүрийг Христийн өршөөл ивээлээр өнгөрөөж буй боловч ямархан их мунхаг бүдүүлэг, гаслан зовлонгийн харанхуй ангалаас биднийг өөд татан гаргасныг бүрэн дүүрэн ухамсарлахгүй байгаа юм. Бидний нүгэлд цоо хатгуулсан Түүний өөдөөс бид хараад Түүний хайр энэрэл хийгээд хүмүүсийн төлөө золиослогдон шаналахдаа эдэлсэн зовлонг нь хайхрахгүй байж болох уу? Эзэн Өөрийгөө хичнээн төв хүлцэнгүй болгосныг харсаар байж, амьдралд хөтлөх бидний зам

тэмцэл, бэрхшээл дундуур өнгөрдөгт унтууцаж болно гэж үү?

Бардам зантай олон хүн “Хүлцэнгүй байж гэмшихийн хэрэг юу байна вэ? Ингэлгүйгээр Бурхан намайг хүлээж авна гэдэгт итгэл дүүрэн байж болохгүй гэж үү?” хэмээн асуудаг. Тэгвэл Христийг харцгаа. Тэр нүгэлгүй байсан. Түүгээр ч барахгүй Тэр Тэнгэрийн Хаан байсан, гэвч хүн төрөлхтнийг цагаатгахын тулд нүглийн Золиос болсон. “Тэр Өөрийн амийг үхэл уруу асгаж, хилэнцэтнүүдтэй хамт тоологдсон. Тэр олны нүглийг Өөртөө тээж, хилэнцэтнүүдийн төлөө зуучилсан” билээ (*Исаиа 53:12*).

Бид сэтгэл санаа бүхнээ Христэд өгөхдөө юунд татгалзана вэ? Есүс нүгэлд автсан бидний зүрхийг Өөрийн цусаар ариусгаж, Өөрийн зүйрлэшгүй хайр энэрлээр биднийг нүглийн бузраас аврахыг л хүсдэг. Гэтэл зарим хүнд байгаа бүхнээ Бурханд зориулах нь маш хэцүү санагддаг. Иймэрхүү үг яриа, бодол санаа бидэнд ичиж зовох сэтгэлийг төрүүлэх ёстойсон.

Бурхан үнэхээр хэрэгтэй зүйлээсээ татгалзахыг биднээс шаарддаггүй. Тэр үргэлж Өөрийн үр хүүхдийн сайн сайхны төлөө байдаг. Христийг хараахан сонгож амжаагүй байгаа хүмүүс, Бурхан тэдэнд энэ хорвоогийн элдэв юмтай зүйрлэшгүй сайн сайхныг хүсдэгийг л ойлгох хэрэгтэй. Хүн Бурханы хүслийн эсрэг бодож, сэтгэж үйлдэх нь өөртөө асар их гай тарьж байгаа хэрэг юм. Бурханы хориглосон замаар явбал жинхэнэ аз жаргалыг эдэлж чадахгүй. Зөвхөн Тэр л бидэнд чухам аль нь сайн бэ? гэдгийг мэдүүлж, бидний сайн сайхны төлөө бүхий л зүйлийг төлөвлөдөг шүү дээ. Харин нүглийн зам бол зовлон гаслан, үхэл мөхлийн зам билээ.

Бурхан Өөрийнхөө үр хүүхдүүдийн зовлонг хараад сэтгэл ханадаг гэж боддог хүмүүс ихээхэн төөрөлдөж байна. Нэлэнхүй Тэнгэр хүнийг аз жаргалтай байгаасай гэж хүсч байдаг юм. Тэнгэр дэх бидний Эцэг Өөрийн гараар бүтээсэн хүмүүний баяр баясгаланг хааж

боогдуулдаггүй. Харин ч Бурхан аз жаргал ба мөнх амьдралд хүрэх замыг боож хаах, зовлон гаслан тарих зүйлээс татгалзахыг бидэнд уриалдаг билээ. Ертөнцийг Аврагч хүмүүсийг жинхэнэ байгаа байдлаар нь, бүхий л гэм зэмтэй нь, төгс төгөлдөр биш, эмзэг сул шинжтэй нь хүлээж авдаг юм. Бурхан тэднийг нүглээс нь цэвэрлэж, Өөрийн цусаар цагаатгадагаар үл барам Түүний «ачааг» үүрэхийг зөвшөөрсөн хүн бүхний нандин хүсэл эрмэлзлийг нь хангадаг юм. Тэр Өөрөөс нь “амьдралын талх” гуйж ирсэн хүн бүрийг энх амгалан байлгахсан гэж хүсч байдаг.

Есүс биднийг жаргал цэнгэлийн оргилд хүргэх тэр л үүргүүдийг биелүүлэгтүн хэмээн уриалан дууддаг билээ. Түүний хүсэл тааллыг эсэргүүцсэн хүмүүс ийм байдлыг хэзээ ч амсч чадахгүй. Суу алдарын найдлага болсон Христийг зүрхэндээ тээгч хүн амьдралын баяр баяслыг дүүрэн эдэлдэг.

“Өөрийнхөө амьдралыг Христээр яаж удирдуулах вэ?” гэж олон хүн асуудаг. Та нар өөрсдийгөө Христэд зориулахыг хүсдэг боловч ёс суртахууны гэсвэр хатуужил үгүй, эргэлзэж тээнэгэлздэг, нүгэлт зуршлын эрхшээлд орсон байдаг. Та нарын өөртөө өгсөн амлалт, шийдвэр тоглоомон байшин шиг нурж унадаг. Та нар өөрийнхөө бодол, сэхээрэл, шохоорхлыг удирдан жолоодож чаддаггүй. Үл биелэгдэх үүрэг амлалтууд та нарыг өөрсдийнхөө чин сэтгэлд эргэлзэхэд аргагүй хүргэдэг.

Бурхан та нарыг хүлээж авахгүй юм шиг санагдавч гутарч цөхрөхийн хэрэг байхгүй. Хүсэл зоригийн жинхэнэ хүч гэж юу вэ? гэдгийг ойлгох хэрэгтэй. Хүний мөн чанараар яривал, энэ нь аливаа шийдвэр гаргах үед зөв сонголт хийхэд хүргэдэг хүч бөлгөө. Хамаг юм хүний хүслийн зөв үйлдлээс шалтгаална.

Бурхан сонголт хийх чадварыг хүнд заяасан юм. Тэр чадварыг ашиглах хэрэгтэй. Хэдийгээр та нар зүрх сэтгэлээ дан өөрсдийн хүчээр өөрчилж чадахгүй боловч

Бурханыг дагах тодорхой сонголт хийж чадна. Хэрэв хүсэл эрмэлзлээ Түүнд даатгах тэнхэлтэй бол, Тэрбээр та нарын хүсэл, үйлдлийн аль алиныг Өөрийн тааллаар зохицуулах болно. Чингэвээс та нар Христийн Сүнсний удирдлагад бүрэн орж, хүсэл сонирхол тань Түүнийхтэй эвсэн нийцнэ.

Ариун ёс, сайн үйлс рүү тэмүүлэх нь сайшаалтай хэрэг, гэвч дан ганц хүсэл эрмэлзлээр хязгаарлагдвал ямар ч ашиг тус гарахгүй. Хэдийгээр Христэд итгэгч болохыг хүсч, Түүний дагалдагчид хэмээн өөрсдийгөө тооцсон ч олон хүн төөрөлдөх болно. Учир нь тэд өөрийн хүслээ Бурханд захируулаагүй, бас ийм сонголт хийхийг даруй шууд шийдэж чадахгүй байна.

Хэрэв та нар өөрсдийнхөө хүсэл зоригийг зөв гольдролд чиглүүлэх юм бол та нарын амьдрал бүхэлдээ өөрчлөгдөх болно. Та бүхэн амьдрал юугаан Христэд даатгавал Ертөнцийн хамгаас хүчирхэг Эзэний тусламж дэмжлэгийг авч чадна. Бурханд бүхнээ зориулваас та шинэ амьдралаар итгэл төгс замнах болно.

БУРХАНД ИТГЭЖ ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ

Ариун Сүнс нинжин сэтгэлийг тань сэргээхэд та нар нүгэл хилэнцийн хор хөнөөл, эвдэн бусниулагч хүчийг нь ухаарч, өөрсдийн гэм буруугаа мэдрэх болно. Нүгэл ямар их гай тарьдагийг олж харснаар та нарт үүнийг жигшин, нүгэл та нарыг Бурханаас салган боолчилсныг ухамсарлана. Нүглээс чөлөөлөгдөх гэж хичнээн их тэмцэх тусам, өөрсдийнхөө сул доройг ойлгож, арчаагүй зан төрх, дотоод сэтгэлийнхээ бузар булай байдлыг улам тод томруун харах болно. Мөн нүгэл хилэнц, амиа хичээх явдал сэтгэл зүрхэнд тань ямар гүнзгий шингэснийг ойлгоно. Та нар өршөөл уучлал, ариун ёс, эрх чөлөөг туйлаас хүснэ. Бурхантай яаж эв зүйгээ олж, Түүнтэй төст байдлыг олох вэ?

Та нарт бүхнээс хэрэгтэй зүйл гэвэл дотоод амар амгалан байдал болой. Энэ бол Тэнгэрийн өршөөл, зүрхэнд дэх хайрын үр дүн мөн. Мөнгө зоос, оюун ухаан, хүний ямар ч мэдлэг энэ амар тайван байдлыг бүрдүүлэн баталгаажуулж чадахгүй. Үүнийг өөрийн хүч чармайлтаар олж авах гэж оролдох нь утгагүй юм.

Гэтэл Бурхан үүнийг та нарт зүгээр, “мөнгөгүйгээр, үнэгүйгээр” өгье гэж байна (*Исаиа 55:1*). Зөвхөн гараа сунгаад л авах хэрэгтэй. Бурхан “Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан болно. Тэдгээр нь хүрэн улаан боловч ноос шиг болох болно” (*Исаиа 1:18*), “Түүнээс гадна, Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор шинэ сүнсийг оруулна” (*Езекиел 36:26*) гэж айлджээ.

Та нар гэм нүгэлдээ гэмшээд түүнээс саллаа. Өөрсдийгөө Бурханд даатгахаар шийдлээ. Тэгвэл одоо Түүн рүү очиж, гэм нүглээс минь ариусгаж, шинэ зүрх хайрлаач гэж гуйгтун. Тэр нэгэнт амласан болохоор хүсэл

тань биелнэ гэдэгт итгэцгээ. Христ энэ хорвоод амьдарч байхдаа үүнийг сургасан юм. Бид Бурханы амласан ивээлийг хүртэнэ гэдэгт итгэх ёстой, тэр хишиг ч биднийх болно.

Хүмүүс Есүсийн хүчинд гүнээ итгэж байх үед л Тэр хүмүүсийн өвчин эмгэгийг эмчлэн эдгээж байсан. Аврагч, гэм нүглийг өршөөж уучилдаг үл үзэгдэх хүчинд нь хүн бүхэн итгээсэй гэсэндээ тэдэнд нүднээ харагдах илт байдлаар тусалдаг байсан юм. Тэр саа өвчтэй хүнийг эдгээхдээ энэ тухай бүр тодорхой өгүүлсэн юм. Есүс “Хүний Хүү газар дэлхий дээр нүглийг уучлах эрх мэдэлтэйг мэдүүлэхийн тулд” хэвтэрт байсан өвчтөнд хандан “Бос, дэвсгэрээ аваад, гэртээ харь” гэж хэлжээ (*Матай 9:6*). Баярын мэдээ тараагч Иохан Христийн үйлдсэн гайхамшгийн тухай ярихдаа: “Есүс бол Христ, Бурханы Хүү мөн гэдэгт та нарыг итгүүлэхийн тулд бичигдсэн бөгөөд ингэснээр итгэлээр дамжуулан та нар Түүний нэрээр амьтай болох юм” гэсэн аж (*Иохан 20:31*).

Есүс өвчтөнүүдийг хэрхэн анагааж байсан тухай Библи дэх өгүүлэмжээс бид Түүнд итгэснээр нүглээ хэрхэн уучлуулж болох талаар мэдэх билээ. Вифездэд ядарч туйлдсан нэгнийг анагаасан тухай түүхийг авч үзье. Хөөрхий тэр өвчтөн гучин найман жил алхаж гишгэж чадахгүй, туйлдаж гүйцсэн амьтан байжээ. Гэвч Есүс: “Чи бос, дэвсгэрээ аваад яв” гэж түүнд тушаажээ. Тэр өвчтөн: “Их Эзэн минь, хэрэв Та намайг эдгээвэл би Таны сургаалийг дагана” гэж хэлж болох байсан шүү дээ. Гэвч тэр өвчтөн Христийн үгэнд орж, эдгэсэн гэдэгтээ бат итгэн, тэр дороо босох гэж оролджээ. Тэгээд өндийн босож, алхан явлаа. Тэр хүн Христийн үгэнд итгэснээр Бурхан түүнд хүч чадал хайрлаж, эрүүл саруул болгосон байна.

Гэм нүгэл та нарыг мөн үүнтэй төстэй байдалд оруулсан байдаг. Та нар урьдын нүглээ бие даан цагаатгаж, өөрийн зүрхээ өөрчилж, ариун болж чадахгүй.

Гэвч Бурхан Христээр дамжуулан энэ бүхнийг хийхээ амлаж байна. Түүний амлалтанд итгэцгээ. Нүглээ наминчилж, өөрсдийгөө Бурханд даатгацгаа. Түүнд хүчин зүтгэх шийдвэр гаргацгаа.

Та нар тийм шийдвэр гаргангуут Бурхан Өөрийн амлалтыг заавал биелүүлнэ. Ариусаж өршөөгдөнө гэсэн амлалтанд итгэвэл Бурхан хүслийг тань ёсоор болгоно. Христ тэр саа өвчтэй хүн өөрийгөө эдгэсэн гэдэгт бүрэн итгэсэн мөчид л түүнийг алхаж гишгэх чадвартай болгосон. Хэрэв та итгэж байгаа бол үүнд болохгүй, бүтэхгүй юм гэж нэгээхэн ч үгүй.

Эдгэснээ мэдрэх цагийг бүү хүлээцгээ, харин: “Би эрүүл болсон учраас үүнд итгэж байгаа юм биш, Бурхан амласан учраас итгэж байгаа юм” гэж бодох хэрэгтэй.

Есүс “Та нар юуны төлөө залбирч, гуйж байна, түүнийгээ авсан гэдэгтээ итгэгтүн. Тэгвэл тэр чинь ёсоор болно” хэмээн айлджээ (*Марк 11:24*). Энэ амлалт нэг болзолтой. Юу гэвэл бид Бурханы хүсэл таалалд нийцсэн зүйлийг л гуйх ёстой.

Гэхдээ Бурхан бидний нүглийг ариусгаж, Өөрийн болгож, ариун амьдралаар амьдрах хүч тэнхээ хайрлахыг л хүсч байдаг юм. Ийм учраас бид тэр ивээлийг гуйж, түүнийг хүртэнэ гэдэгтээ итгэж, нэгэнт хүртсэн бол Бурхандаа талархал илэрхийлэх учиртай. Есүсийн хүчээр нүглээс салж, Бурханы хуулийн өмнө ичиж зовох, сэтгэл түвдэх юмгүй байна гэдэг юутай сайхан бэ! “Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа” махан биеэр бус сүнслэгээр оршигч “хүмүүст ямар ч ял байхгүй” (*Ром 8:1*).

Иймээс та нар өөртөө харьяалагдахаа больж их үнээр золигджээ. “Алт, мөнгө мэтийн устах зүйлсээр золигдсон бус, харин үнэт цусаар, Христийн цус болох гэм зэмгүй бөгөөд толбогүй хурганы цусаар золигдсон гэдгээ мэдэгтүн” (*1 Петр 1:18-19*). Та нар Бурханд итгэх л хэрэгтэй, тэгвэл Ариун Сүнс та нарын дотор шинэ амьдралыг хөгжөөнө. Ингээд та нар Бурханы гэр бүлийн

гишүүд болно. Тэр та нарыг Өөрийн Хүүг хайрладаг шигээ л хайрлана.

Одоо та нар өөрсдийгөө Есүст даатгасан болохоор Түүнээс бүү ухарч холдоцгоо. Өдөр бүр “би Христийнх, би өөрийгөө Түүнд даатгасан” гэж хэлж байгаарай. Та нарт Ариун Сүнсийг өгч, Өөрийн ивээлдээ багтаахыг Түүнээс гуйцгаа. Та нар яаж өөрснийгөө Бурханд даатгаж итгэсэн, Түүний хүүхдүүд болсон шигээ Түүн дотор амьдарцгаа! Номлогч Паул “Та нар Эзэн Христ Есүсийг хүлээн авсан шигээ Түүний дотор алхацгаа” хэмээсэн билээ (*Колоссай 2:6*).

Зарим хүн Түүний ивээл, энэрлийг олж авахаасаа өмнө тодорхой сорилт шалгалтыг давж, өөрсдийнхөө засарсан гэдгийг Их Эзэнд итгүүлэх хэрэгтэй гэж боддог юм. Тэгвэл тэд эдүгээд ч Бурханы ивээлийг хүртэх эрхтэй шүү дээ. Харин ч хүмүүс өөрсдийг нь нигүүлсэгч Христийн Сүнсийг хүлээж авахгүй, Түүний ивээлийг хүртэхгүй бол муу муухайг эсэргүүцэх чадваргүй болдог.

Есүс биднийг яг л байгаагаараа, бүхий л нүгэл хилэнц, мөхөс дорой зан чанартайгаа Өөр рүүгээ ирэхийг хүсдэг. Тэр биднийг Өөрт нь найдаасай гэж хүсдэг юм. Бид Түүнд бүхий л сул тал, мөхөс мунхаг байдалтайгаа очиж, нүглээ наминчлан Түүний өлмийд сөхөрч болно. Тэр үлэмжийн их ивээлээрээ биднийг Өөрийн хайр энэрлийн нөмөрт багтааж, бидний шархыг эдгээж, элдэв бузар булайгаас ариусган цэвэрлэнэ.

Чухамхүү энэ асуудал дээр л олон хүн бүдэрдэг. Тэд Есүс хүн нэг бүрийг уучилдаг гэдэгт эргэлздэг юм. Тэд Бурханы үгэнд шууд итгэдэггүй нь харамсалтай хэрэг. Эзэний тавьсан болзлыг биелүүлж буй хүн бүхэн Түүний өршөөлийг хувийн туршлагаасаа мэдэх давуу талтай байдаг. Бурхан гэмшсэн нүгэлтэн болгоныг уучилдаг. Бурханы амлалт та нарт зориулагдаагүй гэсэн бодол санааг таягдан хаяцгаа. Тэр амлалт нүглээ наминчилсан хүн болгонд зориулагдсан юм. Христ Өөрийн ивээл, хүч

чадлыг Өөрт нь итгэсэн хүн бүхэнд хүргэх гэж тэнгэр элч нарыг илгээдэг ажээ. Хүн ямар ч нүгэлтэй байлаа гэсэн бүх нүгэлтний төлөө амиа өгсөн Есүс дотор хүч чадал, ариусал, зөвт ёсыг олж чадна. Христ нүгэл хилэнцэд бузартаж, буртаглагдсан ямар ч хувцсыг тайлаад, зөвт ёсны цагаан өмсгөлийг өгөхөд бэлэн байдаг юм. Тэрээр нүгэлт хүнд үхлийн оронд мөнхийн амьдралыг санал болгодог.

Бурхан, эгэл хүмүүс нэг нэгэнтэйгээ харьцдаг шиг бидэнтэй харьцдаггүй юм. Тэр бидэнтэй энэрэнгүй, уучлангуй, нигүүлсэнгүй сэтгэлээр ханддаг. “Хилэнцтэн нь өөрийн замаа, шударга бус хүн нь өөрийн бодол санаануудаа орхиод Эзэн рүү эргэх болтугай. Түүнийг Тэр өрөвдөнө, өгөөмрөөр уучилна”, “Чиний хилэнцийг өтгөн манан мэт, чиний нүглийг үүл мэт хөөнө” (*Исаиа 55:7; 44:22*).

Библид “Би үхэгсэдийн хэнийх нь ч үхэлд баярладаггүй гэж Эзэн Бурхан тунхаглаж байна. Тиймээс гэмшиж амьдар” (*Езекиел 18:32*) гэсэн мөрүүд бий. Сатан Бурханы билэг дэмбэрэлт ерөөлийг биднээс нуух гэж ямагт оролдож байдаг юм. Тэр хүний итгэл найдварын бүхий л гэрэл гэгээг унтраахыг хүсч байдаг. Гэвч та нар түүнийг ингүүлэхгүй байх ёстой. Уруу татагчийн үгэнд бүү орцгоо.

Харин “Есүс намайг амьдруулахын тулд үхсэн юм. Тэр надад хайртай, намайг үхээсэй гэж боддоггүй. Надад нигүүлсэнгүй Тэнгэрийн Эцэг бий. Хэдийгээр би Түүний хайрыг даалгүй хөсөрдүүлж надад хайрласан энэрэл ивээлийг нь үрэн таран хийсэн ч Эцэгтээ очиж ‘Би Тэнгэрийн эсрэг, Таны өмнө нүгэл үйлджээ. Би цаашид Таны хүү гэгдэх нь зохисгүй, харин намайг хөлснийхөө нэг хүн болгооч’” хэмээн гуйна гэж хэлээрэй. Энэхүү сургаалт үлгэрт эцэг нь тэнэмэл хүүгээ хүлээн авч байгаа тухай өгүүлнэ. Хүү нь ирж явахыг эцэг нь холоос хараад,

ихэд өрөвдөн тэр дороо гүйж очоод хүзүүгээр нь тэврэн үнссэн гэдэг (*Лук 15:18-20*).

Гэхдээ энэ сургаалт үлгэр ч гэсэн Тэнгэрийн Эцэгийн цаглашгүй хайр энэрэлийг бүрэн илэрхийлж үл чадна. Их Эзэн Өөрийнхөө зөгнөгчөөр дамжуулан “Би чамайг үүрдийн хайраар хайрласан. Тийм учраас Би чамайг хайр энэрлээр татсан” хэмээн айлджээ (*Иеремиа 31:3*). Нүгэлт хүн гэр орноосоо хол, харь газар эдлэн сэлтээ үрэн таран хийж байхад Эцэг түүнийг санаж гуньж суудаг. Нүгэлт хүний зүрхэнд төрж буй Бурханд эргэж очих хүслэн бол тэнэж төөрсөн хүнийг энэрэн ивээгч Тэнгэрийн Эцэгийн зүг урин дуудсан Ариун Сүнсний дуудлагад хариу өгч буй хэрэг юм.

Библид ийм илэрхий амлалт байхад эргэлзэж тээнгэлзэж болох уу даа? Нүглээ орхин эргэн ирж, Түүний өлмийд наминчлан сөхрөх хүсэлтэй үй олон хөөрхий нүгэлтэнг Их Эзэн ширүүн харна гэж бодож болох уу? Ийм бодол санааг таягдан хаяцгаая! Бидний Тэнгэрийн Эцэгийн тухай иймэрхүү төсөөлөлийг сэтгэл санаандаа бодох ч хортой юм. Бурхан нүглийг үзэн ядавч нүгэлтнийг энэрэн хайрладаг. Тэр Христээр төлөөлүүлэн хүссэн хүн болгоныг аварч, суу алдарын Хаант улсад мөнхөд жаргуулахын тулд Өөрөө Өөрийгөө хүмүүст өгсөн юм.

Зөгнөгч Исаиагаар дамжуулан Бурхан Өөрийн энэрэл хайрын тухай өгүүлснээс илүүгээр сэтгэл уяртал хэлж болно гэж үү? “Эх хүн хөхүүл хүүхдээ мартаж чадах уу? Төрүүлсэн хөвгүүнээ энэрэлгүй байж чадах уу? Хэдийгээр тэр мартаж болох ч, Би чамайг мартахгүй” хэмээн Тэр айлджээ (*Исаиа 49:15*).

Эргэлзэж эмээгсэд бүгд сэрцгээ! Есүс бидний төлөө зуучлахын тулд байгаа шүү дээ. Хайрт Хүүгээ бидэнд өгсний нь төлөө Бурханд талархаж, бидний төлөө золиос болсон Түүний үхэл талаар өнгөрөөгүйд залбиран мөргөцгөө. Өнөөдөр Ариун Сүнс таныг урьж байна.

Есүс рүү очигдоо! Үүнийг чин сэтгэлээсээ үйлдвэл та Түүний ивээл ерөөлд найдаж болно.

Бурханы амлалтанд Түүний цаглашгүй хайр хишиг тусгагдсан гэдгийг санацгаагтун! Тэр хязгааргүй хайр энэрэл, нүгэлтнийг өрөвдөх нигүүлсэнгүй сэтгэлээр дүүрэн байдаг. “Түүний дотор цусаар нь золилт, гэм нүглийн маань төлөөх уучлал бидэнд байдаг” (*Эфес 1:7*). Бурхан та нарын Туслагч гэдэгт л итгэцгээ. Тэрбээр хүмүүний дотор Өөрийн дүр төрхийг сэргээхийг хүсч байгаа юм. Та нар нүглээ наминчлан гэмшиж, Түүн рүү ойртох аваас Тэр нигүүлсэнгүй, өршөөнгүй сэтгэлээр та нарт ойртоно.

ХРИСТЭД ХАРЬ-АЛАГДАХУЙ

Хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна” (2 Коринт 5:17).

Хүн заримдаа өөрийгөө Христэд итгэж эхэлсэн цаг хугацаа болон газар байршил, эл байдалд хүргэсэн шалтгаан нөхцлөө нарийн санахгүй байж болох юм. Гэвч энэ нь тэрээр хуучин янзандаа үлдсэн хэрэг биш ээ. Христ Никодемд “Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хааш оддогийг мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг” хэмээн айлджээ (Иохан 3:8). Бурханы Сүнс хүний зүрхэнд нөлөөлөх нь салхины үлээлттэй агаар нэгэн байдаг. Бид салхийг нүдээрээ эс харавч, салхи буйг мэдэрдэг.

Хүний нүднээ үл үзэгдэх, сэргэн оргилсон сүнслэг хүч шинэ амьдралын эх үүсвэрийг тавьж, Бурханы дүрээр шинэ хүнийг бүтээдэг юм. Сүнс үл мэдэгдэм, чимээгүйхэн үйлчлэх авч Түүний үр шим нүднээ илэрхий тусна. Хэрэв хүний сэтгэл зүрх Бурханы Сүнсээр шинэчлэгдсэн бол тэр нь амьдралд заавал илэрнэ. Өөрийгөө өөрчлөн, Бурхантай эе зүйд хүрэхийн тулд бид дан ганцаар юуг ч хийж чадахгүй. Бид өөрсдөдөө юм уу, өөрснийхөө сайн үйлсэд ч мөн найдах ёсгүй. Харин Бурханы ивээл бидний дотор оршин байвал тэр нь анзаарагдалгүй үлдэнэ гэж үгүй билээ. Бидний зан байдал, дадал заншил, ажил төрөлд огцом өөрчлөлт гарна. Тэр өөрчлөлтөөр хүмүүс урьдын хийгээд шинэ амьдралын хооронд эрс ялгаа гарсныг олж хардаг. Хүний зан чанар нь санамсаргүй үйлдсэн сайн юм уу, эсвэл муу үйл хэргээр бус, харин аливаа юмыг ярьж, хийж заншсан ерөнхий чиг хандлагаар тодорхойлогдоно.

Хүний зан байдал Христийн шинэчлэгч хүчний нөлөөгүйгээр өнгөн дээрээ аятайхан харагдаж болох. Эргэн тойрныхоо хүмүүст нөлөө үзүүлж, бүх нийтийн хүндэтгэлийг хүлээх хүсэл эрмэлзлэлийн үүднээс бид биеэ зөв авч явахыг хичээж болох юм. Хувийнхаа нэр төрийг эрхэмлэх явдал элдэв хорлонтой муу хэрэг хийхээс татгалзахад хүргэнэ. Тэр ч байтугай хувиа хичээсэн хүн өглөг буян үйлдэх нь ч бий. Тэгвэл бид буян, нүгэл хоёрын алиных нь талд байгаагаа яаж мэдэх вэ?

Бидний зүрх сэтгэл хэнд харьяалагдаж байна вэ? Бидний бодол санааг хэн удирдаж байна? Бид хэний тухай ярих дуртайсан билээ? Бид хамгийн зөөлөн сайхан сэтгэлээ хэнд илэрхийлж, хүч чадлаа хэнд зориулдаг вэ? Хэрэв бид Христийнхэн бол Түүний тухай бодох л бидэнд юу юунаас илүү эрхэм сайхан байх учиртай. Бид Түүнд өөрсдийгөө, бас байгаа бүхнээ зориулдаг. Бид Түүний дүрийг тусгаж, Түүний Сүнсийг бодижуулан, Түүний хүслийг биелүүлж, Түүнд бүхий л талаар найр тавих хүсэл эрмэлзлэлээр дүүрэн байдаг.

Христ Есүсийн доторх шинэ бүтээл болсон хүн бүхэн “хайр энэрэл, баяр баясгалан, эв зүй, тэсвэр тэвчээр буян хишиг, нигүүлсэнгүй сэтгэл, итгэл бишрэл, хүлцэнгүй чанар, биеэ барих чадвар” зэрэг Сүнсний бүхий л үр шимийг хүртэнэ (*Галат 5:22-23*). Ийм хүмүүс урьдын дур тачаалдаа дахин автахгүй, харин Бурханы Хүүд итгэснээр, Түүний зан байдлыг тусган, Түүнтэй адилхан ариун болохын тулд сэтгэлээ ариусгаж, Түүний зам мөрөөр замнана.

Тэд урьд үзэн яддаг байснаа таашааж, харин таашаадаг байснаа үзэн ядах билээ. Бардам зантай, биеэ тоосон хүмүүс өр зөөлөн номхон, төлөв даруу, тэвчээр хүлээцтэй болж, сүржигнүүр дээрэнгүй хүмүүс буурь суурьтай, даруухан зантай болно. Архичид балгахаа больж, завхайрагчид самуурахаа татна. Хорвоогийн зан заншил, таашаал сонирхлыг огоорно. Христэд итгэгчид

аливаа гадна талын үзэмж чимэглэлд хууртах бус, “харин Бурханы өмнө асар үнэтэй болох дөлгөөн болон даруу сүнсний мөхөшгүй чанараар чимсэн зүрхний нуугдмал хүн” болохыг эрмэлзэх учиртай аж (*1 Петр 3:3-4*).

Хэрэв гэмшсэнийхээ дараа засрахгүй бол түүнийг чин сэтгэлийн гэмшил гэж үзэж болохгүй. Нүгэлт хүн барьцаалснаа эргүүлж өгөөд, хулгайлснаа буцааж тушаагаад, нүглээ наминчлаад, Бурхан болон ойр дотны хүмүүсээ энэрч хайрлаж эхэлсэн цагтаа үхлээс амьдралд шилжлээ гэж баттай бодож болно.

Бид өөрсдийн төөрөгдөл, нүгэл хилэнцийг ухаарч, Христ рүү дөхөж очоод, Түүний өршөөл ивээлийг хүртэхэд бидний зүрх сэтгэл хайр энэрлээр бялхдаг. Христийн буулга зөөлөн учраас ямар ч дарамт хүнд хүчир мэт санагдахгүй. Хүлээсэн үүрэг баяр баясгалан болж, хүчин зүтгэх явдал жаргал цэнгэл болж хувирна. Урьд харанхуй байсан замыг Зөвт ёсны Нарны туяа гийгүүлнэ.

Христийн зан төрхийн эрхэм сайн чанар нь Түүний дагалдагчдад илэрдэг. Есүс Бурханы хүслийг баяртайяа биелүүлдэг. Эзэнийг хайрлах хайр, Түүнийг алдаршуулах чин хүсэл Есүсийг тэтгэж байсан юм. Хайр энэрэл Христийн бүхий л үйл хэргийг гойд эрхэмсэг сайхан, дур булаам болгож байсан.

Хайр Бурханаас эхтэй бөлгөө. Хайр энэрэл болбоос зөвхөн Христийн төлөө лугших зүрхнээ л бий болох учиртай. “Эхлээд Тэр биднийг хайрласан тул бид хайрладаг юм” (*1 Иохан 4:19*). Бурханы ивээлээр шинэчлэгдсэн зүрхэнд хайр энэрэл хөдөлгөгч хүч нь болж өгдөг. Тэрхүү хайр зан төлөвийг өөрчилж, хүсэл сэхээрлийг жолоодож, дур тачаалыг зогсоон барьж, өс хонзонг номхотгож, сэрэл мэдрэхүйг өөд татах авай. Зүрхэнээ орших энэ хайр хүнийг аз жаргалтай болгож, орчин тойрныхондоо өөдрөг сайхан нөлөө үзүүлдэг.

Бурханы үрс болон ялангуяа Түүний ивээлд дөнгөж багтаж эхэлж байгаа хүмүүст сэрэмжилбэл зохих хоёр аюул байна. Нэгдүгээрт, дээр нэгэнт өгүүлсэнчлэн дан ганц өөрийнхөө хичээл зүтгэлээр Бурхантай эв зүйгээ ололцож болно гэж бодож болохгүй. Хуулийг махчлан сахиснаар ариусалд хүрэхийг эрмэлзэгчид байнга бүтэлгүйтдэг. Христ үгүйгээр хүний хийж буй юм бүхэн хар амиа хичээх үзэл, нүгэл хилэнцээр бузартсан байдаг. Итгэл бишрэлээр дамжуулан авч буй Христийн ивээл хишиг л биднийг ариусгаж чадна.

Үүний эсрэг бөгөөд дутахгүй аюултай нэгэн төөрөгдөл бол Христэд итгэх итгэл нь хүнийг Бурханы хуулийг дагаж мөрдөх шаардлагаас чөлөөлдөг, зөвхөн итгэл бишрэлээр Христийн ивээлийг хүртэж байгаа болохоор бидний үйл хэрэг бидний авралд ямар ч хамаагүй мэтээр үздэг явдал юм.

Гэвч хуулийг дуулгавартай сахина гэдэг бол шаардлагыг зүгээр нэг ёс төдий биелүүлж байгаа хэрэг биш, харин хайр энэрлээр хүчин зүтгэж буй явдал юм. Бурханы хууль бол Түүний тэнгэрлиг шинж чанарын илэрхийлэл юм. Энэ хууль хайр энэрлийн аугаа их зарчмын биелэл мөн. Тийм учраас тэнгэр хийгээд газар дээрх Бурханы засаглалын үндэс болж өгдөг юм. Хэрэв бидний дотор Бурхан лугаа төст байдал бий болж, хэрэв бидний сэтгэлд Түүний хайр оршиж байвал, Бурханы хуулийг биелүүлэх нь жам ёсны хэрэг болохгүй гэж үү?

Хайр сэтгэл хүний зүрхийг эзэмдэж, хүн өөрийг нь бүтээсэн Бурханы дүрээр шинэчлэгдсэн цагт түүний хувьд шинэ гэрээний амлалт биелнэ гэсэн үг. Бурхан “Би өөрийн хуулиудыг тэдний зүрхэнд тавина. Би тэдгээрийг тэдний ухаан санаанд бичнэ” (*Еврей 10:16*) хэмээжээ. Хэрэв хууль сэтгэл зүрхэнд бичигдсэн бол тэр нь амьдралд нөлөө үзүүлэхгүй гэж үү? Хайр хүндэтгэлтэйгээр бусдад үйлчлэн, дуулгавартай байх нь Христэд харьяалагдаж буйн шинж лавтай мөн. Сударт өгүүлсэнчлэн: “Түүний

тушаалуудыг сахих нь Бурханы хайр мөн”, “Түүний тушаалуудыг сахьдаггүй нэгэн бол худалч бөгөөд түүний дотор үнэн байхгүй” ажээ (1 Иохан 5:3, 2:4). Итгэл бол хүнийг дуулгавартай байхаас чөлөөлөхгүй. Харин ч бид итгэл бишрэлээр дамжин дуулгавартай байхын хүчийг өгөгч Христийн ивээлд багтдаг.

Дуулгавартай байснаар бид аврагдахгүй, учир нь бид авралыг Бурханд итгэсний бэлэг болгон зүгээр авдаг. Гэвч дуулгавартай байх нь итгэл бишрэлийн үр шим юм. “Нүглүүдийг зайлуулахын тулд Тэр үрэгдсэн гэдгийг та нар мэднэ. Түүнд ямар ч нүгэл байхгүй. Түүний дотор байгч нэг ч нүгэл үйлддэггүй. Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй”. Энэ бол жинхэнэ шалгуур мөн. (1 Иохан 3:5-6)

Хэрэв бид Христ дотор байж, Бурханы хайр бидэн дотор бат оршиж байгаа бол бидний бодол сэтгэл, үйлдэл, эрмэлзэл Бурханы ариун хуулинд илэрхий байдаг Түүний хүсэлтэй нийцнэ. “Хүүхдүүдээ, та нарыг хэн ч бүү мэхлэг. Зөвийг үйлдэгч нэгэн нь Түүний зөвт байгаачлан зөвт байна” (1 Иохан 3:7). Зөвт ёсны хэмжүүр хэмээхүй нь Синай ууланд номлосон арван тушаалаас бүрдсэн Бурханы ариун хууль мөн бөлгөө.

Бурханыг дуулгавартай дагах үүргээс хүнийг чөлөөлдөг “итгэл” гэгч нь жинхэнэ итгэл биш, харин өөртөө итгэх санаархал мөн. Учир нь “нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм”. Гэвч “итгэл нь хэрэв үйлсгүй бол өөрөө үхмэл юм” (Эфес 2:8, Иаков 2:17).

Есүс газар дэлхийд ирэхээсээ өмнө Өөрийнхөө тухай “Бурхан минь, би Таны хүслийг гүйцэлдүүлэхдээ баярладаг юм. Таны Хууль миний зүрхэнд бий” гэж хэлжээ (Дуулал 40:8). Хожим тэнгэрт өргөгдөхийнхөө өмнөхөн Тэр “Би Эцэгийнхээ тушаалыг сахьж, Түүний хайр дотор байдаг” хэмээн тунхагласан (Иохан 15:10). «Хэрэв бид Түүний тушаалуудыг сахивал, үүгээрээ бид Түүнийг таньснаа мэднэ... Түүний дотор оршдог гэж

ярьдаг нэгэн Түүний хэрхэн явсанчлан өөрөө бас тийн явдаг байх ёстой” (1 Иохан 2:3-6). “Та нарыг Өөрийнхөө мөрөөр дагуулахын тулд та нарт үлгэр дуурайллыг үлдээн, Христ та нарын төлөө зовлон эдэлсэн” билээ (1 Петр 2:21).

Мөнхийн амьдралыг олж авах болзол нь огт өөрчлөгдөөгүй бөгөөд бидний өвөг дээдэс нүгэлд унахаасаа өмнө, диваажинд байсан үеийнхтэй нэгэн адил, ямагт Бурханы хуулинд бүрэн захирагдаж, зөвт ёсыг төгс төгөлдөр эзэмших явдал болой. Хэрэв мөнхийн амьдралыг ямар нэг бага шиг болзлоор өгнө гэсэнсэн бол энэ нь хамаг орчлонгийн сайн сайханд аюул занал учруулан, эцэс төгсгөлгүй гай зовлон таригч нүгэл хилэнцийг мөнхжүүлэх магадлал үүсгэж мэдэхсэн билээ.

Адам нүгэлд унахаасаа өмнө Бурханы хуулийг хүлцэн сахиснаар зөвт зан чанараа улам төгөлдөржүүлж чадах байсан. Гэвч тэр энэ замаар замнаагүй юм. Түүний үйлдсэн нүглээс болж бид гэм нүглийн шинж чанарыг залгамжлан авч, өөрөө өөрсдийгөө зөвт болгож чадахаа больжээ. Бид гэм нүгэлдээ баригдсан учир ариун хуулийг төгс төгөлдөр ёсчлон биелүүлж чадахгүй байгаа юм. Бидэнд Бурханы хуулийн шаардлагыг хангаж чадахуйц өөрийн гэсэн зөвт үзэл алга.

Харин Христ бидэнд авралын замыг нээж өгсөн билээ. Тэр бидэнд тохиолддог шиг л шалгалт сорилт, гэм зэмийн дунд амьдарч асан хэдий ч Түүний амьдрал гэм нүгэлгүй байсан юм. Тэр бидний төлөө нас барсан бөгөөд биднийг нүгэл хилэнцээс чөлөөлж, Өөрийн зөвт ёсыг бидэнд хайрлахыг хүсч байна. Хэрэв та нар өөрсдийгөө Түүнд зориулж, Түүнийг Аврагчаа хэмээн хүлээж авах юм бол хэдийгээр нүгэлтэй ч гэсэн, Түүний гавъяа зүтгэлийн ачаар та бүхэн зөвт үзэлтэнд тооцогдож, Христийн зан чанарыг олж авах болно. Бурхан та нарыг хэзээ ч нүгэл үйлдэж байгаагүй юм шиг л хүлээж авна.

Түүгээр ч барахгүй Христ сэтгэл зүрхийг тань өөрчлөнө. Та нар Түүнд итгэсэн болохоор Тэр та нарын зүрхэнд шингэнэ. Та нар итгэл бишрэлээрээ дамжуулан Христэй холбоо тогтоож, өөрийнхөө хүслийг Түүнд үргэлж захируулж байх нь чухал. Тэгж чадаж гэмээ нь Тэр Өөрийнхөө таалал соёрхлоор та нарын хүсэл, үйлдлийг зохицуулна. Ийм учраас та бүхэн: “Эдүгээ би махан биендээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм” гэж зоригтой хэлж болно (*Галат 2:20*).

Есүс шавь нартаа “Яригч бол та нар бус, та нарын дотор яригч Эцэгийн чинь Сүнс юм” хэмээн айлджээ (*Матай 10:20*). Чухам тэр л үед та нарын дотор үйлдэгч Христэй хамт та нар мөнхүү сүнсний илэрхийлэл болж, зөвт ёс хийгээд итгэл бишрэлийн сайн үйлийг бүтээж чадна.

Ингэхлээр бидэнд өөрсдөд маань магтаад сайрхаад байхаар юм юу ч алга. Өөрийгөө өргөмжлөх өчүүхэн ч үндэслэл байхгүй юм байна. Цорын ганц найдлага бол Христийн бидэнд шингээж байгаа зөвт ёс, Түүний Сүнс биднээр дамжуулан үйлчилсний үр дүн болох тэрхүү зөвт ёс юм.

Итгэл бишрэлийн тухай эргэцүүлэн бодохдоо доор дурьдсан нэгэн зүйлийг анхаарах нь чухал. Маргашгүй илэрхий баримтыг хүлээн авч итгэнэ гэдэг бол жинхэнэ итгэгчийн шинж хараахан биш. Хамгаас хүчит Бурханы бодит оршихуй бөгөөд Түүний сургаалийн үнэн зөв баримтуудыг Сатан болоод муу ёрын сүнснүүд ч үгүйсгэж үл чадна. Библи сударт өгүүлснээр “чөтгөрүүд ч итгэдэг бөгөөд чичирдэг юм” (*Иаков 2:19*). Гэвч энэ бол Бурханы биднээс хүлээж байгаа итгэл биш ээ.

Жинхэнэ итгэл бишрэл нь хайр энэрлээр илэрч, сэтгэл санааг ариусгана. Энэ бол Бурханы сургаалийг хүлээн зөвшөөрсөн хэрэг төдийгүй бас өөрийн хүслээ Түүнд захируулж, Түүнд татагдан, дуулгавартайгаар сэтгэл

зүрхээ бүрэн зориулах явдал юм. Ийм итгэл хүнийг шинэчилж, түүний дотор Бурханы дүрийг сэргээнэ. Итгэлгүйгээр хүн Бурханы хуулинд захирагдаж байгаагүй, захирагдаж чадах ч үгүй байсан. Одоо харин хүн ариун сургаалд баярлаж, дуулалчтай хамт “Таны хуулийг би ямар их хайрладаг вэ! Тэр нь бүхий л өдөржингөө миний бясалгал байдаг” (*Дуулал 119:97*) гэж эргэцүүлэн баясах бөлгөө. Одоо уг хуулийн зөвт шаардлага “Мах бодиор биш сүнсээр” амьдарч байгаа бидний дотор биелж байна (*Ром 8:1*).

Христийн бүхнийг өршөөгч хайр энэрлийг танин мэдэж, Бурханы хүүхэд болохыг чин сэтгэлээсээ хүсч буй хүмүүс бий. Гэвч тэд өөрсдийнхөө төгс төгөлдөр биш шинж, гэм зэмийг ухаардаг учраас зүрх сэтгэл нь Ариун Сүнсээр шинэчлэгдсэн гэдэгт эргэлзэх хандлагатай байдаг. Тийм хүмүүст би “Та нар бүү гутарч цөхрөгтүн!” гэж хэлмээр байна. Бид хойшид ч нэг биш удаа Христийн хөлд сөхөрч, алдаж эндсэндээ харамсан гашуудах болно. Бид сэтгэлээр унах ёсгүй. Дайсанд ялагдлаа ч гэсэн Бурхан биднийг хэзээ ч орхихгүй. Христ биднийг өмгөөлөхийн тулд Эзэн Тэнгэрийн өмнө очоод байна.

Есүсийн хайрт шавь Иохан: “Та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээрийг та нарт бичиж байна. Хэрэв хэн нэгэн нь нүгэл үйлдвэл, Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн” хэмээн өгүүлжээ (*1 Иохан 2:1*). “Эцэг Өөрөө та нарыг хайрладаг” (*Иохан 16:27*) гэсэн Христийн үгийг бүү мартагтун!

Та нарт Өөрийн цэвэр ба ариун шинжийг тусгахын тулд Бурхан та нарын дотор Өөрийнхөө дүрийг сэргээхийг хүсч буй юм. Хэрэв та нар Түүнд захирагдах л юм бол та нарын дотор сайн үйлийг Эхлүүлэгч, Есүс Христийн дахин ирэх өдрийг хүртэл тэр үйлээ хийсээр байх болно.

Хичээнгүйлэн залбирцгаагтун! Итгэл үнэмшлээ бататгацгаагтун! Өөрийн хүчинд итгэх итгэл алдармагц

бид Цагаатгагчийн хүчинд найдаж, бидний сэтгэлийг Анагаагч Түүнийг алдаршуулна. Христ рүү хичнээн их ойртох тусам сүнслэг хараа тань хурцдах тул өөрийнхөө зан байдлаас төчнөөн их дутагдал олж үзнэ. Түүний төгс төгөлдөр шинжтэй харьцуулаад үзэхэд та нарын сул тал улам ч тод томруун харагдана. Энэ нь муу ёрын сүнсний уруу татах хүчин та нарыг эзэмдэхээ больж, Бурханы Сүнсний амьдралыг тэтгэгч нөлөө та бүхнийг сэхээн сэргээж буйг харуулж байгаа хэрэг.

Өөрийнхөө нүглийг ухаардаггүй хүн Христийг үнэнхүү хайрлаж чадахгүй. Христийн ивээлээр өөрчлөгдсөн зүрх сэтгэл Түүний тэнгэрлиг зан чанарыг ямагт бахдан бишрэх болно. Харин бид өөрсдийнхөө ёс суртахууны өө дутагдлыг олж харахгүй байгаа бол, энэ нь бид Христийн зан байдлын гоо сайхан, төгөлдөр шинжийг хараахан таньж мэдээгүй гэдгийг баттай гэрчилж байна.

Бид өөрсдийгөө хичнээн бага өргөмжлөн бардамнах тусам Аврагчийнхаа цаглашгүй цэвэр тунгалаг, ариун сайхан шинжийг төчнөөн их үнэлж цэгнэх болно. Нүглээ ухамсарлах явдал нь биднийг ямагт уучилж чадах Түүний зүг аргагүй хөтөлнө. Арчаагүй доройгоо мэдэрсэн хүн Христийг үгүйлэн эрэхэд, Тэр Өөрийн сүр хүчийг дэлгэн үзүүлдэг. Бид Бурханы айлдварыг хичнээн их үгүйлэх тусам Түүний зан чанарын тухай төчнөөн бадрангуй сайхан төсөөлөлтэй болж, Түүний дүрийг төчнөөн бүрэн дүүрэн тусгах болно.

ХРИСТИЙН ДОТОР ӨСӨХ НЬ

Биднийг Бурханы хүүхдүүд болгож буй дотоод өөрчлөлтийг Библи сударт дээрээс мэндлэхүй хэмээн нэрлэжээ. Үүнийг бас тариачны тарьсан сайн чанарын үр тариа ургахтай зүйрлэдэг. Үүнтэй адил Христэд дөнгөж итгэж эхэлж буй хүмүүс «нялх хүүхдүүд» шиг болоод “Христ Есүсийн дотор бүх талаар өсөх ёстой” байдаг (*1 Петр 2:2; Эфес 4:15*). Тэд тариалангийн талбайд тарьсан сайн чанарын үр шиг ургаж, үр шимээ өгөх ёстой. Зөгнөгч Исаиа Бурханыг «алдаршуулахын тулд тэднийг үнэн зөвийн царснууд, Эзэний суулгац» хэмээн нэрлэжээ (*Исаиа 61:3*). Байгаль ертөнцөөс авсан эдгээр жишээ нь сүнслэг амьдралын далдхан хэдийнээ бодит үзэгдлүүдийг улам сайн ойлгоход бидэнд тус болж байна.

Байгаль дахь туйлын өчүүхэн зүйлд ч амь оруулахад хүний мэргэн ухаан, мэдлэг чадвар огт хангалтгүй юм. Ургамал болоод амьтан нь Бурханы тэдэн дотор оруулсан хүчээр л амьдарч байдаг билээ. Сүнслэг амьдрал ч мөн ялгаагүй Бурханаас өгөгдсөн амин хүчээр л хүн дотор үүсдэг аж. Хэрэв хүн “дээрээс төрөхгүй юм бол” (*Иохан 3:3*) Христийн бидэнд өгөх амьдралыг хүртэж чадахгүй.

Өсөн торнихын тухайд ч бас тэгж ойлгож болно. Бурхан бутыг дэлбээлж цэцэглүүлэн үр шимийг нь гаргадаг. Бурханы хүчээр л “газар эхлээд өөрөөсөө үрийг соёолуулж, дараа нь түүрүүг, тэгээд боловсорсон тариаг бий болгодог” юм (*Марк 4:28*). Зөгнөгч Хосса Израиль улсыг “сараана цэцэг шиг дэлбээлэн”, “усан үзмийн мод шиг цэцэглэх болно” гэж хэлжээ (*Хосса 14:5,7*). Есүс бидэнд “Сараана цэцэг хэрхэн ургадгийг хар” (*Лук 12:27*) хэмээн бас айлдсан билээ.

Ургамал, цэцэгс өөрийнхөө хүч чармайлт эсвэл хүслээр ургадаггүй, харин амьдралд хэрэгцээтэй юмаа

Бурханаас авдаг учраас ургадаг юм. Хүүхэд хичнээн ч хичээсэн өөрөө өсч чадахгүй. Үүнтэй адил та нар өөрсдийн хүсэл эсвэл хүч чармайлтаар оюун санааны буюу сүнслэг байдлынхаа өсөлтийг хангаж чадахгүй. Ургамал, хүүхэд хоёр орчин тойрноосоо амьдралд зайлшгүй чухал агаар, нарны гэрэл, хүнс тэжээл авч өсдөг. Байгалийн эдгээр хишиг ургамал амьтанд хэрэгтэйн адил Христ Түүнд найдсан хүмүүст хэрэгтэй. Тэрбээр хүмүүсийн хувьд “үүрдийн гэрэл”, “нар болон бамбай” юм (*Исаиа 60:19; Дуулал 84:11*). Тэр “Израильд шүүдэр шиг байж”, “хатсан өвсөн дээр бороо шиг бууж ирнэ” (*Хосеа 14:5; Дуулал 72:6*). Тэрбээр амьд ус бөгөөд “тэнгэрээс буун ирж, ертөнцөд амийг нь өгдөг Бурханы талх” юм (*Иохан 6:33*).

Өөрийнхөө Хүүгээр төлөөлүүлсэн хосгүй хишгийг илгээхдээ Бурхан агаар мандал шиг бодит ивээлийн уур амьсгалаар хөвчин дэлхийг бүрхжээ. Амьдралыг тэтгэгч энэ ивээлээр амьсгалахыг эрмэлзсэн хүн бүхэн Христ Есүсийн дотор амьдарч торних болно.

Цэцэг навч наран өөд тэмүүлж, гэрэл туяанд нь тэгш хэмтэй болоод үзэсгэлэн гоо болдгийн адил тэнгэрийн гэрэл биднийг гийгүүлж, бидний зан чанар Христийн зан байдалтай төстэй болтол хөгжөөсэй гэсэн сэтгэлийн үүднээс бид Зөвт ёсны Наран өөд тэмүүлэх ёстой.

Христийн айлдварт ч мөн тийм сургамж бий. “Миний дотор байгтун. Би ч та нарын дотор байна. Усан үзмийн модонд холбогдохгүй юм бол мөчир өөрөөсөө жимс ургуулж чадахгүйн адил хэрэв та нар Миний дотор байхгүй бол тийм байх болно... Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй” (*Иохан 15:4-5*). Мөчир модныхоо голтой холбогдохгүй бол ургаж жимслэж чаддаггүйн адил та нарын ариун амьдралаар амьдрах нь Христээс хамаарах болно. Түүнээс салангид та нар аж төрж чадахгүй. Та нарт уруу татах явдлыг эсэргүүцэх юм уу эсвэл ивээл, ариун ёсны хувьд өсөж дэгжих хүч

тэнхээ байхгүй. Харин Христ дотор байсан цагт та нар цог жавхаатай амьдрах болно. Та нар Түүнээс амьдралын хүчийг сэлбэж авбал сэргэг сайхан байж үр жимсээ өгч чадна. Та бүхэн булгийн усны дэргэд тарьсан мод шиг болно.

Энэ үйл хэргийн заримыг бие дааж хийх хэрэгтэй гэж олон хүн үздэг. Тэд нүгэл хилэнцээ цагаатгуулахад л Христэд найдаж байсан, харин одоо өөрийнхөө хүчээр зүй зохистой амьдрахыг хичээж байна. Гэвч ийм чармайлт нь амжилтанд хүргэхгүй. Есүс “Надгүйгээр та нар юу ч хийж чадахгүй» хэмээн айлджээ. Буян хишгийн өлгийд бидний өсөн торнихуй, бидний баяр баясгалан, ашигт үйл бүгд Христтэй нэгдэн нийлэхээс шалтгаална. Бид өдөр тутам, цаг тутам Түүнтэй харилцаж, Түүн дотор оршиж байж гэмээ нь л буян хишгийн өлгий дотор өсөн торниж чадна. Тэр бол бидний итгэлийн эхлэл төдийгүй бас төгсгөл юм. Христ анхны бөгөөд сүүлчийн мөнх оршигч билээ. Тэр бидний замын эхэнд болон төгсгөлд төдийгүй алхам бүрт бидэнтэй хамт байх ёстой. “Би Эзэнийг өөрийн өмнө үргэлж байхаар тавьсан. Тэр миний баруун гар талд байгаа учраас би ганхахгүй” (Дуулал 16:8) хэмээн Давид өгүүлжээ. “Би яаж Христ дотор орших вэ?” гэж та нар асууж байна. Түүнийг анх хүлээж авсантайгаа л адилаар хий. “Тиймээс та нар Эзэн Есүс Христийг хүлээн авсан шигээ Түүн дотор алх” (Колоссай 2:6) “Ариун журамтан итгэлээр амьд явна” (Еврей 10:38). Та нар Түүнд бүрэн харъяалагдаж, хүчин зүтгэж, захирагдахын тулд Бурханд өөрсдийгөө даатгасан. Та нар Христийг өөрсдийнхөө Аврагч хэмээн хүлээж авсан. Та нар нүгэл хилэнцээ өөрсдийнхөө гавъяа зүтгэлээр цагаатгаж, эсвэл сэтгэл зүрхээ өөрчилж чадаагүй. Гэхдээ өөрсдийгөө Бурханд даатгаад, Христийг бодож, Тэр энэ бүхнийг та нарын төлөө хийсэн гэж итгэж байсан. Та нар итгэлээр Христэд харъяалагдсан, итгэлээрээ ч Түүний дотор бойжих ёстой. Та нар сэтгэл зүрх, хүсэл зориг,

хичээл зүтгэл юу байгаагаа зориулах хэрэгтэй. Түүний бүх тушаалыг биелүүлэхийн тулд хамаг биеэ Түүнд зориулах ёстой. Тэр та нарын дотор байж, та нарын хүч, та нарын зөвт үзэл болж, дуулгавартай байхад тань та нарт туслаасай гэвэл Христээр төлөөлүүлэн бүхий л срөөл айлдварыг нь хүлээн авагтун.

Өглөө болгон Бурханд өөрсдийгөө зориулцгаа. Энэ нь та нарын анхны үйл хэрэг болог. «Эзэн тэнгэр минь намайг Өөртөө аваач, би Таны мэдэлд бүрэн байна. Би хамаг төлөвлөгөөгөө таны өлмийд дэлгэн тавъя. Намайг өнөөдөр Өөрийнхөө үйл хэрэгт ашигла. Миний бүхий л үйл хэрэг Таны дотор хийгдэхийн тулд надтай хамт байгаач» гэж залбирцгаа. Үүнийг өдөр болгон хийх хэрэгтэй. Ирэх өдрийг бодож өглөө бүр Бурханд өөрсдийгөө зориулцгаа. Түүнд хамаг төлөвлөгөөгөө захируулагтун. Тэр Өөрийнхөө зөн билгээр та нарт айлдах тушаалыг сүслэн дагаж, тэдгээр төлөвлөгөөгөө биелүүлэх, эсвэл тэдгээрээс татгалзахад бэлэн байцгаа. Ийнхүү та нар өдрөөс өдөрт өөрсдийн амьдралыг Бурханд даатгаж чадна, тэгээд та нарын амьдрал Христийн амьдралтай улам бүр адил төстэй болно.

Христ доторх амьдрал бол энх амгалан амьдрал. Христийн шүтлэгтэн бээр оволзсон сэтгэлгүй байж болох хэдий ч ямагт итгэл төгс, амгалан тайван байх юм. Та нар өөрсөндөө биш, харин Христэд найдах болно. Та нарын мөхөс хүчин Түүний хүч лүгээ, та нарын өчүүхэн мэдлэг Түүний цэцэн мэргэн ухаан лугаа, та нарын ядмаг хүч Түүний агуу чадалтай нэгдэн нийлнэ. Та нар өөрсдийгөө харж өөр дээрээ анхаарал төвлөрүүлэхийн хэрэггүй. Христ өөд харцгаа. Түүний хайр энэрэл, Түүний зан байдлын гоо сайхан, төгс төгөлдөрийн тухай эргэцүүлэн бодоцгоо. Христ ба Түүний амь бие хайргүй зүтгэл, Христийн ариун гэгээн чанар, Түүний зүйрлэшгүй хайр энэрэл-энэ бүхэн эргэцүүлэн бодвоос зохилтой сэдвүүд юм. Хэрэв та нар Түүнийг хайрлаж, Түүнийг

дууриаж, Түүнд найдах л юм бол Түүнтэй төст чанарыг олж чадна. Есүс айлдруун: “Та нар Миний дотор байгтун”. Эдгээр үгс тогтвортой, итгэлтэй, энх амгалан байх үзэл санааг илэрхийлжээ. Тэр “Та нар над дээр хүрч ирцгээ ... Би та нарыг тайтгаруулья» хэмээн дахин урьж байна. (Матай 11:28) Дуулагч: “Эзэн дотор дуугай байж, Түүнийг тэвчээртэйгээр хүлээ!” (Дуулал 37:7) хэмээн мөн тэр санааг илэрхийлжээ. Зөгнөгч Исаиа “Үнэнч итгэл ба чимээгүй байх нь та нарын хүч мөн” (Исаиа 30:15) хэмээн сэнхрүүлж байна. Энэхүү энх амгалан байдлыг гар хумхин сууснаар олж авч чадахгүй. Учир нь Аврагчийн урилганд хүслэн төдийгүй бас ажил хөдөлмөрт уриалсан уриа агуулагдаж байгаа юм. “Буулгыг минь өөр дээрээ авч ... Та нар сэтгэлдээ амралтыг олох болно» хэмээн Есүс айлджээ. (Матай 11:29) Христэд бүрэн найдсан хүн Түүний талбар дээр хамгийн хичээнгүй, идэвх зүтгэлтэй хөдөлмөрчин болно.

Хүн өөрийнхөө “би”-д анхаарлаа төвлөрүүлвэл аж амьдрал, хүчин чадлын эх сурвалж болсон Христээс салдаг юм. Сатан хүмүүсийн анхаарлыг Аврагчаас хөндийрүүлж, улмаар тэдний Христэй нэгдэн нийлэхэд саад тотгор учруулахыг цаг үргэлж оролддогийн учир энэ билээ. Тэр та бүхний бодол санааг хорвоогийн жаргал цэнгэл, ахуй амьдралын гачаал зовлон, эмх замбараагүй байдал, бусад хүмүүсийн өө дутагдал, та нарын төгөлдөржөөгүй байгаа шинж чанар руу чиглүүлдэг юм. Өөрийгөө хэтэрхий анхаарч, авралын тухай зовиурлан бодож, сэтгэлээ түгшээх хэрэггүй юм. Энэ бүхэн биднийг хүчин чадлын Эх сурвалжаас холдуулна. Өөрийнхөө амьдралыг Бурханд даатгаж Түүнд найдацгаа. Есүсийн тухай ярьж, бодож явцгаа. Та нарын “би” Түүнд уусах ёстой. Хамаг эргэлзээ, айдсаа таягдан хаяцгаа. Ном айлдагч Паултай хамт «Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна. Эдүгээ би махан биедээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө

тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм» хэмээн сэтгэцгээ. (Галат 2:20) Бурхан дотор энх амгаланг эрцгээ. Тэр та нарын Өөрт нь итгэж найдсан юмсыг сахин хамгаалах чадвартай. Хэрэв та нар Түүний гарын доор байвал таныг Энэрэн Хайрлагчийн хүчээр бүхнийг гэтэлнэ.

Христ хүний төрхийг олоод Өөрийгөө хүн төрөлхтөнтэй хайр энэрлийн бөх бат хэлхээгээр холбосон юм. Хэрэв хүн өөрөө л хүсэхгүй бол ямар ч хүч тэр холбоог тасалж чадахгүй. Сатан энэ холбоог тасалж, Христ үгүйгээр амьдрах шийдвэр гаргуулах гэж биднийг цаг үргэлж ятгаж уруу татахыг оролдоно. Цовоо сэргэлэн байж, мөргөл үйлдэж, яаж ч уруу татлаа гэсэн өөр эзэнтнийг сонгож авахгүй байхын тулд хүчин чармайлтаа гаргах хэрэгтэйн учир энэ билээ. Сонголт хийх эрх ямагт бидэнд л үлдэнэ шүү дээ. Өөрийн харцыг Христ өөд төвлөрүүлсе, тэгвэл Тэр биднийг ивээлдээ авна. Бид Христийг шимтэн харж буй цагт аюулгүй байдалд байна. Хэн ч биднийг Түүний гараас салгаж чадахгүй. “Сүнс болох Эзэн биднийг алдраас алдарт Өөртэйгөө ижил дүрээр өөрчилдөг билээ” хэмээн үргэлж бясалгагтун. (2 Коринт 3:18).

Анхны шавь нар чухамхүү ийм байдлаар бидний хайрт Аврагч лугаа төст байдлыг олсон юм. Тэдгээр шавь нар нь Есүсийн айлдварыг сонсонгуут чухамхүү Түүнийг үгүйлж байснаа тэр даруйдаа мэдэрсэн билээ. Тэд Түүнийг эрж, Түүнийг олоод, Түүний хойноос дагажээ. Шавь нар нь орон гэртээ, ширээний ард, хүнгүй газар, хөдөө гадаа хаана ч Түүний дэргэд байсан юм. Тэд Түүнээс өдөр бүр суралцаж, ариун үнэний сургаалыг Түүний амнаас сонсож байлаа. Өөрснийхөө үүргийг ухаарахын тулд, зарц нь эзнээ харах лугаа адил Түүнийг харж байв. Тэр шавь нар нь бүхий л талаараа бидэнтэй адилхан байсан. (Иаков 5:17). Тэд бидэнтэй л адилхан

нүгэлтэй тэмцэж ариун амьдралаар замнахад нь бас л буян хишиг дутагдаж байсан юм.

Хэн хэнээс илүү Аврагчтай төстэй хайрт шавь Иохан нь ч гэсэн төрөлхийн тийм сайхан зан чанартай байгаагүй юм. Тэр нэр алдарт дуртай, биеэ тоосон бас тавтиргүй, санал зөрөхийг тэвчдэггүй нэгэн байсан ажээ. Гэвч Христийн Тэнгэрлиг зан байдлыг олж хараад тэр өөрийнхөө өө дутагдлыг мэдэж, номхон дөлгөөн болсон билээ. Бурханы Хүүгийн хүч тэнхээ, тэсвэр тэвчээр, аугаа чадал, зөөлөн сэтгэл, сүр жавхлан, номхон хүлцэнгүйг тэр өдөр бүр харахдаа хязгааргүй ихээр Түүнийг хайрлан биширч байсан юм. Иохан өдрөөс өдөрт Христэд улам бүр татагдаж, аажмаар Эзэнийг хайрлах хайр нь өөрийгөө хайрлах хайрыг зүрхнээс нь шахан гаргажээ. Тэр өөрийнхөө гомдомхой, нэр алдарт шунамтгай зан чанарыг өөрчилж өгөхийг Христээс хүссэн юм. Тэгэхэд Ариун Сүнсний сэргэн мандуулагч хүч Иоханы сэтгэл зүрхийг шинэчилсэн болой. Христийн хайр энэрлийн нөлөөгөөр түүний зан байдалд үлэмж өөрчлөлт гарчээ. Есүстэй холбоо тогтоовол иймэрхүү үр дүнд заавал хүргэнэ. Хэрэв Христ сэтгэл зүрхэнд бат оршиж байвал хүн бүрэн дүүрэн өөрчлөгдөнө. Христийн үзэл санаа, хайр энэрэл сэтгэл зүрхийг уяруулан эзэмдэж, бодол санаа, хүсэл эрмэлзлийг Бурханы зүг, хувиршгүй мөнх юм болгоны зүг чиглүүлдэг юм.

Христ тэнгэрт өргөгдсөний дараа ч Түүнийг залгамжлагчид Түүний оршин буйг мэдэрсээр байжээ. Тэр гэрэл гэгээ, хайр энэрлээ сацруулсаар тэдэнтэй хамт байсан юм. Ярьж, залбирч, зоригжуулж, тайтгаруулж байсан Аврагч Есүс энх амгалангийн зарыг сонордуулж байх үедээ тэнгэрт өргөгдсөн билээ. Түүнийг Тэнгэр элч нарын үүлс хүрээлж байх үед Түүний шавь нарын чихнээ “Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно” (Матай 28:20) гэж хэлэх нь сонсогдсоор

байжээ. Тэр хүний дүрээр тэнгэрт өргөгдсөн юм. Түүний шавь нар нь Тэр Бурханы хаан ширээний өмнө очсон, тэдний Анд, Аврагч хэвээрээ үлдсэн, Түүний хайр хувиршгүй, Тэр зовж ядарсан хүн төрөлхтний төлөө урьдын адил санаа зовсоор байгаа гэдгийг мэдэж байсан юм. Христ Бурханд Өөрийнхөө гавьяа зүтгэл, Өөрийнхөө эрдэнэт цус, Өөрийнхөө цоо хатгуулсан гар, хөлийг үзүүлж, хүн зоныг ямар үнээр цагаатгаснаа мэдүүлж байгаа. Хүмүүс, тэдэнд байр орон бэлтгэх гэж Тэрбээр Тэнгэрт өргөгдсөн, Тэр эргэж ирээд тэднийг Өөртөө авна гэдгийг мэдэж байсан юм.

Христийг өргөгдсөний дараа шавь нар нь цуглараад Есүсийн нэрээр хүсэлт гуйлтаа тэнгэрийн Эцэгт хүргэхийг туйлаас хүсчээ. Тэд гүн бишрэлтэй сөхрөн залбирч, “Миний нэрээр Эцэгээс минь юуг ч гуйвал Тэр түүнийг чинь өгнө. Одоо болтол та нар Миний нэрээр юу ч гуйгаагүй. Гуйгтун. Та нарын баяр баясгалан дүүрэн болгогдохын тулд та нар хүлээн авна” (Иохан 16:23-24) гэж өөрсдөд нь өгсөн амлалтыг дахин давтан хэлцгээсэн юм. Тэд залбиран залбиран гараа улам бүр дээш өргөж “Христ Есүс нь үхээд, бүр амилуулагдсан, Бурханы баруун талд байдаг, бидний төлөө зуучлан гуйдаг Нэгэн юм” хэмээх няцаагдашгүй, учир шалтгаант үгсийг хэлсэн билээ. (Ром 8:34). Тэгээд Петекостын өдөр тэдэн дээр Туслэгч бууж ирсэн аж. Христ Түүний тухай “Тэр ... та нарын дотор байна” гэж айлджээ. Христ бас айлдруун: “Миний явах нь та нарт хэрэгтэй. Хэрэв би явахгүй бол Туслэгч та нар руу ирэхгүй. Харин би явбал Өөрөө Түүнийг та нар руу илгээнэ” (Иохан 14:17; 15:6) Энэ цагаас хойш Христ Өөрийнхөө Ариун Сүнсээр дамжуулан Өөрийнхөө хүүхдүүдийн сэтгэл зүрхэн дотор байнга орших ёстой байлаа. Одоо тэд Түүний газар дэлхий дээр байх үеийг бодвол Түүнд улам ойрхон болжээ. Тэднээс Христийн гэрэл гэгээ, хайр энэрэл, хүч

чадал цацарч байсан юм. Тийм болохоор хүн зон тэднийг хараад “гайхацгаан ... тэднийг Есүстэй хамт байсныг нь мэдэв” (Үйлс явдал 4:13).

Өнөөдөр Христ анхныхаа шавь нарт хийсэн бүхнээ Өөрийнхөө хүүхдүүдэд хийхийг бас хүсч байна. Есүс Өөрийн шавь нарын хүрээнд сүүлчийн удаа мөргөл үйлдэхдээ: “Би зөвхөн та нарын төлөө бус, та нарын үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө мөн гуйж байна” (Иохан 17:20) гэж хэлжээ.

Есүс Өөрөө Эцэгтэйгээ нэгдмэл байсантайгаа адил биднийг Түүнтэй нэгдмэл байгаасай гэж бидний төлөө залбирч байсан. Энэ юутай аугаа холбоо вэ! Аврагч өөрийнхөө тухай: “Хүү Өөрөөсөө юуг ч хийж чадахгүй”. (Иохан 5:19) “Миний дотор оршигч Эцэг өөрийнхөө ажлуудыг хийж байгаа юм” (Иохан 14:10) гэж хэлжээ. Иймд, хэрэв Христ бидний зүрхэн дотор амьдарч буй бол “Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлэн, хүсүүлнэ”. (Филиппой 2:13) Бид Түүний үйлдэж байсан шиг үйлдэнэ. Бидний дотор мөн тийм үзэл санаа буй болно. Түүний хайрын дотор байж, “бид Тэргүүн болох Христ рүү бүх талаар өсөх ёстой” (Эфес 4:15).

БИДНИЙ АМЬДРАЛ БА АЖИЛ ҮЙЛС

Бурхан бол орчлон ертөнцийн аж амьдрал, гэрэл гэгээ, баяр баясгалангийн эх сурвалж мөн. Түүний адислал нарны гэрэл, ариун усны урсгал мэт. Түүний бүхий л бүтээл туурвилд сацран гэрэлтэж байдаг юм. Бурхан хүн зоны сэтгэл зүрхэнд оршиж байх үед хүн зон ч бас ойр тойрныхоо хүмүүст хайр энэрлээр буян үйлдэх чадвартай болдог билээ.

Бидний Аврагч цөхөрч доройтсон хүмүүсийг өөд нь татаж аврахдаа баяр баясгалан эдэлдэг юм. Үүний төлөө Тэр халуун амиа үл хайрлан, хараал зүхлийг үл хайхран загалмайг тэвчсэн. Тэнгэр элч нар ч мөн бусдын аз жаргалын төлөө байнга хөдөлмөрлөж байдаг. Үүндээ тэд баярладаг. Биеэ тоосон хүмүүс зовлонд нэрвэгдсэн хөөрхий ядуус, нүгэлтэй олонд туслах явдлыг ичгүүртэй хэрэг гэж үздэг байна. Тэгвэл энэ нь Тэнгэрийн ариун элч нарын эрхэм үйл хэрэг мөн ажээ. Христийн ариун хайр энэрлийн үзэл санаа, уур амьсгал хамаг тэнгэрийг дүүргэж, тэнгэрийн жаргалангийн мөн чанар нь болдог байна. Христийг залгамжлагчид эзэмших учиртай энэ үзэл санаа тэдний үйл ажиллагаанд заавал тодорно.

Хэрэв бидний сэтгэл зүрхэнд Христийн хайр энэрэл оршиж байгаа бол түүний анхилуун тансаг үнэрийг хүн бүхэн мэдэрнэ. Бидэнд шингэсэн Христийн үзэл санаа ангамал элсэн цөлд ядарч туйлдсан аянчны цангааг тайлж, дотры нь онгойлгогч булгийн хүйтэн устай адил болно.

Есүсийг хайрлах хайр Түүний хүн төрөлхтнийг адислан ерөөж, оюун санааны хувьд өөд татахын тулд хөдөлмөрлөж байсан шиг хөдөлмөрлөх хүслээр илэрнэ. Тэр хайрын ачаар бид улам уриалгахан, улам зөөлхөн, Бүтээгчийн бүхий л бүтээлд улам нигүүлсэнгүй ханддаг болно.

Аврагчийн амьдрал энэ хорвоод хөнгөн байгаагүй бөгөөд Тэр Өөрийгөө ер бодож байсангүй. Тэр мөхөж доройтож буй хүн зоныг аврахын тулд шургуу, цуцалтгүй, ариун чармайлт гарган хөдөлмөрлөсөн юм. Тэр төрөхөөсөө аваад загалмайд цовдлуулах хүртлээ саад бэрхшээл, хүнд хэцүү аялал, ядаргаатай ажил хөдөлмөрөөс үл шантран Өөрийгөө огоорох замаар явсан юм. Есүс Өөрийнхөө тухай “Хүний хүү үйлчлүүлэхийн тулд биш, харин үйлчлэхийн тулд ирсэн бөгөөд амиа олны төлөө золиос болгон өгөхөөр ирсэн билээ” хэмээн өгүүлжээ. (Матай 20:28) Түүний амьдралын гол зорилго үүнд оршиж байлаа. Бусад бүх зүйл Түүний хувьд гол ажилд нь дэм болдог хоёрдугаар зэргийн зүйл байсан юм. Бурханы хүсэл зоригийг биелүүлэх явдал Түүний хувьд уух унд, идэх хүнс мэт эрхэм байлаа. Есүс цуцалтгүй хөдөлмөрлөж байх үедээ Өөрийгөө болон Өөрийнхөө эрх ашгийг умартдаг байсан юм.

Үүнтэй нэгэн адилаар Христийн буян хишгийг хүртсэн хүн бүр амьдарч буй газар дэлхийгээ ариусган сайжруулахын тулд бололцоотой бүхнийг хийж, ямар ч хохирол хүлээхэд бэлэн байх болно. Энэ үзэл санаа бол үнэнхүү төгс төгөлдөр хандлагын гэрчлэл мөн. Хүн Христ рүү дөхөж ирмэгц, түүний зүрхэнд Есүс дотор ямар хосгүй сайхан анд нөхөртэй учирснаа хүн бүхэнд ярих хүслэн төрдөг ажээ. Авран ариусгагч үнэн сэтгэлд далд нууцгай үлдэх ёсгүй. Хэрэв бид Христийн зөвт ёсыг дагаж, Түүний аз жаргал хайрлагч Сүнс сэтгэлд минь байгаа л бол бид дуугүй байж таарахгүй. Хэрэв бид Эзэн тэнгэрийн ивээл хайрыг амталж үзсэн л бол бусдад ярих юмтай болно. Аврагчийг олсон Филиптэй адил бид хүн бүхнийг Түүнтэй харилцаач гэж урин дуудах болно. Бид тэдэнд Христийн сэтгэл татам сайхан чанар, ирээдүйн ертөнцийн нүднээ үл үзэгдэх бодит байдлыг толилуулахыг хичээнэ. Есүсийн замнасан замаар явж ойр тойрныхоо хүмүүст: “Хорвоогийн

нүглийг Өөртөө авсан Бурханы Хурга энэ байна” гэж хэлэх чин хүсэл бидэнд төрөх болно. (Иохан 1:29).

Бусдыг жаргаах гэсэн бидний эрмэлзлэл бидэнд өөрсдөд маань буян болно. Ийм учраас Их Эзэн авралын үйлст биднийг оролцоосой гэж хүлээж байна. Хүмүүс ойр дотныхондоо буян үйлдээсэй гэсэндээ Тэр Бурханы мөн чанарт нэвтрэх давуу талыг тэдэнд олгосон юм. Энэ бол хамгийн эрхэм нэр хүнд. Бурханаас хүмүүст хайрласан хамгийн агуу их баяр баясгалан. Хайр энэрлийн энэ үйлст оролцож буй хүн бүхэн Бүтээгчдээ улам ойр дөт болно.

Эзэн тэнгэр хүмүүст Түүний авралын зар, хайр энэрэл, итгэл найдварын сайн мэдээг хүргэж өгөгтүн хэмээн тэнгэр элчүүдэд даатгаж болох байсан. Тэр Өөрийнхөө зорилгыг биелүүлэхийн тулд өөр бусад аргыг ч хэрэглэж болох байсан. Гэвч хязгааргүй хайртайдаа Тэр биднийг туслагчаараа сонгож авсан юм. Бид Христ болон тэнгэр элч нарын хамт хөдөлмөрлөж, буян жаргалыг нь хуваалцаж болно, бид энэ чин сэтгэлийн үйлстээ оюун санааны хувьд өсч чадна.

Христ биднийг аврахын тулд хичнээн их зовж тарчилсныг ойлгомогц Түүнтэй зохирон амьдарч эхэлнэ. Бусдын аз жаргалын төлөө хийсэн амь бие хайргүй үйлдэл бүхэн биднийг улам нигүүлсэнгүй болгож, хорвоогийн Цагаатгагчтай улам нягт холбоно. Тэрбээр “баян байсан боловч Өөрийнхөө ядуурлаар та нарыг баян болгохыг тулд та нарын төлөө Тэр ядуу болжээ” (2 Коринт 8:9) Бид анхлан бүтээгдэхдээ хийх ёстой байсан тэр л үйл хэргийг биелүүлж гэмээ нь бидний амьдрал Бурханы ерөөлөөр болох байв.

Христийн хүссэнчлэн хөдөлмөрлөхийн цагт оюун санааны гүнзгий туршлага эзэмшиж, Бурханыг улам гүнзгий ойлгох хэрэгтэй гэдгийг бид мэдрэх болно. Бид зөвт ёсыг туйлаас хүсч, Бурхантай залбирлаар харилцахыг эрмэлзэх болно. Энэ харилцаа бидний

итгэлийг бататгаж, сэтгэл санааны цангаагаа тайлахын тулд бид авралын эх сурвалж өөд тэмүүлэх болно. Амьдралд тохиолдох бэрхшээл, сорилтын улмаас бид Библийг байнга судалж, залбирлыг тасралтгүй үйлдэх болно. Бид Христийн буян хишгийг хүртэж, танин мэдэх талаар улам өсч оюун санааны баялаг туршлага хуримтлуулна.

Хүн бусдын төлөө чин үнэнээсээ сэтгэл харамгүй хүчин зүтгэвэл, хатуу шийдмэг зантай, бат тогтвортой болж, Христийн их хайр түүнийг төвшин, жаргалтай болгоно. Түүний хүсэл эрмэлзлэл улам бадрангуй болж, сэтгэл зүрх нь хойргоших, хар амиа бодох зайгүй болно. Христийн ивээл хишгийг хүртэгсэд оюун санааны хувьд өсч, Бурханд үйлчлэх суу хүчийг өгнө. Тэд тов тодорхой сүнслэг хараатай болж, хэлбэрэлтгүй арвижих итгэлийг олж, мөргөх залбирлаа эрч хүчтэйгээ үйлдэх бөлгөө. Бурханы Сүнс хүний сэтгэлд нөлөөлж, ариун эгшиглэн үүсгэнэ. Ийм маягаар бусдын тусын тулд өөрийгөө умартан хөдөлмөрлөсөн хэн бүхэн авралын замаар замнаж буй нь тэр болой.

Христийн бидэнд даалгасан үйл хэргийг чин сэтгэлээсээ, амь биеэ огоорон байж биелүүлсэн цагт, гачигдаж ядарсан хүмүүст тусалж, аз жаргалынх нь төлөө зүтгэж, өөрснөөсөө шалтгаалах бүхнийг хийсэн тэр л үед бид буян хишгийн өлгий дотор өсөн торних юм. Байнгын тасралтгүй үйл ажиллагаа биднийг хүчирхэгжүүлнэ. Энэ бол амьдралын эхний болзол. Христийн төлөө юугаа ч зориулалгүйгээр өөрийнхөө оюуны амьдралыг хэвээр хадгалахыг хүсч байгаа хүн бол ажил хийлгүй хоол идэхийг хүсч байгаа хүнтэй адил юм. Оюун санааны ертөнц ч бодит ертөнцийн адил уруудаж, доройтон байдаг. Бие эрхтнээ хөдөлгөх дургүй хүн төдөлгүй түүнээ ашиглах ч тэнхэлгүй болдог. Үүний нэгэн адил Бурханы хайрласан хүчийг ашигладаггүй Христийн шүтлэгтэн

бээр өөртөө байсан хүчийг алдаж, Христийн дотор өсөн дэвжиж чадахгүйд хүрнэ.

Христийн сүм бол Бурханы соёрхсон хүн зоныг аврах зэвсэг юм. Түүний зорилго нь авралын зарыг бүх дэлхийд түгээх явдал билээ. Энэ үүргийг бүх Христэд итгэгчдэд ногдуулжээ. Хүн бүр өөрийнхөө чадвар, боломжийн хэрээр Аврагчийн даалгаврыг биелүүлэх ёстой. Христийн хайр энэрэл биднийг Түүнийг мэдэхгүй хүн бүхний өмнө өртөн болгож байна. Бурхан гэрэл гэгээг зөвхөн бидэнд биш бас тэр гэрлийг бусдад дэлгэрүүлэхийн тулд хайрласан юм.

Хэрэв Христийг залгамжлагчид өөрсдийнхөө үүргийг тодорхой ойлгосонсон бол авралын зарыг өнөөдөр ганцхан мэдээч номлож байгаа тэр газарт олон мянган хүн номлож байхсан билээ. Энэхүү ажилд биеэр оролцож чадахгүй байгаа хүмүүс хөрөнгө сэлт, нигүүлсэнгүй сэтгэл, залбирал юугаараа энэ ажлыг дэмжихсэн биз ээ. Христийн номлолт улс орнуудад хүнийг сэтгэл оюуны хувьд аварч хамгаалах ажил улам улмаар өрнөнө.

Хэрэв бид Христийн ажлыг өөрийн гэр бүл юм уу, эсвэл орон байрныхаа ойр хавийн хүмүүсийн дунд хийх учиртай юм бол заавал алс холын улс оронд очих шаардлага байхгүй. Бид үүнийг орчин тойрондоо хийж болно.

Бидний Аврагч өөрийнхөө хорвоо дахь амьдралын ихэнх хэсгийг Назарет дахь мужааны давчуухан байранд, цөхрөлтгүй ажил хийж өнгөрөөсөн билээ. Тэр Өөрийг нь Бурханы Хүү гэж огтхон ч сэжиг ажиг аваагүй тариачид, хөдөлмөрчидтэй уулзаж учирч байхад Тэнгэр элч нар Есүстэй хамт байсан юм. Есүс Өөрийнхөө хар бор дархны ажлыг хийж байхдаа ч, өвчтөнийг анагааж байхдаа ч, Галилийн тэнгисийн ширүүн давалгаан дээгүүр явж байхдаа ч Өөрийнхөө үүргийг үнэнчээр биелүүлж байсан юм. Бид ч гэсэн хамгийн эгэлхэн үүргийг

биелүүлж, хамгийн доогуурхан байр суурийг эзэлж, Есүстэй хамт амьдарч ажиллаж болно.

Сургаал номлогч: “Ах дүү нар аа, хэн юун дотор дуудагдсан байна, түүн дотроо хүн бүр Бурхантай хамт үлд” гэжээ. (1 Коринт 7:24) Христэд итгэгч, хөдөлмөрч хүн өөрийнхөө ажлын байранд үүргээ шудрагаар биелүүлэн өөрийнхөө Эзэн тэнгэрийг алдаршуулж болно. Хэрэв тэр Христийн үнэнч залгамжлагч мөн бол түүний шүтлэг бүхий л үйлдэлд нь илэрч, хүн зонд Христийн номлолыг нээж өгнө. Хөдөлмөрч, шудрага ажилтанд Түүний дүр илрэх болно. Есүс Галилийн толгод дунд амьдарч байхдаа хамгийн хар бор ажлыг ч маш хичээнгүйлэн хийдэг байсан шүү дээ. Христэд итгэгч хүн бүхэн бусад хүмүүс буянтай үйлсийг нь хараад өөрийнхөө Бүтээгч, Цагаатгагчийг алдаршуулж чадахуйцаар хөдөлмөрлөх ёстой.

Зарим нь өөр бусад хүн энэ зорилгод заяасан илүү их авъяас билэгтэй гэж үзээд өөрийнхөө төрөлхийн чадвараар Христэд хүчин зүтгэхдээ цааргалдаг ажээ. Тэдний бодлоор бол зөвхөн онцгой чадвартанууд л Бурханд хүчин зүтгэдэг байх нь. Тэр ч байтугай олон хүн тийм онцгой чадварыг Бурхан өөрийн сонгосон тодорхой нэг бүлэг хүмүүст л хуваарилан өгч, бусад нь ажил хөдөлмөр эрхэлж, түүнийхээ шан харамжийг хүртэх эрхгүй хэмээн төсөөлдөг. Гэвч сургаалт үлгэрт авъяас чадварын тухайд өөрөөр өгүүлжээ. Гэрийн эзэн албат зарц нараа дуудаад, хийх ажлыг нь хүн нэг бүрт хэлж өгдөг шүү дээ.

Бид хамгийн ялимгүй өчүүхэн ажлыг ч гэсэн “Эзэн Тэнгэрийн төлөө” биелүүлж байгаа юм шиг хичээнгүйлэн биелүүлж болно. (Холосас 3:23) Хэрэв Бурханы хайр бидний зүрхэнд оршиж байвал, тэр нь өдөр тутмын амьдрал, ажил хэрэгт маань тусгалаа олно. Бид орчин тойрныхондоо Христийн ариун уур амьсгалыг түгээж, бусдад ерөөл буяны сайхан нөлөө үзүүлнэ.

Бурханы төлөө хөдөлмөрлөхөд таатай нөхцөл, бололцоо, эсвэл ер бусын авьяас билгийг хүлээж суухын хэрэггүй. Энэ хорвоо та нарын тухай юу гэж бодох бол гэж сэтгэл бүү зовцгоо. Хэрэв та нарын өдөр тутмын амьдрал та нарын сүсэг бишрэл ариун бөгөөд чин сэтгэлийнх гэдгийг гэрчилж, хүмүүс та нарыг өөрсдөд нь тус хүргэхийг хүсч байгаа гэдэгт итгэж үнэмшиж л байгаа бол та нарын хүчин чармайлт талаар өнгөрөхгүй.

Есүсийн хамгийн номхон, жирийн шавь нар бусад хүмүүст ерөөл буян болж чадна.

Ихэнхдээ тэд ямар нэг гойд сайн юм хийснээ ухамсарладаг ч үгүй. Гэхдээ тэдний тааламжит нөлөө буян ерөөлийн давалгааг үүсгэж болно. Тэр давалгаа цаашдаа улам хүчтэй болж болно. Үүнд Есүсийг залгамжлагчид төгс ачлалын өдөр хүртэл өөрийнхөө нөлөөний үр шимийг мэдэхгүй ч байж болох юм. Тэд ямар нэг аугаа их зүйл хийж байгаагаа ухаардаг ч үгүй. Ийм хүмүүс амжилт гэж зовохын хэрэггүй, харин Бурханы даалгасан үйл хэргийг үнэн сэтгэлээсээ сайн хийж урагшаага тайван явах хэрэгтэй. Тэгвэл тэдний амьдрал талаар өнгөрөхгүй. Тэд Христтэй улам бүр адил төстэй болно. Тэд энэ насандаа Бурханы хамтран зүтгэгчид болж, ирээдүйн баясгалан, саруул амьдралд бэлтгэцгээж байна.

БУРХАНЫГ ТАНИН МЭДЭХҮЙ

Бурхан Өөрийгөө бидэнд нээж, Өөртэйгөө харилцаа тогтоолгохыг эрмэлздэг олон арга зам буй. Байгаль бидний ухамсар, мэдрэхүйд байнга нөлөөлж байдаг. Бурханы үйл хэргээр илэрдэг Түүний энэрэл хайр, суу алдар нь сайхан сэтгэлтэй хүнд гүнзгий сэтгэгдэл төрүүлдэг. Хүн байгаль дэлхийн нууц битүүлэг амьдралыг анхааралтай ажиглан чагнаж, Бурхан Өөрийнхөө бүтээлээр дамжуулан түүнийг юунд сургахыг хүсч байгааг сонсон ойлгодог. Ногоорон харагдах тал хөндий, сүрлэг сайхан ой мод, цэцэг навч Бурханыг танин мэдээч хэмээн биднийг урин дуудаж, хөвөлзөн нүүх үүлс, дээд тэнгэрийн суу хүчин, Түүний тухай бидэнд өгүүлж, борооны шиврээ, горхины хоржигноон бидний оюун ухааныг Бүтээгчийн зүг хандуулам.

Бидний Аврагч байгалийн үзэгдэл, дүр зургийг харуулж байж Өөрийнхөө эрхэм нандин үнэнийг тайлбарласан юм. Ой мод, жигүүртэн шувуу, хээрийн цэцэг, дов толгод, нуур цөөрөм, тэнгэрийн одод мөн түүнчлэн амьдрал ахуйн өдөр тутмын үйл явдал нь үнэн үг, хүний хөдөлмөр, зүтгэлтэй нягт холбоотой байдаг.

Бурхан Өөрийнх нь хүүхдүүд Түүнийг дурсан санаж байгалийн энх амгалан, намуухан гоо үзэсгэлэнгээр сэтгэлээ баясгаж байгаасай гэж хүсдэг юм. Бурхан энэ ертөнцийн сайхан юм болгонд хайртай, гэвч Түүнд зан байдлын сайхан, өнгөн дээрээ нүд булаах сайхнаас илүү эрхэм байдаг. Бурхан цэвэр ариун, эгэл жирийн байдлаа улам төгөлдөр болгоосой гэж биднээс хүсдэг. Цэцэг навчны тийм чанарт бид дуртай шүү дээ.

Хэрэв бид орчлон ертөнц дэх Бурханы бүтээлүүдийг харах аваас, орчин тойрныхоо бүх зүйлийг соргогоор

чагнаж, сүсэг бишрэлийн сургамжийг авах билээ. Заяа тавилант замаараа мөнхөд хөдлөгч аварга том оддоос эхлээд хамгийн өчүүхэн атомыг хүртэл байгалийн юмс үзэгдэл бүхэн Бүтээгчийн хүсэл зоригт захирагдана. Бурхан юм бүхэнд санаа тавьж Өөрийнхөө бүтээлүүдийг тэжээн тэтгэж байдаг. Тэрбээр хязгааргүй Орчлонгийн тоо томшгүй од мичдээс эхлээд жиргэн дуулагч бяцхан шувуухайг ч бас удирддаг. Бидний Тэнгэрийн Эцэг бид бүхнийг энхрийлэн халамжилдаг. Тэр бидний ажилдаа явахыг хардаг, мөргөл үйлдэхийг сонсдог. Бидний унтахаар хэвтэхэд ч өглөө сэрэхэд ч Түүний мэлмий биднийг дээрээс ширтэн байдаг. Баян хүн орд харшдаа найрлаж байхыг ч, ядуу хүн үр хүүхдээ тэжээх гэж зовж байгааг ч Тэр мэднэ. Бурхан дусалсан нулимс бүрийг мэднэ, нэг ч инээмсэглэлийг Тэр анзааралгүй үл өнгөрөөнө.

Хэрэв бид энэ бүхнийг гүнзгий ухаарсан бол дэмий шаналж, сэтгэл түгшихгүй байхсан билээ. Бид амьдралдаа өнөөдрийнх шиг ингэж гутарч, гунихрахгүйсэн. Яагаад гэвэл их ч бай, бага ч бай бүхий л асуудал бэрхшээл юугаа санаа тавих зүйл хичнээн их байсан ч түүртэн үл зовох Бурханы мутарт даатгах байсан.

Газар дэлхийн гоо сайхныг гайхан баясахдаа гуниг зовлон, нүгэл хилэнц, үхэл мөхөл цөм үгүй болсон, байгаль дэлхийд хараал зүхлийн сүүдэр огт үл тусах ирээдүйн ертөнцийн тухай бодоцгоогтун! Аврагдагсдын эх орныг төсөөлж, тэр эх орон хамгийн зоримог, амьд төсөөллөөс ч илүү сайхан болно гэдгийг санацгаа. Байгальд байгаа Бурханы янз бүрийн хишиг Түүний суу алдарын хамгийн бүдэгхэн тусгал төдий юм. “Нүдэнд үзэгдээгүй, чихэнд сонсогдоогүй, хүний санаанд ороогүй юмсыг Бурхан Өөрийг нь хайрладаг хүмүүст бэлджээ”. (1 Коринт 2:9).

Яруу найрагчид, эрдэмтэн мэргэд байгалийн тухай их зүйлийг хэлж чадах боловч гагцхүү Христийн шүтлэгтэн л хүнийг хайрлах Бурханы хайрыг янз бүрийн зүйлээс олж харж, уул, хөндий, гол, тэнгис юм бүхнийг хүний тусын тул бүтээсэн гэдгийг ойлгодог юм. Энэ бүхэн Эцэгийн мутраар бүтээгдсэн гэж хүлээн зөвшөөрдөг хүн л байгалийн гоо сайханд жинхэнэ ёсоор баясч, түүнийг дээд зэргээр үнэлж чадна.

Бурхан Өөрийн оролцоо, Ариун Сүнснийхээ сэтгэл зүрхэнд нөлөөлөх нөлөөллөөр дамжуулан бидэнд ханддаг билээ. Бидний өдөр тутмын амьдралд тохиолдож байгаа юм бүхнээс, бидний эргэн тойронд өдөр тутам болж буй өөрчлөлт, хувиралтаас ойлгоё л гэж хичээх юм бол үнэ цэнэтэй сургамж авч чадна. Дуулалч Бурханы гайхамшигт хайр халамжийн тухай эргэцүүлэн бодоод “Дэлхий Эзэний хайр энэрлээр дүүрэн” (Дуулал 33:5) “Хэн мэргэн бэ? Тэр нь Эзэний хайр энэрлийг тунгааг” (Дуулал 107:43) хэмээн өгүүлжээ.

Бурхан бас Өөрийнхөө айлдвараар бидэнд ханддаг. Библи сударт Түүний зан байдал, аврал болон хүмүүстэй харьцах харилцааны аугаа их үйл хэргийг тод тодхон, бүрэн дүүрэн дэлгэн харуулжээ. Уг сударт эрт цагийн өвөг дээдэс, зөнч мэргэд зэрэг бие хүмүүсийн тухай өгүүлжээ. Тэд “бидэнтэй л адилхан” хүмүүс байсан. (Иаков 5:17). Тэд бидэнтэй адил сэтгэлээр унаж, гуниг гутралтай тэмцэж байсан, бидэнтэй л адилхан уруу татагдаж байснаа дахин сэргэж, Бурханы буян хишгийн хүчээр ялж гарсан ажээ. Бид тэдний тухай уншаад зөвт ёсыг эрмэлзэх хүсэл зориг маань бадардаг. Бид тэдний гайхамшигт туршлагатай танилцаж, тэд ямар гэрэл гэгээ, ямар хайр энэрэл, ямар өлзий буянтай байсныг, тэд Бурханы заяасан буян хишгээр ямар үйлс бүтээснийг үзэхүй тэднийг зоригжуулсан нөгөө л Ариун Сүнс бидний зүрхэнд гэгээн баярын очисыг асааж, тэдэнтэй зан

байдлаар адилхан болж, тэдэнтэй адил Бурхан лугаа хамт явах хүслийг бадраана.

“Тэдгээр нь Намайг гэрчилдэг” (Иохан 5:39) хэмээн Есүс Хуучин гэрээ судрын тухай өгүүлсэн бөгөөд энэ нь Шинэ гэрээний хувьд бүр ч үнэн зөв юм. Өөрөөр хэлбэл мөнхийн амьдралд найдах бидний бүхий л найдвар болсон Аврагчийн тухай гэрчилж буй хэрэг билээ. Тийм ээ, бүхий л Библи Христийн тухай өгүүлдэг. Дэлхийг бүтээсэн тухай “Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй” гэсэн өгүүлэмжээс эхлээд “Би удахгүй ирнэ!” гэсэн сүүлчийн амлалт хүртэл бид Түүний үйл хэргийн тухай уншиж, Түүний дуу хоолойг сонсдог. (Иохан 1:3; Илчлэлт 22:12) Хэрэв бид Аврагчийг улам сайн мэдье гэвэл Ариун Судрыг унших хэрэгтэй.

Бурханы айлдвар бидний зүрхэнд шингэх болтугай! Энэ бол тэсгэлгүй цангааг тайлагч амьд ус мөн. Энэ бол тэнгэрээс буцаж ирсэн амьд талх мөн.

Есүс: “Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй” гээд Тэр айлдсанаа “Миний та нарт хэлсэн үгс бол сүнс ба амь билээ” (Иохан 6:53, 63) хэмээн тайлбарлажээ. Газрын хишгийг хүртэж бидний бие цогцос бүрддэг. Биет ертөнцөд болж байгаа зүйл оюун санааны мөн чанарт маань ч ёс зүйн тулгуур болж, хүч сэлбэдэг юм.

Цагаатгал гэдэг бол тэнгэр элч нар нэвтрэн орохыг хүсдэг тэрхүү нууц юм. Тэр нууцыг цагаатгагдсан хүмүүс үүрд судалж магтан дуулах болно. Үүнийг яг одоо, маш чимхлүүр, нарийн судлах хэрэггүй гэж үү? Есүсийн хязгааргүй нигүүлсэнгүй сэтгэл, энэрэл хайр, бидний төлөө үзсэн хохирлыг тун нухацтай, хүндэтгэлтэй эргэцүүлэн бодох нь зүйтэй. Бид хайрт Цагаатгагч, Зуучлагчийнхаа зан байдалд анхаарлаа төвлөрүүлж “Өөрийнхөө хүмүүсийг нүгэл хилэнцээс нь аврах” гэсэн Түүний гол зорилгыг эргэцүүлэн бодох ёстой. Хэрэв бид

тэнгэрийн үнэний тухай эргэцүүлэлд цагаа зориулах юм бол бидний итгэл хайр батжина. Бидний залбирал Бурханыг хүлээн авахад улам тохиромжтой болно. Учир нь бидний залбирал улам амьд, оргилуун болж, бишрэл хайраар бялхах бөлгөө. Бид Есүст улам их итгэж, бид Түүгээр дамжин Эцэгт очиж буй бүх хүмүүсийг аврагч Түүний хүчийг өдөр болгон харах болно.

Аврагчийн төгс төгөлдөр чанарын тухай эргэцүүлэн бодохдоо бид шинэчлэгдэж, Түүний ариун дүртэй адил болохыг туйлаас хүсдэг. Бишрэн хүндэтгэдэг Нэгэнтэйгээ адил байхсан гэсэн хүсэл бидний сэтгэлд төрдөг. Христийн тухай бодох тусам Түүний тухай бусдад ярьж, Түүнийг дэлхийд дуурсгамаар санагддаг.

Библийг зөвхөн эрдэмтэн мэргэдэд зориулж бичсэн юм биш, харин ч эгэл жирийн хүмүүст илүүтэй зориулагдсан болой. Авралд хэрэг болох аугаа их үнэнгэгээн өдөр мэт тов тодорхой. Хэрэв өөрийн бодлыг Бурханы илт шулуун хүсэл зоригоос дээгүүр тавихгүй л бол хэн ч алдаа гаргаж замаасаа хазайхгүй.

Ариун судар юунд сургаж байгааг мэдэхийн тулд бусдын гэрчлэлд найдахын оронд бид өөрсдөө Бурханы айлдварыг судлах ёстой. Хэрэв бид өөрийнхөө өмнөөс бодох боломжийг бусдад олгох юм бол бидний оюун санааны хүч суларч мошно. Бид Бурханы айлдварын гүнзгий үнэнийг ойлгох чадвараа алдана. Харин ч хэрэв бид Библи дэх нэг бичвэрийг нөгөөтэй нь харьцуулж, оюуны зүйлийг оюуны зүйлтэй нь жишиж харилцаа холбоогий нь нухацтай судлах юм бол бидний ухаан саруулсаж, бидний өмнө Библийн гайхамшигт гоо сайхан, үнэ цэнэ нээгдэнэ.

Ариун судраас өөр оюун ухааныг саруул болгох зүйл гэж байхгүй. Гүнзгий буянлиг үнэнийг агуулсан Библи судраас өөр ямар ч ном ийм хүчтэй сэтгэлгээг төрүүлж, ухааныг гүнзгийрүүлж чадахгүй. Хэрэв Бурханы айлдварыг зохих ёсоор судалсансан бол хүн зон уужим

ухаан, сайхан зан, төгс зорилго, өөрөөр хэлбэл өнөө үед дутагдаад байгаа юм бүхэнтэй байхсан билээ.

Судрыг гүйлгэн уншвал нэг их тус болохгүй, Библийг эхнээс нь аваад эцсийг нь хүртэл уншсан хэр нь хамаг гоо сайхныг нь ойлгохгүй, гүнзгий далд утгыг нь ухаарахгүй өнгөрч болно. Судрын нэг хэсгийг сайтар судалсан нь дээр. Тэр хэсгийн утга агуулга, ач холбогдол тодорхой болж, авралын Тэнгэрлэг сэдэл санаа ойлгомжтой болтол нарийн судлах нь зүйтэй. Тодорхой зорилгогүй, өөртөө амьдралын чухал сургамжийг олж харалгүйгээр олон бүлгийг гүйлгэн унших нь тусаар бага. Таны Библи үргэлж тантай хамт байх болтугай! Боллоцоо л гарвал Библийг уншиж, уншсанаа тогтоохыг хичээцгээ. Гудамжаар явж байхдаа ч нэг хэсгийг нь уншиж утга агуулгыг нь эргэцүүлэн бодож, ийм маягаар цээжиндээ тогтоож болно.

Библийг нухацтай шинжлэхгүйгээр, залбиран судлахгүйгээр бид үнэнхүү цэцэн билгийг ухаарч чадахгүй. Ариун судрын зарим хэсэг ойлгохгүй байхын аргагүй тодорхой байдаг юм. Гэхдээ зарим хэсгийн утга нь төдий л тодорхой бус, нэг уншихад гүйцэд сайн ойлгогддоггүй. Иймээс нэг бичвэрийг нөгөөтэй нь харьцуулах хэрэгтэй. Нарийн судалж залбиран эргэцүүлбэл хариу нь гарахдаа л нэг гарна.

Газрын хэвлий дэх үнэт металын судлыг эрж олдог хүдэр малтагч лугаа адил Бурханы айлдварыг судлагч Библийг өнгөцхөн уншихад үл ойлгогдох тэрхүү аугаа их нандин үнэнийг эрж олох болно. Хайнга уншигчаас нуугдсан зориг бардам үгсийг гүнзгий ойлгож, нягтлан тунгааж чадвал тэдгээр үгс мөнхийн амьдралын эх ундрагаас гарсан урсгал лугаа адил болой.

Библийг мөргөл үйлдэлгүйгээр судалж хэзээ ч болохгүй. Түүний хуудсыг нээхээсээ өмнө Ариун Сүнсээрээ гэгээрүүлж өгөхийг Бурханаас гуйх ёстой. Тэр хүсэлтийг тань ёсоор болгоно.

Натанаел Есүс дээр ирэхэд Аврагч: “Дотроо заль мэхгүй жинхэнэ израйль хүнийг харагтун” гэж айлдав. Натанаел Есүсээс — Та намайг яаж мэднэ вэ? гэж асуухад, Тэр — Филип чамайг дуудахаас өмнө, инжирийн модны дор байхад чинь Би чамайг харсан» гэдэг билээ.(Иохан 1:47, 48)

Есүс өнөөдөр ч гэсэн бид Түүнд мөргөн, “үнэн гэж юу вэ?” гэдгийг ойлгохын тулд бид Түүнээс сэхээрэл гуйж буйг харж л байгаа. Бурхан Өөрийнхөө зааврыг номхоноор дагах хүмүүсийн зүг Гэрэл гэгээний ертөнцөөс Тэнгэр элч нараа илгээж байна.

Ариун Сүнс Аврагчийг өргөмжлөн алдаршуулж байна. Түүний үйл хэрэг бидэнд Христ, Түүний зөвт ёс, Түүний хүн төрөлхтөнд авчирсан авралын суу гайхамшгийг мэдүүлнэ. Есүс “Тэр Минийхийг авч түүнийгээ та нарт мэдүүлнэ” хэмээн айлджээ. (Иохан 16:14) Гагцхүү Үнэний ариун Сүнс Тэнгэрлиг үнэнийг зааж чадна. Бурхан Өөрийнхөө ганц Хүүг бидний төлөө үхүүлж, Тэр биднийг үргэлж сургаж, хөтөлж байгаасай гэж Өөрийнхөө Ариун Сүнсийг илгээснийг бодохоор хүн төрөлхтөн Бурханд юутай эрхэм билээ!

МӨРГӨЛИЙН ДАВУУ ТАЛ

Бурхан байгаль хийгээд илчлэлээр дамжуулан, өөрийн хайр халамж болон Ариун Сүнсний нөлөөгөөр дамжуулан, бидэнд үгээ хэлдэг билээ. Гэхдээ Түүнтэй тогтоосон бидний харилцаа холбоо үүгээр хязгаарлагдах ёсгүй. Бидний хэн ч гэсэн Түүнд сэтгэл зүрхээ нээх нь аргагүй чухал. Бид оюун санааны амьдрал, хүч чадалтай байхын тулд Тэнгэрийн Эцэгтэйгээ амьд харилцаа холбоотой байх ёстой. Бидний бодол санаа Түүний зүг хандсан байж болно. Бид Түүний үйл хэргийн тухай, Түүний нигүүлсэнгүй сэтгэл, ерөөл сургаалын тухай эргэцүүлэн бодож болно. Гэвч энэ нь бүрэн утгаар Түүнтэй тогтоосон харилцаа болж хараахан чадахгүй. Бурхантай жинхэнэ холбоо тогтоохын тулд бид Түүнд өөрснийхөө амьдралын хийгээд зовлон жаргалын тухай өгүүлэх ёстой.

Залбирал үйлдэхдээ бид Бурханыг анд нөхрөө хэмээн үзэж сэтгэл зүрхээ нээдэг билээ. Энэ нь бидний хэн болохыг Бурхан мэдэхгүй гэсэн утгаар бус харин Түүнийг хүлээн авахад, бидэнд туслахын тулд чухал юм. Залбирал Бурханыг бидэнд авчирдаггүй, харин биднийг Бурханд аваачдаг.

Есүс газар дэлхий дээр байхдаа өөрийн шавь нарт залбирлын хичээл заасан юм. Тэрбээр Бурханы өмнө өдөр тутмын гачаал хяслангаа дэлгэн яривал, Аврагч тэдний залбирлыг дуулна гэж амалсан юм. Энэ амлалт бидэнд ч бас хамаарна.

Есүс Өөрөө хүмүүсийн дунд байхдаа үргэлж залбирдаг байжээ. Тэрээр бидний хэрэгцээ шаардлага, сул талыг Өөртөө авч, ажиллаж зүтгэх, шалгалт сорилтыг даван туулах байнгын шинэ нөөц хүчтэй байхын тулд Өөрийн тэнгэр дэх Эцэгээс тусламж гуйсан юм. Есүс юм бүхэн дээр бидэнд үлгэр жишээ болж байдаг. Тэрээр

биднийг ядарч туйлдахын цагт Ах маань болсон. Тэрээр “Бидэнтэй адил бүх талаар уруу татагдсан” хэдий боловч муу муухайг жигшин үзэж, нүгэл үйлдээгүй юм. Нүгэл хилэнцийн ертөнцөд Аврагч сэтгэл санаагаар шаналж, тэмцэлдэж байсан юм. Залбирал Түүний хувьд зайлшгүй шаардлага хийгээд давуу тал, аятай боломж байлаа. Тэрээр Эцэгтэйгээ харилцахдаа уяран тайтгарч, баясан баярладаг байсан. Хүн зоньг Аврагч, Бурханы Хүүд залбирах хэрэгцээ шаардлага байсан юм бол үхэх тавилантай өчүүхэн дорой, нүгэлт амьтан бидэнд хичээнгүйлэн залбирах хэрэгцээ шаардлага хичнээн их байх ёстой билээ.

Бидний тэнгэрийн Эцэг өөрийнхөө өлзий срөөлийг бид бүхэнд бүрэн дэвшүүлэхэд бэлэн байна. Хязгааргүй хайр энэрлийн эх булгаас тасралтгүй амсах хувь бидэнд байна. Бид ийм бага залбирч байгаа маань гайхалтай биш гэж үү? Бурхан Өөрийнхөө үрсийн дотроос хамгийн номхон хүлцэнгүй хүүхдийнхээ чин сэтгэлийн залбирлыг дуртайяа сонсдог боловч бид Түүнд хэрэгцээ шаардлагаа нээж хэлэхдээ даанч алгуур удаан байна. Уруу татагдсан, арчаагүй, хөөрхийлөлтэй хүмүүсийг хараад хязгааргүй хайр энэрлээр дүүрэн Бурханы сэтгэл зүрх гуйж хүссэнээс нь илүү ихийг өгөхөд бэлэн байсаар байхад харин тэд ийм цөөхөн залбирч, ийм бага итгэж байхыг хараад тэнгэр элчүүд юу гэж боддог бол? Тэнгэр элчүүд Бурханы төлөө хайрын сэтгэлээр хүчин зүтгэж, Түүний ойр хавьд байхдаа баяр баясгалантай байдаг юм. Тэдний хувьд Бурхантай харилцана гэдэг аугаа их баяр баясгалан, гэтэл гагцхүү Бурханы хайрлаж чадах тусламж дэмжлэг маш хэрэгцээтэй байгаа газрын хүүхдүүд бид Түүнтэй холбоо харилцаагүй байх шиг санагдах юм.

Муу ёрын сүнс залбирлыг үл ойшоогсдын дээгүүр харанхуй манан мэт нүүгэлтэж байна. Тэрсүүд дайсны шивнэн ятгаж буй адын сонирхол тэднийг нүгэл хилэнц рүү улам бүр чангаасаар. Энэ бүхэн Бурханаас тэдэнд

хайрласан залбирлын давуу талыг үл ойшоосноос л болж байгаа юм. Залбирал нь Бүхнийг Чадагчийн хязгааргүй бололцоог хангаж байдаг тэнгэрийн эрдэнэсийн санг нээгч сүсэг бишрэлийн түлхүүр мөн юм бол Бурханы хөвгүүд, охид яагаад ийм дургүй залбирал үйлднэм бэ? Бид цовоо сэргэлэн байж, цуцалтгүйгээр залбирал эс үйлдвээс хэнэггүй, алмай болж, жинхэнэ үнэн замаасаа хазайх аюул биднийг нөмөрнө. Дайсагнагч этгээд бидний буян хишгийн хаан ширээнд хүрэх замд үргэлж саад тотгор учруулж байна. Залбирал сүсэглэлийг үл ойшоодог болгохын тулд, буян хишиг хийгээд уруу татагдах явдлыг даван туулах хүчийг бидэнд өгөхгүй байхын тулд дайсан этгээд чадах бүхнээ хийж байна.

Тодорхой нөхцөлд Бурхан бидний залбирлыг сонсч, тэр залбиралд хариулж байгаа гэдэгт бид итгэл төгс байж болно. Анхны болзлуудын нэг нь бид Түүний тусламж хэрэгтэй гэдгийг ухамсарласан байх явдал юм. “Би ангамал хөрсөн дээр ус асгаж, хуурай газар дээр горхи урсгана” гэж Тэр амалсан билээ. (Исаиа 44:3) Зөвт ёсыг хүсэн мөрөөдөж, Бурханы зүг тэмүүлж байгаа хүний сэтгэл ханамжтай байна гэдэгт итгэл төгс байж болно. Ариун Сүнсний нөлөөнд орохын тулд сэтгэл зүрхээ нээсэн цагт л Бурханы ерөөл адислалыг хүлээж авах болно.

Бидэнд дутагдаж буй тэр л хэрэгцээ шаардлага нь бидний тусын тулд хамгийн үнэмшилтэйгээр онож хэлсэн гэрчлэл мөн. Гэвч Их Эзэн бидний хэрэгцээ шаардлагад хариулт өгөхийн тул бид өөрснөө Түүнд хандах ёстой. “Гуй. Тэгвэл та нарт өгнө”, “Тэр Өөрийн Хүүгээ үл өршөөн, харин Түүнийг бид бүхний төлөө тушаасан юм. Тэгвэл Тэр яаж бүх юмыг Түүний хамт бидэнд сул өгөхгүй байх билээ”. (Матай 7:7; Ром 8:32).

Хэрэв бид сэтгэл зүрхэндээ муу муухайг тээж явах юм бол, хэрэв бид ямар нэг нүгэл хилэнцэд автсан байх юм бол Эзэн тэнгэр бидний залбирлыг сонсохгүй ээ. Гэвч гэмшсэн, цөхөрсөн хүний залбирлыг ямагт сонсч,

хүлээж авна. Гэхдээ Бурханы тааллыг бид өөрийн гавъяа зүтгэлээр олж авч чадахгүй. Зөвхөн Есүс Христийн гавъяа зүтгэл, Түүний пус биднийг ариусгах билээ.

Итгэл бишрэл бол хичээнгүйлэн мөргөхийн бас нэг нөхцөл юм. “Бурхан руу ирж ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” (Еврей 11:6) Есүс шавь нартаа “Та нар юуны төлөө залбирч, гуйж байна, түүнийгээ авсан гэдэгтээ итгэгтүн. Тэгвэл тэр чинь ёсоор болно” гэж айлджээ. (Марк 11:24). Тэгвэл бид Түүний айлдварт итгэдэгсэн бил үү?

Христийн энэ батлан хэлсэн үгэнд зааг хязгаар байхгүй. Тэрээр Өөрийн амлалтанд үнэнч байдаг. Бид гуйснаа тэр даруйд нь авч үл чадавч Эзэн тэнгэр биднийг сонсч залбиралд маань хариу өгнө гэдэгт итгэх ёстой. Бид хүсэж мөрөөдөхдөө алдаж эндэх маань их, бас алсын хараатай байж чаддаггүйгээс заримдаа өөртөө гай тарих зүйлийг ч гуйх удаа бий. Тэнгэрийн Эцэг үүнийг мэднэ, тэгээд ч бидний залбиралд хариу өгөхдөө бидний сайн сайхны төлөө үйлчлэх зүйлсийг, өөрөөр хэлбэл хэрэв бидний билгийн хараа хурц, төгс гэгээрсэн бол гуйх байсан тэдгээр зүйлсийг өгдөг юм. Бидний залбиралд хариу өгөхгүй байна гэж бодогдох үед ч гэсэн хамаагүй бид Бурханы буян хишигт найдах ёстой. Цаг нь болоход хариу заавал ирнэ, бид юу юунаас илүү үгүйлээд байгаа ерөөл соёрхлыг хүлээж авахаа л авна. Гэвч бид чухам тийм цагт, хүссэн маягаараа хариу авна гэвэл биедээ хэт найдсан хэрэг болох юм. Бурхан алдаа гаргахааргүй мэргэн. Тэр Өөрийг нь эрж хайж байгаа хүнийг зөнд нь орхихгүй өгөөмөр, тиймээс ч та нарын залбиралд хариу өгөөгүй байлаа ч гэсэн “Гуй, Тэгвэл та нарт өгнө” гэсэн амлалтад нь найдацгаа (Матай 7:7).

Хэрэв бид өөрсдийн эргэлзээ, айдсын нөлөөнд автаж, хязгаарлагдмал оюун ухаанаараа юм бүхнийг ойлгож тайлбарлах гэж оролдох аваас бидний бэрхшээл улам

нэмэгдэж гүнзгийрнэ. Гэхдээ бид арчаагүй, хараат (үнэндээ ч тийм л шүү дээ) гэдгээ ухамсарлан Бурханд ойртож, хязгааргүй оюун ухаант, Өөрийнхөө бүтээсэн бүхнийг харж, Өөрийнхөө хүсэл, айлдвараар хамаг юмыг удирддаг Түүний өмнө номхон хүлцэнгүй, чин сүсгээр гачаал зовлонгоо нээж хэлэх юм бол, Тэр бидний мөргөлийг сонсч, Өөрийн гэрэл гэгээгээр бидний сэтгэл зүрхийг гийгүүлнэ. Бид чин сэтгэлээсээ залбирч, хэмжээлшгүй Нэгэний оюун ухаантай ойртон нийлнэ. Тэр үед Цагаатгагч маань биднийг хайрлан өрөвдөж, дээрээс маань тонгойж байгаа гэдгийг батлах илэрхийх баримт бидэнд байхгүй ч байж болох юм. Чухамдаа бол тэгж буй. Түүний гар биенд маань яг хүрч байгаа нь мэдрэгдэгдэхгүй байж болох боловч хайр халамжийн гар нь бидний дээр дэлгээстэй байгаа нь лавтай.

Бид Бурханаас ерөөл, өршөөл гуйхдаа өөрсдөө уучлах, хайрлах сэтгэлээр дүүрэн байх ёстой. “Өр ширтэй улсаа бид уучилдаг шиг, өр шириг маань уучилж үз” (Матай 6:12) гэж мөргөсөн атлаа ойр дотныхоо хүмүүсийг уучлахгүй байж яаж болох билээ? Хэрэв Бурхан бидний залбирлыг сонсоно гэж хүсэн хүлээж байгаа бол бид өөрсдөө ямар маягаар, ямар хэмжээгээр уучлал үзэхийг хүснэв тийм л байдлаар бусдыг уучлах ёстой.

Хичээнгүйлэн залбирах нь гуйснаа авах чухал нөхцөл мөн. Бид сүсэг бишрэл, оюун санааны туршлагаа арвижуулахын тулд тасралтгүй залбирах ёстой. “Та нар тогтмол залбирч байцгаа, нойргүй сэрүүн байж талархан залбирцгаа” (Колоссай 4:2; Ром 12:12) Сургаал номлогч Петр: “Та нар хэрсүү байцгаа, сэргэг ухаанаар мөргөцгөө” (1 Петр 4:7) хэмээн итгэгчдэд сэнхрүүлэн айлджээ. Сургаал номлогч Паул сургамжилсан нь: “Үргэлж залбирч талархалтайяа гуйж байж өөрийн хүслийг Бурханы өмнө нээцгээ” (Филип 4:6) Сургаал номлогч Иуда “Ариун Сүнсээр залбиран... Бурханы хайран дотор өөрийгөө сахь” хэмээн бичжээ. (Иуда 20-21) Тасралтгүй мөргөл бол

бидний сэтгэлийг Бурхантай холбосон бат бэх холбоо мөн бөгөөд Түүний ачаар Бурханаас амь ирж бидний амьдралд шингэн, бид өөрийн амьдралын цэвэр тунгалаг, ариун гэгээн чанараар Түүнийг баярлуулдаг билээ.

Мөргөл залбиралд ямар ч саад тотгор учруулахгүй байх нь чухал. Есүстэй харилцах харилцааг бүрэн дүүрэн, баяр баясгалантай болгохын тулд хамаг хүчин чармайлтаа дайчлагтун! Бурхантай харилцъя гэж үнэнхүү эрмэлзэж байгаа хүмүүс мөргөлийн хуралд очиж өөрийн үүргийг чин сэтгэлээсээ биелүүлж болно. Тэд амлагдсан бүх ерөөл айлдварыг хүлээн авч, тэнгэрийн гэрлийн туяа сэтгэл зүрхийг нь гийгүүлэх тэр газарт очих аливаа боломжийг ашиглах хүсэл эрмэлзэл дүүрэн байх бөлгөө.

Бид гэр орныхныхоо дунд залбирах ёстой, гэвч юун түрүүнд ганцаараа мөргөх ёстойг бас мартаж болохгүй. Тэр залбиралд сэтгэлийн гүнд орших нууц бий. Ганцаарчилсан залбирлыг огоорвол буян хишгийн өлгий дотор өсөн бэхжиж чадахгүй. Зөвхөн гэр бүлийн буюу эсвэл олон нийтийн мөргөл хангалттай биш. Сэтгэл зүрхээ Бурханы бүхнийг харагч мэлмийн өмнө нээцгээе. Хүн амьтангүй газар үйлдэж буй залбирал зөвхөн Түүнд сонсогдох ёстой. Бурханаас өөр хэн ч нууцгай хүсэлтийг сонсох ёсгүй. Сүсэгтэн Бурхантай хоёулхнаа байхдаа гаднын нөлөө, хий хоосон сэтгэлийн догдлолоос ангид байдаг юм. Тэр тайван атлаа маш хичээнгүйгээр Бурханыг сүслэн гуйх болно. Нууцыг харж, сэтгэлийн гүнээс оргилсон залбирлыг сонсож буй Түүнээс ачтай сайхан нөлөө тасралтгүй сацрах болно. Ийм хүн цагаан цайлган итгэлээрээ Бурхантай харилцаж, Сатантай тэмцэх тэмцэлд бат түшигтэй байх дэмжлэг авахын тул Бурханы гэрлийн туяаг өөртөө шингээдэг юм. Бидний хүч Бурханы дотор орших амуй.

Ганцаарчлан залбирцгаа, өдөр тутмын ажил, явдлын үед ч залбирцгаа, Бурханы өмнө сэтгэл зүрхээ үе үе нээж байцгаа! Енох чухамхүү ийн “Бурхантай хамт явж байсан

юм”. Энэ нууцгай залбирал нь хүж сан шиг буян хишгийн хаан ширээ өөд суунаглана. Сэтгэл зүрх нь Бурхан дотор батажсан хүнийг Сатан дийлж чадахгүй.

Бурханд залбирахад ямар ч цаг, ямар ч газар зохимжтой. Чин үнэнээсээ залбирал үйлдэж сэтгэл зүрхээ нээхэд бидэнд юу ч саад болох учиргүй. Гудамжны шуугиан үймээн, олон хүний бужигнаан дунд ч эсвэл ердийнхөө ажил төрлийг хийж байхдаа ч бид Бурханд хандаж, Нехемиа Артаксеркс хаанд өөрийн хүсэлтийг илэрхийлэх яг тэр үедээ үйлдсэн шиг Түүний тусламж, зааврыг гуйж болно. Хаа ч гэсэн Бурхантай нягт холбоо тогтоож болно. Христ бидний сэтгэл зүрхэнд хүсч хүлээсэн тэнгэрийн зочны ёсоор морилон ирж, оршин байгаасай хэмээн бид зүрхнийхээ үүдийг Түүний өмнө үргэлж бэлэн нээлттэй байлгах ёстой.

Биднийг гэм зэмтэй, ялзарсан орчин хүрээлж байж болох юм. Тэглээ ч гэсэн бидэнд тэр орчны хортой муухай уураар амьсгалж байхын хэрэг огт байхгүй. Бидэнд тэнгэрийн цэнгэг агаарт амьдрах бололцоо байна шүү дээ. Бид чин сэтгэлээсээ Бурханд залбирч, элдэв атгаг муу санаанаас өөрсдийгөө хамгаалж болно. Бурханы нөлөөлөл, срөөл айлдварыг зүрх сэтгэлээрээ хүлээж авдаг хүмүүс илүү ариун орчинд амьдарч, Бурхантай байнга харилцах бололцоотой байх юм.

Бид Есүсийг улам сайн ойлгож мөнхийн оршихуйн үнэ цэнийг улам бүрэн дүүрэн төсөөлөх хэрэгтэй. «Ариун байдлын гоо сайхан» Бурханы хүүхдүүдийн сэтгэл зүрхнээ бялхах учиртай. Үүнд хүрэхийн тулд бид тэнгэрийн үнэний талаарх Бурханы гэгээрлийг эрж хайх ёстой.

Бидний сэтгэл зүрх Бурханы бидэнд айлдаад байгаа тэнгэрийн цэнгэг агаар өөд, дээш тэмүүлэх болтугай! Бид Бурханд маш ойртож болох бөгөөд ямар нэг санамсаргүй шалгалт сорилт болоход цэцэг навч нарны гэрлийг жамаараа шүтдэг шиг бидний бодол санаа Түүний зүг хандах болно.

Бурханы өмнө өөрийн баяр баясгалан, уйтгар гуниг, өөрийн гачаал зовлон, болгоомжлол түгшүүрээ нээж өгөгтүн! Та нар ингэснээрээ Түүнийг ядраахгүй, Түүнд төвөг удахгүй. Та нарын толгойн үсийг ширхэгчлэн тоолдог Бурхан өөрийн хүүхдүүдийн гаслан зовлонг анхаарахгүй өнгөрөх нь үгүй билээ. “Эзэн тэнгэр маш нигүүлсэнгүй бөгөөд өрөвдөнгүй”. (Иаков 5:11) Гуниг зовлонгоо ярихад Тэр бидэнтэй хамт шаналдаг билээ. Та нар зовоож түгшээж байгаа юм бүхнээ аваад Түүн рүү хүрч очоорой. Ямар ч ачаа Түүнд хүнддэхгүй. Тэр замбуулин хорвоог дааж орчлон ертөнцийг удирдаж байна шүү дээ! Бидний дотоод ертөнцтэй холбоотой бүх зүйлийг Тэр бас чухалчилж үздэг юм. Бидний амьдралын түүхэнд Түүний уншихын аргагүй болтол буруу зөрүү бичигдсэн нэг ч бүлэг байхгүй. Тэр бидэнд тусалж чадахааргүй тийм хүнд хэцүү эндүүрэл ташаарал байхгүй. Түүний хүүхдүүдийн хамгийн багад нь тохиолдож болох ямар ч гай зовлон, сэтгэлийг эмзэглүүлэх ямар ч түгшүүр, аливаа баяр баясгалан, чин сэтгэлийн залбирал бүхэн, бидний Тэнгэрийн Эцэгийн хараанд өртөхгүй байх нь үгүй. “Тэр сэтгэлээр шаналагсдыг анагааж уй гашуугий нь эмчилдэг” (Дуулал 147:3) Бурхан хийгээд хүн бүрийн хоорондох харилцаа маш тодорхой бүрэн дүүрэн байдаг бөгөөд тухайн хүн Тэнгэрийн Эцэгийн халамжилдаг, түүний төлөө Өөрийнхөө Хүүг зориулсан газар дээрх ганц хүү шиг нь л санагддаг.

Есүс “Та нар Миний нэрээр гуйх болно. Би та нарын өмнөөс Эцэгээсээ гуйна гэж байгаа юм биш. Учир нь Эцэг Өөрөө та нарыг хайрладаг”, “Би та нарыг сонгосон... Миний нэрээр та нар Эцэгээс юу ч гуйсан Тэр та нарт өгөх юм» хэмээн айлджээ. (Иохан 16:26-27; 15:16) Гэхдээ Есүсийн нэрээр залбирна гэдэг нь Түүний нэрийг залбирлын эхэнд болон төгсгөлд зүгээр нэг дурьдаад өнгөрнө гэсэн үг биш. Энэ нь Есүсийн амлалтанд итгэж, буян хишигт нь найдаж, Түүний үйл

хэргийг биелүүлж, хүсэл зориг, үзэл санааны нь дагуу залбирна гэсэн үг юм.

Бид лам юм уу эсвэл даяанч болоод өөрсдийгөө Бурханы албанд зүтгүүлэх зорилгоор хүн амьтнаас холдож хөндийрөхийг Тэр шаарддаггүй юм. Бид Христийн амьдарч байсан шиг л ажил үйлс, мөргөл залбирлаар амьдрах хэрэгтэй. Мөргөлөөс өөр юу ч хийдэггүй хүн төдхөн мөргөхөө болино, эсвэл мөргөл нь ердийн нэг дадал зуршил болно. Хүмүүс нийгмийн амьдрал, Христийн үүргээс болон загалмай зүүхээс зайлхийж өөрсдийнх нь төлөө цуцалтгүй хөдөлмөрлөж байсан Их Эзэний төлөө хичээнгүйлэн хөдөлмөрлөхөө болихын цагт тэдэнд залбираад байх өөр юм байхгүй болно. Амь биеэ зориулах хүсэл эрмэлзэл ч үгүй болно Тэдний мөргөл хувиа хичээсэн шинжтэй болж өөрсөд дээр нь л төвлөрнө. Тэд хүн төрөлхтний төлөө Христийн хаанчлалыг цогцлон бүтээхийн төлөө, Түүнд хүчин зүтгэх хүч чадал олж авахын төлөө залбирах тэнхэлгүй болно.

Бид Бурханы төлөө хүчин зүтгэх үйлсэд бие биеэ дэмжиж зоригжуулахын тулд хамтдаа байх боломжийг ойшоохгүй байгаагаас их зүйл алдаж байна. Түүний Айлдварын чин үнэний хүч нөлөө, ач холбогдол алдагдаж байна. Тэрхүү чин үнэн биднийг гэгээрүүлэн, бидний сэтгэл зүрхийг гийгүүлэхээ больж, бид оюун санааны хувьд мөхөж байна. Бид бие биеэ өрөвдөж хайрлахгүй байгаагаас маш их юм алдаж байна. Христэд итгэгчид зожигроод Бурханы даалгасан үйл хэргийг биелүүлэхгүй байна. Тэгвэл Христэд итгэгчдийн бусдыг хайрлах зөвт хүмүүжил биднийг өрөөл бусдад өрөвч зөөлөн, анхааралтай ханддаг болгож, Бурханд хүчин зүтгэх үйлсэд биднийг хатуужуулах юм.

Хэрэв Христэд итгэгчид бүгдээрээ нэгдэн нийлээд Бурханы хайр энэрлийн тухай, цагаатгалын эрхэм үнэний тухай бие биедээ ярих юм бол тэд өөрсдөө оюун санааны хувьд бэхжиж, бусдад сайнаар нөлөөлж чадахсан билээ.

Бид Тэнгэрлэг Эцэгийн буян хишгийн өлгийд амьдралын шинэ туршлага сууж, өдөр ирэх тутам Түүний тухай улам их зүйлийг мэдэж авч чадна. Энэ нь Түүний хайр энэрлийн тухай ярих хүслийг бидэнд төрүүлэх юм. Ингэж чадваас бидний сэтгэл зүрх бүлээцэж, цог золбоотой болно. Хэрэв бид Есүсийн тухай их, өөрсдийнхөө тухай бага бодож, ярих аваас Түүний оршин буйг бүрэн дүүрэн мэдрэхсэн билээ.

Хэрэв бид Бурханы хайр халамжийн илрэлийг харах бүрдээ Түүнийг дурсдагсан бол бидний бодол санаа байнга Түүн дээр төвлөрч, бид Түүний тухай ярьж, Түүнийг алдаршуулан магтаж баяр баясгалантай байсан билээ. Бидэнд сонин учраас ахуй амьдралынхаа талаар ярьж хөөрөх нь нэн их. Бид анд нөхдөө хайрлаж, тэдэнтэйгээ зовлон жаргалаа хуваалцдаг болохоор тэднийхээ тухай мөн ярьцгаадаг. Гэвч бидэнд найз нөхдөөс илүүтэй Бурханыг хайрлан үзэх олон шалтгаан бий. Бурханы тухай бодож, Түүний буян хишгийн тухай ярьж, Түүний хүчин чадлын тухай өгүүлэх нь бидэнд хамгаас эрхэм байх ёстой. Бурхан бидэнд өгөөмөр хишиг хүртээхдээ, тэр нь бидний амь амьдралыг даагч Түүнийг умартгал бидний бодол санааг эргүүлж, сэтгэл зүрхийг эзэмдээсэй гэсэн хэрэг огт биш ээ. Харин ч биднийг баяжуулсан юм бүхэн Түүний тухай бидэнд байнга сануулж, тэнгэрийн хамаг сайн сайхныг Хүртээгч лүгээ биднийг хайр энэрэл, баяр талархлын хэлхээсээр холбож байх ёстой. Бид хорвоогийн явдлыг хэтэрхий их боддог. Бурханы суу алдрын гэрэл Христийн тэргүүнээс сацран буй тэнгэрийн ариун сүмийн нээлттэй үүд хаалгын зүг хараагаа чиглүүлцгээе. “Тэр Өөрөөр нь дамжуулан Бурханд ойртогсодыг бүрэн төгс аврах чадвартай” (Еврей 7:25).

Бид Бурханыг “Хайр энэрлийнх нь төлөө, Хүний хөвгүүдэд үйлдсэн гайхамшгуудынх нь төлөө” алдаршуулан дуулна. (Дуулал 107:8) Бидний мөргөлийн амьдрал дан ганц хүсэлт гуйлт, түүнийхээ хариуг хүлээх

явдлаар хязгаарлагдах ёсгүй. Бид зөвхөн өөрсдийнхөө гачаал зовлонг бодоод, Бурханы хайрлаж буй буян хишгээ умартаж болохгүй шүү дээ. Бид яасан цөөхөн залбирч, талархлын үгийг яасан ядмаг хэлж байна вэ! Бурханы ивээлийг өдөр бүхэн хүртэж байж бид хичнээн талархалгүй хандана вэ! Бидний тусын тулд хийсэн бүхнийх нь төлөө Түүнийг яасан бага өргөмжлөн алдаршуулна вэ!

Эрт урьдын цагт Израйлчууд Бурханд хүчин зүтгэхээр цугларахад Тэр “Та нар Эзэн Бурханыхаа өмнө тэндээ хооллож, гараараа хийсэн бүхнийг чинь чиний Бурхан Эзэн ивээсэн учраас гэр хотлоороо наргиж цэнгэцгээ” (Дэд хууль 12:7) хэмээн айлдсан гэдэг. Бурханы суу алдрын төлөө бүх зүйлийг гуньж гутралгүй, баяр баясгалантай, дуу хууртай хийх ёстой.

Бидний Бурхан бол хайр халамжит, нигүүлсэнгүй сэтгэлт Эцэг мөн. Түүний төлөө хүчин зүтгэх явдал хүнд хүчир, гуниг зовлонтой үйл байх ёсгүй. Залбиран мөргөж, Түүний үйл хэрэгт хүчин зүтгэхүй нь бидний сэтгэлийг үнэнхүү хангаж чадах юм. Бурхан авралын аугаа их гавъяа зүтгэлээ зориулсан Түүний хүүхдүүд, Түүн лүгээ шаардангуй, ширүүн захирагч мэтээр харьцахыг хүсэхгүй байсан билээ. Бурхан-бидний хамгийн сайн Нөхөр. Биднийг мөргөл үйлдэхээр цугларахад, Тэр бидэнтэй хамт байж, биднийг ерөөж, тайтгаруулж, бидний сэтгэл зүрхийг баяр баясгалан, хайр энэрлээр бялхуулдаг. Их Эзэн Өөрт нь хүчин зүтгэх явдал Өөрийнх нь хүүхдүүдэд хүнд дарамт бүү болоосой, харин ч тэднийг цэнгүүлж тайтгаруулж байгаасай гэж хүсдэг юм. Эзэн тэнгэр Өөрт нь залбирахаар сүмд ирэгсэд Бурханы хайр халамжийн тухай нандин сайхан бодол санаа өвөрлөж буцаасай, тэд энэ харилцаанаас өдөр тутмынхаа ажил хөдөлмөрт цог золбоо, хүч чадал сэлбэж аваасай, тэд Өөрийнх нь буян хишгийг хүртээд юм бүхэн дээр үнэнч шудрага байгаасай гэж хүсдэг юм.

Бид загалмайн хөлд эвлэлдэн нэгдэх ёстой. Тэлэгдэн хадагдсан Христ бидний эргэцүүлэл, ярилцлагын сэдэв, хамгийн нандин баясгалант сэтгэлийн эх сурвалж болох ёстой. Бид Бурханы ерөөл айлдварыг санаж явах хэрэгтэй. Бид Түүний хязгааргүй хайр энэрлийг ухамсарласан цагт бидний төлөө загалмайд тэлэгдэн хадагдсан тэр хоёр гарт хамаг бүхнээ дуртайяа өргөн барих болно.

Их Эзэнтэй ийн харилцаа тогтоовол хүн магтаалын жигүүрээр тэнгэрт дүүлэн хөөрнө. Тэнгэрийн орноо суугчид Бурханд дуу хөгжим, эгшиг аялгуутайгаар мөргөдөг юм. Сэтгэл зүрхнийхээ угаас Түүнд талархал илэрхийлэх үед бидний мөргөл тэнгэрийн хүчнийхний хичээл зүтгэлтэй улам бүр адил төстэй болно. “Магтаалын тахил өргөгч хүн Бурханыг хүндэтгэнэ” (Дуулал 50:23) Түүний өмнө ариун нандин баяр баясгалантай байцгаая. “Талархал, дуу хуур өргөж” Түүнд мөргөцгөөс! (Исаиа 51:3)

ЭРГЭЛЗЭХҮЙ

Христийн амьдралд хөл тавиад удаагүй олон хүнд Эргэлзэн тээнэгэлзэх явдал их байдаг. Библид тэдний ойлгож, тайлбарлаж чадахгүй зүйл нилээд бий. Сатан түүнийг нь ашиглан Ариун Библид итгэх итгэлийг нь алдагдуулах гэж оролддог байна. Тийм хүмүүс “Би зөв замыг яаж олох вэ? Хэрэв Библи үнэхээр л Бурханы Айлдвар мөн юм бол би эргэлзээ тээнэгэлзээ, шаналган зовоож байгаа бодол санаанаасаа хэрхэн ангижрах вэ?” гэж асуудаг.

Бурхан бидний итгэл бишрэлийг нотлохын тулд хангалттай баталгааг гаргаж өгөөгүйсэн бол биднийг Өөртөө итгээч гэж хэзээ ч хүсэхгүйсэн билээ. Түүний оршихуй, Түүний зан төрх, Түүний Айлдварын үнэн мөн чанар нь бидний ой ухаанд хоногшсон гэрчлэлүүдэд үндэслэсэн байдаг бөгөөд тийм гэрчлэлүүд хангалттай буй. Гэхдээ Бурхан эргэлзэх зүйл бий гэдгийг үгүйсгэдэггүй юм. Бидний итгэл баталгаанд үндэслэсэн байх ёстой, гэхдээ тийм баталгаа нь ямар нэгэн онцгой үзэгдэл байх огтхон ч албагүй. Эргэлзээг эрэлхийлэгчид шалтаг олж хэзээ ч чадна, гэхдээ чин үнэнийг мэдэхсэн гэж чухамхүү хүсч байгаа хүмүүс л өөрийнхөө итгэл бишрэлд үндэслэж болох хангалттай баталгаа олж чадна.

Бидний явцуу ухаан цаглашгүй Бурханы зан байдал, үйл хэргийг бүрэн ухаарч чадахгүй. Хамгийн мэргэн ухаантай, эрдэм боловсролтой хүнд ч энэхүү Ариун Нэгэн тайлагдашгүй нууц хэвээр байх болно. “Чи судалснаараа Бурханы гүнийг олж чадах уу? Эсвэл чи Төгс Хүчит Нэгэний хязгаарыг олж чадах уу? Тэдгээр нь тэнгэрээс ч өндөр. Чи юу хийж чадах юм бэ? Тэдгээр нь үхэгсдийн орноос ч гүн. Чи юу мэдэж чадах юм бэ?” (Иов 11:7-8).

Сургаал номлогч Паул “Аяа, Бурханы мэргэн ухаан болон мэдлэгийн баялаг нь ямар гүн гүнзгий вэ! Түүний

шүүлтүүд нь ямар ухаарагдашгүй, Түүний замууд нь ямар олж илрүүлшгүй вэ?” хэмээн дуу алджээ. (Ром 11:33). Гэхдээ “Үүлс ба түнэр харанхуй Түүнийг хүрээлдэг. Зөв шудрага ба шудрага ёс бол Түүний сэнтийний суурь юм” гэсэн үг бас буй. (Дуулал 97:2) Түүний хайр халамж, түүний удирдлага болгодог сэдэл санааг эргэцүүлэн бодоод бид Түүний хязгааргүй хүчин чадалтай холбогдсон цаглашгүй хайр хишгийг ойлгож болно. Бид түүний хүсэл санааг бидний сайн сайханд хэрэг болох хэмжээгээр л ойлгож чадна. Бусад бүх зүйлийг бид энэрэл хайраар биднийг тэтгэгч Аугаа хүчит Бурханы гарт даатган үлдээх ёстой.

Бурханы Айлдвар түүний Тэнгэрлиг зохиогчийн зан байдалтай адил хүмүүст хэзээ ч бүрэн тайлж үл чадах гүн нууцыг агуулдаг юм. Хорвоод нүгэл хилэнц буй болсон, Христ дахин амилсан зэрэг Библид бичсэн олон зүйл бол хүний ухаан ойлгож тайлбарлахын аргагүй нууц юм. Гэхдээ бид Бурханы сургаал үгийг эцэст нь тултал ойлгож чадахгүй байна гээд тэр сургаалд эргэлзэх учиргүй. Эх байгальд ч бид эцэст нь хүртэл ойлгож үл чадах өдий төдий нууц зүйлтэй үргэлж тааралдаж байдаг. Амьдралын хамгийн энгийн тохиолдолд ч гэсэн бидний ой ухаанаараа тайлж, ойлгохын аргагүй оньсого таавар тааралддаг. Бид газар сайгүй бидний ойлголтоос хавьгүй давж гарсан гайхамшигт үзэгдлүүдийг харсаар байна. Иймээс оюун санааны ерөнцөд бидний тайлбарлаж чадахгүй нууц бас бий гэдэгт бид гайхах ёстой гэж үү? Хүний оюун ухаан сул бөгөөд хаязгаарлагдмал гэдэгт л хамаг нарийн учир нь байгаа юм. Ариун Библид өөрийнхөө Тэнгэрлиг гарлыг нотолсон зүйл хангалттай бий. Бид түүний бүх нууцыг тайлж чадахгүй байна гээд түүний Айлдварт эргэлзэх ёсгүй. Сургаал номлогч Петр Библид “...ойлгоход хэцүү зарим зүйлс байдаг бөгөөд харанхуй, мунхаг туйлбаргүй хүмүүс өөрсдийгөө

сүйрүүлэн судрын бусад зүйлсийг ч гуйвуулдаг шигээ тэдгээрийг мөшгин гуйвуулдаг” (2 Петр 3:16) гэжээ.

Өөрөөр хэлбэл, орчин цагийн хэллэгээр “гажуудуулан буруутгадаг” байна. Хэрэв Библид бидний ойлгох энгийн зүйлийг л бичсэнсэн бол, хэрэв эгэл хүний мулгуу ухаанаар Түүний сүр хүчин, далд нууцыг ойлгохсон бол Бурханы үнэнхүү айлдвар мөн гэдэгт эргэлзэж болох юм.

Библи сударт чин үнэнийг энгийн үгээр нээж тайлбарладаг нь хүний сэтгэл зүрхний эрэлт хэрэгцээнд бүрэн нийцэж хамгийн боловсорсон оюунтаныг ч бишрүүлэн дагуулдаг юм. Библиэс хамгийн номхон хүлцэнгүй, эрдэм боловсролгүй хүмүүс ч авралынхаа замыг олж авна. Библийн энгийн үгс бидэнд хүний ойлгож ухаарах түвшингээс хэтэрсэн гүнзгий, бадрангуй, цаглашгүй үнэний тухай өгүүлнэм бөгөөд тэрхүү үнэнийг Бурхан Өөрөө нээсэн учраас л бид хүлээн авч чадаж байна. Бурханы авралын төлөвлөгөө маш тодорхой. Бурханы өмнө нүглээ наманчлах, Христэд итгэх нь авралын цорын ганц зам болон бидэнд нээгдэж байна. Гэхдээ эдгээр үнэн ойлгомжтой хэдий боловч цаана нь Бурханы суу алдрын нууц агуулагдаж байгаа юм. Тэрхүү нууц нь хүний оюун ухаанаар тайлагдашгүй боловч чин үнэнийг уйгагүй эрэн сурвалжлагчийг итгэл хийгээд соёрголоор бялхуулах бөлгөө. Тэрээр Библийг хичнээн их судлах тусам тэр ном амьд Бурханы айлдвар мөн бөгөөд хүний оюун ухаан Бурханы илчлэлийн суу алдарын өмнө бөхөлзөнө гэдэгт итгэх итгэл нь улам бүр гүнзгийрнэ.

Библийн аугаа их үнэнийг бүрэн ойлгох чадваргүйгээ ухаарахын хамт бидний явцуу оюун ухаан Мөнхийн зүйлийг мэдрэхэд хүчин мөхөсдөж, бүхнийг хөтлөгч Бурханы санаа бодлыг хүн хязгаарлагдмал мэдлэгээр тайлж чадахгүй гэдгээ хүлээн зөвшөөрөхөд хүрдэг юм.

Туйлшран эргэлзэгчид, бурхангүйчүүд Бурханы айлдварын бүх нууцыг тайлж чадахгүйдээ түүнийг үгүйсгэдэг юм. Гэхдээ Библид итгэдэг гэж ярьдаг хүн бүхэн энэ аюулаас ангид байдаггүй. Сургаал номлогч: “Ах дүү нар аа, та нарын дотроос хэн нэгэн нь бузар, итгэлгүй зүрхтэй байж Амьд Бурханаас салах вий гэдгээс болгоомжлогтун” (Еврей 3:12) хэмээн бичжээ. Хүн Библийн сургаалыг нарийвчлан судалж, Бурханд ойртохын хэрээр Түүний “гүн юмсад” нэвтэрч буй нь сайн хэрэг. (1 Коринт 2:10) Энд харин “Нууц зүйлс нь бидний Бурхан Эзэнд хамаарах бөгөөд, илэрч мэдэгдсэн зүйл нь бидэнд хамаарах” болой. (Дэд хууль 29:29)

Сатан хүний оюун ухааны шинжлэн судлах чадварыг сулруулахыг эрмэлздэг. Зарим хүн Библийн зүйл бүхнийг хангалттай тайлбарлаж, Бадрангуй сайхан үгсийг ойлгож чадахгүй болохоороо ундууцаж эгдүүцдэг. Бадрангуй сайхан үгсийг ойлгох чадваргүй гэдгээ зөвшөөрөн хүлээх нь тэдэнд маш ичгүүртэй юм шиг санагддаг. Тэд Бурханы чин үнэнийг нээх болсон гэж үзэх цагийг тэсвэртэй хүлээхийг хүсэхгүй байгаа юм. Ийм хүмүүс Ариун Библийг бие даан ойлгох хангалттай ухаантай гэж өөрсдийгөө санадаг. Гэвч тэд энэ талаар амжилт олохгүй болохоороо Библийн нэр хүндийг унагааж эхэлдэг.

Олон онол, шашны сургаал Библиэс үндэслэгдсэн гэдэг боловч үнэн хэрэгтээ тэдгээр онол, сургаал нь Бурханы Ариун Библийн агуулгатай зөрчилдөж байдаг юм. Энэ нь олон хүнд эргэлзээ, гайхлыг төрүүлдэг. Гэхдээ үүнд Бурханы Айлдварын буруу гэж байхгүй, харин Ариун Библийг гутааж гуйвуулсан явдал буруутай юм.

Хэрвээ Бурханы бүтээсэн амьтай бүхэн Бурхан хийгээд Түүний үйл хэргийг бүрэн ойлгосон бол мэдлэгээ тэлэн, сэтгэл оюунаа хөгжүүлж, чин үнэнийг улам бүр ухаарах гэхийн хэрэг огт үгүй байхсан билээ. Бурхан эрхэм дээд Нэгэн байхаа болиод, харин хүн мэдлэг, ололт

нь туйлдаа хүрээд цаашид хөгжих чадваргүй болохсон биз ээ. Ийм болоогүйд нь Бурханд талархацгаая.

Тэр хязгааргүй аугаа. “Түүнд мэргэн ухаан, мэдлэг боловсролын хамаг эрдэнэс бий”. (Колоссай 2:3) Хүмүүс насан туршдаа Түүний мэргэн ухаан, буян хишиг, хүчин чадлын эрдэнэсийг танин мэдэж, сурч судлах болно, гэхдээ хэзээ ч шавхаж чадахгүй.

Бурхан Өөрийнхөө Айлдварын чин үнэнийг ард олондоо яг одоо, энэ насанд нь нээгдээсэй гэж хүсдэг юм. Ийн танин мэдэхүйд ганцхан замаар л хүрч болно. Энэ нь Ариун Сүнсээр дамжуулан, гэгээрэх зам болой. “Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч мэддэггүй” “Сүнс бүх зүйлийг, тэр байтугай Бурханы гүн юмсыг ч гэсэн нэвтэлдэг ажгуу” (1 Коринт 2:11, 10) Аврагч Өөрийнхөө дагалдагчдад “Үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн рүү удирдана... Тэр Минийхийг авч, түүнийгээ та нарт мэдүүлнэ” хэмээн амалсан билээ. (Иохан 16:13,14)

Бурхан хүн өөрийнхөө оюун ухааны чадварыг хөгжүүлээсэй гэж хүсдэг. Библийг судлах нь өөр ямар ч хичээл сургуулиас илүү бидний оюун ухааныг бататган гүнзгийрүүлнэ. Гэхдээ бид оюун ухааныг Бурханчлан үзэж хэрхэвч болохгүй, учир нь хүний ухаан сул дорой, төгс төгөлдөр биш юм. Бурханы Айлдварыг, түүний хамгийн энгийн үнэнийг ч гэсэн зөв ойлгохын тулд бид бяцхан хүүхэд шиг итгэмтгий, цайлган байж, Ариун Сүнснээс суралцаж, тусламж гуйхад бэлэн байх ёстой. Бурханы хүч чадал, мэргэн ухааныг ухамсарлаж, мөн түүнчлэн Түүний сүр хүчийг мэдрэх тэнхэлгүй гэдгээ ойлгож байгаа маань биднийг номхон хүлцэнгүй болгох ёстой. Бид яг л Түүний дэргэд байгаа юм шиг, ариун бишрэлтэйгээр Түүний Айлдварыг нээх ёстой. Бид Библийг уншиж эхлэхдээ бидний дээр Эрхэм дээд Нэр төр бий гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Бидний оюун ухаан аугаа их «Би байдаг»-ийн өмнө бөхөлзөх ёстой.

Библид дээр өгүүлсэнчлэн ойлгож мэдэхэд хэцүү, тодорхой биш, зөвхөн Бурхан л ойлгох гэсэн хүнд нээж өгч чадах тийм зүйл нилээд бий. Бид Ариун Сүнсний удирдлагагүй бол Библийг гуйвуулж, буруу тайлбарлах аюулд ямагт нэрвэгдсээр байх болно. Зарим хүмүүс Библийг ашиггүй уншдаг, зарим тохиолдолд ерөөл залбиралгүй уншдаг учраас өөртөө хор хүргэх ч удаа бий. Хэрэв бодол сэтгэл нь Бурхан өөд эс чиглэж, Түүний хүсэл зоригтой үл нийцэх аваас уншигч эргэлзээ тээнэгэлзлээс ангижрахгүй. Ийм тохиолдолд Библийг уншвал үл итгэх үзлийг улам гүнзгийрүүлнэ. Хүний бодол сэтгэхүй муу сүнсний эрхшээлд орж, Библи уншигчийг буруу ойлгож тайлбарладаг болгоно. Хэрэв хүмүүс Бурхантай бүрэн эв зүйтэй байхыг эрмэлзэхгүй бол тэд хичнээн ч эрдэм боловсролтой байлаа гэсэн судрыг ойлгох талаар төөрөлдөх аюулд орно. Иймээс тэдний тайлбарт итгэх нь аюултай. Библиэс зөрчил эрдэг хүн нь билгийн хараа байхгүй хүн юм. Буруу зөрүү үзэлтэй хүн бодит байдлын энгийн бөгөөд тов тодорхой зүйлд эргэлзэх, үл итгэх олон шалтаг олдог байна.

Үүнийг яаж ч нуулаа гэсэн олонхи тохиолдолд үл итгэх, эргэлзэж тээнэгэлзэх явдлын жинхэнэ шалтгаан нь нүгэл хилэнцийг шохоорхох шохоорхол юм. Бурханы Айлдварын сургаал заавар, хэмжээ хязгаарыг нүгэлд дурлагч, бардам зүрх хийгээд Судрын шаардлагад захирагдахыг үл хүсэгч, Түүний нэр алдарт эргэлзэгчид хүлээн авдаггүй юм. Үнэнийг олохын тулд бид Түүнийг мэдэх, Түүнд захирагдах чин хүсэлтэй байх ёстой. Библийг ийм үзэл санаагаар судлаж эхэлж байгаа хүн бүхэн энэ судар бол Бурханы сургаал мөн гэдгийг гэрчлэх өдий төдий зүйлийг олж үзэх болно. Тэд аврагдахуйн ухааныг тэлэх Библийн үнэнийг ойлгож чадна.

Христ “Түүний хүсэл зоригийг биелүүлэхийг хүсэгч хүн энэ сургаал Бурханых уу, биш үү гэдгийг ойлгож мэдэх болно” (Иохан 7:17) хэмээн айлджээ. Библид

эргэлзэж, өөрийнхөө ойлгохгүй юмыг өөчлөхийн оронд та нарыг гийгүүлж байгаа гэрэл туяаг харцгаа, тэгвэл улам их гэрэл гэгээ та нар дээр тусна. Христийн буян хишгийн хүчээр та нар өөрсдийнхөө ойлгож авсан үүрэг бүхнийг биелүүлж, эргэлзэж байгаа зүйлээ ойлгож улмаар биелүүлэх чадвартай болно.

Эрдэм боловсролтой, эгэл жирийн ямар ч хүмүүст ойлгомжтой нэг баталгаа бий. Энэ бол хувийн туршлагын гэрчлэл юм. Бурхан Өөрийнхөө Айлдварын жинхэнэ чанар хийгээд Өөрийнхөө амлалтын үнэн мөнийг өөрсдөө шалгаж үзэцгээ хэмээн бидэнд санал болгож байна. Бурхан: “Эзэн тэнгэр хичнээн ачтайг амталж, мэдэрч, харцгаа” хэмээн биднийг уриалж байна. (Дуулал 34:8). Бид бусдын үгэнд найдалгүй, өөрсдөө амталж үнэмших хэрэгтэй. Тэр: “Та нар хэрэв гуйвал, гуйснаа авах болно” гэж амлаж байна. (Иохан 16:24). Аврагч хэлсэн үгэндээ ямагт эзэн болсоор ирсэн билээ. Түүний амлалт биелэгдэнэ. Түүнд итгэсэн хүмүүс хууртаж байсан удаагүй. Бид Есүст ойртож, Түүний аугаа их хайр энэрлийг амсахад бидний эргэлзээ, сэтгэлийн бараан сүүдэр Түүний оршихуйн гэрэл гэгээнд уусан замхардаг билээ.

Сургаал номлогч Паул Бурхан “биднийг харанхуйн эрх мэдлээс авраад, Өөрийн хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн юм” хэмээн бичжээ. (Колоссай 1:13) Үхлээс амьдралд дэвшиж ирсэн хүн “үүгээр Бурхан үнэн гэдгийг нотолсон” (Иохан 3:33) Тэр ийн гэрчилж чадна: “Надад тусламж хэрэгтэй байсан би түүнийг Есүс дотор олж авсан. Их Эзэн миний бүх гачигдлыг хангаж сэтгэлийн минь цангааг тайлсан. Одоо миний хувьд Библи нь Есүс Христийн илчлэл мөн. Та нар намайг яагаад Есүст итгэсэн бэ гэж асууж байна. Яагаад гэвэл Тэр миний Тэнгэрлиг Аврагч. Яагаад би Библид итгэдэг вэ? Би Библийг миний сэтгэл зүрхэнд хандсан Бурханы дуу хоолой мөн гэдгийг ойлгосон. Бид өөрсдөөсөө Библи - үнэн, Христ - Бурханы

Хүү гэдгийн нотолгоог олж чадна. Бид тусгай боловсруулсан худал хуурмаг үлгэр домогт итгээгүй гэдгээ мэднэ”.

Сургаал номлогч Петр ах дүү нараа “Бидний Эзэн бөгөөд аврагч Есүс Христийн нигүүлсэл болон мэдлэг дотор өсөгтүн” хэмээн уриалдаг.(2 Петр 3:18) Бурханы ард түмэн буян хишгийн өлгий дотор өсөж дэвшихдээ Түүний Айлдварыг улам гүнзгий ойлгож, Түүний ариун үнэний дотор шинэ гэрэл гэгээ, шинэ гоо сайхныг олж харах чадвартай болж байна. Сүмийн түүхийн бүхий л үеүдэд ийм л байсан, эцсийн эцэс хүртэл ийм л байх болно. “Харин шудрага зөв хүмүүсийн жим болбоос үүрийн гэгээ мэт агаад, Тэр нь өдрийг авчрах хүртэл улам тод гэрэлтсээр байх болно”. (Сургаалт үгс 4:18) Итгэл бишрэлээр бид ирээдүйг харж бидний ухаан, сэтгэлийн тэнхээ гэрэл гэгээний Эх сурвалж лугаа шууд, амьд холбоотой байж, улам улмаар хүч сэлбэнэ гэсэн Бурханы амлалтыг ойлгох болно. Тэр цагт Бурханы зөн билэг дотор биднийг шаналгаж байсан юм бүхэн тодорхой болж, ойлгоход бэрх юм бүхэн тайлагдаж, бид бүхэн баярлах болно. Бидний явцуухан ухаан зөвхөн биеллээгүй найдлага, шаналан зовлонг хардаг байсан тэр газарт бид төгс төгөлдөр эв зохицлыг олж харах болно. “Учир нь бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч , харин дараа нь нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ харин дараа нь би бүрэн мэдэх болно” (1 Коринт 13:12).

Их Эзэн доторх ба-р ба-сгалан

Бурханы үр хүүхдүүд Христийн төлөөлөгчид байх учиртай. Тэдний амьдрал их Эзэний нигүүлсэнгүй зөөлөн сэтгэлтэйг гэрчилнэ. Есүс бидэнд Эцэгийнхээ жинхэнэ зан байдлыг нээсэнтэй адил бид Христийн энхрий хайр, нинжин сэтгэлийг огт мэдэхгүй хүмүүст Түүнийг нээж өгөх ёстой. Есүс “Та Намайг ертөнц уруу илгээсний адил Би тэднийг мөн ертөнц уруу илгээв. Би тэдний дотор, Та Миний дотор байдаг. Ингэснээр тэд төгс нэгдэн, Таныг Намайг илгээснийг болон Намайг хайрласны адил тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно” хэмээн айлдсан нь буй. (Иохан 17:18,23). Сургаал номлогч Паул Есүсийн шавь нарт: “Та нар бол Христийн захиа хэмээн танигдсан билээ... Бүх хүнээр уншигдаж, мэдэгддэг захиа шүү дээ” гэж бичжээ. (2 Коринт 3:2-3). Есүс Өөрийн хүүхэд бүрээр төлөөлүүлж, энэ хорвоод захидал илгээж байгаа юм. Хэрэв та Христийн залгамжлагч мөн бол Тэр, танаар төлөөлүүлэн таны гэр бүл, таны бүх хөршүүдэд захидал илгээж байгаа юм. Таны дотор амьдарч буй Есүс Өөртэй нь хараахан танилцаагүй байгаа хүн бүхний бодол санааг ойлгохыг хүсдэг юм. Тэд Библийг уншдаггүй юм уу эсвэл судрын хуудаснаас тэдэнд хандаж буй Түүний дуу хоолойг сонсдоггүй байж болох юм. Тэд Түүний гараар бүтээсэн үйл хэргээр илэрч буй Бурханы хайрыг олж харахгүй байж болох юм. Гэвч хэрэв та Христийн үнэнч төлөөлөгч мөн бол тэдэнд Түүний нигүүлсэнгүй сэтгэлийг бага багаар ойлгуулж, Түүнийг хайрлах, Түүнд хүчин зүтгэх сонирхолыг төрүүлж болох юм.

Христийн мөргөлтөн нь тэнгэрт хүрэх замд гэрэл гэгээ түгээх бүрэн эрхт төлөөлөгч юм. Тэд Христээс авч

буй гэрэл гэгээгээр хорвоо дэлхийг гэрэлтүүлэх ёстой. Тэдний аж амьдрал, зан байдал хүн зонд Христ болон Түүний хүчин зүтгэлийн тухай зөв төсөөлөл өгөх ёстой.

Христийн жинхэнэ залгамжлагчид, Түүнд хүчин зүтгэх явдлыг тааламжтай болгодог, үнэн хэрэг дээрээ ч тийм л байдаг. Гуньж гутарч, үглэж гоморхож явдаг Христийн мөргөлтнүүд бусдад Бурхан ба Христийнхэний амьдралын тухай буруу төсөөлөл өгдөг юм. Тэд Бурханы хүүхдүүд аз жаргалтай байх нь Бурханы таалалд нийцдэггүй мэт сэтгэгдэл төрүүлдэг бөгөөд энэ нь бидний Тэнгэрийн Эцэгийн тухай хуурамч гэрчлэл болдог.

Сатан Бурханы хүүхдүүдийг сүсэггүй, цөхрөнгүй хэцүү байдалд оруулахдаа баярлан хөөрдөг. Сатан биднийг Бурханд үл итгэн, биднийг аврахад бэлэн байдаг Түүний хүчин чадалд нь эргэлзэхэд хорсон баярладаг. Бурханы зөн билэг бидэнд хор хүргэж байна гэж бидний бодоход тэр баярладаг. Сатан Бурханыг өршөөнгүй, нигүүлсэнгүй биш гэж бидэнд ойлгуулахын тулд юм бүхнийг хийдэг. Тэр үнэнийг гажуудуулж хүн зоныг Бурханы тухай хуурамч төсөөлөлтэй болгохыг санаархдаг. Харин бид Тэнгэрлиг үнэний тухай эргэцүүлэн бодохын оронд Сатаны хуурамч төсөөллийг байн байн сэтгэлдээ тунгааж, Бурханд үл итгэн, Түүнийг зүхэн гүнгэнэцгээж буйгаараа Бурханы нэр төрийг гутааж байгаа юм. Сатан ямар нэг аргаар шүтлэгтний амьдарлыг гутаахыг эрмэлзэж, тэр нь хүнд хэцүү байгаасай гэж хүсч байдаг. Хэрэв Христ шүтлэгтэн өөрийн амьдралаар шашин номын талаарх тийм төсөөллийг нотлох юм бол атаат дайсандаа тусалж буй хэрэг.

Олон хүн өөрсдийнхөө алдаа, дутагдал, гутрал, зовлонгийн тухай хэтэрхий их боддог. Тэдний зүрх сэтгэл гуниг, гутралаар дүүрэн байдаг. Намайг Европод байх үед зовж цөхөрсөн нэг эмэгтэй надад захиа бичиж, өөрийг нь тайтгаруулж, сэтгэлийг нь сэргээж өгөхийг надаас гуйж билээ. Түүний захидлыг авсан тэр шөнө би

зүүдэллээ. Би цэцэрлэгт байж байх юм. Эзэн нь бололтой нэг хүн намайг цэцэрлэгийн жимээр хөтөлж явна. Би цэцэг зулгааж, анхилуун сайхан үнэрт нь мансуурч байтал нөгөө эмэгтэй явахад нь саад болоод байсан өргөсийг хараач гэж байх юм. Тэр эмэгтэй үглээд л, гүнгэнээд л тэгснээ тэр цэцэрлэгийн жимээр хөтчийг дагасангүй, харин өргөст ургамлын дундуур орж явчлаа. “Энэ сайхан цэцэрлэг өргөст ургамлаар дүүрсэн нь даанч тоогүй ээ” гэж тэр эмэгтэй гансран өгүүлнэ. Тэгэхэд нь хөтөч түүнд: “Та наад өргөст ургамлаа орхиоч. Сарнай, сараана, лиш цэцгийг түү л дээ” гэж хэлж билээ.

Таны зүрх Бурханы Ариун Сүнсний нөлөөгөөр хөөрөн цохилж байх үед таны амьдралд саруул сайхан, баяр баясгалант агшин байгаагүй гэж үү? Өнгөрснөө эргэн харж, үзэж өнгөрүүлснээ дурсан санахад танд ямар нэг тааламжтай сэтгэгдэл төрөхгүй байна уу? Бурханы амлалтууд анхилуун цэцэг мэт замын чинь хажуугаар ургахгүй байна гэж үү? Түүний гоо сайхан, анхилуун үнэр нь сэтгэл зүрхийг тань баярлуулахыг та нар эс хүснэ үү?

Өргөс, чичүүр таныг ердөө л шархлуулж өвтгөнө! Хэрэв та нар зөвхөн өргөс, зангуу цуглуулж, түүнийг бусдад үзүүлж явах юм бол Бурханы сайн сайхныг үл ойшоож, амьдралын замаар явж буй хүмүүсийн замд саад тотгор учруулна.

Сэтгэлдээ өнгөрсөн үеийн эвгүй бараан дургал, нүгэл хилэнц, гутрал гунигийг хадгалж тэр тухайгаа дандаа л ярьж, харуусан үглэж, бүрмөсөн цөхрөх нь ухаалаг явдал биш ээ. Гуньж гутарсан хүн харанхуй манан дотор орж, тэр манан Бурханы гэрэл гэгээ сэтгэл зүрхэнд нь нэвтрэхэд саад болж, бусдын замд сүүдрээ тусгана.

Тэгэхийн оронд Бурхан та нарт саруул сайхан агшин бэлэглэсэнд талархал илэрхийлцгээ. Бурханы энэрэл хайрын бүхий л баталгааг сэтгэлдээ нэгтгэн зангидаж, байнга харцгааж байя. Эцгийнхээ хаан ширээг орхиж

Сатаны хүчнээс хүнийг аврахын тулд Бурханы Хүү бидний мөн чанарт Өөрийнхөө тэнгэрлиг чанарыг шингээснийг бодоцгооё. Хүн төрөлхтнийг Бурханы суу алдрын Хаанчлалыг сүсгээрээ үзэх боломжтой болгохын тулд, Түүний бидний төлөө хийгээд тэнгэрийг нээсэн ялалтын тухай бодоцгооё. Цөвтөж доройтсон хүн төрөлхтнийг санацгаая. Нүглээсээ болж мөхлийн ёроолгүй ангалдунаж, мөнхийн Бурхантай дахин эв эеэ ололцсон хүн төрөлхтнийг санацгаая. Цагаатгагчид итгэх итгэлээр Тэнгэрийн сорилтыг давсан хүн бүхэн Христийн зөвт ёсыг дагаж, Түүний хаан ширээг бишрэн бахархдагийг санацгаая. Энэ бол Бурхан биднийг эргэцүүлэн бодооч хэмээн урин залж буй тэрхүү үнэн юм.

Бурханы хайр энэрэлд эргэлзэж Түүний амлалтанд үл итгэснээрээ бид Түүнийг гутааж, Ариун Сүнсийг гомдооно. Эх хүн хүүхдүүдийнхээ төлөө санаа зовж, аз жаргалынх нь төлөө бүхий л хүчээрээ зүтгэж байхад хүүхдүүд нь та биднийг анхаарахгүй байна гэж хэлбэл эх хүн юу бодох вэ? Хэрэв хүүхдүүд нь хайртай гэдэгт нь эргэлзвэл эхийн зүрх эмзэглэнэ. Хэн ч гэсэн хүүхдүүд нь ингэж харьцвал ямар шуу бодолтой байх билээ дээ? Тэнгэрийн Эцэг маань Түүний энэрэл хайранд итгэхгүй байхад бидний тухай юу бодож болох вэ? Тэр хайр энэрэл нь биднийг мөнхийн амьтай болгохын тулд цорын ганц Хүүгээ үхүүлэхэд хүргэсэн шүү дээ. Сургаал номлогч: “Тэр Өөрийн Хүүгээ үл өршөөж, харин Түүнийг бид бүхний төлөө тушаасан юм. Тэгвэл Тэр яаж бүх юмыг Түүний хамт бидэнд сул өгөхгүй байх билээ?” хэмээн бичжээ. (Ром 8:32). Гэхдээ л тун олон хүн үгээр биш ч үйл хэргээрээ “Эзэн тэнгэр Түүнийг надад өгөөгүй. Магадгүй, Тэр бусдыг хайрлаж болох. Даанч намайг биш” хэмээн өгүүлсээр байна.

Энэ бүхэн бидний сэтгэлийг сэвтүүлэхээс цаашгүй, яагаад гэвэл эргэлзсэн үг болгон биднийг Сатаны хорлолд өртүүлж, итгэлийг мохоон, Тэнгэр элчүүдийг гомдоон

биднээс холдуулдаг. Тиймээс Сатан биднийг уруу татахад эргэлзэл, гунигийн нэг ч үгийг бүү дуугар. Хэрэв та нар Сатаны шивнэн ятгахыг сонсох юм бол ухаанд чинь үл итгэх, зэвүүцэх сэтгэл төрнө. Та нар энэ тухай бусдад яривал өөртөө хор хүргээд зогсохгүй бас эргэн тойрныхоо хүмүүсийн ухамсарт гашуун үр тарина. Тэр үр нахиалаад тэдний амьдралд гай болно. Та нарын үг тэдэнд засаршгүй, хөнөөлт нөлөө үзүүлж мэднэ. Та уруу татагдалгүй, Сатаны торноос мултарч болох юм. Гэхдээ таны нөлөөллөөр гуйвж дайвж байгаа хүмүүс таны төрүүлсэн эргэлзээ тээнэгэлзлээс ангижирч чадахгүй. Ийм учраас оюуны хүч, амь амьдралыг хайрлаж буй тэр зүйлийн тухай л ярих нь чухал.

Тэнгэр элчүүд та нарын хорвоо дэлхийд дэлгэрүүлж буй Их Эзэний тухай гэрчлэлийг анхааралтай сонсож байна. “Бидний төлөө Эцэгийн өмнө зуучлах гэж ямагт амьд байгаа” Түүний тухай илүү их ярьцгаая. Та анд нөхөртэйгөө гар барихдаа Бурханыг чин сэтгэлээсээ магтан дуулж байгаарай. Тэгвэл анд нөхрийн чинь бодол сэтгэл Есүст хандана.

Хүн бүхэнд л хүнд хэцүү сорилт шалгалт, гуниг зовлон, уруу татагдахаас аргагүй зугаа цэнгэл тохиолддог. Гуниг зовлонгоо эгэл жирийн хүмүүст битгий хэл, залбирлаар Бурханд л сонордуулагтун. Эргэлзсэн, гутарсан нэг ч үгийг хэзээ ч хэлэхгүй байхыг журам болгоцгоо. Таны найдвар, сайшаалын үгс өөр бусдын амьдралыг гийгүүлэн, хүч чадлыг нь сэлбэж, их зүйлийг хийж чадна.

Олхиогүй олон хүн уруу татагдаж цөхөрсөн байдаг. Тэд өөрийнхөө “би” хийгээд муу хүчинтэй тэмцэлдээд, бараг бууж өгөх шахдаг. Тийм хүмүүсийн хүнд хэцүү тэмцэлдээ ялж гарах итгэлийг нь бүү алдагдуул. Тэдэнд урам хайрласан итгэл найдвар төрүүлэхүйц үг хэл. Тэгвэл Христийн гэрэл гэгээ та нарын амьдралд сацран гийх болно. “Бидний хэн нь ч өөрийнхөө төлөө амьдардаггүй”.

(Ром 14:7). Санаанд маань ч ороогүй бидний нөлөө бусдыг сэргээн зоригжуулж чадна, эсвэл бүр сэтгэлээр унагаж, Христээс буюу үнэнээс холдуулж чадна.

Олон хүн Христийн зан байдал, аж амьдралын талаар буруу төсөөлөлтэй байдаг. Тэд Христийг өөдрөг сэтгэлгүй, догшин, гуниглангуй байсан гэж боддог. Тийм учраас зарим Христэд итгэгчдийн амьдрал хар бараан өнгөтэй байх нь олонтаа.

Есүс уйлдаг байсан, харин хэзээ нэгэн цагт инээмсэглэж байсан эсэхийг нь мэдэхгүй гэж ярьцгаах нь элбэг. Бидний Аврагч үнэхээр “Өвчин эмгэгт нэрвэгдсэн гуниг зовлонг хүн” байсан юм. Тэр сэтгэл зүрхээ хүн зоны бүхий л гуниг зовлонгийн төлөө нээн дэлгэсэн. Гэхдээ Түүний амьдрал биеэ огоорох явдал, гуниг зовлонгоор дүүрэн байсан хэдий ч Түүний ариун сүнс дарагдаагүй юм. Түүний нүүр царай уйтгар гунигтай юм уу, эсвэл сэтгэл дундуур байгааг илэрхийлдэггүй, харин дотоод дахь амар амгаланг гэрчилдэг билээ. Есүсийн сэтгэл зүрх амьдралын эх сурвалж байсан, Тэр очсон газар болгондоо энх амгалан, баяр баясгалан, аз жаргалыг ямагт хүргэдэг байсан.

Аврагч ямагт буурь суурьтай, чиглэсэн зорилготой байсан, тэгэхдээ хэзээ ч уйтгар, гунигтай байгаагүй. Тиймээс Түүний залгамжлагчид ч тодорхой зорилготой, хувийн хариуцлагаа гүнзгий ухамсарлан амьдрах болно. Хөнгөмсөг зан арилж, зэрлэг цэнгэл, элдэв муу наргиа үгүй болно. Есүс Христийн номлол дөлгөөн их гол мөрөн адил энх амгаланг авчирна. Энэ номлол баяр баясгалангийн гэрэл гэгээг унтраахгүй, хөөрсөн сэтгэлийг гонсойлгохгүй, мишээсэн тунгалаг нүүр царайг барайлгахгүй. Христ Өөрийнхөө төлөө бусдыг зүтгүүлээ гэж ирээгүй, харин бусдын төлөө зүтгэх гэж хүрч ирсэн. Хэрэв бидний зүрхэнд жинхэнэ хайр сэтгэл байгаа бол бид Түүний замаар замнана.

Хэрэв бид бусдын муу муухай, шудрага бус явдлын тухай үргэлж бодоод байх юм бол Христ биднийг хайрласан шиг тэднийг хайрлаж чадахгүй. Бидний бодол санаа Христийн гайхамшигт хайр, нигүүлсэнгүй сэтгэлд төвлөрсөн цагт бид ойр дотныхондоо мөн тийм үзэл санааг илэрхийлж чадна. Бид алдаа дутгадлыг нь үл харгалзан бие биеэ хайрлаж хүндэтгэх ёстой. Даруухан, хүлцэнгүй байж бусдын алдаа эндэгдэлд тэвчээртэй өршөөнгүй хандаж сурах хэрэгтэй. Энэ нь бидний хувиа бодох өчүүхэн бодлыг арилгаж, биднийг өгөөмөр сайхан сэтгэлтэй болгоно. Дуулалч “Эзэн тэнгэрт найд, буян үйлд, тэгвэл цагалан сайхан амьдарна” (Дуулал 37:3) хэмээн бичжээ. “Их Эзэнд итгэ”. Шинэ өдөр бүхэн л элдэв зүдгүүр, хүндрэл, бэрхшээл тохиолдоно. Бид уулзаж учрахдаа бие биетэйгээ юу юунаас илүү зовлон зүдгүүрээ л ярьдаг. Хэрэггүй хичнээн юманд бид сэтгэл түгшнэм бэ! Хичнээн их айдас, түгшүүр бидний амьдралыг түйвээнэм бэ! Түүнээс болж бид нигүүлсэнгүй сэтгэлт Аврагчийнхаа хараанаас гарах шахнам биш үү. Бидний ойр тойрны хүмүүс гуйлт хүсэлтийг маань сонсч, хүнд хэцүү үед тусламж илгээж чадах нигүүлсэнгүй хайрт Аврагч бидэнд байхгүй гэж бодож болох юм.

Зарим хүмүүс байнгын айдас түгшүүр, хөл үймээн дунд амьдардаг. Гэтэл тэд өдөр болгон Бурханы энэрэл хайрын илт баталгааг мэдэж, Түүний зөн билгийн арвин хишгийг хүртэж байдаг Түүний ерөөл буянг анзаардаггүй. Тэд хожим аюул тулгарах вий гэж элдэв муу юмыг байнга санаж, эсвэл чухамдаа ялимгүй бэрхшээл хүндрэлийг бодсоор байгаад харалган болж, Эзэн Тэнгэрт талархвал зохих олон юмыг олж харж чадахаа больдог байна. Тэдэнд тохиолдсон бэрхшээл зовлон тусламжийн цорын ганц Эх сурвалж Бурханд ойртуулдаггүй. Харин ч Түүнээс холдуулж сэтгэлий нь үймүүлэн түгшээдэг.

Бид ийм итгэлгүй байж болох уу? Бид яагаад ийм талархалгүй, найдлагагүй байна вэ? Есүс бидний хамгийн сайн Анд бөгөөд асар Тэнгэр бидэнд амар мэндийг хүсдэг шүү дээ! Бидний өдөр тутмын амьдралын үймээн түгшүүрт оюун сэтгэлээ уймруулахгүй байхыг хичээцгээе! Тэгэхгүй бол бидэнд эгдүүцэх, ундууцах шалтаг хэзээ ч мундахгүй. Бид сэтгэл шаналгаж зовоосон, сорилт шалгалтыг давахад огтхон ч тус болдоггүй тийм байдалд орох ёсгүй. Та ахуй амьдралдаа бүтэлгүйтэн, хохирол үзэж, ирээдүй чинь харанхуй, бүрхэг санагдаж болох юм. Гэвч сэтгэлээр бүү унагтун! Өөрийнхөө зовлонг Бурханд даатгаад тайван, сэргэлэн байцгаа! Өөрийн үйл хэргийг ухаалаг жолоодож, гай гамшгаас ангижрахын тулд Бурханаас цэцэн билгийг гуйцгаа. Нааштай сайн үр дүнд хүрэхийн тулд өөрсдөөсөө хамаарах бүхнийг хийцгээ. Есүс тусална гэж амласан, гэхдээ бид өөрийн зүгээс хүчин чармайлтаа гаргах ёстой. Хэрэв та нар үлэмж хүчит Туслэгчдаа бүрэн итгэж, чадах бүхнээ хийсэн бол ирээдүйн зүг зоригтой харж болно.

Бурханы хүсэл зориг Түүний хүүхдүүд гачаал зовлондоо нухлагдахыг тэвчдэггүй. Гэхдээ Эзэн тэнгэр биднийг хуурдаггүй. Тэр бидэнд: “Бүү ай, замд чинь аюул алга” гэж хэлдэггүй. Учир нь Тэр аюул осол ч бий, шалгалт сорилт ч бий гэдгийг мэддэг. Тэр энэ тухай бидэнд шууд хэлдэг. Бурхан Өөрийн хүмүүсийг нүгэл хилэнц, бузар бусармагийн ертөнцөөс заагладаггүй боловч бидэнд аюулгүй газрыг зааж өгдөг. Есүс шавь нарынхаа төлөө “Би Танаас тэднийг ертөнцөөс аваач гэж гуйхгүй, харин тэднийг муугаас хамгаалаач гэж гуйж байна” хэмээн залбираад (Иохан 17:15) “Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан” гэж айлдсан билээ. (Иохан 16:33).

Уулын номлолд Христ нь шавь нартаа Бурханд итгэхийн чухлыг сургажээ. Эдгээр сургаал нь Бурханы хүүхдүүдийг мөнхөд зоригжуулах зорилготой байсан

бөгөөд одоо ч гэсэн сургамж, тайтгарууллын увдис нь хэвээр байна. Есүс залгамжлагчиддаа: Тэнгэрийн шувуудыг харцгаа. “Шувууд тариа тарьж хураадаггүй” гэхдээ бидний Тэнгэрийн Эцэг тэднийг тэжээдэг хэмээн айлджээ. Тэгээд Аврагч “Та нар тэднээс илүү дээр үү?” хэмээн асуужээ. (Матай 5:25) Аугаа их Бурхан хүн амьтныг халамжилж, Өөрийнхөө мутрыг сунгаж, Өөрийнхөө бүтээл туурвилын гачигдал хэрэгцээг хангадаг. Тэнгэрийн шувуудыг ч тэр анхаардаг. Тэр шувууны хошуунд шууд будаа хийж өгдөггүй боловч амь зогооход нь хэрэгтэй юм бүхнийг урьдаас бодож боловсруулжээ. Жигүүртэн шувууд цацаж өгсөн үр будаагийг нь цуглуулах ёстой, үүрээ засаж, ангаахайгаа тэжээх ёстой. Тэнгэрийн Эцэг маань тэднийг тэжээж байгаа учраас жигүүртэн шувууд өөрийн ажлыг жиргэнхэн, донгодонхон хийдэг. “Та нар тэднээс илүү дээр үү?” Сэтгэн бодож, Бурханд ухамсартайгаар залбирах чадвартай та нар жигүүртэн шувуудаас илүү их үнэ цэнэтэй биш гэж үү? Өөрийнхөө дүр төсөөр биднийг бүтээсэн Бүтээгч, Хамгаалагч маань хэрэв бид Түүнд итгэж найдвал хэрэгцээтэй бүх юмыг маань илгээхгүй гэж үү дээ?

Христ газар сайгүй элбэг ургадаг хээр талын тансаг сайхан цэцгийг шавь нартаа зааж, Эцэг хүмүүнд хайртайн тэмдэг болгож тэр цэцгийг гоо сайхан болгосон юм гэжээ. Тэр айлдахдаа: “Талын лиш цэцгийн яаж ургаж байгааг харцгаа” хэмээжээ. Амьд цэцгийн жирийн үзэсгэлэн Соломон хааны гоёмсог өмсгөлөөс ч хавьгүй сайхан харагдана. Хүний ураар бүтээгдсэн нүд гялбам хамгийн сайхан хувцас хунарыг ч Бурханы бүтээсэн цэцэг лянхаун эгэл туяа сацруулсан гоо сайхантай зүйрлэхийн арга байхгүй. Есүс “Талын сараана цэцэг хэрхэн ургаж буйг хараач...Өнөөдөр ургаж, маргааш зууханд хаягдах хээрийн өвсийг Бурхан ийнхүү гоёдог бол, та нарын төлөө Тэр түүнээс хавьгүй илүүг хийхгүй гэж үү, итгэл

багатай хүмүүс ээ?” (Матай 6:28,30) хэмээн асуужээ. Бурхан, Тэнгэрийн Зураач өдөртөө л ганддаг цэцгийг ямар сайхан, янз бүрийн өнгөөр буднам бэ? Тэгвэл Тэр Өөрийнхөө дүрээр бүтээгдсэн хүмүүсийн төлөө хичнээн их санаа тавих билээ? Христийн үгс итгэл багатай зүрхний түгшүүр, сандрал, эргэлзээг зэмлэн буруушаадаг.

Их Эзэн Өөрийн хөвгүүд охидыг аз жаргалтай, дуулгавартай байгаасай гэж хүсдэг. Есүс “Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай”, “Миний баяр баясгалан та нар дотор байж, та нарын баяр баясгалан нь дүүрэн болохын тулд энэ бүхнийг Би та нарт хэлэв” хэмээн айлджээ. (Иохан 14:27; 15:11).

Атгаг муу санаагаар улайрч, үүрэг зорилгоо биелүүлэхээс татгалзаж байж олсон аз жаргал бат бэх, урт удаан үргэлжилдэггүй. Тийм аз жаргал тэр дорхноо замхран одож хүн ганцаардан гунихардаг. Бурханд хүчин зүтгэхүй нь баяр баясгалан, сэтгэлийн таашаал авчирна. Христ мөргөлтөн тодорхой бус байдалд аж төрдөггүй, дэмий шаналж зовдоггүй. Хэрэв бид энэ насны жаргалыг эдлэхгүй аваас ирээдүйн амьдралын жаргалыг хүлээн баясах болно.

Христ мөргөлтөн энэ хорвоо дээр Христтэй нэгдсэнээр баярлаж, Түүний энэрэл хайрын гэрэл гэгээнд цэнгэн жаргаж, Түүний оршин буйд үргэлж тайтгаран сууж болно. Бид энэ насандаа алхам алхмаар Есүст ойртож, Түүний энэрэл хайрыг ойлгох талаар улам гүн гүнзгий туршлага сууж, яруу алдарт, энх амгалант мөнхийн Улсад дөхөх болно. Ийм учраас итгэл найдвараа алдалгүй урьд өмнө хэзээ ч байгаагүй хатуу итгэл найдвартай болцгооё. “Энэ газар хүртэл Их Эзэн бидэнд тусалсан”, эцэст нь хүртэл Тэр тусална. (1 Самуел 7:12) Бурханы тусламжийг авч, дайсны савраас

чөлөөлөгдсөнөө тодхон харж болох өнгөрсөн, дурсгалт үеүдийг эргэн харцгаая. Бидэнд зориулсан бүхий л хайр хишгийг нь, хатааж өгсөн нулимсыг нь, анагааж өгсөн өвчнийг нь, сарниаж өгсөн түгшүүрийг нь, хангаж өгсөн хэрэгцээг нь, бидэнд хүртээсэн адислалыг нь санацгаая. Ингэвэл бид зовлон зүдгүүрийнхээ үлдсэн замыг туулах хүч чадалтай болно.

Бид хожмын тэмцэлд учрах саад бэрхшээлийн тухай бодохгүй байж болохгүй. Гэвч өнгөрснийг эргэн харж ирээдүйг өнгийн шинжихдээ бид: “Амьдрах өдрийн чинь уртад хүч чадал оршино.” (Дэд хууль 33:25) хэмээн зоригтой хэлж чадах билээ. Эзэн тэнгэр бидэнд хүчнээс маань хэтэрсэн сорилт шалгалтыг илгээхгүй. Ийм учраас хүн бүхэн ямар ч шалгалт сорилт тохиолдлоо гэсэн түүнийг давж гарах хүчийг Тэр бидэнд өгнө гэдэгт итгэж, тус тусынхаа ажил хөдөлмөрийг эрхлэх учиртай.

Удахгүй Бурханы үр хүүхдүүдэд тэнгэрийн хаалга нээгдэж суу алдарын хосгүй эгшиглэн мэт “Миний Эцэгээр ерөөгдөгсөд өө, та нар нааш ир. Ертөнцийн сууриас та нарт бэлэглэсэн хаанчлалыг өвлөн авсугай” (Матай 25:34) гэсэн ерөөлийн үгсийг Хааны амнаас сонсох болно.

Тэр цагт Есүсийн бэлтгэсэн орон байрнаа цагаадагсдыг баяртайгаар хүлээж авах болно. Тэдгээр шинэ иргэд нүгэлт хорвоод байсан иргэдээс нь эрс ялгарах болой. Тэнд гэм зэм, шудрага бус, худал хуурмаг явдал, хий хоосон бишрэл шүтээн үгүй байх юм. Аврагдагсад Сатаныг ялж, Бурханы хишиг буянаар төгс төгөлдөр зан чанарыг олсон хүмүүстэй харилцах болно. Нүгэлт зан авир бүхэн, өдгөө тэднийг энэлгэн зовоож буй аливаа төгс бус байдал цөм Христийн цусаар арчигдан үгүй болно. Тэд алтан нарнаас ч хурц тод Түүний суу алдрын гэрэл гэгээгээр туяаран гийгүүлэгдэнэ. Тэднээс Христийн ёс зүйн гоо сайхан, төгс төгөлдөр чанар туяаран

гэрэлтэнэ. Нүглээс ангижирсан нэгний адил тэд Бурханы аугаа их хаан ширээний өмнө зогсож тэнгэр элчүүдийн сүр хүч, онцгой эрх мэдлийг хуваалцах бөлгөө.

Өмнөө хүлээж буй алдар суут өвийг хараад “Хүн аминаасаа өөр юугаа өгөх билээ?” (Матай 16:26). Тэр ядуу байж болох хэдий ч дэлхий ертөнц хэзээ ч заяаж үл чадах тийм дотоод баялаг, эрхэм чанарыг олно. Нүгэл хилэнцээс цэвэрлэгдэж цагаатгагдсан, Бурханы үйлст ариун нандин бүхнээ зориулсан хүн тэнгэрийн мэлмийд цаглашгүй үнэ хүндтэй харагдана. Бурхан хийгээд Тэнгэр элч нар лугаа асар Тэнгэр цагаатгагдсан хүн бүрийн төлөө баярлаж, аугаа их ялалтын гэгээн дууллаар баяр баясгалангаа илэрхийлэх амуй.

2 ДУГААР ХЭСЭГ

ХРИСТЭД ИТГЭГЧДИЙН ЗАМНАХ ЗАМ

“Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай. Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм.”

2 Тимот 3: 16, 17

БИБЛИД ИТГЭЖ НАЙДАЖ БОЛОХ УУ?

Библийн номоос хэдий хэр нь Бурханаас ирсэн бэ?

“Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай.” 2 Тимот 3:16

Бурхан эш үзүүлэгчиддээ үгээ хэрхэн дамжуулсан бэ?

“Учир нь нэг ч эш үзүүлэгч хэзээ ч хүний хүслээр хийгдсэнгүй, харин Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүс Бурханаас айлджээ.” 2 Петр 1:21

Хуучин Гэрээ номын ямар гурван хэсгийг Есүс Христ Өөрийн сургаалдаа ашигласан бэ?

“Тэгээд Тэр тэдэнд ингэж айлдав. Та нартай хамт байхдаа Миний ярьж байсан үг маань ийм болой. Энэ нь Мосегийн Хууль, Эш үзүүлэгчид болоод Дуулал дахь Миний тухай бичигдсэн бүхэн биелэгдэх ёстой гээд Судрыг ухааруулахын тулд тэдний оюун ухааныг нээв.” Лук 24:44, 45

Тайлбар: Есүсийн үед Шинэ Гэрээ бичигдээгүй байсан учир Судар гэж Хуучин Гэрээ номыг хэлж байсан юм.

Есүсийн хэлснээр Хуучин Гэрээ ном хэний тухай өгүүлж байсан бэ?

“Та нар Судруудыг судалдаг. Учир нь тэдгээрийн дотор мөнх амь бий гэж та нар боддог. Тэдгээр нь Намайг гэрчилдэг билээ.” Иохан 5:39

“Есүс ‘Мунхаг хүмүүсээ! Эш үзүүлэгчдийн хэлсэн бүхэнд итгэхдээ хойрго сэтгэлтэнгүүд ээ! Христ энэ бүх зовлонг эдлэн, тэгээд Өөрийн сүр жавхланд орох ёстой байсан биш үү? гэв. Тэгээд тэр Мосегээс эхлэн бүх эш үзүүлэгчид, бүх Судар Өөрийнх нь тухай юу хэлснийг тэдэнд тайлбарлав.’”

Лук 24:25- 27

Яагаад Библид хүмүүсийн амьдралд тохиолдсон туршлагаас бичдэг юм бэ?

“Энэ бүхэн жишээ болон тэдэнд тохиолдсон бөгөөд үүнийг энэ үеийн эцэст амьдарч буй бидэнд сануулга болгон бичжээ.”

1 Коринт 10:11

Яагаад Шинэ Гэрээнд Есүсд тохиолдсон зүйлийг бичсэн байдаг вэ?

“Харин эдгээр нь Есүс бол Христ, Бурханы Хүү мөн гэдэгт та нарыг итгүүлэхийн тулд бичигдсэн бөгөөд ингэснээр итгэлээр дамжуулан та нар Түүний нэрээр амьтай болох юм.”

Иохан 20:31

Библи судалснаар ямар үр ашиг гарах вэ?

“Христ Есүст итгэх итгэлээр дамжуулан авралд хүргэх мэргэн ухааныг чамд өгөх чадалтай Ариун Бичээсүүдийг чи бага наснаасаа мэдэх болсон.”

2 Тимот 3:15

Библи ямар ашиг тустай вэ?

“Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай. Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм.”

2 Тимот 3:16, 17

Хүмүүс хаанаас үнэнийг олдог гэж Есүс хэлсэн бэ?

“Үнэн дотор тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн мөн.”
Иохан 17:17

Садукайчууд (Еврей бүлэг) Библийн талаар ямар алдаа гаргасан бэ?

“Есүс хариуд нь тэдэнд- ‘Та нар Судрыг ч, Бурханы хүчийг ч мэдэхгүйгээс болж төөрөлдөж байна.’”
Матай 22:29

Гэмт зан чанартай хүн яагаад Бурханлаг (сүнслэг) зүйлсийг ойлгож чаддаггүй вэ?

“Бурханы бидэнд үнэгүй өгсөн юмсыг мэдэхийн тулд бид ертөнцийн сүнсийг бус, харин Бурханаас ирсэн Сүнсийг хүлээн авсан юм. Бид үүнийг хүний мэргэн ухааны сургасан үгсээр бус, харин Сүнсний сургаснаар ярьдаг бөгөөд сүнслэг зүйлсийг сүнслэгээр тайлбарладаг. Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг.”
1 Коринт 2:12-14

Хэн биднийг үнэн рүү чиглүүлж чадах вэ?

“Харин үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана. Учир нь Тэр Өөрийн санаагаар биш харин алив сонссон юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ.”
Иохан 16: 13

Яагаад бид Библи судлах хэрэгтэй вэ?

“Чи өөрийгөө ичих явдалгүй ажилчин, үнэний үгийг зөв заагч гэж Бурханд сайшаалган харуулахыг хичээгтүн.”
2 Тимот 2:15

Библиэс бид хэр ихийг сурч, судлах шаардлагатай вэ?

“Харин тэндхийхэн (Беройн итгэгчид) Тесалоник хүмүүсийг бодвол уужим сэтгэлтэй байсан бөгөөд тэд үгийг дуртайяа хүлээн авч, эдгээр нь үнэн эсэхийг мэдэхийн тулд Судрыг өдөр бүр нягтлан үзэж байлаа.”

Үйлс 17:11

Бодож бясалгах амлалтууд:

“Таны үг бол миний хөл дэх дэнлүү, Миний зам дахь гэрэл юм.”

Дуулал 119:105

“Таны эсрэг нүгэл хийхгүйн тулд Таны үгийг би зүрхэндээ хадгалсан.”

Дуулал 119:11

БУРХАН ГЭЖ ХЭН БЭ?

Библид Бурханыг хэрхэн танилцуулсан байдаг вэ?

“Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжээ.” Эхлэл 1:1

Бурхан хэр удаан оршиж байсан бэ?

“Уулс бий болохоос ч өмнө, Таныг дэлхий ба ертөнцийг төрүүлэхээс ч өмнө, үүрдээс үүрд мөнх хүртэл Та бол Бурхан.” Дуулал 90:2

Бурхан хаана амьдардаг вэ?

“Энэ газрыг харан залбирах үед Таны боол болон Таны ард түмэн Израилийн хүсэлтийг сонсооч. Тэнгэр дэх Өөрийн орших газраасаа сонсооч. Сонсоод, өршөөн соёрхооч.” Хаадын дээд 8:30

Бурхан байдаг болохыг харуулсан ямар баримтыг бид харж, ойлгож болох вэ?

“Тэнгэр нь Бурханы сүр жавхланг зарлаж, огторгуй нь Түүний гарын бүтээлийг тунхаглаж байна.” Дуулал 19:1

“Би аймшигтай болоод гайхамшигтай бүтээгдсэн тул Танд талархал өргөнө. Таны үйлс бол гайхалтай бөгөөд Миний сэтгэл ч үүнийг маш сайн мэддэг юм.” Дуулал 139:14

“Харин одоо араатан амьтдаас асуу, тэд чамд сургаг. Мөн тэнгэрийн шувуудаас асуу, тэд чамд хэлж өгөг. Эсвэл газар дэлхийтэй ярилцаж, тэрээр чамайг сургаг. Далайн загас чамд тунхаглаг. Эзэний мутар үүнийг хийсэн гэдгийг эдгээр бүгдийн дунд хэн мэддэггүй юм бэ?” Иов 12:7-9

Хүмүүсийн шүтдэг бурхадаас диваажингийн жинхэнэ Бурхан юугаараа ялгагддаг вэ?

“Өнө эртний, урьдын зүйлсийг санагтун. Учир нь Би бол Бурхан, өөр байхгүй. Би бол Бурхан. Надтай адил өөр байхгүй. Би эхлэлээс төгсгөлийг тунхаглаж, хийгдээгүй байгаа зүйлсийг өнө эртнээс мэдүүлсэн. ‘Миний зорилго хэрэгжинэ. Би Өөрийн тааламжит бүхнийг гүйцэтгэнэ’ гэж айлдаж байна.”

Исаиа 46:9, 10

“Учир нь хүмүүсийн бүх бурхад бол хоосон шүтээнүүд, харин ЭЗЭН тэнгэрүүдийг бүтээсэн.”

Дуулал 96:5

“Тэнгэрийг бүтээсэн ЭЗЭН ингэж айлдаж байна. (Тэр бол газрыг бий болгосон Бурхан юм. Тэр газрыг хоосноор бүтээгээгүй бөгөөд хүмүүсийг оршин суулгахын тулд бүтээсэн билээ.) Би бол ЭЗЭН. Өөр байхгүй.”

Исаиа 45:18

Библид Бурханы тухай ийн өгүүлдэг:

а) “Бидний Эзэн ба Бурхан минь, Та алдар, хүндэтгэл, хүчийг авах нь зохистой. Учир нь Та бүх юмсыг бүтээсэн билээ. Таны хүслийн улмаас тэдгээр нь оршсон бөгөөд бүтээгдсэн юм.”

Илчлэлт 4:11

б) “Манай Бурхан бүх бурхадаас агуу учир.”

Шастирын дэд 2:5

в) “Учир нь Бурханд бүх юм боломжтой гэж айлдав.”

Марк 10:27

г) “Тэр эмтэрсэн зүрхтэй хүмүүсийг анагааж... Түүний оюун ухаан хязгааргүй.” Дуулал 147:3-5

д) “Учир нь ЭЗЭН Би өөрчлөгдөшгүй.» Малахи 3:6

е) “Хайрладаггүй нэгэн нь Бурханыг мэддэггүй.
Учир нь Бурхан бол хайр билээ.” 1 Иохан 4:8

Бурхан Өөрийн талаар Мосед юу гэж тайлбарласан бэ?

“Дараа нь ЭЗЭН түүний урдуур өнгөрч, ЭЗЭН, ЭЗЭН Бурхан өрөвч, нигүүлсэнгүй, уурлахдаа удаан ба энэрэл хайр, үнэнээр бялхам билээ. Тэр энэрэл хайрыг мянган үеийн турш хадгалж, гэмт хэрэг, гэм буруу, нүглийг уучилдаг. Гэсэн ч Тэр гэмтнийг шийтгэлгүй орхихгүй. Эцгүүдийн гэм бурууг гурав, дөрөв дэх үеийг хүртэл үр хүүхэд, ач нарт нь буулгадаг гэж тунхаглав.”

Египетээс гарсан нь 32, 33

Бид бүхэнтэй ямар харилцаа тогтоохыг Бурхан хүсдэг вэ?

“Бид Бурханы хүүхдүүд гэж дуудуулахаар ямар их хайрыг Эцэг бидэнд соёрхсоныг хараач!”

1 Иохан 3:1

“ЭЗЭН бол бүгдэд сайн, Түүний өршөөлүүд Өөрийнх нь бүтээл бүхний дээр байдаг.”

Дуулал 145:9

“Тэгснээрээ та нар тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхдүүд болно. Учир нь Тэр Өөрийнхөө нарыг хорон муу болоод сайн хүмүүс дээр мандуулж, зөвт болоод зөвт бус хүмүүс дээр бороо оруулдаг юм.”

Матай 5:45

ГЭМ БА ЗОВЛОН БЭРХШЭЭЛ ХААНААС БИЙ БОЛСОН ЮМ БЭ?

Анхны нүглийг хэн үйлдсэн бэ?

“Нүгэл үйлддэг нэгэн нь диаволынх юм. Диавол эхнээсээ нүгэл үйлдсэн. Диаволын үйлсийг устгахын тулд Бурханы Хүү энэ зорилгын төлөө үзэгджээ.”

1 Иохан 3:8

Диавол (Сатан- муу ёрын сүнс) хэрхэн энэ дэлхий дээр ирсэн юм бэ?

“Тэр тэдэнд ‘Би Сатаныг аянга адил тэнгэрээс буухыг нь харав.’”

Лук 10:18

Сатан урьд нь хэн байсан бэ?

“Чи бол халхалдаг тослогдсон херуб байсан ба Би чамайг байрлуулсан. Чи Бурханы ариун ууланд байлаа. Чи галт чулуунуудын дундуур явав. Чамайг бүтээсэн өдрөөс эхлэн чиний дотор зөвт бус нь олдох хүртэл чи өөрийн замууддаа гэмгүй байв.”

Езекиел 28: 14, 15

Тайлбар: “Халхалдаг тослогдсон херуб” гэдэг нь диваажинд Бурханы сэнтийн дэргэд байх тэнгэрийн элчийг хэлж байгаа юм (Дуулал 80:1). Энэ тэнгэрийн элч нь төгс бүтээгдсэн ба бусад амьд бүхнээс илүү хүндлэгддэг байсан. Харин тэрээр Бурханы хүслээс өөрийн хүслийг дээр тавьснаар өөрийгөө диавол болгосон юм.

Сатаныг диваажинд эсэргүүцэл дэгдээн, гэм нүгэлд унахад юу нөлөөлсөн бэ?

“Чиний гоо үзэсгэлэнгээс болж зүрх чинь бардамнав. Чи сүр жавхлангаасаа болж цэцэн ухаанаа завхруулсан. Би чамайг газарт хаяж, хаадад чамайг харуулахын тулд тэдний өмнө тавьсан.”

Езекиел 28:17

Лусиферийн гол хүсэл нь юу байв?

“Аяа, Үүрийн хүү, гялбаат цолмон. Чи яаж тэнгэрээс унав аа? Үндэстнүүдийг дордуулагч чи газарт хаягдлаа. Учир нь чи зүрхэндээ ‘Би тэнгэр уруу гарна. Би Бурханы оддын дээр сэнтгийгээ босгоно. Би умардын хамгийн чанадад чуулганы уулан дээр заларна. Би үүлсийн орой дээр гарна. Би өөрийгөө Хамгийн Дээд Нэгэн шиг болгоно.’ гэсэн.”

Исаиа 14:12- 14

ТАЙЛБАР: ЛУСИФЕР ГЭДЭГ НЬ САТАНЫ ГЭМ ХИЙХЭЭС ӨМНӨ ДУУДАЖ БАЙСАН НЭР ЮМ.

Сатан Бурханы эсрэг боссоноор диваажинд юу болсон бэ?

“Тэнгэрт дайн болов. Михаел болон түүний тэнгэр элч нар луутай тулалдлаа. Луу болон түүний тэнгэр элч нар тулалдаад, тэдэнд хүч дутсан бөгөөд тэдэнд тэнгэрт байх газар олдсонгүй. Өнөөх агуу том луу буюу бүх ертөнцийг мэхлэгч диавол ба Сатан гэгддэг эртний могой доош хаягдав. Тэр дэлхий уруу хаягдлаа. Түүний хамт тэнгэр элч нар нь ч доош хаягдав.”

Илчлэлт 12:7- 9

Диваажингаас шидэгдсэнийхээ дараа Сатан хэнийг уруу татахаар шийдсэн бэ?

“ЭЗЭН Бурханы бүтээсэн аливаа хээрийн зэрлэг амьтдын дотроос могой хамгийн илүү зальтай байжээ. Тэр могой, ‘Та нарт энэ цэцэрлэгт байгаа бүх модны жимснээс идэж болохгүй гэж Бурхан үнэхээр хэлсэн үү?’ хэмээн эмэгтэйгээс асуужээ. Тэр эмэгтэй могойд хандаж, ‘Бид энэ цэцэрлэг дэх модны жимснээс идэж болно. Харин цэцэрлэгийн голд байгаа модны жимсний тухайд Бурхан Та нар түүнээс бүү ид, бас түүнд бүү хүр, тэгвэл та нар үхнэ’ гэж айлдсан хэмээжээ. Тэр могой эмэгтэйд, ‘Та нар ерөөсөө үхэхгүй. Та нар түүнээс идсэн тэр өдөртөө л нүд чинь нээгдэн, Бурхан шиг болж, сайн мууг мэдэх болно гэдгийг Бурхан мэддэг билээ гэжээ. Тэгээд тэр модны жимс идэхэд амттай, харахад тааламжтай, оюун ухааныг нь задалмаар байсныг тэр эмэгтэй үзээд, түүнээс авч иджээ. Тэр бас өөртэйгөө хамт байсан нөхөртөө өгч, тэр ч иджээ.’”

Эхлэл 3:1- 6

Хүнийг гэм хийсний дараа Сатан аль газар нутгийг өөрийн эзэмшил гэж тунхаглаж байна вэ?

“Дараа нь тэр (диавол) Түүнийг дээш аваачаад, хоромхон зуур дэлхийн бүх хаанчлалуудыг үзүүлэв. Тэгээд диавол Түүнд, ‘Энэ бүх эзэмшил болон тэдгээрийн сүр хүчийг би Чамд өгье. Учир нь энэ бүгд надад өгөгдсөн юм. Би үүнийг хүссэн хүндээ өгч чадна.’”

Лук 5, 6

Сатан хүн төрөлхтөнийг хэрхэн дарлан доромжилож эхэлсэн бэ?

“Тэгээд Сатан ЭЗЭНий оршихуйгаас явж, Иовыг хөлийнх нь улнаас толгойн орой хүртэл нь яр хатиганд бариулав.”
Иов 2:7

“Абрахамын охин энэ эмэгтэйг Сатан арван найман жилийн турш хүлээтэй байлгажээ. Тэгвэл энэ эмэгтэй Амралтын өдөр тэрхүү хүлээснээс ангижрах ёсгүй болж байна уу? гэв.”
Лук 13:16

Сатан яагаад хүн төрөлхтнийг устгахаар шаргуу хичээж байгаа юм бэ?

“Би тэнгэрт чанга дуугаар ингэж хэлэхийг сонсов. ‘Бурханы өмнө ах дүүсийг маань өдөр шөнөгүй буруутгадаг тэднийг буруутгагч доош хаягдсан учраас эдүгээ бидний Бурханы аврал, хүч, хаанчлал ба Түүний Христийн эрх мэдэл хүрч ирлээ. Тиймээс тэнгэр ээ, тэнд нутаглагсад аа, баярлан хөөрөгтүн. Газар ба тэнгис золгүй еэ! Яагаад гэвэл диавол үлэмж их уур хилэнтэйгээр та нар уруу бууж ирсэн. Өөрт нь богинохон хугацаа байгааг тэр мэдэж байгаа.’”
Илчлэлт 12:10,12

Есүс диаволыг устгах эрхээ хэрхэн олж авсан бэ?

“Нүгэл үйлддэг нэгэн нь диаволынх юм. Диавол эхнээсээ нүгэл үйлдсэн. Диаволын үйлсийг устгахын тулд Бурханы Хүү энэ зорилгын төлөө үзэгджээ.”

1 Иохан 3:8

“Тийнхүү хүүхдүүд нь цус ба махан биеийн тасархай болов. Түүнчлэн Тэр Өөрөө бас тасархай болсон. Ингэснээр Тэр үхлийн хүч буюу диаволыг үхлээрээ

устгаж, бүх насаараа үхлийн айдсаар боолчлогдож байсан тэдгээр хүмүүсийг чөлөөлөх юм.” Еврей 2:14

Бүхний эцэст Бурхан диаволыг хэрхэн устгах вэ?

“Чиний наймааны хөгжлөөр чи дотроосоо хүчирхийллээр дүүрч, чи нүглийг үйлдэв. Тиймээс Би чамайг Бурханы уулнаас бузартсан юм мэт хөөсөн. Халхлагч херуб аа, Би чамайг галт чулуунуудын дундаас устгав. Чиний гоо үзэсгэлэнгээс болж зүрх чинь бардамнав. Чи сүр жавхлангаасаа болж цэцэн ухаанаа завхруулсан. Би чамайг газарт хаяж, хаадад чамайг харуулахын тулд тэдний өмнө тавьсан. Өөрийн тоо томшгүй хууль бус явдал ба зөв бус наймаагаар чи ариун газруудаа бузарлав. Тиймээс Би чиний дотроос гал гаргаж, тэр нь чамайг шатаасан. Чамайг харагч бүхний нүдэн дээр Би чамайг газрын үнс болгов. Ард түмнүүдийн дунд чамайг мэддэг бүгд чамаас болж чичрэв. Чи айдаст автаж, хойшид байхгүй болно.”

Езекиел 28:16- 19

ГЭМ НҮГЭЛ ГЭР БҮЛД ШУРГАЛСАН НЬ

Едений цэцэрлэгт Адамд Бурхан ямар заавар өгсөн бэ?

“ЭЗЭН Бурхан хүнийг аваад, Еден цэцэрлэгийг арчлуулан сахиулахын тулд тэнд суулгав. Тэгээд ЭЗЭН Бурхан тэр хүнд тушаан ийнхүү өгүүлэв. Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг дураараа идэж болно. Харин чи сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй үхнэ! хэмээн айлдав.”

Эхлэл 2:15-17

Гэвч Адам, Ева хоёр Бурханы зааврыг зөрчсөн ...

“Тэр могой эмэгтэйд, та нар ерөөсөө үхэхгүй. Та нар түүнээс идсэн тэр өдөртөө л нүд чинь нээгдэн, Бурхан шиг болж, сайн мууг мэдэх болно гэдгийг Бурхан мэддэг билээ гэжээ. Тэгээд тэр модны жимс идэхэд амттай, харахад тааламжтай, оюун ухааныг нь задалмаар байсныг тэр эмэгтэй үзээд, түүнээс авч иджээ. Тэр бас өөртэйгөө хамт байсан нөхөртөө өгч, тэр ч иджээ.”

Эхлэл 3:4-6

Бурханы зааврыг зөрчсөнөөс болж юу тохиолдсон бэ?

“ЭЗЭН Бурхан, Үзэгтүн! Энэ хүн одоо сайн мууг мэдэх талаараа бидний нэгэн адил болсон. Тэр одоо гараа сунган, бас амийн модны жимснээс авч идээд, мөнх наслах вий хэмээн айлджээ. ЭЗЭН Бурхан

хүнийг өөрийг нь гаргаж авсан газар шороог хагалуулахаар Еден цэцэрлэгээс гарган явуулжээ. Тэгээд Бурхан тэр хүнийг хөөж гаргаад, амийн мод уруу хөтлөх замыг нхамгаалуулахаар Еден цэцэрлэгийн зүүн талд херубууд болон зүг бүрд эргэлддэг галт илдийг байрлуулан тавьжээ.”

Эхлэл 3: 22-24

Бурхан хүн хоёрын харилцаанд гэм нүгэл ямар хор уршиг тарьсан бэ?

“Харин та нарын гэм буруу нь та нарыг Бурханаас хагацуулан, та нарын нүглүүд Бурханы нүүрийг та нараас далдалжээ. Тийм учраас Тэр сонсдоггүй.”

Исаиа 59:2

Адамын хийсэн гэм нүглийн үр дүн хүн төрөлхтөнд хэрхэн нөлөөлсөн бэ?

“Тиймээс нүгэл нь ганц хүнээр ертөнцөд орсны адил үхэл нь нүглээр дамжуулан орж ирэв. Тэрчлэн бүгд нүгэл үйлдсэн тул бүх хүмүүст үхэл тархав.”

Ром 5:12

Есүсээс өөр гэм нүгэлгүй хүн дэлхий дээр байдаг уу?

“Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй.”

Ром 3:23

Гэмт хүн өөрийн дорой байдлаа ямар нэгэн аргаар өөрчилж чадах уу?

“Етиоп хүн арьсаа, ирвэс толбоо өөрчилж чадах уу? Мууг үйлдэж зуршсан чи ч бас сайныг үйлдэж чадна.”

Иеремиа 13:23

Бид хэрхэн мөнх амь авч болох вэ?

“Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн.”

Ром 6:23

ТАЙЛБАР: Мөнхийн амь гэдэг бол үнэгүй бэлэг, бид зөвхөн түүнийг хүлээн зөвшөөрөх л хэрэгтэй.

Бурхан хэдэн хүнийг аврах хүсэлтэй вэ?

“Эзэн удаашралыг тооцдог зарим хүмүүсийн боддог шиг Өөрийнхөө амлалтад хойрго биш билээ. Харин ч Тэр хэнийг ч мөхүүлэхийг хүсэлгүй, бүгдийг гэмшилд ирээсэй хэмээн хүсэн та нарт тэвчээртэй ханддаг.”

2 Петр 3:9

Бурхан бидэнд хайртайгаас гадна, шударага бөгөөд ямар ч гэм нүглийг анзаарахгүй өнгөрдөггүй ...

“ЭЗЭН үүлэн дотор буун ирж, Мосег ЭЗЭНий нэрийг дуудсанаар тэнд түүнтэй хамт зогсов. Дараа нь ЭЗЭН түүний урдуур өнгөрч ЭЗЭН, ЭЗЭН Бурхан өрөвч, нигүүлсэнгүй, уурлахдаа удаан ба энэрэл хайр, үнэнээр бялхам билээ. Тэр энэрэл хайрыг мянган үеийн турш хадгалж, гэмт хэрэг, гэм буруу, нүглийг уучилдаг. Гэсэн ч Тэр гэмтнийг шийтгэлгүй орхихгүй. Эцгүүдийн гэм бурууг гурав, дөрөв дэх үеийг хүртэл ур хүүхэд, ач нарт нь буулгадаг гэж тунхаглав.”

Египетээс гарсан нь 34:5-7

Нүгэлт хүн төрөлхтнийг аврахаар Бурхан ямар төлөвлөгөө боловсруулсан бэ?

“Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.»

Иохан 3:16

Яагаад Есүс энэ дэлхийд ирэх болов?

“Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ.”
Лук 19:10

“Учир нь Тэр Өөрийн ард түмнийг нүглээс нь аварна.”
Матай 1: 21

Есүсийг загалмайд цовдлогдоход Бурхан Эцэг Түүнд юуг тохсон бэ?

“Бид бүгдээрээ хонь мэт төөрч, хүн бүр өөрийн замаар явав. Харин ЭЗЭН бидний гэмийг бүгдийг нь Түүнд тохов.”
Исаиа 53:6

Бурханаас ивээл авахын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?

“Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг юм.”
Ефес 2:8

Шоронгийн хуягт аврагдахын тулд юу хийх хэрэгтэй гэж Пауль хэлсэн бэ?

“Эзэн Есүст итгэгтүн. Чи болон гэрийнхэн чинь ч аврагдана гэлээ.”
Үйлс 16:31

Авралын үнэгүй ирэх бэлэг хүртэхийн тулд хэзээ шийдвэрээ гаргах вэ?

“Харагтун, одоо бол ‘Тааламжтай цаг’ байна. Харагтун, одоо бол ‘Авралын өдөр’ байна.”
2 Коринт 6:2

Есүс бидний зүрх сэтгэлийн үүдийг тогшиж байна гэж Библийн номонд бичсэн. Есүс биднийг юу хийгээсэй гэж хүсдэг вэ?

“Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа

нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.” Илчлэлт 3:20

Христийг сэтгэлдээ хүлээн авах үед бид ямар итгэл найдвартай байж болох вэ?

“Хүүтэй хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй. Та нар мөнх амьтай гэдгээ мэдээсэй гэсэндээ би Бурханы Хүүгийн нэрд итгэдэг та нарт эдгээр зүйлийг бичсэн.” 1 Иохан 5:12,13

Христийг амьдралдаа хүлээн зөвшөөрөх үед Аврагч Эзэнээс бид юуг өвлөн авах вэ?

“Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв.” Иохан 1: 12

Есүс хүн дүртэй Бурхан

Бурханы Хүү, Есүс хэр удаан оршин байсан бэ?

“Харин чиний хувьд, Бетлехем Ефрата аа, хэдийгээр чи Иудагийн бүлүүдийн дунд өчүүхэн авч, Миний төлөө Израйлийг захирах Нэгэн нь чамаас гарах болно. Түүний гарч ирэх нь эртнээс мөнхийн өдрүүдээс байсан юм.» Мика 5:2

“Одоо, Аав аа, ертөнцийг бүтээхээс өмнө Таньтай хамт Надад байсан сүр жавхлангаар Та Намайг Өөрийнхөө хамт алдаршуулаач.” Иохан 17:5

Библийн тайлбарласнаар Үг буюу

Есүс гэж хэн бэ?

“Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц Хүүгийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байсан юм.”

Иохан 1:1,14

Паул Есүсийн талаар юу гэж бичсэн бэ?

“Бурханлаг байдлын нууц нь агуу гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрнө. Махан биеэр илчлэгдсэн Тэр нь Сүнс дотор зөвтгөгдсөн, Тэнгэр элч нарт харагдсан, Үндэстнүүдийн дунд тунхаглагдсан, Ертөнцөд итгэгдсэн, Алдар дотор дээш аваачигдсан юм.” 1 Тимот 3:16

Бусад гэрчүүд Есүсийн талаар юу гэж

хэлсэн бэ?

а) “Симон Петр, ‘Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн’ гэв.” Матай 16:16

б) “Есүсийг харгалзаж байсан зуутын дарга болон харуулууд газар хөдлөлт болон болж буй бүхнийг хараад ихэд айн, ‘Үнэхээр энэ хүн Бурханы Хүү байжээ’ гэв.” Матай 27:54

в) “Тэнгэрээс, ‘Энэ бол Миний хайрт Хүү Түүнд Миний таалал оршдог’ гэх дуу гарлаа.” Матай 3:17

г) “Томас Түүнд, ‘Эзэн минь, Бурхан минь’ гэв.” Иохан 20:28

Дэлхий ертөнцийг бүтээхэд Есүсийн оролцсон хувь нэмэр юу вэ?

“Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй. Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц Хүүгийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байсан юм.”

Иохан 1:1- 3,14

“Учир нь Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс, үзэгдэх ба үл үзэгдэх юмс, хаан ширээнүүд, эсвэл ноёрхлууд, удирдлагууд, эсвэл эрх мэдлүүд ч бүтээгдсэн. Бүх юмс Түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн байна.” Колосай 1:16

“Эрт үед эш үзүүлэгчдээр дамжуулан эцэг өвгөдөд олон хэсгээр болон янз бүрийн арга замаар айлдсан Бурхан эдгээр эцсийн өдрүүдэд Өөрийн Хүүгийн дотор бидэнд хандаж айлдав. Тэр Хүүгээ бүхний өвлөгчөөр томилсон бөгөөд Хүүгээрээ ертөнцийг бүтээсэн билээ.” Еврей 1:1, 2

Бидний Аврагч болохын тулд Есүс юу хийсэн бэ?

“Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай. Тэрээр хэдийгээр Бурханы мөн чанараар оршин байсан боловч, Бурхантай тэгш байх явдлыг Өөртөө хадгалах зүйл гэж үзсэнгүй, харин Өөрийгөө хоослож, боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ. Хүн төрхийг олсон Тэрээр үхэлд ч төдийгүй загалмайн үхэлд ч хүртэл дуулгавартай байснаараа Өөрийгөө даруу болгов.”
Филиппой 2:5-8

Есүс яагаад диваажинг орхин энэ дэлхийд ирж амиа алдсан бэ?

“Христ Есүс нүгэлтнүүдийг аврахаар ертөнцөд ирсэн гэдэг нь итгэмжит үг мөн. Тэдгээр нүгэлтнүүдийн эхнийх нь би байна.” 1 Тимот 1:15

“Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ.”
Лук 19:10

Есүсийн талаар Мари ямар үг сонсов?

“Тэнгэр элч, ‘Ариун Сүнс чам дээр ирж, Хамгийн Дээдийн хүч чамайг бүрхэнэ. Тиймээс төрөх ариун нэгэн нь Бурханы Хүү гэж дуудагдах болно.’”
Лук 1:35

Есүсийн амьдралын талаар Петр юу гэж хэлсэн бэ?

“Энэ нь Назарын Есүсийн тухай бөгөөд Бурхан хэрхэн Түүнийг Ариун Сүнс ба хүч чадлаар тосолсон хийгээд диаволд дарлагдсан бүгдийг эдгээн, сайныг үйлдэж явсан тухай юм. Учир нь Бурхан Түүнтэй хамт байсан.”
Үйлс10:38

Дагалдагч нар нь Есүсээс Эцэгийгээ үзүүлээч гэхэд Тэр юу гэж хариулсан бэ?

“Филип Түүнд, ‘Эзэн, бидэнд Эцэгээ харуулаач. Энэ л бидэнд хангалттай’ гэв. Есүс, Би та нартай ийм удаан хамт байхад, чи Намайг таньсангүй гэж үү, Филип ээ? Намайг харсан хүн Эцэгийг харсан. Гэтэл ‘Бидэнд Эцэгээ харуулаач’ гэж чи яаж хэлнэ вэ?”

Иохан 14:8-10

Энэ дэлхий дээр Есүс ямар амьдралаар амьдарсан бэ?

“Тэр нүгэл үйлдээгүй, Түүний аманд ямар ч заль мэх олдоогүй. Тэр зүхэгдэж байхдаа, хариуд нь зүхээгүй. Тэр зовон тарчилж байхдаа заналхийлээгүй, харин шударга шүүдэг Нэгэнд Өөрийгөө даатгасаар байлаа.” 1 Петр 2:22,23

Бурхан Хүүгийнхээ үхлээр бидэнд юуг харуулсан бэ?

“Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм.” Ром 5:8

Бодож цэгнэх амлалтууд:

“Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй.” Үйлс 4:12

“Бид Бурханы хүүхдүүд гэж дуудуулахаар ямар их хайрыг Эцэг бидэнд соёрхсоныг хараач! Бид бол тийм юм. Иймээс ертөнц Түүнийг мэдээгүй тул биднийг мэддэггүй.” 1 Иохан 3:1

МӨНХИЙН АМЬДРАЛД ХҮРЭХ ЗАМ

**Энэ дэлхий дээр «зөв» хүмүүс хичнээн
байдаг вэ?**

“Энэ нь ингэж бичигдсэнчлэн, ‘Зөвт хүн алга.
Ганц ч алга.’” Ром 3:10

**Дагалдагч Паул хүний нөхцөл байдлын
талаар хэлэхдээ:**

“Учир нь миний дотор буюу миний махан биед
ямар ч сайн зүйл байдаггүйг би мэддэг. Учир нь
хүсэл нь миний дотор байвч, харин сайныг хийх нь
үгүй. Би өөрийн хүсдэг сайныг хийдэггүй, харин
хүсдэггүй бузар муугаа хэрэгжүүлдэг. Хэрэв би
өөрийн хүсдэггүй зүйлээ хийж байгаа бол цаашид
би биш, харин миний дотор оршин байгч нүгэл нь
үүнийг үйлддэг.” Ром 7:18-20

**Хүн төрөлхтөн яагаад одоогийн ийм нөхцөл
байдалтайгаар Бурханы тааллыг олж чадахгүй
гэж Паул хэлсэн бэ?**

“Яагаад гэвэл махан биеийн бодол санаа бол
Бурханы эсрэг дайсагнал юм. Учир нь энэ нь
Бурханы хуульд захирагддаггүй бөгөөд тэгж чадах
ч үгүй. Махан бие дотор байгсад Бурханд
таашаагдаж чадахгүй.» Ром 8:7,8

Гэмт зан чанартаа хөтлөгдөх юм бол бидэнд юу тохиолдох вэ?

“Махан биеийн бодол санаа бол үхэл, Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой.”

Ром 8:6

Паул гэмт зангаасаа бүр мөсөн ангижирсан уу?

“Би юутай хөөрхийлөлтэй хүн бэ! Хэн намайг үхлийн энэ биеэс ангижруулах вэ? Бидний Эзэн Есүс Христээр Бурханд талархал нь байх болтугай. Иймд нэг талаар би өөрийн оюун ухаанаар Бурханы хуульд үйлчилдэг боловч, нөгөө талаар би өөрийн махан биеэрээ нүглийн хуульд үйлчилдэг.”

Ром 7:24,25

Христэд итгэх итгэл нь Паулыг Христэд итгэгчдийн зөв амьдралаар амьдрахад тус болсон юм:

“Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна. Эдүгээ би махан биендээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм.”

Галат 2:20

Есүс хүний дотоод өөрчлөлтийг юутай зүйрлэсэн бэ?

“Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалыг үзэж чадахгүй.”

Иохан 3:1-3

Никодем (нэр хүндтэй еврей) Есүсийн хэлсэн зүйлийг ойлгож чадсан уу?

“Никодем Түүнд, ‘Настай болсон атлаа хүн хэрхэн төрөх билээ? Хүн эхийн хэвлийд хоёр дахиа орж, төрж чадна гэж үү? гэлээ.’”
Иохан 3:4

Есүс Никодемд дахин шинээр төрж болох талаар хэрхэн тайлбарласан бэ?

“Есүс, ‘Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй. Махан биеэс төрсөн нь махан бие, Сүнснээс төрсөн нь сүнс болой.’ ‘Чи дээрээс төрөх ёстой’ гэж Би чамд хэлсэнд бүү гайх.”
Иохан 3:5-7

Бидний амьдралыг Бурхан хэрхэн өөрчилдөг бол?

“Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хааш оддогийг мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг гэж айлдав.”
Иохан 3:8

“Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм.”
Ром 8:14

Паул «дахин шинээр төрсөн» хүнийг хэрхэн дүрслэн хэлсэн бэ?

“Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Жуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна.”
2 Коринт 5:17

Бурханыг дагах хүсэл, мэдлэгийг Тэрээр бидэнд хэрхэн өгдөг вэ?

“Учир нь Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд та нарын дотор ажиллаж буй нь Бурхан юм.” Филиппой 2:13

“Тэр өдрүүдийн дараа тэдэнтэй байгуулах Миний гэрээ энэ юм. Би Өөрийн хуулиудыг тэдний зүрхэнд тавина. Би тэдгээрийг тэдни ухаан санаанд бичнэ.” Еврей 10:16

Шинэхэн Христэд итгэгчид гэмт амьдралаар амьдрах ёстой юу?

“Тэгвэл бид юу гэж хэлэх вэ? Нигүүлсэл нь ихсэхийн тулд бид нүгэл дотор байсаар байх уу? Бүү ийм байх болтугай! Нүгэлд үхсэн бид, цаашид түүн дотроо хэрхэн амьдрах вэ? Эсвэл Христ Есүс уруу баптисм хүртсэн бид цөмөөрөө Түүний үхэл уруу баптисм хүртсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тиймд Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явахын тулд үхэл уруу баптисм хүртсэнээр Түүнтэй хамт оршуулагдсан юм.” Ром 6:1-4

Бид шинээр төрснийхөө дараа санаандгүй гэм үйлдсэн тохиолдолд өршөөл уучлал хүсэж болох уу?

“Бяцхан хүүхдүүд минь, та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээрийг та нарт бичиж байна. Хэрэв хэн нэгэн нь нүгэл үйлдвэл, Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн.» 1 Иохан 2:1

“Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.”

1 Иохан 1:9

Бодож цэгнэх амлалтууд:

“Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна.”

Филиппой 4:13

ДИВААЖИН БОЛ БОДИТ ГАЗАР

Нас барж, дахин амилахынхаа өмнөхөн Есүс Өөрийн дагалдагч нарт ямар амлалт өгсөн бэ?

“Та нар зүрхээ бүү зовоо. Бурханд итгэ, мөн Надад итгэ. Миний Эцэгийн гэрт орон байр олон бий. Хэрэв тийм биш байсан бол Би та нарт орон байр бэлдэхээр явна. Хэрэв Би явж та нарт орон байр бэлдвэл, дахин ирж, та нарыг Өөртөө авна. Би хаана байна, та нар мөн тэнд байх болно.”

Иохан 14:1-3

Библид “Эцэгийн гэрийг” хэрхэн дүрсэлсэн байдаг вэ?

“Ариун хот, шинэ Иерусалим нь нөхөртөө очихоор гоёсон сүйт бүсгүй мэт бэлтгэгдэн Бурханаас гарч, тэнгэрээс буун ирэхийг би харлаа.”

Илчлэлт 21:2

Шинэ Иерусалим, Ариун Хотыг Библид хэрхэн дүрсэлсэн байдаг вэ?

а) “Хот нь дөрвөлжин бөгөөд урт нь өргөнтэйгөө адил аж. Тэнгэр элч хотыг шугамаараа хэмжихэд урт, өргөн, өндөр нь адилхан арван хоёр мянган стадиа байлаа.”

Илчлэлт 21:16

Тайлбар: Нэг стадиа гэдэг нь Английн хэмжээгээр 1/8 бээр болох ба өнөөгийн хэмжээсээр бүх талаараа ижил дөрвөлжин хэлбэртэй бөгөөд нэг тал нь ойролцоогоор 600 километрийн урттай байх юм.

- б) “Хэрмийг хас чулуугаар хийсэн бөгөөд хот нь тунгалаг шил мэт шижир алт ажээ.”
Илчлэлт 21:18
- в) “Хотын хэрмийн сууриуд нь төрөл бүрийн эрдэнийн чулуугаар чимэглэгджээ.”
Илчлэлт 21:19
- г) “Тэр нь асар том өндөр хэрэмтэй бөгөөд арван хоёр хаалгатай байлаа... Арван хоёр хаалга нь арван хоёр сувд ажээ. Хаалга нэг бүр нь нэгэн цул сувд байсан бөгөөд хотын гудамж нь тунгалаг шил мэт шижир алт байв.”
Илчлэлт 21:12, 21
- д) “Хотод дээрээс нь гэрэлтүүлэх нар, сар хэрэггүй ажээ. Учир нь Бурханы цог жавхлан түүнийг гэрэлтүүлсэн бөгөөд дэнлүү нь Хурга байлаа.”
Илчлэлт 21:23

Еден цэцэрлэгт байсан, ямар өвөрмөц мод Шинэ Иерусалимд ургах вэ?

- а) “Голын хоёр талд арван хоёр төрлийн үр жимс ургуулан, сар бүр жимсээ боловсруулж буй амийн мод байлаа. Тэр модны навчис нь үндэстнүүдийг эдгээхийн тулд байв.”
Илчлэлт 22:2
- б) “Эзэн Бурхан хүнийг өөрийг нь гаргаж авсан газар шороог хагалуулахаар Еден цэцэрлэгээс гарган явуулжээ. Тэгээд Бурхан тэр хүнийг хөөж гаргаад, амийн мод уруу хөтлөх замыг хамгаалуулахаар Еден цэцэрлэгийн зүүн талд херубууд болон зүг бүрд эргэлддэг галт илдийг байрлуулан тавьжээ.”
Эхлэл 3:23,24

Бурхан энэ дэлхийг аврагдсан хүмүүсийн амьдрал мөнхийн гэр орон болгоно:

“Дөлгөөн хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд дэлхийг өвлөн авах болно.” Матай 5:5

ТАЙЛБАР: Энэ үйл ҮВДАЛ АВРАГДАГСАД БУРХАНТАЙ ХАМТ ДИВААЖИНД 1000 ЖИЛ АМЬДАРСНЫ ДАРАА ТОХИОЛДОНО. “1000 ЖИЛИЙН АМАР ТАЙВАН” ГЭСЭН ХИЧЭЭЛЭЭС БИД ЭНЭ ТАЛААР ИЛҮҮ ТОДОРХОЙ ХАРИУЛТ АВАХ БОЛНО.

Бурхан дэлхийг дахин шинээр бүтээнэ:

а) “Харин Түүний амлалтын дагуу бид зөвт байдал оршдог шинэ тэнгэр, шинэ газрыг хүлээн байна.” 2 Петр 3:13

б) “Би шинэ тэнгэр, шинэ газрыг харлаа. Учир нь анхны газар нь өнгөрөн одож, тэнгис байхгүй болов.” Илчлэлт 21:1

Бурхан Өөрийн нийслэл хот болох Шинэ Иерусалимаа дэлхий дээр шилжүүлэн байрлуулна!

“Ариун хот, шинэ Иерусалим нь нөхөртөө очихоор гоёсон сүйт бүсгүй мэт бэлтгэгдэн Бурханаас гарч, тэнгэрээс буун ирэхийг би харлаа. Сэнтийнээс чанга дуу гарахыг би сонсов. ‘Харагтун, Бурханы асар хүмүүсийн дунд байна. Тэр тэдний дунд нутаглах болно. Тэд Түүний ард түмэн болж, Бурхан Өөрөө тэдний дунд байж тэдний Бурхан нь болно.’” Илчлэлт 21:2,3

Шинээр бүтээгдэх дэлхий маань төгс байх болно!

а) “Тэгээд сохрын нүд нээгдэж, дүлийгийн чих нь онгойно. Тэгээд доголлон хүн буга мэт дүүлж,

хэлгүй нь баяртайгаар хашхирна. Учир нь цөлөөс ус гарч, Арабад урсана.” Исаиа 35:5,6

б) “Чоно хургатай хамт бэлчин, арслан үхэр мэт сүрэл идэж, шороо нь могойн хоол болно. Тэд Миний бүх ариун ууланд ямар ч муу, хор хөнөөл үйлдэхгүй. гэж Эзэн айлдаж байна.”

Исаиа 65:25

в) “Тэд цаашид өлсөх ч үгүй, цангах ч үгүй. Тэд наранд шарагдах ч үгүй, ямар ч халуунд халах ч үгүй.”

Илчлэлт 7:16

г) “Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо.”

Илчлэлт 21:4

Бурханы аварсан хүмүүс бүгд сэтгэл дүүрэн байх болно!

“Тэд гэр барьж, түүн дотроо сууна. Тэд бас усан үзэм тариалж, үр жимсийг нь иднэ. Тэд барихгүй, өөр хүн сууна. Тэд тарихгүй, бусад нь иднэ. Харин Миний ард түмний өдрүүд нь модны амьдрах хугацаа шиг болох бөгөөд Миний сонгосон хүмүүс өөрсдийнхөө гарын бүтээлийг өмсөнө.”

Исаиа 65:21,22

Тэд Бурханыг магтан хүндэлж, Түүнд залбиран мөргөнө:

“Шинэ сараас шинэ сар хүртэл, амралтын өдрөөс амралтын өдөр хүртэл бүх махан бие Миний өмнө мөргөхөөр ирнэ.”

Исаиа 66:23

Есүсийн хэлснээр бид Библид гардаг зарим нэгэн хүмүүстэй танилцах болно:

“Та нарт Би хэлье. Дорноос хийгээд өрнөөс олон хүн ирж тэнгэрийн хаанчлалд Абрахам, Исаак, Иаковтай хамт ширээнд сууна.” Матай 8:11

Дагалдагч Паулын хэлснээр, найз нөхөд бие биентэйгээ диваажинд тааралдаж, түүнчилэн бие биенээ ч таних болно:

“Учир нь бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, харин дараа нь нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ харин дараа нь би бүрэн мэдэх болно.”

1 Коринт 13:12

Бодож цэгнэх амлалтууд:

“Нүдэнд үзэгдээгүй, чихэнд сонсогдоогүй, хүний санаанд ороогүй юмсыг Бурхан Өөрийг нь хайрладаг хүмүүст бэлджээ.” 1 Коринт 2:9

ЕСҮС ДАХИН ИРЭХ БОЛНО!

Есүс шүүгдэж байхдаа Тэргүүн тахилчид ямар амлалт хэлсэн бэ?

“Та өөрөө хэллээ. Харин Би та нарт хэлье. Та нар үүнээс хойш Хүчит Нэгэний баруун талд залрах Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дээр залран ирэхийг харах болно.” Матай 26:64

Яагаад Есүс дэлхийд дахин ирэх вэ?

“Та нар зүрхээ бүү зовоо. Бурханд итгэ, мөн Надад итгэ. Миний Эцэгийн гэрт орон байр олон бий. Хэрэв тийм биш байсан бол Би та нарт хэлэх байсан. Би та нарт орон байр бэлдэхээр явна. Хэрэв Би явж та нарт орон байр бэлдвэл, дахин ирж, та нарыг Өөртөө авна. Би хаана байна, та нар мөн тэнд байх болно.” Иохан 14:1-3

Есүсийн ирэх өөр шалтгаан байна уу?

а) “Учир нь Хүний Хүү тэнгэр элч нарын хамт Эцэгийнхээ алдрын дотор ирж, хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө.” Матай 16:27

б) “Харагтун, Би удахгүй ирнэ. Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөхийн тулд Миний шагнал Надтай хамт байгаа.”

Илчлэлт 22:12

Түүний дахин ирэлт бодитой байх болно!

Диваажингийн элч нарын хэлснээр, Христ энэ дэлхий дээр хэрхэн ирнэ гэж хэлсэн бэ?

“Тэр ийнхүү айлдсаны дараа тэднийг харж байхад нь дээш өргөгдөж үүлэнд орж тэдэнд харагдахгүй болов. Түүний одохыг харж тэнгэр өөд гөлрөн байсан тэдний хажууд цагаан өмсгөлтэй хоёр хүн зогсоод хэлсэн нь, ‘Галилын эрчүүд ээ, юунд та нар тэнгэр ширтэн зогсоно вэ? Та нараас өргөгдөн тэнгэрт аваачигдсан энэ Есүс нь та нарын Түүнийг тэнгэр өөд явсныг нь харсан лугаа адил тийн буцаж ирнэ’ гэв.”

Үйлс 1:9-11

Түүний ирэлт нь харагдахуйц байх болно!

**Есүсийн дахин ирэхэд амьдарч байх бүх хүмүүс
Түүний ирэхийг харах болно:**

а) “Харагтун, Тэр үүлсийн хамт ирэх бөгөөд нүд бүр Түүнийг харна. Тэр байтугай Түүнийг жадалсан хүмүүс ч харна. Дэлхийн бүх овгууд Түүнээс болж гашуудах болно. Тийм ээ, Амен.”

Илчлэлт 1:7

б) “Дэлхийн хаад, агуу хүмүүс, мянгатын дарга нар, баячууд, хүчтэнүүд, боол хийгээд чөлөөт хүн бүр агуй болоод уулсын хавцалд нуугдацгааж, уулс ба хадан цохионуудад хандан, ‘Бидний дээр унаж, биднийг сэнтийнд Залрагчийн нүүрнээс, Хурганы уур хилэнгээс

далдлаач. Тэдний уур хилэнгийн агуу өдөр нь иржээ. Хэн тэсэж чадах вэ?” гэгцгээв.”
Илчлэлт 6:15-17

Түүний дахин ирэлт нь сонсогдохуйц байх болно!

**Есүсийг ирэх үед ямар сүр хүчтэй дуу дэлхийг
доргиож байх бэ?**

“Учир нь Эзэн Өөрөө тушаалын үгтэй, тэргүүн тэнгэр элчийн дуу ба Бурханы бүрээн дуунаар тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христийн дотор үхэгсэд эхлээд амилах болно.”
1 Тесалоник 4:16

**Есүсийн ирэх өдрийн чих дүлийрэм дуу чимээг
Петр хэрхэн дүрслэн хэлсэн бэ?**

“Гэвч Эзэний өдөр нь хулгайч мэт ирэх болно. Тэгэхэд тэнгэр нүргэлээд өнгөрнө. Аливаа бодисууд нь галд устгагдах бөгөөд газар болоод түүн дээрх ажлууд нь шатаагдана.”
2 Петр 3:10

Түүний ирэлтийн үед гэнэтийн, гайхалтай өөрчлөлт гарах болно!

**Есүсийг ирэх үед ямар гайхалтай өөрчлөлт
гарах вэ?**

“Харагтун, би та нарт нэгэн нууцыг хэлье. Бид бүгдээрээ нойрсохгүй, харин бүгдээрээ өөрчлөгдөх болно. Ингэхдээ нүд ирмэхийн зуур, нэг агшинд, бүрээн эцсийн дуугаар тийм болно. Учир нь бүрээ дуугарч, үхэгсэд үл муудах уруу амилуулагдаж, бид ч өөрчлөгдөнө.”
1 Коринт 15:51,52

Тэнгэр элч нар бууж ирэхэд Есүс ямар тушаал өгөх вэ?

“Тэгээд Хүний Хүүгийн тэмдэг тэнгэрт илэрхийлэгдэхэд газрын бүх овог гашуудан уйлж, Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дээр сүр хүч болоод агуу цог жавхлантайгаар ирэхийг харна. Тэр тэнгэр элч нараа их бүрээн дуугаар илгээхэд тэд сонгогдогсдыг нь тэнгэрийн нэг хязгаараас нөгөө хязгаар хүртэл дөрвөн салхинаас цуглуулах болно.”

Матай 24:30,31

Христийг ирэх үед зөв шударгаа, амьд буй хүмүүст юу тохиолдох вэ?

“Дараа нь амьд хийгээд үлдсэн бид тэдэнтэй хамт агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн дотор өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно.”

1 Тесалоник 4:17

Агуу газар хөдлөлт болох болно:

“Асар хүчтэй газар хөдлөлт болж...хуйлсан хуйлмал ном лугаа адил тэнгэр ч заагдан салж, алив уулс, арлууд ч байрнаасаа хөдөлсөн байлаа.”

Илчлэлт 6:12,14

Түүний ирэлт сүр жавхлантай байх болно!

Христийн ирэлтийн үеийн сүр жавхланг юутай зүйрлэж болох вэ?

“Аянга зүүн зүгээс цахиж, баруун зүгт ч гялбуулдаг шиг, Хүний Хүүгийн заларч ирэх нь тийм байх болно.”

Матай 24:27

Христийн ирэхэд Түүний агуу алдраас гадна хэний алдар гэрэлтэх вэ?

“Хэн Надаас болон Миний үгсээс ичнэ, Хүний Хүү Эцгийн болон Өөрийн, мөн ариун тэнгэр элч нарын суу алдраар ирэхдээ түүнээс ичих болно.”

Лук 9:26

Хуурамч Христүүдээс сэрэмжил!

Есүс дагалдагч нараа хууртагдахгүй байхыг сануулан ямар тодорхой сэрэмжлүүлгийг өгсөн бэ?

а) “Тиймээс хэрэв тэд та нарт ‘Хараач, Тэр цөлд байна’ гэвэл бүү оч, эсвэл ‘Хараач, Тэр дотоод өрөөнд байна’ гэвэл бүү итгэ. Аянга зүүн зүгээс цахиж, баруун зүгт ч гялбуулдаг шиг, Хүний Хүүгийн заларч ирэх нь тийм байх болно.”

Матай 24:26,27

б) “Хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж, хэрэв боломжтой бол сонгогдогсдыг хүртэл төөрөлдүүлэхийн тулд агуу тэмдгүүд, гайхамшгуудыг харуулах болно.”

Матай 24:24

Түүний ирэлт нь гэнэтийн ирэлт байх болно!

Зөвхөн хэн Есүсийн ирэх өдөр, цагийг мэддэг вэ?

“Харин тэр өдөр, цагийн тухайд хэн ч мэдэхгүй. Тэнгэрийн элч ч , Хүү ч мэдэхгүй. Зөвхөн Эцэг л мэднэ.”

Матай 24:36

Яагаад бид Есүсийн ирэлтэнд ямагт бэлэн байх ёстой вэ?

- а) “Тиймээс та нар бас бэлэн бай. Хүний Хүү та нарын бодоогүй цаг мөчид ирнэ.” Матай 24:44
- б) “Та нарын зүрх сэтгэл хэт идэж уух явдал, согтуурал болон амьдралын санаа зовнилоор дарамтлагдахгүйн тулд болгоомжтой байгтун. Тэрхүү өдөр та нар дээр хавх мэт гэнэт ирнэ. Энэ нь газрын бүх гадаргаар нутаглагсдын дээр ирэх болно. Харин Хүний Хүүгийн өмнө зогсох, мөн болох гэж буй энэ бүхнээс зайлсхийх хүч чадалтай байхын тулд залбирч, ямагт сэргэг байгтун.” Лук 21:34-36

Бодож цэгнэх амлалтууд:

“Хайртууд минь, бид одоо Бурханы хүүхдүүд. Бидний ямар байх нь хараахан үзэгдээгүй. Түүний үзэгдэх үед бид Түүнтэй адил болно гэдгийг мэднэ. Учир нь бид Түүнийг яг байгаагаар нь харах болно. Түүнд ийнхүү найдаж байгаа аливаа хүн өөрийгөө цэвэршүүлдэг. Учир нь Тэр цэвэр ажээ.”

1 Иохан 3:2,3

“Тэр өдөр, ‘Үзэгтүн. Энэ бол бидний Бурхан байна. Тэр биднийг аврахыг бид хүлээж байсан. Энэ бол бидний хүлээсэн ЭЗЭН. Түүний авралд бүгдээрээ баясан цэнгэцгээе.’ гэж ярих болно”

Исаиа 25:9

ЦАГ ХУГАЦАА БАГА ҮЛДЛЭЭ

Дэлхийн сүүлчийн үеийн талаар Есүсээс дагалдагчид нь ямар асуулт асуусан бэ?

“Түүнийг Чидун ууланд сууж байхад шавь нар Түүн уруу хувьчлан ирж, “Эдгээр зүйл чинь хэзээ болох юм бэ? Таны заларч ирэхэд болон үеийн төгсгөлд ямар шинж тэмдэг байх вэ?”

Матай 24:3

Есүс дэлхийн сүүлчийн үед тохиолдох шинж тэмдгүүдийн талаар ингэж хэлсэн:

Цус урсах ба дайн дажин болно:

“Та нар дайн болоод дайны сураг чимээг удахгүй сонсоно. Айж сандруузай. Тэдгээр нь зайлшгүй болох учиртай бөгөөд төгсгөл нь хараахан биш юм. Үндэстэн үндэстнийхээ эсрэг, хаанчлал хаанчлалынхаа эсрэг босно.”

Байгалийн гамшиг:

“Энд тэндгүй өлсгөлөн болоод газар хөдлөлт болно. Харин энэ бүгд нь төрөх өвдөлтийн эхэн юм.”

Шашин шүтлэгээсээ болж хавчигдана:

“Тэгэхэд хүмүүс та нарыг зовлон гамшигт тушааж, та нарыг ална. Миний нэрээс болж та нарыг бүх үндэстэн үзэн ядах болно. Тэр үед олон хүн бүдрэх бөгөөд нэг нэгнээ тушааж, үзэн ядна.”

Хуурамч зөнч, багш нар бий болж, гэр бүл салж ёс зүйгүй болно:

“Олон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж олныг төөрөгдүүлнэ. Ёс бус байдал өссөнөөс болж олонх хүмүүсийн хайр хөрнө.” Матай 24:6-12

“Сүүлчийн үеийн” бусад шинж тэмдгүүд:

Эдийн засгийн гамшиг

“Баян хүмүүс та нар, нааш ирэгтүн. Өөрсөд дээр чинь ирж буй зовлонгийнхоо төлөө гашуудан уйл. Эд баялаг чинь ялзарч, дээлийг чинь эрвээхий иджээ. Алт, мөнгө чинь зэвэрч... Та нар эцсийн өдрүүдэд эрдэнэсээ хураажээ.” Иаков 5:1-3

Сүүлчийн үед хүн төрөлхтөн хувиа хичээсэн, бардам зантай болно:

“Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг мэдэж ав. Учир нь хүмүүс өөрсдийгөө хайрлагчид, мөнгийг хайрлагчид, сагсуурагчид, их зантай, доромжлогчид, эцэг эхдээ захирагдахгүй, үл талархагч, ариун бус, үл хайрлагч, эвлэршгүй, гүжирдэгчид, биеэ хянадаггүй, хэрцгий, сайныг үзэн ядагчид, тэрслэгчид, бодлогогүй, биеэ тоодог, Бурханыг хайрлагчид байхаас илүү зугаа цэнгэлийг хайрлагчид болох болно. Тэд бурханлаг байдлын дүртэй байх боловч түүний хүчийг нь үгүйсгэдэг. Чи ийм хүмүүсээс зайлсхийж яв.” 2 Тимот 3:1-5

Дэлхийн сүүлчийн үед зөгнөлийн хоёр бичээст хүмүүс анхаарлаа хандуулна:

а) “Харин Даниел чи, цаг хугацааны төгсгөл хүртэл эдгээр үгсийг битүүмжилж, энэ номыг лацдагтун. Олон хүн нааш цааш яван, мэдлэг өсөн нэмэгдэнэ.” Даниел 12:4

б) “Удахгүй болох ёстой юмсыг Өөрийн боолууддаа үзүүлэхийн тулд Бурханы Түүнд өгсөн Есүс Христийн илчлэлт... Энэхүү эш үзүүллэгийн үгсийг уншигч болон сонсоод, үүнд бичигдсэн зүйлсийг сахигчид нь ерөөлтэй ээ! Учир нь цаг ойрхон байна.” Илчлэлт 1:1,3

ТАЙЛБАР: Зөгнөлийн хоёр ном бол дэлхийн сүүлчийн үеийн тухай бичсэн: Эдгээр нь Хуучин гэрээний Даниел, Шинэ гэрээний Илчлэлт номууд юм.

Даниелын зөгнөл болон дэлхийн сүүлчийн үеийн тухай Есүс юу гэж хэлсэн бэ?

“Иймд эш үзүүлэгч Даниелын хэлсэн хоосролын бузар юм ариун газар байхыг та нар (сүүлчийн үеийн Христийн дагалдагчид) харвал (уншигч нь ойлгог), Иудейд байгсад нь уул уруу зугтааг... Учир нь ертөнцийн эхнээс өнөөг хүртэл болоогүй, мөн хэзээ ч болохгүй агуу их гай гамшиг болно. Хэрэв хэн нэгэн та нарт ‘Харагтун, Христ энд байна’, эсвэл ‘Тэнд’ гэвэл түүнд бүү итгэ. Хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж, хэрэв боломжтой бол сонгогсдыг хүртэл төөрөлдүүлэхийн тулд агуу тэмдгүүд, гайхамшгуудыг харуулах болно.”

Матай 24:15,16,21,23,24

Христийг ирэхийн өмнөхөн Илчлэлт номонд бичигдсэн ямар тусгай мэдээ дэлхий даяар тунхаглагдана гэсэн бэ?

«Тэнгэрийн дундуур өөр нэгэн тэнгэр элч нисэж явахыг би харав. Газар дээр суугчид ба аливаа үндэстэн, овог, хэлтэн, ард түмэнд тунхаглагдах

мөнхийн сайн мэдээ түүнд байна. Тэр чанга дуугаар, ‘Бурханаас эмээгтүн. Түүнд алдрыг өргө. Яагаад гэвэл Түүний шүүх цаг ирчихээд байна. Тэнгэр ба газрыг, тэнгис ба усны ундаргуудыг бүтээсэн Түүнд мөргөцгөө.’ гэлээ.” Илчлэлт 14:6,7

Дэлхийн сүүлчийн үеийн эцсийн хямрал нь ямар үйл явдал байх вэ?

“Нар, сар, одод дээр тэмдэг бий болж, тэнгисийн болон давалгааны хүрхрэх шуугианаас үүдэж газар дээрх үндэстнүүдийн дунд айдас төрнө. Тэнгэрийн хүчнүүд сэгсрэгдсэнээс болж дэлхийд ирж буй зүйлсийг тэд санаж, айснаасаа ухаан алдана. Дараа нь тэд хүч болон агуу сүр жавхлантайгаар үүлэн дээр залран ирэх Хүний Хүүг харна.” Лук 21:25-27

Эдгээр шинж тэмдгүүд биелсэний дараа Бурханы аварсан хүмүүс юу хийх хэрэгтэй вэ?

“Харин эдгээр нь биелж эхлэх үед цэх зогсож тэргүүнээ өргө. Учир нь та нарын золилт ойртож байна.” Лук 21:28

Эцэст нь Есүс дагалдагч нартаа ямар зөвлөгөө өгсөн бэ?

“Та нарын зүрх сэтгэл хэт идэж уух явдал, согтуурал болон амьдралын санаа зовнилоор дарамтлагдахгүйн тулд болгоомжтой байгтун. Тэрхүү өдөр та нар дээр хавх мэт гэнэт ирнэ... Харин Хүний Хүүгийн өмнө зогсох, мөн болох гэж буй энэ бүхнээс зайлсхийх хүч чадалтай байхын тулд залбирч, ямагт сэргэг байгтун.” Лук 21:34,36

БУРХАНЫ ХУУЛИЙН ТАЛААР

Христ Бурханы хуулийн тухай юу гэж үздэг байв?

“Бурхан минь ээ, би Таны хүслийг гүйцэлдүүлэхдээ баярладаг юм. Таны Хууль миний зүрхэнд бий.” Дуулал 40:8

Есүс хамгийн алдартай сургаал номлолдоо Бурханы Хуулийн талаар юу гэж хэлсэн бэ?

“Хуулийг эсвэл Эш үзүүлэгчдийг хэрэгсэхгүй болгохоор Намайг ирсэн гэж бүү бод. Хэрэгсэхгүй болгохын тулд бус, харин гүйцэлдүүлэхийн тулд Би ирсэн юм. Үнэнээр Би та нарт хэлье, тэнгэр газрыг алга болтол, бүгд биелэгдтэл Хуулиас ганц ч үсэг, ганц ч зураас алга болохгүй.” Матай 5:17,18

Бурхан Өөрийн хуулийг хэрхэн хүмүүст таниулсан бэ?

“Тэр Мосетэй Синай уулан дээр ярилцаж дуусаад, түүнд гэрчлэлийн хоёр хавтан болох Бурханы хуруугаар бичигдсэн чулуун хавтангуудыг өгөв.” Египетээс гарсан нь 31:18

Бурханы хуулийн талаар доорхи баримтуудыг сайтар анхаарна уу?

- а. Египетээс гарсан нь 20: 1-17 дээр бичигдсэн Бурханы Арван Хууль бичигдэхэд ямар ч хүний оролцоо шаардагдаагүй. Библийн бусад бүх бичээсүүд зөгнөлчдийн гараар бичигдсэн. Харин Арван Хуулийг хүний гараар бичээгүй!

Бурханы Үг болох Библийн үгсийн аль нэг хэсэг нь нөгөөгөөсөө илүү ариун байх аваас энэ нь Арван Хууль байх болов уу!

Засгийн газар хууль, дэг журамгүйгээр оршин тогтнож чадахгүй. Нийгэм ч гэсэн хууль дүрэмгүйгээр байж чадахгүй. Хүн тодорхой дүрэмгүйгээр ажил эрхэлж чадахгүй. Хүүхдүүд тоглоомын дүрмийг мэдэхгүйгээр тоглож чадахгүй ба байгаль хүртэл өөрийн хуультай байдаг! Тэгвэл Бурхан Өөрийн орчлон ертөнцийг хуулиараа удирддагт гайхах хэрэг байна уу?

б. Бурхан гараараа чулуун хавтан дээр бичсэн Арван хууль нь Гэрээний хайрцаг ДОТОР байрлаж байсан.

“Тэгэхэд ЭЗЭН надад ‘Чи түрүүчийнх шигээ хоёр чулуун хавтанг засаж янзлаад, уулан дээр Над уруу хүрч ир... Чиний буталсан түрүүчийн хавтангууд дээр байсан үгсийг Би тэр хавтан дээр бичье. Чи түүнийг тэр авдартаа хий’... Чуулган болсон тэр өдөр Эзэн уулан дээр галын дундаас та нарт хандаж айлдсан Арван Хуулиа түрүүчийн адил хавтангууд дээр бичээд, түүнийгээ надад өгсөн билээ... Тэгээд би буцаж, уулаас буугаад, ЭЗЭНий надад тушаасан ёсоор нөгөөх хавтангуудаа өөрийнхөө хийсэн авдарт хийсэн бөгөөд хавтангууд одоо ч тэндээ байгаа.”

Дэд хууль 10:1-5

в. Мосегийн (чулуун дээрхээс гадна) бичсэн хоёр дахь “хууль” нь гэрээний авдрын дэргэд байрлуулагдсан байв.

“Мосе энэ хуулийн үгсийг номонд бүрэн бичиж дууссанахаа дараа, ЭЗЭНий гэрээний авдрыг өргөлцөж явдаг левичүүдэд хандан тушааж ‘Энэ хуулийн номыг аваад, ЭЗЭН Бурханыхаа гэрээний авдрын хажууд тавь. Тэр нь та нарын эсрэг гэрч болж тэндээ байг.’” Дэд хууль 31:24-26

Бурханы хуулийн зорилго нь юу вэ?

“Тэгвэл бид юу ярих вэ? Хууль нь нүгэл үү? Бүү ийм байх болтугай! Гэхдээ Хуулиар биш бол би нүглийг мэдэхгүй байх байсан. Учир нь хэрэв Хууль ‘Бүү шунахайр’ гэж хэлээгүй байсан бол би шунахайрлыг мэдэхгүй байх байсан.” Ром 7:7

Мосегийн хуулийн зорилго нь юу байсан бэ?

“Тэгвэл юуны тулд Хууль байгаа юм бэ? Нүгэл хилэнцээс болж нэмэгджээ.” Галат 3:19

ТАЙЛБАР: Аз дутахад Паул хоёр хуулийг хооронд нь нэг их зааглалгүйгээр бичдэг байсан. Тэрээр хоёр төрлийн хуулийг зөвхөн “хууль” гэж өгүүлсэн байсан. Үүнээс болж ихэнх хүмүүс Бурханы Хуулийг (Арван Хууль) хүчингүй болгосон гэж бодож эхэлжээ. Ямар ч байсан гол утгыг нь сийрүүлэн уншвал Паул ёмар хуулийг онцлон ёрьж байсан болохыг ойлгож болно. “Хуулийн номд бичигдсэн” Галат 3:10 дээр бичсэнээр бол энэ нь чулуун дээр бичигдээгүй Мосегийн хуулийн тухай өгүүлж байсан юм.

Бурхан болон өөрийн хөршийг хайрладаг хүн Бурханы Хуулийг биелүүлдэг!

Есүс хэлэхдээ:

“Чи бүх зүрх, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла. Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн. Удаахи нь ‘Чи хөршөө өөрийн

адил хайрла’ гэсэнтэй адил юм. Энэ хоёр тушаал дээр бүх Хууль болоод Эш үзүүлэгчид тулгуурладаг юм.”
Матай 22:37-40

Тайлбар: Зарим хүмүүс Библийг хэтэрхий тайлбарлан Арван Хууль бол Эцэг Бурханых, харин Христийн хууль нь Хуучин Гэрээний Арван Хуулиас тустай хоёрхон хуулиас бүрддэг гэж номчирхдог. Арван Хуулийг сайтар судлаад үзвэл эхний дөрөв нь Бурханыг хайрлах тухай, үлдсэн зургаан хууль нь хөршийгөө хайрлах тухай заасан байдаг. Ийм ч учраас Есүс, “энэ хоёр тушаал дээр бүх Хууль болоод эш үзүүлэгчид тулгуурладаг” гэж хэлсэн юм. Эцэг Бурханы болон Есүсийн хууль нэг ижил зүйл юм.

“Би Эцэгийнхээ тушаалыг сахьж, Түүний хайр дотор байдгийн адил, та нар Миний тушаалыг сахивал Миний хайр дотор байх болно.”

Иохан 15:10

“Хэн боловч эдгээр тушаалуудаас хамгийн өчүүхнийг нь ч үл тоомсорлож, бусдад тийн сургавал тэнгэрийн хаанчлалд хамгийн өчүүхэн нэгэн гэгдэх болно. Харин хэн боловч тэдгээрийг сахьж, сургавал тэнгэрийн хаанчлалд агуу нэгэн гэгдэх болно.”

Матай 5:19

“Хэрэв чи амьтай болохыг хүсэж байгаа бол тушаалуудыг сахь.”

Матай 19:17

Паул бичихдээ:

“Нэг нэгэндээ хайртай байхаас өөр хэнд ч ямар ч өргүй бай. Учир нь бусдыг хайрладаг хүн хуулийг биелүүлсэн хэрэг. Учир нь ‘Бүү завхайр, бүү ал, бүү хулгай хий, бүү шунахайр’ гэсэн тушаал болоод өөр ямар ч тушаал байна, энэ нь ‘Хөршөө өөрийн адил

Бурханы Хууль, Мосегийн хуулийн
хоорондын харьцуулалт

Бурханы Хууль	Мосегийн Хууль
«ЭЗЭНий хууль» гэж нэрлэгддэг Исаиа 5:24	«Мосегийн хууль» гэж нэрлэгддэг Лук 2:22, 1 Коринт 9:9
Бурхан чулуун хавтан дээр бичсэн Египетээс гарсан нь 31:18; 32:16	Мосе ном болгон бичсэн Шастирын дэд 35:12, Дэд хууль 31:24
Гэрээний хайрцагт хадгалагдаж байсан Дэд хууль 10:2,5	Гэрээний хайрцагны хажууд байсан Дэд хууль 31:26
Гэмийг таниулдаг Ром 7:7, 3:20	Гэмээс болж нэмж бичигдсэн Галат 3:19
Хүнд дарамт биш 1 Иохан 5:3	Бидний эсрэг Колоссай 2:14
«Хаан хууль» гэж нэрлэгддэг Иаков 2:8	«Зарлигийн хууль» гэж нэрлэгддэг Ефес 2:15
Бүх хүн төрөлхтнийг шүүдэг Иаков 2:10-12	Хэнийг ч шүүдэггүй Колоссай 2:14-16
Сүнслэг Ром 7:14	Махан биеийн Еврей 7:16
Төгс Дуулал 19:7	Юуг ч төгс болгодоггүй Еврей Еврей 7:19

хайрла’ гэсэн үгийн дотор агуулагддаг юм. Хайр бол хөршдөө буруу зүйл үйлддэггүй. Иймд хайр нь хуулийн биелэлт мөн.” Ром 13:8-10

Библийн дүгнэлт:

Хуучин Гэрээ

“Энэ бүхнийг сонордоод дүгнэхэд Бурханаас эмээж, Түүний тушаалыг дагагтун. Энэ нь хүн бүхэнд хамаарна.” Номлогчийн үгс 12:13

Шинэ Гэрээ

“Учир нь бүх хуулийг сахивч нэг дээр нь бүдрэх хэн боловч бүх хуулийг зөрчсөн болно. Учир нь ‘Бүү завхайр’ гэж айлдсан Тэр бас ‘Хүн бүү ал’ гэсэн юм. Хэрэв чи завхайраагүй хэрнээ хүн алвал, хуулийн гэмт хэрэгтэн болно. Эрх чөлөөний хуулиар шүүгдэх гэж буй тэдгээр хүмүүс шиг тийнхүү ярь, тийнхүү үйлд.” Иаков 2:10-12

Хууль ба Нигүүлсэл

Библид гэгийг юу гэж тодорхойлсон бэ?

“Нүгэл үйлддэг хүн бүр бас ёс бус хэрэг үйлддэг. Нүгэл бол ёс бус хэрэг юм.” 1 Иохан 3:4

Хичнээн хүмүүс гэм нүгэл үйлдсэн бэ?

“Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй.” Ром 3:23

Гэм нүгэлтнүүд бүгдээрээ ямар үүрэг хүлээх вэ?

“Учир нь нүглийн хөлс бол үхэл.” Ром 6:23

Тэгвэл гэмтнүүдийг Бурхан хэрхэн авардаг юм бэ?

а. “Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний зэн Христ Есүс доторх мөнх амь мөн.” Ром 6:23

б. “Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно.” Ефес 2:8,9

Паулын хэлснээр, бидний Христэд итгэсэн итгэл Бурханы хуульд ямар нөлөө үзүүлдэг вэ?

“Тэгвэл бид итгэлээрээ Хуулийг хүчингүй болгох уу? Бүү ийм байх болтугай! Харин ч, бид Хуулийг тогтоодог.” Ром 3:31

Хэрэв бид хуулийг сахивал, энэ нь биднийг авралд хүргэх үү?

“Яагаад гэвэл ямар ч махан бие Хуулийн үйлсээр Түүний өмнө зөвтгөгдөхгүй...” Ром 3:20

Тэгвэл хуулийн зорилго нь юу юм бэ?

“Яагаад гэвэл ямар ч махан бие Хуулийн үйлсээр Түүний өмнө зөвтгөгдөхгүй. Хуулиар нүглийн мэдлэг ирдэг юм.”
Ром 3:20

Хэрэв хууль зөвхөн гэмийг таниулж өгдөг юм бол, бид хэрхэн гэм нүглээсээ ангижирч, аврагдаж болох юм бэ?

“Харин Тэр Өөрөө гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс ангижруулдаг ажээ.”

1 Иохан 1:7

Тайлбар: Хууль нь зөвхөн бидний гэм нүглийг тодорхой болгож өгдөг. Хууль бидний тодорхой гэм нүглийг уучилж өгч чадахгүй. Уучлал зөвхөн Есүс Христийн загалмайн үхлийг хүлээж авснаар ирдэг. Иаков 1:23-25 дээр толь бидний нүүр царайг хиртэй байгааг мэдүүлж өгдөг ч бидний нүүрийг цэвэршүүлж өгдөггүй гэж бичсэн байдаг. Бид нүүрээ цэвэрлэхийн тулд саван, усаар нүүрээ угаах хэрэгтэй. Гэм нүглийн тухайд бол Бурханы хууль бол гэмийг мэдүүлж өгдөг толь юм. Есүсийн цус бидний гэмийг биднээс зайлуулдаг.

Нигүүлсэл нь биднийг Бурханы хуулийг зөрчих зөвшөөрөл олгодог уу?

“Тэгвэл бид юу гэж хэлэх вэ? Нигүүлсэл нь ихсэхийн тулд бид нүгэл дотор байсаар байх уу? Бүү ийм байх болтугай! Нүгэлд үхсэн бид, цаашид түүн дотроо хэрхэн амьдрах вэ? Учир нь нүгэл та нарыг захирахгүй. Яагаад гэвэл та нар хуулийн дор байгаа бус, харин нигүүлслийн дор байдаг.”

Ром 6:1,2,14,15

ТАЙЛБАР: Бурханы хуулийг зөрчихийг гэм нүгэл гэдэг. Есүс бид бүгдийг гэм нүглээс аврахаар ирсэн болохоос биш гэм нүгэлтэй байлгахаар ирээгүй. Нигүүлсэл, уучлал гэдэг нь гэм үйлдээд бай гэсэн зөвшөөрөл биш. Бурхан бидэнд Өөрийн хүчийг өгснөөр бид гэм нүгэл хийхгүй байх боломжтой болдог.

Тэнгэрийн Эцэг Өөрийн хуулийн талаар ямар амлалт өгсөн бэ?

“Учир нь тэр өдрүүдийн дараа Израилийн гэртэй байгуулах Миний гэрээ энэ юм. Би Өөрийн хуулиудыг тэдний ухаан санаанд оруулж, Би тэдний зүрхэнд бичнэ. Би тэдний Бурхан болж, тэд Миний ард түмэн болно.”

Еврей 8:10

Библийн сүүлчийн бүлэгт ямар тусгай ивээлийн тухай өгүүлдэг вэ?

“Амийн мод уруу очих эрхтэй болохын тулд болон хаалгаар хот уруу орохын тулд дээлээ угаагчид нь ерөөлтэй ээ!”

Илчлэлт 22:14

Бодож цэгнэх амлалт:

“Намайг ‘Эзэн минь, Эзэн минь’ гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно.”

Матай 7:21

САНАН ДУРСАХ ӨДӨР

Бурхан тэнгэр, дэлхийг зургаан өдөрт бүтээсэн. Тэрээр долоо дахь өдрийг тусгай өдөр болгон юу хийсэн бэ?

- а. “Долоо дахь өдөр болоход Бурхан Өөрийн хийж бүтээсэн бүх ажлаа дуусгаж,
- б. хийж бүтээсэн ажил нь дууссан учир долоо дахь өдөртөө Тэрээр амарчээ.
- в. Бурхан долоо дахь өдрийг срөөж, ариун болгов.”

Эхлэл 2:2,3

Долоо дахь өдөр гэж аль өдөр вэ?

Толь бичигт бичигдсэнээр:

“Долоо дахь өдөр буюу Бямба гариг нь долоо хоногийн жинхэнэ долоо дахь өдөр юм.” (Webster’s New Twentieth Century Dictionary, Unabridged Second Edition, 1973).

Библийн туршид, долоо дахь өдрийг онцгойлон юу гэж нэрлэж байсан бэ?

“Учир нь ЭЗЭН тэнгэр, газар, далай болон тэдгээрийн дотор байгч бүгдийг зургаан өдөрт бүтээж, долоо дахь өдөрт амарсан. Тиймээс Эзэн Амралтын (Шаббат) өдрийг срөөн, тэр өдрийг ариун болгосон юм.” Египетээс гарсан нь 20:11

Библиэс авч үзэхэд, энэ өдөр хэнд зориулагдсан бэ?

“Амралтын өдрийг ариунаар сахихын тулд санагтун. Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, бүх ажлаа

хий. Харин долоо дахь өдөр бол чиний Бурхан ЭЗЭНий амралт тул... ямар ч ажил хийж болохгүй.”

Египетээс гарсан нь 20:8-10

ТАЙЛБАР: Өмнөх хичээлдээр бид Бурханы Арван Хууль ямар чухал болох талаар судалсан. Учир нь Бурхан Өөрийн гараар бичиж үлдээсэн юм. Арван Хуулийг уншиж үзвэл Шаббат өдрийн хууль буюу дөрөв дэх хуулийг бусад хуулиудтай харьцуулахад Бурхан хичнээн үгээр бичсэнийг ажиглья.

Дөрөв дэх хуулинд тодорхой ямар гурван заавар өгөгдсөн бэ?

1. “Амралтын өдрийг ариунаар сахихын тулд санагтун.” Египетээс гарсан нь 20:8
2. «Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, бүх ажлаа хий.” Египетээс гарсан нь 20:9
3. “Харин долоо дахь өдөр (Шаббат)... ямар ч ажил хийж болохгүй.” Египетээс гарсан нь 20:10

Бодож цэгнэгтүн:

Есүсийн үгс:

А. “Би Эцэгийнхээ тушаалыг сахиж, Түүний хайр дотор байдгийн адил, та нар Миний тушаалыг сахивал Миний хайр дотор байх болно.”
Иохан 15:10

Есүсийн жишээ:

- Б. “Есүс Өөрийн өссөн хот Назартаа ирж, заншсан ёсоороо Амралтын өдөр синагогт орж, Судраас уншихаар босов.” Лук 4:16
- В. “Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байна.” Еврей 13:8

Бурханы Хууль

1

Чи Надаас өөр бурхадтай байж болохгүй.

2

Чи өөртөө зориулан шүтээн эсвэл дээр тэнгэр дэх, доор газар дахь, газрын доор усан доторх юмны ямар нэг дүрсийг бүү хий.

Чи тэдэнд мөргөж, тэдэнд үйлчилж болохгүй. Учир нь чиний Бурхан ЭЗЭН Би бол хартай Бурхан бөгөөд Намайг үзэн ядагчдын гурав, дөрөв дэх үеийн хүүхдэд нь хүртэл эцгүүдийнх нь нүглийн шийтгэлийг буулгадаг. Харин Намайг хайрлаж, Миний тушаалыг сахигчдад мянган үед нь хүртэл хайр энэрлээ үзүүлдэг.

3

Чи өөрийн Бурхан ЭЗЭНий нэрийг дэмий бүү дурд.
Учир нь ЭЗЭН Өөрийнх нь нэрийг дэмий дурдагчийг шийтгэлгүй орхихгүй.

4

Амралтын өдрийг ариунаар сахихын тулд санагтун. Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, бүх ажлаа хий. Харин долоо дахь өдөр бол чиний Бурхан ЭЗЭНий амралт тул чи болон чиний хүү, чиний охин, чиний зарц, шивэгчин, чиний мал, танайд байгаа зочин ямар ч ажил хийж болохгүй. Учир нь ЭЗЭН тэнгэр, газар, далай болон тэдгээрийн дотор байгч бүгдийг зургаан өдөрт бүтээж, долоо дахь өдөрт амарсан. Тиймээс ЭЗЭН Амралтын өдрийг срөөн, тэр өдрийг ариун болгосон юм.

5

Эцэг эхээ хүндэл. Тэгвэл чиний Бурхан Эзэний чамд өгсөн газар дээр чи урт наслах болно.

6

Чи хүн бүү ал.

7

Чи бүү завхайр.

8

Чи бүү хулгайл.

9

Чи хөршийнхөө эсрэг худал бүү гэрчил.

10

Чи хөршийнхөө гэр оронд бүү шунахайр. Чи хөршийнхөө эхнэр болон түүний зарц, түүний шивэгчин, түүний үхэр, түүний илжиг, хөршийнхөө юунд ч бүү шунахайр.

Шинэ Гэрээ номон дээр бүхнийг хэн бүтээсэн гэж бичсэн байдаг вэ?

А. “Эрт үед эш үзүүлэгчдээр дамжуулан эцэг өвгөдөд олон хэсгээр болон янз бүрийн арга замаар айлдсан Бурхан эдгээр эцсийн өдрүүдэд Өөрийн Хүүгийн дотор бидэнд хандаж айлдав. Тэр Хүүгээ бүхний өвлөгчөөр томилсон бөгөөд Хүүгээрээ ертөнцийг бүтээсэн билээ.”

Еврей 1:1,2

Б. “Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй. Тэр ертөнцөд байсан. Ертөнц Түүгээр бий болсон атал, ертөнц Түүнийг таньсангүй. Тэр өөрийнхөндөө ирсэн боловч, өөрийнх нь Түүнийг хүлээн авсангүй. Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц Хүүгийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байсан юм.”

Иохан 1:1,3,10,11,14

Тайлбар: Есүс бидний амьдардаг дэлхийг бүтээсэн. Бүтээгч Өөрөө бидний төлөө амиа зориулахын тулд ирсэн. Бурхантай эн зэрэгцэх Нэгэн, Тэр Өөрөө Бурхан байсан юм. ШАББАТ өДРИЙГ АРИУНААР САХИСНААР БИД ЕСҮСТ ИТГЭСЭН ИТГЭЛЭЭ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, зөвхөн Аврагч биш харин Түүнийг Бүтээгч хэмээн хүлээн зөвшөөрч байгааг харуулж байгаа хэрэг билээ.

Дагалдагч Паул долоо хоногийн хэд дэх өдрийг ариунаар сахидаг байсан бэ?

“Паул өөрийнхөө заншлаар тэдэн уруу очиж, гурван Амралтын өдөр тэдэнд Судраас ухуулав.”

Үйлс 17:2

Паул Еврейчүүд болон харь үндэстнүүдэд Шаббат өдөр сургаалаа айлддаг байсан уу?

“Тэр Амралтын өдөр бүр синагогт сургамжилж, иудейчүүд, грекчүүдийг итгүүлэхийг оролдож байв. Тэр тэдний дунд Бурханы үгийг сурган жил зургаан сар амьдрал.”

Үйлс 18:4,11

Үйлс номд өгүүлснээр харь үндэстнүүд Христийн тухай үнэн мэдээг хэзээ хэлж өгөхийг хүссэн бэ?

“Паул, Барнаб нарыг гарч явахад, хүмүүс дараагийн Амралтын өдөр энэ үгээ ярьж өгөхийг тэднээс хүссээр байлаа... Дараагийн Амралтын өдөр тэр хотынхон бараг бүгдээрээ Эзэний үгийг сонсохоор хуран цугласан байв.”

Үйлс 13:42, 44

Олон зуун жил өнгөрсөн боловч өнөөгийн Христэд итгэгчид Шаббат өдөр долоо хоногийн яг аль өдөр болохыг баттай мэдэж болох уу?

Библийн хариулт:

- “Тэр хүн Пилатад бараалхаж Есүсийн цогцсыг гуйв. Тэгээд цогцсыг нь буулган авч, маалинган даавуунд ороож, хад ухаж бэлтгэсэн булшинд тавив. Тэнд шарил ер нь тавьж байгаагүй ажээ. Энэ нь Амралтын өдрийн өмнөх бэлтгэлийн өдөр байсан юм.” Лук 23:52-54

Тайлбар: Христ “БЭЛТГЭЛИЙН БААСАН” ГАРИГТ НАС БАРСАН. ЕВРЕЙЧҮҮДИЙН ХУВЬД БААСАН ГАРИГ БОЛ ЗУРГАА ДАХЬ ӨДӨР БӨГӨӨД БЭЛТГЭЛИЙН ӨДӨР ГЭЖ НЭРЛЭГДДЭГ. ТЭД БААСАН ГАРИГТАА БЭЛТГЭЛЭЭ ХИЙЖ ТЭР ӨДРИЙНХӨӨ НАР ЖАРГАСНААС ЭХЛЭН ШАББАТ ӨДРИЙГ САХИДАГ БАЙЖЭЭ. БУРХАН ДЭЛХИЙГ БҮТЭЭХДЭЭ ҮДЭШ БОЛОХОД ТЭР ӨДӨР ТӨГСӨХ БУЮУ ШИНЭ ӨДРИЙГ ЭХЛҮҮЛЖ БАЙСАН. (ЭХЛЭЛ 1:5-31). ТИЙМЭЭС Ч БУРХАН ШАББАТ ӨДРИЙГ “НАР ЖАРГАХААС НАР ЖАРГАХ ХҮРТЭЛ” ТЭМДЭГЛЭХИЙГ ЗАХИСАН. (ЛЕВИТ 23:32, МАРК 1:21,32- ҮГ УНШИНА УУ?)

б. “Есүстэй хамт Галилаас ирсэн эмэгтэйчүүд нь дагаж, булш болон Түүний цогцсыг тэнд хэрхэн тавихыг харав. Тэд буцаж ирээд, анхилуун үнэртэн болон үнэрт тос бэлджээ. Амралтын өдөр тэд тушаал ёсоор амрав.” Лук 23:55-56

Тайлбар: Есүсийн хамгийн дотно дагалдагч нар Түүний нас барах үед болон дахин амилсны дараагаар ч ШАББАТ ӨДРИЙГ АРИУНААР САХИЖ БАЙСАН. Есүс өөрөө ШАББАТ ӨДӨР БУЛШИНД АМАРЧ ШАББАТЫГ ӨНГӨРҮҮЛСЭН БА НАС БАРАХДАА ХҮРТЭЛ БУРХАНЫ ТУШААЛУУДЫГ БИЕЛҮҮЛСЭН ЮМ!

в. “Тэд буцаж ирээд, анхилуун үнэртэн болон үнэрт тос бэлджээ. Амралтын өдөр тэд тушаал ёсоор амрав. Харин долоо хоногийн эхний өдөр эрт үүрээр тэд булш үрүү ирэхдээ, бэлдсэн анхилуун үнэртнээ авчрав... дотогш орсон боловч Эзэн Есүсийн цогцсыг олсонгүй.”

Лук 23:56, 24:1,3

Тайлбар: Энэ Библийн ишлэл долоо дахь өдөр ҮГ хэзээ вэ? ГЭДГИЙГ БАРИМТТАЙ НЭЭЖ ОЛОХОД МАШ ИХ ТУС БОЛНО. ТЭГЭХЭЭР ӨНӨӨДРИЙН ХУАНЛИГААР “БҮМБА” ГАРИГ НЬ БИБЛИД ЗААСАН “ШАББАТ” ӨДӨР БУЮУ ДОЛОО ДАХЬ ӨДӨР ЮМ. (МАРК 16:1,2).

Шаббат өдрийн талаархи баримтууд:

Шаббат өдөр нь хүн төрөлхтөнд ивээл болохоор өгөгдсөн юм:

“Тэр тэдэнд бас, ‘Хүн Амралтын өдрийн төлөө бус, Амралтын өдөр нь хүний төлөө бий болсон’.”

Марк 2:27

Шаббат өдөр бол Эзэний өдөр:

“Хүний Хүү Амралтын өдрийн ч Эзэн мөн гэж айлдав.”

Марк 2:28


Шаббат өдөр ажил эрхлэх, худалдаа наймаа хийх өдөр биш билээ:

“Тэр өдрүүдэд Иудад амралтын өдрөөр зарим хүмүүс усан үзмийн шахуурга гишгэж, ууттай үр тариаг авчран, илжгэндээ дарс, үсан үзэм, инжир болон бүх төрлийн ачаа ачаалан, тэднийг амралтын өдрөөр Иерусалимд авчирж буйг би үзэв. Хүнс зарж байсан тэр өдөр нь би тэдэнд анхааруулан сануулав. Мөн тэнд амьдарч байсан Тирийн хүмүүс загас болон бүх төрлийн барааг гаднаас оруулж, тэднийгээ Иудагийн хөвгүүдэд, Иерусалимд ч хүртэл амралтын өдрөөр зарж байв. Тэгэхэд нь би Иудагийн язгууртнуудыг зэмлэн, тэдэнд хандан, ‘Та нар юунд амралтын өдрийг бузарлан, ямар муу үйлийг хийнэ вэ?’”

Нехемиа 13:15-17

Шаббат өдөр нь зугаа цэнгэл хөөх өдөр биш харин сэтгэлээ Бурханд зориулах өдөр юм:

“Хэрэв чи амралтын өдрийг үл бузарлаж, Миний ариун өдөр өөрийн таашаалыг үйлдэхээс татгалзан хөлөө татвал, амралтын өдрийг баясгалант,



ЭЗЭНий ариун өдрийг эрхэм хүндэт гэж нэрлэж, өөрийн замаар явалгүй, өөрийн таашаалыг хайлгүй, чалчилгүй, энэ өдрийг хүндэтгэвэл чи ЭЗЭНий дотор баяр хөөрийг авна. Би чамайг газрын өндөрлөгүүдээр аялуулан, эцэг Иаковын чинь өв хөрөнгөөр чамайг тэжээнэ гэж ЭЗЭНий ам айлдсан юм.”
Исаиа 58:13,14

Есүс шинэ дэлхийг бүтээхэд бид Шаббат өдөр юу хийх вэ?

“Миний бүтээх шинэ тэнгэр, шинэ газар Миний өмнө мөнхөд байх мэт та нарын үр удам, та нарын нэр ч мөнхөд байна” гэж ЭЗЭН тунхаглаж байна. ‘Шинэ сараас шинэ сар хүртэл, амралтын өдрөөс амралтын өдөр хүртэл бүх махан бие Миний өмнө мөргөхөөр ирнэ,’ гэж ЭЗЭН айлдаж байна.”

Исаиа 66:22,23

Есүс Шаббат өдөр ямар зүйл хийх нь хуулинд нийцнэ гэж хэлсэн бэ?

“Есүс тэндээс явж, тэдний синагогт орлоо. Хатингар гартай нэгэн хүн тэнд байжээ. Тэд Есүсийг буруутгахаар, ‘Амралтын өдөр эдгээх нь хуульд нийцэх үү?’ гэж асуухад, Тэр тэдэнд ‘Хэрэв та нарын дундаас хэн нэгэн нь ганцхан хоньтой байгаад тэр нь Амралтын өдөр нүхэнд уначихвал, хонио барьж, тэндээс гаргана биз дээ? Тэгвэл хүн хониноос аль хир эрхэм билээ? Тиймээс Амралтын өдөр сайныг үйлдэх нь хуульд нийцнэ.’”

Матай 12:9-13

Бодож цэгнэх амлалтууд:

“Харин Түүний үгийг сахидаг хэний ч дотор Бурханы хайр үнэхээр төгс болгогджээ. Үүгээрээ бид Түүний дотор байгаагаа мэднэ. Түүний дотор оршдог гэж ярьдаг нэгэн Түүний хэрхэн явсанчлан өөрөө бас тийн явдаг байх ёстой.” 1 Иохан 2:5,6

“Түүний тушаалуудыг сахих нь Бурханы хайр мөн. Түүний тушаалууд нь хүнд дарамт биш билээ.”

1 Иохан 5:3

НЯМ ГАРИГ ЯАГААД ОЛНЫ АНХААРЛЫГ ТАТАХ БОЛОВ?

Бурхан юу гэж амласан бэ?

“Өөрийн гэрээг би зөрчихгүй, Амнаас гарсан авиагаа өөрчлөхгүй.” Дуулал 89:34

Бурханы өөрчлөгдөшгүй гэрээ гэж юу вэ?

“Ингэж ЭЗЭН та нарт гэрээгээ зарлаж, та нарт даган мөрдүүлэхээр тушаасан. Энэ нь Арван Хууль бөгөөд түүнийгээ хоёр чулуун хавтан дээр Өөрөө бичсэн билээ.” Дэд хууль 4:13

Тайлбар: Бурхан Өөрийн бидэнтэй тогтоосон гэрээ, хуулиа хэзээ ч өөрчилж, үгүй болгохгүй гэж амласан билээ. Хэрэв Үмар нэгэн өөрчлөлт гарах байсан бол, гэхдээ Есүс лавтай Үмар ч өөрчлөлт хийгээгүй. Харин Түүнээс өөр нэгэн хийсэн байж болно. Учир нь Тэрээр, “Хуулийг эсвэл Эш үзүүлэгчдийг хэрэгсэхгүй болгохоор Намайг ирсэн гэж бүү бод. Хэрэгсэхгүй болгохын тулд бус, харин гүйцэлдүүлэхийн тулд Би ирсэн юм. Үнэнээр Би та нарт хэлье, тэнгэр газрыг алга болтол, бүгд биелэгдтэл Хуулиас ганц ч үсэг, ганц ч зураас алга болохгүй. Хэн боловч эдгээр тушаалуудаас хамгийн өчүүхнийг нь ч үл тоомсорлож, бусдад ийн сургавал тэнгэрийн хаанчлалд хамгийн өчүүхэн нэгэн гэгдэх болно. Харин хэн боловч тэдгээрийг сахиж, сургавал тэнгэрийн хаанчлалд агуу нэгэн гэгдэг болно.” Матай 5:17-19

Шинэ Гэрээний найман ишлэл

Тайлбар: Библид НҮм гаригийг байнга долоо хоногийн эхний өдөр гэж бичсэн байдаг. Шинэ Гэрээ номонд долоо хоногийн эхний өдрийн тухай найман ишлэл байдаг.

ХЭРЭВ НҮЁМ ГАРИГИЙГ АРИУНААР САХЬ ГЭСЭН ТУШААЛ ГАРСАН БОЛ ЭДГЭЭР НАЙМАН ИШЛЭЛИЙН АЛЬ НЭГЭН ДЭЭР ЗААВАЛ БИЧИГДСЭН БАЙХ ЁСТОЙ ЮМ.

Шинэ Гэрээ номонд долоо хоногийн эхний өдрийн тухай таван ишлэл бичигдсэн байна. Эдгээр ишлэлүүдийн аль нэгэн дээр Ням гаригийг ариун өдөр болгосон тухай үг бичигдсэн байна уу?

1. “Амралтын өдрийн дараа долоо хоногийн эхний өдөр үүрээр Магдалын Мариа болон нөгөө Мариа нар булшийг үзэхээр ирэв.” Матай 28:1
2. “Амралтын өдөр өнгөрөхөд Магдалын Мариа, Иаковын эх Мариа, Саломе нар ирж Түүнийг тослохын тулд анхилуун үнэртэн авлаа. Долоо хоногийн эхний өдөр маш эрт, нар мандсан үед тэд булш уруу хүрч ирэв.” Марк 16:1,2
3. “Долоо хоногийн эхний өдөр Тэр эрт амилаад, эхлээд Магдалын Мариад үзэгджээ. Есүс Мариад шүглэсэн долоон чөтгөрийг зайлуулсан юм.” Марк 16:9
4. “Харин долоо хоногийн эхний өдөр эрт үүрээр тэд булш уруу ирэхдээ, бэлдсэн анхилуун үнэртнээ авчрав.” Лук 24:1
5. “Долоо хоногийн эхний өдөр эрт харанхуй байхад Магдалын Мариа хадан булш уруу очиж, булшны амнаас хадыг зайлуулсан байхыг харав.” Иохан 20:1

Эхний өдрийн тухай зургаа дахь ишлэл дээр Есүсийн дахин амилалтын өдрийн орой дагалдагч нар цугласан байсан тухай өгүүлдэг.

Энэ ишлэл дээр, тэд ямар учраас цугласан гэж бичсэн бэ?

6. “Долоо хоногийн эхний өдөр буюу тэр өдрийн үдэш, шавь нар нь иудейчүүдээс айснаас хаалгаа түгжсэн байв. Гэтэл Есүс ирээд тэдний дунд зогсож, тэдэнд ‘Амар амгалан та нартай хамт байх болтугай’ гэв.”
Иохан 20:19

Тайлбар: Зарим хүмүүс дагалдагч нар Есүсийн дахин амилсан долоо хоногийн эхний өдрийг ариунаар сахихаар цугласан гэж үздэг. Ямар ч байсан, Марк дагалдагч нар Есүсийг дахин амилсан гэдэгт итгэж чадахгүй байсан ба Есүс тэр орой тэдний дунд ирэх хүртэл Түүнийг дахин амилсан гэдэгт итгэхгүй байсан юм. “Дараа нь арван нэгэн шавь нар нь тухлан сууж байхад нь Есүс тэдэнд үзэгдлээ. Тэрээр тэдний итгэлгүйг, хатуу зүрхтэйг зэмлэв. Учир нь Түүнийг амилсных нь дараа харсан хүмүүст тэд итгээгүй юм.” Марк 16:14

Эхний өдрийн тухай долоо дахь ишлэл нь Паул ядууст тусламж үзүүлэх тухай ишлэл дээр бичигдсэн байдаг:

7. “Ариун хүмүүсийн төлөөх хуримтлалын талаар би Галатын чуулгануудад ямар чиг өгсөнчлөн та нар тийнхүү үйлд. Намайг очиход цуглуулахгүйн тулд долоо хоног бүрийн эхний өдөр хүн болгон бололцоогоороо цааш нь хийж хадгал.”

1 Коринт 16:1,2

Тайлбар: Энэ ишлэл дээр Паул Нём гаригийн цуглаан дээр тусламжийн өргөлийг цуглуулахын тулд Шаббат өдрийг өөрчлөх санал гаргаагүй. Харин ч, Паул тусламжийн өргөлийг долоо хоногийн туршид цуглуулж, Шаббат өдөр заах, сургаал айлдахад илүү анхаарал хандуулж байсныг харуулж байна!

Эхний өдрийн тухай сүүлчийн буюу найм дахь ишлэл нь Паулын долоо хоногийн эхний өдөр үдэлтийн цугларалт хийсэн тухай юм:

8. “Долоо хоногийн эхний өдөр талх хуваахаар хамтдаа цуглах үед Паул маргааш явахаар шийдэн, тэдэнтэй ярилцан шөнө дунд болтол яриагаа үргэлжлүүлжээ. Бидний цугласан дээд өрөөнд олон дэнлүү байлаа.” Үйлс 20:7,8

Тайлбар: Дагалдагч нар цуглаад талх хуваалцсан нь тэр өдөр ариун байсан гэсэн үг биш, эхний үеийн итгэгч нар долоо хоногийн эхний өдөр бүр талх хуваалцдаг байсан: “Өдөр өдрөөр тэд нэг санаагаар сүмд цуглаж, талхаа айлуудад хувааж, ба **Ё** хөөртэйгээр болон чин сэтгэлээсээ хооллоцгоож байв.” Үйлс 2:46. Энэхүү цугларалт нь орой болсон гэдгийг та бүхэн сайтар ажиглана уу? 8 дугаар ишлэл дээр, “Бидний цугласан дээд өрөөнд олон дэнлүү байлаа.” Өмнөх хичээлээр Библид өдрийг нар жаргахаас дараа өдрийн нар жаргах хүртэл нэг өдөр хэмээн тооцдог тухай өгүүлж байсан. Үдэш буюу харанхуй болж өдөр эхлээд дараагаар нь нар манддаг байсан. (Эхлэл 1:5,8,13). Паул энэ цугларалтыг **Н** **Ё** гаригийн өдөр эхлэсэн ба өнөөдрийн тооллоор **Б** **Ё** **М** **Б** **А** гаригийн шөнө байсан юм. **Х** **Ё** **Л** **Б** **А** **Р** **Ш** **У** **У** **Л** **С** **А** **Н** **Б** **И** **Б** **Л** **И** дээр, “**Б** **Ё** **М** **Б** **А** **Р** **Ш** **У** **У** **Л** **С** **А** **Н** **Б** **И** **Б** **Л** **И** **Н** **О** **Р** **И** **Д** **Б** **И** **Д** **Н** **Ө** **Х** **Ө** **Р** **Л** **Ө** **Л** **И** **Й** **Н** **З** **О** **О** **Г** **Б** **А** **Р** **И** **Х** **А** **А** **Р** **Ц** **У** **Г** **Л** **А** **С** **А** **Н** **Ю** **М**. **П** **А** **У** **Л** **Х** **У** **М** **Ү** **Ү** **С** **Т** **Э** **Й** **Б** **Ё** **М** **Б** **А** **Р** **Ш** **У** **У** **Л** **С** **А** **Н** **О** **Р** **И** **Д** **Ё** **Р** **И** **Л** **Ц** **А** **Н**, **Ш** **Ө** **НӨ** **Д** **У** **Н** **Д** **Х** **Ү** **Р** **Т** **Э** **Л** **Ү** **Р** **Г** **Э** **Л** **Ж** **И** **Л** **С** **Э** **Н**, **Т** **Э** **Р** **Э** **Э** **Р** **Д** **А** **Р** **А** **А** **Ө** **ДӨР** **НЬ** **Ё** **В** **А** **Х** **А** **А** **Р** **ТӨ** **ЛӨ** **В** **ЛӨ** **Ж** **Б** **А** **Й** **Ж** **ЭЭ**.” гэж орчуулсан байна. Үйлс номонд **Ш** **А** **Б** **Б** **А** **Т** **Ц** **У** **Г** **Л** **А** **Р** **А** **Л** **Т** **Ы** **Н** **Т** **У** **Х** **А** **Й** **84** **У** **Д** **А** **А** **Д** **У** **Р** **Ь** **Д** **С** **А** **Н** **Б** **А** **Й** **Д** **А** **Г** **Б** **О** **Л** **О** **В** **Ч** **ЗӨ** **В** **ХӨ** **Н** **НЭ** **Г** **Л** **У** **Д** **А** **А** **Б** **Ё** **М** **Б** **А** **Р** **Ш** **У** **У** **Л** **С** **А** **Н** **О** **Р** **И** **Д** **А** **Г** **Б** **И** **Ч** **С** **Э** **Н** **Б** **А** **Й** **Д** **А** **Г**. **Э** **НЭ** **НЬ** **З** **А** **Л** **Б** **И** **Р** **Л** **Ы** **Н** **Ц** **У** **Г** **Л** **А** **Р** **А** **Л** **Т** **Ы** **Г** **ӨӨ** **Р** **Ч** **И** **Л** **ГЭ** **СЭ** **Н** **Т** **У** **Ш** **А** **А** **Л** **ГЭ** **Ж** **Ү** **ЗЭ** **Ж** **Б** **О** **Л** **О** **Х** **У** **У**?

Гэвч ихэнх Христэд итгэгчид Шаббат өдрийн оронд Ням гаригийг Бурханы өдөр хэмээн сахиж байна. Хэзээ ийм өөрчлөлт гарсан юм бэ?

ТАЙЛБАР: “Манай Эриний 4 дүгээр зууны эхээр Константин Хаан Ромын хаант улс дахь Ням гаригийг олон нийтийн багц тэмдэглэдэг өдөр болгох тушаал гаргасан юм. Нарны өдөр буюу Ням гариг нь хааны албатууд болох буруу шүтлэгтнүүдийн болон зарим Христэд итгэгчдийн дээдэлдэг өдөр байсан. “Хааны гол зорилго нь Христэд итгэгчид болон буруу шүтлэгтнүүдийн зөрчлийг арилгаж нэгтгэх байсан юм. Үүнийг сүмийн санваартнууд эрх мэдэлд шунан Христэд итгэгчид буруу шүтлэгтнүүд нэг өдрийг дээдлэн үздэг болох юм бол буруу шүтлэгтнүүдийг бараг тэр чигээр нь Христэд итгэгчид болгон сүмийг агуухуч, алдартай болгох боломжтой гэсэн үзлээр Хаанаас хүсэмжилж байжээ.” ЭЛЕН УАЙТ. “АГУУ МЭТГЭЛЦЭЭН” 53-р хуудас.

Дараагаар нь МЭ 364 онд Католик сүмийн Лаодикийн зөвлөл дээр Бурханы ариун өдрийг өөрчилж хүн бүрийг Бямба гаригийн оронд Ням гаригийг ариунаар сахиж тушаал гарчээ.

Асуулт: Католик сүмийнхэн Ням гаригийн талаар Протестант сүмд хандан ямар мэдэгдэл хийсэн бэ?

Хариулт: “Шаббат өдрийг Ням гаригт шилжүүлэх эрхийг сүмийг үндэслэгч, сүмд эрх мэдэл олгогч, тэнгэрлэг, хэзээ ч алдаа гаргадаггүй Есүс Христ өгсөн ба энэ эрх мэдлээр сольсон. Библи бол бидний итгэлийн гол баримтлал гэж тунхагласан Протестант сүмүүдэд Ням гаригийг сахиж эрх байхгүй.” - *The Catholic Universe Bulletin*, August 14, 1942.

“Католицизм өгүүлж байна”

“Ням гариг гэдэг бол Католик сүмийн тогтоосон хууль, Ням гаригийн ёслол, тайлбар нь зөвхөн Католик сүмийн зарчимд хөтлөгдөх ёстой... Библийн судрын эхнээсээ төгсгөл хүртэл долоо хоногийн сүүлчийн өдөр болох хүндэтгэлийн өдрийг долоо хоногийн эхний өдөр болгон өөрчилсөн ганц ч баталгаа байхгүй.”

- *Catholic Press, Sydney, Australia, August, 1900*

“Протестантууд Сүмийн (Ромын Католик) эрх мэдлийг үл зөвшөөрснөөрөө Ням гаригийг дагах ямар ч зөв шалтгаан байхгүй, харин Бямба гаригийг Шаббат хэмээн сахих ёстой билээ.” гэж үзсэн.
- *John Gilmary Shea, in the “American Catholic Quarterly Review,” January 1883*

“Библийн хаана ч Ням гаригийг сахих талаар бичээгүй гэдгийг Пресвитериан, Баптист, Методист буюу бүх Христэд итгэгчдэд сануулах нь зүйтэй байх. Ням гариг гэдэг нь Ромын Католик Сүмийн тогтоосон хууль, Ням гаригийг сахидаг хүмүүс Католик сүмийн тушаалыг сахидаг гэсэн үг.”
- *Priest Brady, in an address, reported in the Elizabeth, N.J. “News” of March 18, 1903*

“Асуулт: - Сүм (Католик) ямар нэгэн ёс заншил, хууль дүрэм тогтоох (ариун өдрийг өөрчлөх) эрхтэй гэдгээ өөр ямар нэгэн аргаар баталж болох уу?”

“Хариулт: - Хэрэв ийм эрх мэдэл байхгүйсэн бол, бүх орчин үеийн пашин шүтлэг бүрээр хүлээн зөвшөөрүүлсэн өөрчлөлт гаргаж чадахгүй байх байсан. Мөн Бямба гариг буюу долоо дахь өдрийг Ням гариг буюу долоо хоног уруу шилжүүлж чадахгүй байх байсан. Энэ өөрчлөлт нь Библийн эрх мэдэл биш байсан.”

- *Stephan Keenan, “A Doctrinal Catechism.” Page 176*

“Эрүүл ухаанаар сайтар бодож үзвэл Протестантчууд Бямба гаригийг ариунаар сахих, эсвэл Католикчууд Ням гаригийг ариунаар сахихаас өөр хоорондын нийцэл, зохицол гэж байхгүй. Үүнийг тохиролцох арга байхгүй.”
- *“The Catholic Mirror,” December 23, 1893*

“Бурхан Өөрийн (Католик) Сүмдээ Ариун Өдөрт тохирох аль ч өдрийг, өдрүүдийг тогтоох хүчийг өгсөн юм. Сүм долоо хоногийн эхний өдөр болох Ням гаригийг сонгож, түүхийн туршид өөр өдрүүдийг ариун болгосон юм.”
- *Vincent J. Kelly, “Forbidden Sunday and Feast-day Occupations,” page 2.*

“Католикчуудын Бямба гаригийн оронд Ням гаригийг олон нийтийн мөргөлийн өдөр болгосныг Протестантчууд хүлээн зөвшөөрсөн... Гэвч Ням гаригийг сахисанаар Протестантчууд сүмийн эрх мэдлээр яригч, Папыг хүлээн зөвшөөрөх ёстой гэдгийг ойлгохгүй байх шиг байна.”
- *“Our Sunday Visitor,” February 5, 1950*

“Агуу Эзэн Бурханы газар дэлхийг бид гартаа атгадаг.”

- *Pope Leo XIII, in an Encyclical Letter, dated June 20, 1894*

“Католицизм өгүүлж байна”

“Пап бол зөвхөн Есүс Христийг төлөөлдөг биш, тэрээр өөрөө хүний махан биед хувилсан Есүс Христ мөн.”

- *“The Catholic National,”*

July 1895

“Хэрэв Протестантууд Библийг дагадаг юм бол Бурханыг Шаббат өдөр магтан хүндлэх ёстой. Ням гаригийг сахиснаараа тэд Католик Сүмийн хуулийг дагаж байгаа юм.”

- *Albert Smith, Chancellor of the*

Archdiocese of Baltimore, replying for the Cardinal, in a letter dated Feb. 10, 1920

“Бид Ариун Апостолууд (Ватикан) ба Ромын Понтифууд дэлхий дахины пашны мяндагийг атгадаг гэж тодорхойлдог.”

- *A Decree of the Council of Trent, quoted in Phillippe Labbe and Gabriel Cossart “The Most Holy Councils,” Vol. 13, col. 1167*

“Католик Сүм Есүс Христийн эрх мэдлээр энэхүү амралтыг (Библийн Шаббат өдрийг) Ням гариг руу шилжүүлсэн... Иймээс Протестантууд Ням гаригийг сахих нь (Католик) Сүмд хүндэтгэл үзүүлж байгаа гэсэн үг юм.”

- *Monsignor Louis Segur;*

“Plain Talk about the Protestantism of Today,” p. 213

“Католик Сүм Бямба гаригийн ёслолыг Ням гариг руу шилжүүлсэн учраас бид Бямба гаригийн оронд Ням гаригийг сахин тэмдэглэдэг.”

- *Peter Geiermann, CSSR, “A Doctrinal Catechism,” 1957 edition, p. 50*

“Католикчууд бид Сүмийн эрх мэдэл, болон бусад итгэл шүтлэгтэй ижил хэмжээнд Бямба гаригийн оронд Ням гаригийг маш чанд ариунаар сахидаг... Тиймээс Протестантууд та бүхэнд Библи дээр заагаагүй энэ эрх мэдлийг (Ням гаригийг ариусгасан) сахих ямар ч эрх мэдэлгүй ба энэ эрх мэдлийг ч хүлээн зөвшөөрч чаддаггүй. Та болон бид, энэ мэтчилэн энэ ёс заншлыг дагадаг. Гэвч бид энэ эрх мэдэл Бурханы Үгнээс бус, харин (Католик) Сүм тэнгэрлэг тайлбараар тайлбарласан гэдэгт итгэдэг. Та нар үүнийг (Католик сүм) дагадаг мөрглөө, ‘Бурханы хуулийг ямар ч нөлөөгүй болосон гэж Матай 15: 6- г иш татан’ өнгөрсөн түүхийн турш хуурамч, буруу удирдагчид гэж шүүмжилж байсан.”

- *The Brotherhood of St. Paul, “The Clifton Tracts,” Vol 4, p. 15*

“Шаббат өдрийг Ням гаригт шилжүүлэх эрхийг сүмийг үндэслэгч, сүмд эрх мэдэл олгогч, тэнгэрлэг, хэзээ ч алдаа гаргадаггүй Есүс Христ өгсөн ба энэ эрх мэдлээр ч солигдсон. Библи бол бидний итгэлийн гол баримтлал гэж тунхагласан Протестант сүмүүдэд Ням гаригийг сахих эрх байхгүй.”

- *The Catholic Universe Bulletin, August 14, 1942.*

“Хүн төрөлхтөнд долоо хоногийн ажлаасаа хэдийд амрахыг хэлж өгөх эрх мэдэл, хүндэтгэл (Эхлэл 2: 1- 3) Орчлон Ертөнцийг Бүтээгчид биш харин Католик сүмд байдаг.”

- *S.D. Mosna, «Storia della*

Domenica,» 1969, pp. 366- 367

“Протестантизм өгүүлж байна”

Баптист: “Библид Шаббат өдрийг ариунаар сахих тухай тушаал байсан, одоо ч бий. Шаббат өдөр нь Ням гариг биш. Гэхдээ ихэнх нь Шаббат өдрийг долоо дахь өдрийн эхний өдөр лүү бүх л үүрэг, ивээл, заавартай нь шилжүүлсэн болохыг батлан хэлдэг ба үүнийг ч дэмждэг. Энэхүү асуудлыг нягтлахаар мэдээлэл цуглуулан олон жил судласан боловч энэхүү өөрчлөлт гарсан тухай хаана бичсэн байдаг юм бэ? гэж би асуух болсон. Ямар ч байсан Шинэ Гэрээн дээр байдаггүй. Шаббат ёслолыг долоо хоногийн эхний өдөрт шилжүүлсэн тухай Библи дээр ямар ч баримт байхгүй юм.”

- *Dr. E. T. Hiscox, author of the “Baptist Manual”*

Конгрегешнал: “Хичнээн тууштай, итгэлтэйгээр Ням гаригийг сахисан ч бай энэ нь Шаббатыг сахиагүй гэсэн үг... Шаббат өдөр нь тэнгэрлэг, тусгай захирамжаар бий болсон. Ням гаригийг сахих талаар үүнтэй төстэй захирамж байхгүй гэдэгтэй санал нэг байна... Шинэ Гэрээнд ариусгасан гэж үзэж байгаа Ням гаригийг зөрчих юм бол ямар нэгэн шийтгэл тохионо гэсэн ганц ч ишлэл байхгүй.”

- *Dr. R. W. Dale, “The Ten Commandments,” p. 106- 107*

Лютерийн Чөлөөт сүм: “Ариун Библид Эзэн Өөрөө эсвэл дагалдагч нар Шаббат өдрийг Ням гариг руу шилжүүлсэн гэсэн захирамж байсан бол, хэн Шаббат өдрийг өөрчилсөн, хэн ийм эрх мэдэлтэй юм бэ? гэсэн асуултанд хариулахад дөхөмтэй байх байсан. Харин энэ тухай батлах ганц ч баталгаа байхгүй.” - *George Sverdrup, “A New Day”*

Протестант Епископ: “Долоо дахь өдөр эхний өдөр лүү шилжсэн... Өөрчлөлтийн тухай Библид ямар ч заавар байхгүй тул, сүм өөрийн эрх мэдлээр энэхүү өөрчлөлтийг гаргасан гэж дүгнэж болно.”

- *“Explanation of Catechism”*

Баптист: “Библид хаана ч Шаббат өдрийг эхний өдөр хэмээн нэрлээгүй... Библи ийм өөрчлөлт гаргах эрхгүй ба ийм ч шаардлага байхгүй.”

- *“The Watchman”*

Пресбитериан: “Шинэ Гэрээнд Ням гаригт ажил бүү хий гэсэн ганц ч үг, ганц ч санаа байхгүй. Лент, үнсэн Лхагва гаригийг сахих нь Ням гаригийг сахихтай ижил юм. Ням гаригт амрах тухай тэнгэрлэг Хуулинд юу ч бичигдээгүй юм.” - *Canon Eyton, in “The Ten Commandments”*

Англикан: “Библийн аль хэсэгт долоо хоногийн эхний өдрийг сахь гэж бичсэн юм бэ? Тушаал дээр долоо дахь өдрийг сахь гэж байдаг, харин эхний өдрийг хаана ч сахь гэж бичээгүй.”

- *Isaac Williams, “Plain Sermons on the Catechism,” pp. 334, 336*

Христийн дагалдагчдын сүм: “Эзэний өдөр” хэмээн долоо хоногийн эхний өдрийг тогтоосон гэсэн Библийн ямар ч эрх мэдэл байхгүй.”

- *Dr. D.H. Lucas, “Christian Oracle,” January, 1890*

“Протестантизм өгүүлж байна”

Методист: “Баптисмыг шинээр ёслол явуулах ямар ч тушаал байхгүй гэдэг нь үнэн. Мөн долоо хоногийн эхний өдрийг ариунаар сахих тушаал байхгүй. Олон хүмүүс Христ Шаббат өдрийг сольсон гэж боддог. Гэвч Өөрийнх нь үгнээс аваад үзэхэд, Тэрээр ийм зорилго агуулж ирээгүй. Есүсийг Шаббат өдрийг өөрчилсөн гэж үздэг хүмүүс ерөнхийдөө таамагласан гэсэн үг.”

- Amos Binney, “Theological Compendium,” pp. 180- 181

Епископалийн: “Ариун, католик, дагалдагчдын сүмийн бүрэн эрх мэдлээр бид долоо дахь өдрийг эхний өдөр болгон, Бямба гаригийг Ням гариг болгон өөрчилсөн юм.” - Bishop Symour, “Why We keep Sunday”

Өмнөд баптистууд: “Долоо дахь өдрийн ариун нэр нь Шаббат юм. Энэ баримт нь маргахын аргагүй тодорхой зүйл юм. (Египетээс гарсан нь 20: 10)... Олон мянган жилийн турш Бурханы Үгийг энэ энгийн баримтан дээр үндэслэн сургаж байсан... Дагалдагчид ганц ч удаа Шаббат өдрийн хуулийг долоо хоногийн эхний өдөрт шилжүүлж байгаагүй ба эхний өдөр долоо дахь өдрөөс илүү гэдгийг харуулж байгаагүй. Энэ балмад явдал хожуу тохиолдсон юм.”

- Joseph Judson Taylor, “The Sabbath Question,” pp. 14- 17, 41

Америкийн конгрегешнал: “Христ, Түүний дагалдагчид өөрсдийн эрх мэдлээр долоо дахь өдрийг эхний өдөрт шилжүүлсэн гэсэн үзэл бодол Шинэ Гэрээн дээр огт байхгүй билээ.”

- Dr. Layman Abbot, in the “Christian Union,” June 26, 1890

Христ сүм: “Диваажинд Шаббат өдрийг өөрчилсөн, эсвэл Эзэний Өдөр ийм богино хүрээтэй болсон тухай гэрчлэл хаа ч алга.”

- Alexander Campbell, in “The Reporter,” October 8, 1921

Баптист: “Миний бодлоор Есүс дагалдагч нартайгаа гурван жилийн туршид Шаббатын тухай, Шаббат өдрийн зорилго, утга учрыг тайлбарлан байхдаа хуурамч үзлээс нь (Еврей ёс заншил) салгаж байхдаа тэрхүү өдрийг өөрчилсөн тухай юу ч яриагүй, дахин амилаад дөч хонохдоо ч ийм санаа гаргаагүй. Мөн бүхнийг, Түүний хэлсэн үгийг ч сануулах үүрэгтэй өгөгдсөн Сүнс хүртэл энэ талаар яриагүй, энэ тухай хэлэлцэхийг ч захиагүй. Дагалдагч нар хүртэл сайн мэдээг тунхаглахдаа, сүмүүдийг байгуулахдаа, аврагдагсад зааж, зөвлөж байхдаа ч, энэ талаар ярьж байгаагүй билээ.

“Итгэгч өвөг Эцгүүдээс болон бусад эх үүсвэрээс суралцахад мэдээж Ням гаригийг бид анхны итгэгчдийн бүлгээс эхлээгүй болохыг сайн мэдэж байна. Харин буруу номтнуудаас үүсэж, нарны бурханы нэрийг зүүж, Попын завхралаар танигдан, ариусгагдсан гэж нэрлэгдэж, Протестанчуудын ариун дүрэм болон гэрээслэгдэн ирсэн нь ямар харамсалтай вэ?”

- Dr. E. T. Hiscox, report of his sermon at the Baptist Minister’s Convention, in “New York Examiner,” November 16, 1893

Асуулт: Сүм ямар нэгэн үзэл баримтлалыг өөрчлөх эрхтэй гэдгээ өөр маягаар тайлбарлаж болох уу?

Хариулт: “Хэрэв сүмд ийм эрх мэдэл байгаагүй бол өнөө үед бүх сүсэгтнүүд хүлээн зөвшөөрсөн ийм өөрчлөлт гаргаж, долоо хоногийн долоо дахь өдөр Бямба гаригийн оронд долоо хоногийн эхний өдөр Ням гаригийг мөргөлийн өдөр болгон Библид хаана ч заагаагүй эрх мэдлээр Бурханы хуулийг өөрчилж чадахгүй байсан.” - Rev. Stephan Keenan, *A Doctrinal Catechism*, page 174.

Ням гаригийг ариусгасан заавар, ёслон өнгөрүүлсэн тухай Библид байдаггүй.

“Та бүхэн Библийн Эхлэл номноос Илчлэлт ном хүртэл уншиж үзэж болно. Тэгээд Ням гаригийг ариусгасан гэсэн ганц ч өгүүлбэрийг олохгүй. Библийн судар Бямба гаригийг ариунаар сахих өдөр гэж өгүүлдэг, энэ өдрийг бид (Католикчууд) хэзээ ч ариусгаагүй.” Гиббонс Кардинал, Эцэг өвгөдийн Итгэл, 111-р хуудас.

Бодож цэгнэнэ үү?

“‘Тэд хүмүүсийн тушаалыг сургаал мэт зааж, харин Надад дэмий хоосон мөргөдөг.’ Бурханы хуулиудыг та нар орхигдуулан, хүний ёс заншилд баригддаг гээд, Тэр мөн тэдэнд хандан ‘Та нар ёс заншлаа сахихын тулд Бурханы хуулиудыг орхигдуулахдаа гарамгай юм.’” Марк 7:7-9

ЯАГААД УСАН БАТАЛГАА ХИЙЛГЭДЭГ ВЭ?

ТАЙЛБАР: Англи хэлний “BAPTIZE” гэсэн үг нь Грек “BAPTIZO” буюу “усанд дүрэх” гэсэн утгатай үгнээс гаралтай юм. Библид энэ нь “усанд дүрэн булшлах” гэсэн утгатай.

Есүсийн хэлснээс авч үзвэл, усан баталгаа хир чухал байсан вэ?

“Есүс, ‘Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй.’”
Иохан 3:5

“Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно.”
Марк 16:16

Шинэ Гэрээний үед хэн хамгийн анх усан баталгаа (баптисм) хүртээсэн бэ?

“Тэр өдрүүдэд баптисм хүртээгч Иохан ирж, Иудейн цөлд сургаал айлдаж, ‘Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал ойрхон байна’ гэж байлаа... Тэд нүглээ улайгаад, Иордан голд түүгээр баптисм хүртэж байв.”
Матай 3:1-6

Иохан яагаад цөлд баптисм хүртээж байсан бэ?

“Мөн Иохан Салимын ойролцоо Аенонд баптисм хүртээж байв. Учир нь тэнд ус ихтэй ажээ. Хүмүүс ирж баптисм хүртэж байлаа.”
Иохан 3:23

ТАЙЛБАР: Иоханд баптисм хүртээхэд “их ус” хэрэгтэй байсан. Баптисм хүртээхдээ толгой дээр нь ус цацдаг заншил МЭ 12-р зуунд сүмд орж ирсэн юм. Түүх энэ талаар: “Христийн шүтлэг бий болсноос хойж хэдэн зууны

ТУРШИД БАПТИСМ, УСАН БАТАЛГААГ УСАНД БҮХЭЛ БИЕЭР НЬ ДҮРЖ ҮЙЛДДЭГ БАЙСАН. Харин 12-р зуунаас эхлэн Католик сүмд баптисмыг толгой дээр нь ус цацан үйлддэг болсон, энэ заншил нь бүхэл биеэр усанд орохоос илүү хѐлбар байсан. Сүм газар нутаг, цаг хугацаанд тааруулан өөрийн эрх мэдлийн дагуу хамгийн хѐлбар боломжийн аргуудыг хэрэглэх болсон юм.”Жэймс Кардинал Гиббонс, Эцэг өвгөдийн итгэл, 277-р хуудас.

Есүс бүхэл биеэрээ усанд орж баптисм хүртсэн болохыг хэрхэн мэдэж болох вэ?

“Голын уснаас гарч ирсэн тэр даруй тэнгэр заагдан, Сүнс тагтаа мэт Өөр дээр нь буухыг Есүс үзэв.”

Марк 1:10

Есүс яагаад усаар батлуулах шаардлагатай байсан юм бэ?

“Тэгээд Есүс Иоханаар баптисм хүртэхийн тулд Галилаас Иорданд түүн дээр ирэв. Харин Иохан ‘Би Танаар баптисм хүртэх учиртай байтал Та над уруу ирнэ үү? гээд, Түүнийг болиулахыг оролдтол, Есүс хариуд нь ‘Энэ удаад үүнийг зөвшөөр. Ингэснээрээ аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэх нь бидэнд зохицож байна,’ гэж хэлэхэд тэр Түүнд зөвшөөрөв.”

Матай 3:13-15

Тайлбар: “Есүс Өөрийн гэм нүглийг гэмшихийн тулд баптисм хүртээгүй. Тэрээр Өөрийгөө гэмт хүмүүстэй ижилд тооцож, бидний хийх ёстой байсан алхмыг хийж, бидний хийх ёстой бүхнийг хийсэн юм. Түүний баптисм хийлгээд зовлон бэрхшээл, тэсвэр тэвчээрийг туулан гарах амьдрал нь бидний амьдралын жишээ болох ёстой байлаа.”

Эллен Уайт, Эрин зууны хүслэн, 111-р хуудас.

Библид заасан баптисм хүртэх гурван нөхцөл:

1. “Петр тэдэнд, ‘Гэмшигтүн, хүн бүр өөрсдийн нүглийн уучлалын төлөө Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Та нар ч Ариун Сүнсний бэлгийг авах болно.’”
Үйлс 2:38
2. “Мөнөөх тайган хүн Филипг хандаж, ‘Хараач, ус байна. Баптисм хүртэхэд болохгүй нь юу билээ.’ гэв. Филип, ‘Хэрэв чи бүх зүрхээрээ итгэвэл, болно.’ гэсэнд тэр ‘Есүс Христ бол Бурханы Хүү мөн гэдэгт би итгэж байна’ хэмээн хариулав.”
Үйлс 8:34-37
3. “Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно, гэж айлдав.”
Матай 28:19,20

Петр Пентекөст баярын өдөр Есүсийг “Христ-Аврагч” гэж сургасан. Хүмүүс үүнийг сонсоод ямар хариу хэлсэн бэ?

“Ийнхүү түүний үгийг хүлээн авсан хүмүүс баптисм хүртэцгээв. Тэр өдөр гурван мянга орчим хүн нэмэгджээ.”
Үйлс 2:41

Авралын Төлөвлөгөөг ойлгосны дараа Паулд ямар заавар өгөгдсөн бэ?

“Одоо чи юунд удна вэ? Бос, Түүний нэрийг дуудаж, баптисм хүрт. Нүглээ угаа.”
Үйлс 22:16

Баптисм хүртсэнээр ямар сүнслэг сургамж авч болох вэ?

“Эсвэл Христ Есүс уруу баптисм хүртсэн бид цөмөөрөө Түүний үхэл уруу баптисм хүртсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тиймд Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явахын тулд үхэл уруу баптисм хүртсэнээр Түүнтэй хамт оршуулагдсан юм. Учир нь, хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж бас Түүний амилалттай нь ч холбогдох болно. Ингэхдээ хойшид биднийг нүгэлд боолчлуулалгүй, нүглийн биеийг маань хүчингүй болгохын тулд бидний хуучин хүн нь Түүнтэй хамт цовдлогдсоныг бид мэддэг.”

Ром 6:3-6

Тайлбар: Усан баталгаа хийлгэснээрээ бид Аврагчийн нас барсан, булшлуулсан, дахин амьдарсан гэдэгт итгэдэг болохоо баталж байгаагаа харуулдаг. Есүсийн нэрээр баптисм хүртсэнээрээ бид өөрсдийн гэм нүглүүдээ үхүүлдэг. Бид Есүсийн нэрээр баптисм хүртэн булшлагддаг ба бид өнгөрсөн гэмт амьдралаа булшилдаг. Эцэст нь бид шинэ сүнслэг биетэйгээр дахин амьдарч, “Түүний амилалттай нь ч холбогдох болно.”

Бодож цэгнэх амлалтууд:

“Христ уруу баптисм хүртсэн та нар бүгдээрээ Христ уруу Христийг өмссөн юм.” Галат 3:27

“Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгээр, гэм зэмгүйгээр зогсоож чадах Түүнд, бидний Аврагч болох цорын ганц Бурханд, бидний Эзэн Есүс Христээр алдар суу, сүр жавхлан, ноёрхол, эрх мэдэл нь бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай.”

Иуда 24, 25

ҮХСЭНИЙ ДАРАА ЮУ ТОХИОЛДДОГ ВЭ?

**Есүс яагаад тэр үеийн багш нар,
Садукайчуудыг залруулж байсан бэ?**

“Есүс хариуд нь тэдэнд, ‘Та нар Судрыг ч, Бурханы хүчийг ч мэдэхгүйгээс болж төөрөлдөж байна.’”
Матай 22:29

**Хэрэв бид үхлийн талаар мэдэхийг хүсэж
байгаа бол ямар баталгаатай эх сурвалжаас
судлах хэрэгтэй вэ?**

“Тэд та нарт ‘Шивнэн чалчдаг сүнс дуудагчид болон шидтэнүүдтэй зөвлөлд’ гэж хэлэх үед ард түмэн өөрсдийнхөө Бурханаас асуухгүй гэж үү? Амьд хүмүүсийн төлөө үхэгсдээс асуух гэж үү? Хууль хийгээд гэрчлэлд анхаарагтун. Хэрэв тэд энэ үгийн дагуу ярьдаггүй бол тэдэнд гэгээ байхгүй болжээ.”
Исаиа 8:19, 20

**Библид хүн үхэхэд юу тохиолддог гэж
бичсэн байдаг вэ?**

“Тэгээд тоос нь урд байсан газар шороондоо буцаж, сүнс нь үүнийг өгсөн Бурхандаа буцах ажгуу.”
Номлогчийн үгс 12:7

**Библийн судрын энгийн ишлэл Эхлэл номын
утга санаатай бүрэн нийцэж байна. Бурхан
хүнийг бүтээхдээ ямар хоёр зүйлийг ашиглан
амьд оршигч болгосон бэ?**

“ЭЗЭН Бурхан тоос шорооноос хүнийг бүтээж, амин амьсгалыг хамраар нь үлээж оруулахад, хүн амьд оршигч болжээ.” Эхлэл 2:7

Тайлбар: Энэхүү ишлэлд Номлогчийн үгс 12: 7 дээр гарсан зүйлсийг ашигласан гэж бичжээ. “Газар шороо” нь бие мах бодь, “амин амьсгал” гэдэг нь Бурханаас ирдэг “сүнс” юм. Бурхан Адамын биед амьд сүнсийг оруулаагүй! Бурхан Адамын хамраар амин амьсгалыг үлээж оруулахад л тэрээр амьд оршигч, сүнс болсон. Гэрлийн чийдэн цахилгаангүйгээр асахгүй. Цахилгаан чийдэнд дамжихад л гэрэл асдаг. Цахилгааныг нь таслахад гэрэл унтардаг. Хүнээс амин амьсгал гарахад сүнс амьд байхаа больдог гэж Библи өгүүлдэг. Үүнийг энгийнээр тайлбарлабѐ

Тоос + Сүнс = Амьд Сүнс

Тоос - Сүнс = Үхсэн хүн

Библийн “Амин амьсгал,” “Сүнс” гэсэн хоёр үг ижил утга санаа агуулж байгаа гэдгийг баттай мэдэж болох уу?

“Миний дотор амь хийгээд хамрын нүхэнд минь Түүний амьсгаа байсаар байх хугацаанд.” Иов 27:3

Тайлбар: Дахин нэг томъёолж үзье.

Тоос + Амьсгал (эсвэл Сүнс) = Амьд Сүнс

Тоос - Амьсгал (эсвэл Сүнс) = Үхсэн Сүнс

Библи хүн үхээд ямар нөхцөлд байдаг талаар юу гэж өгүүлсэн байдаг вэ?

Хүн ямар ч бодол санаагүй болдог:

“Түүний сүнс гарч явдаг бөгөөд тэрээр газар шороо уруу буцдаг. Яг тэр өдөр түүний бодлууд мөхдөг.”
Дуулал 146:4

Юуг ч мэддэггүй:

“Амьд байгсад нь үхнэ гэдгээ мэддэг байтал, үхдлүүд юу ч мэддэггүй аж. Цаашдаа тэдэнд шагнал ч байхгүй болдог. Учир нь тэдний дурсамж мартагддаг юм.”
Номлогчийн үгс 9:5

Ямар ч мэдрэмжгүй болдог:

“Тэдний хайр, хорсол, атаа жөтөө хэдийнээ мөхөж, наран доор хийгддэг үйлсэд тэд цаашид үл оролцох бөлгөө.”
Номлогчийн үгс 9:6

Ямар нэгэн үйл хөдлөлгүй болдог:

“Гар чинь юуг хийхээр тэмүүлнэ, түүнийг бүхий л чадлаараа хийгтүн. Учир нь чиний очих Үхэгсдийн оронд мэргэн ухаан, ажил үйлс, бодох сэтгэх гэдэг нь байхгүй.”
Номлогчийн үгс 9:10

Тэрээр Бурханыг магтан хүндлэхгүй:

“Үхэгсэд ЭЗЭНийг магтдаггүй. Анир чимээгүй уруу доош одогч хэн боловч магтдаггүй.”
Дуулал 115:17

“Учир нь үхэлд Таныг дурсан санана гэж үгүй. Үхэгсдийн оронд хэн танд талархах вэ?”

Дуулал 6:5

Есүс дагалдагч нартаа “үхлийг” хэрхэн тайлбарласан бэ?

“Ингэж айлдсаныхаа дараа Тэр тэдэнд, ‘Бидний анд Лазар унтжээ. Гэвч Би түүнийг нойрноос нь сэрээхээр явна,’ гэхэд шавь нар нь Түүнд, ‘Эзэн, хэрэв унтсан бол тэр эдгэнэ’ гэв. Есүс Лазарын үхлийн тухай айлдсан ажээ. Харин тэд Түүнийг зүгээр л унтах тухай ярьж байна гэж боджээ. Тэгтэл Есүс тэдэнд шуудхан, ‘Лазар үхсэн.’”

Иохан 11:11-14

Марта ах Лазарыгаа дахин хэзээ амьдарана гэж бодож байсан бэ?

“Есүс түүнд, ‘Чиний ах амилна,’ гэхэд Марта Түүнд, ‘Эцсийн өдрийн амилалтад тэр амилна гэдгийг би мэднэ.’ гэв.”

Иохан 11:23,24

ТАЙЛБАР: Марта Есүсийн дотны найз, дагалдагч байсан. Марта Есүсийн үхлийн талаар заасан бүхнийг маш сайн анхааралтай сонсдог байв. Тэрээр Христийн амласнаар дэлхийн сүүлчийн үед үхэгсэд дахин амилна гэдэгт итгэдэг байжээ.

Есүсд итгэн нас барсан бүх хүмүүс хэзээ дахин амьдрах вэ?

“Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно. Харин тус бүр өөрийн дараалал дотор байна. Христ бол анхны үр жимс юм. Дараа нь Христийн хүмүүс Түүнийг ирэхэд амилуулагдана.”

1 Коринт 15:22,23

Үхэгсэд дахин амилахын өмнө хэний дуу хоолойг сонсоно гэж Библид бичсэн бэ?

“Үүнд бүү гайхагтун. Учир нь булшинд байгчид бүгдээрээ Түүний дууг сонсон, гарч ирэх цаг ирж байна. Сайн үйлийг үйлдсэн хүмүүс нь амийн амилалт уруу, муу үйлийг үйлдсэн хүмүүс нь ялын амилалт уруу гарч ирнэ.”

Иохан 5:28,29

Итгэгчид хэзээ дахин амилж, дээш тэнгэрт өргөгдөнө гэж Паул хэлсэн бэ?

“Учир нь Эзэн Өөрөө тушаалын үгтэй тэргүүн тэнгэр элчийн дуу ба Бурханы бүрээн дуунаар тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христийн дотор үхэгсэд эхлээд амилах болно. Дараа нь амьд хийгээд үлдсэн бид тэдэнтэй хамт агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн дотор өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно.”

1 Тесалоник 4:16,17

Дахин амилалтын үед бидний бие хэрхэн өөрчлөгдөх вэ?

“Харин бидний иргэний харьяалал нь тэнгэрт байгаа бөгөөд тэндээс би Аврагч Эзэн Есүс Христийг хүлээж байна. Тэр бүх юмсыг Өөртөө захируулж чадах хүчээрээ бидний дорд биеийг Өөрийнхөө цог жавхланта биетэй адил болгон өөрчилнө.”

Филиппой 3:20,21

Есүс дахин амилсныхаа дараагаар дагалдагч нартайгаа уулзсан. Тэр үед Есүс зарим хүмүүсийн бодож байсанчлан “сүнслэг биетэй” байсан уу?

“Тэд ийнхүү ярьж байтал Тэр Өөрөө тэдний дунд зогсож байлаа. Тэр тэдэнд, ‘Амар амгалан нь та нарт байх болтугай.’ гэв. Гэвч тэд айн сандарч, сүнс үзэгдэв хэмээн боджээ. Есүс тэдэнд, ‘Та нар юунд

зовж, зүрхэнд чинь эргэлзээ төрнө вэ? Миний гар, Миний хөлийг хараач. Энэ чинь Би Өөрөө байна. Надад гараа хүргээд үз. Учир нь сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй юм' гэв.»

Лук 24:36-39

ТАЙЛБАР: Дахин амилсан Есүсийн бие “Үс, махнаас” бүрэлдсэн байсан боловч дагалдагч нар итгэж чадахгүй байсан юм. “Тэд ба Үрлан, гайхсандаа итгэж Үдан байхад нь Есүс тэднээс, “Та нарт идэх юм байна уу?” гэж асуухад тэд хайрсан загас Түүнд өгөв. Тэр загасыг авч, тэдний өмнө иджээ.” Лук 24:41-43

Бодож цэгнэх амлалтууд:

“Би бол амьд Нэгэн мөн. Би үхсэн байсан. Харагтун, Би үеийн үед амьд байна. Надад үхэл ба Үхэгсдийн орны түлхүүр бий.” Илчлэлт 1:18

“Харагтун, би та нарт нэгэн нууцыг хэлье. Бид бүгдээрээ нойрсохгүй, харин бүгдээрээ өөрчлөгдөх болно. Ингэхдээ нүд ирмэхийн зуур, нэг агшинд, бүрэн эцсийн дуугаар тийм болно. Учир нь бүрээ дуугарч, үхэгсэд үл муудах уруу амилуулагдаж, бид ч өөрчлөгдөнө. Учир нь муудах нь үл муудахыг өмсөх ёстой бөгөөд энэ үхлийн бие нь үхэшгүйг өмсөх ёстой. Энэхүү муудах нь үл муудахыг өмсөж, энэ үхлийн бие нь үхэшгүйг өмсөх үед ‘Үхэл ялалтад залгигдсан’ гэж бичигдсэн үг биелнэ. ‘Үхэл ээ, чиний ялалт хаана байна вэ? Үхэл ээ, чиний хатгуур хаана байна вэ?’”

1 Коринт 15:51-55

1000 ЖИЛИЙН АМАР ТАЙВАН

ТАЙЛБАР: “МҮНГАН ЖИЛ” ГЭСЭН ҮГ ИЛЧЛЭЛТ НОМЫН 20-Р БҮЛЭГ ДЭЭР ЗУРГААН УДАА ГАРСАН БАЙДАГ. ЭНЭХҮҮ “МҮНГАН ЖИЛ” ГЭСЭН ҮГИЙГ ИХЭВЧЛЭН ЛАТИН MILLE БУЮУ ANNUS ГЭСЭН ҮГИЙГ ХАМТАТГАН MILLENNIUM ГЭЖ НЭРЛЭДЭГ.

Есүс хэдэн удаа дахин амилалт болно гэж хэлсэн бэ?

“Үүнд бүү гайхагтун. Учир нь булшинд байгчид бүгдээрээ Түүний дууг сонсон, гарч ирэх цаг ирж байна. Сайн үйлийг үйлдсэн хүмүүс нь амийн амилалт уруу, муу үйлийг үйлдсэн хүмүүс нь ялын амилалт уруу гарч ирнэ.” Иохан 5:28,29

Нас барсан зөв шударга хүмүүсийн дахин амилалт хэзээ болох вэ?

“Учир нь Эзэн Өөрөө тушаалын үгтэй, тэргүүн тэнгэр элчийн дуу ба Бурханы бүрээн дуунаар тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христийн дотор үхэгсэд эхлээд амилах болно.” 1 Тесалоник 4:16

ТАЙЛБАР: Есүсийн хоёр дахь ирэлтийн үед нас барсан зөв шударга хүмүүс дахин амилах болно.

Илчлэлт номонд зөв шударга хүмүүсийн дахин амилалтыг юу гэж нэрлэсэн байдаг вэ?

“Анхны амилалтад багтсан хүн ерөөлтэй агаад ариун юм. Хоёр дахь үхэл тэднийг захирах ямар ч хүчгүй ажээ. Харин Бурханы ба Христийн тахилч нар болцгоож, Түүнтэй хамт мянган жилийн турш хаанчлах болно.” Илчлэлт 20:6

Есүс ирэх үед “амьд байгаа зөв шударга” хүмүүст юу тохиолдох вэ?

“Дараа нь амьд хийгээд үлдсэн бид тэдэнтэй хамт агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн дотор өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно.”
1 Тесалоник 4:17

Есүс ирэх үед “амьд байгаа гэм нүгэлтэй” хүмүүст юу тохиолдох вэ?

Хуучин Гэрээний зөгнөлд:

“Тэр өдөр ЭЗЭНээр хядуулсан хүмүүс газар дэлхийн нэг адгаас нөгөөг хүртэл байна. Тэдний төлөө гашуудахгүй, тэднийг цуглуулахгүй, оршуулахгүй. Тэд газрын гадаргуу дээрх ялгадас мэт болно.”
Иеремиа 25:33

Шинэ Гэрээний зөгнөлд:

“Дараа нь ёс бус нэгэн илчлэгдэх бөгөөд Эзэн Есүс амныхаа амьсгалаар түүнийг алж, Өөрөө ирж үзэгдсэнээрээ төгсгөлийг нь авчирна.”
2 Тесалоник 2:8

“Нас барсан гэм нүгэлтэй” (аврагдаагүй нас барсан бүх хүн) хүмүүс Есүсийн Хоёр дахь Ирэлтийн үеэр дахин амилуулагдахгүй гэдгийг бид хэрхэн мэдэж авсан юм бэ?

“Үхэгсдээс үлдсэн нь мянган жилийг дуустал амилсангүй. Энэ бол анхны амилалт юм.”
Илчлэлт 20:5

Тайлбар: Есүсийн Хоёр дахь Ирэлтийг дагаад 1000 жилийн АМАР ТАЙВАН ЭХЛЭХ БОЛНО. 1000 жилийн ЭХЭН БА ТӨГСГӨЛД ХОЁР ТӨРЛИЙН ДАХИН АМИЛАЛТ БОЛОХ БОЛНО: 1) Есүсийг ирэх үед 1000 жилийн ЭХЭНД ЗӨВ ШУДАРГА ХҮМҮҮС ДАХИН АМИЛАХ

болно, 2) 1000 жилийн амар тайвны эцэст гэм нүгэлтэй хүмүүс дахин амилах болно. Энэхүү хичээлд хавсаргасан тайлбарыг сайтар судлана уу? Тэрхүү тайлбар Библийн судлалыг ойлгоход тус болно.

Зөв шударга (аврагдсан бүх хүн) хүмүүс диваажинд 1000 жилийн туршид юу хийх вэ?

“Би сэнтийнүүдийг харав. Тэд дээр нь заларчээ. Тэдэнд шүүх эрх өгөгдсөн байлаа. Мөн Есүсийн гэрчлэл болон Бурханы үгээс болж цаазлуулсан хүмүүсийн болон араатанд ба түүний хөрөгт мөргөөгүй, дух хийгээд гар дээрээ араатны тэмдгийг хүлээн аваагүй хүмүүсийн сэтгэлүүдийг би харав. Тэд амилаад Христтэй хамт мянган жилийн турш хаанчилжээ... Анхны амилалтад багтсан хүн ерөөлтэй агаад ариун юм. Хоёр дахь үхэл тэднийг захирах ямар ч хүчгүй ажээ. Харин тэд Бурханы ба Христийн тахилч нар болцгоож, Түүнтэй хамт мянган жилийн турш хаанчлах болно.”

Илчлэлт 20:4-6

“Эсвэл ертөнцийг ариун хүмүүс шүүнэ гэдгийг та нар мэддэггүй юм уу?”

1 Коринт 6:2

1000 жилийн туршид дэлхий ямар байдалтай байх вэ?

Хуучин Гэрээний зөгнөлд:

“Намайг газар дэлхийг харахад, үзэгтүн, энэ нь хэлбэр дүрсгүй, эзгүй хоосон байв. Тэнгэрүүд уруу харахад, тэд ямар ч гэрэлгүй байлаа. Намайг уулс уруу харахад, үзэгтүн, тэд доргиж байв. Мөн бүх дов толгод хойшоо урагшаа хөдөлж байв. Намайг харахад, үзэгтүн, тэнд ямар ч хүн байсангүй. Тэнгэрийн бүх шувууд ниссэн байв. Намайг

In Heaven

The redeemed assist in the judgment of the wicked

1000 ЖИЛ

Анхны, хоёр дахь амилгалтын хооронд



Анхны амилгалт/ Дэлхийн төгсгөл

1. олоон тамшиг дуусна
2. Христийн хоёр дахь ирэлт
3. Нас барсан зөв шударга хүмүүс дахин амилна
4. Гэм нүгэлт хүмүүс нас барна/
Сатан гинжлэгдэнэ
5. Зөв шударга хүмүүс диваажин руу хөөрнө



End of
World

Дэлхий дээр

Саган өөрийн хийсэн үйлдлээ бодож цогцх цаг гарна. Муу сүнслүүдийн харгалзах хугацаа өшгөрч, гэмт хүмүүс бүгд нас барсан байна

Хоёр дахь дахин амилгалт/ Шинэ дэлхий бий болж, мөнхийн амьдрал залгамжилна

1. Христэд итгэгчид болон Ариун хүмүүс дэлхий дээр буцаж бууна
2. Ариун хот бууж ирнэ
3. Гэмт хүмүүс булшнаасаа дахин амилна
4. Саганы хүлээс тайлагдана
5. Гэмт хүмүүс устана.



New Earth
& eternity

Библийн мянган жил

Бид түүхийн сүүлчийн үед амьдарч байна. Хүний амьдралын цаг хугацаа дуусах дөхсөн байна. Удахгүй Есүс ирэх болно. Бидэнд оногдсон нэг л амьдрал бий- энэ нь өнөөгийн бидний амьдрал. Энэ нь алдар нэр хүнд, амар тайван байдлаар дэлхий дээр мянган жил амьдрах тухай биш юм! Энэ нь техникийн хөгжлийн эрин үе байх, □гэмт хүмүүст бололцоо олгосон□ хоёр дахь амьдрал байхгүй юм. Хүн төрөлхтөн мянган жил иртэл, мянган жилийн туршид, дараа нь ч өөрчлөгдөхгүй! Христ болон Түүнээс аврал хүртсэн хүмүүс ч мянган жилийн туршид дэлхий дээр амьдрахгүй.

Мянган жилийн тухай бодит үнэн, үйл явдал, эхлэх төгсөх хугацааг хамтдаа авч үзэцгээе!

1. Есүс Өөрийн хүмүүсийнхээ төлөө буцаж ирнэ: Тэрээр дахин ирнэ гэж амласан (Иохан 14:1-3), Тэрээр ирнэ гэдэгт найдаж болох юм.

2. Есүсийн хоёр дахь ирэлтийг харуулах 4 тодорхой шинж тэмдэг байх болно. Энэ шинж тэмдгийг Сатан хуурамчаар дуурайж чадахгүй: 1. Түүний ирж байгааг амьд байгч бүгд харах болно. (Илчлэлт 1:7, Үйлс 1:9, Матай 24:30, 23-27) 2. Түүний ирэлтийг хүн бүр сонсох юм. (Матай 24:31, 1 Тессалоник 4:16). 3. Тэрээр Өөрийн Эцэгийн сая сая элч нарын агуу алдар сууг гэрэлтүүлэн ирнэ. (Лук 9:26, Матай 28:2-4, Матай 25:31, Илчлэлт 6:14-17). 4. Тэрээр санаандгүй байхад ирнэ. (Матай 24:44, 24:36).

3. Есүсийн хоёр дахь ирэлт мянган жилийн эхлэл байх болно. Энэ үед 6 үйл явдал тохиолдоно: 1. Есүс зөв шударга үхэгсдийг амилуулна. (1 Тессалоник 4:16). 2. Тэрээр амьд байгаа зөв шударга хүмүүсийг, амилуулсан үхэгсэдтэй цуг дээш хөөргөхөд үүлэн дээр Түүнтэй уулзана. (1 Тессалоник 4:17). 3. Тэрээр гэмт мөхөс бисийг минь Өөрийн төгс биеэр өөрчилж (Филиппой 3:20-21) бид шинэчлэгдэнэ. (1 Коринт 15:51-55, Исаиа 25:9). 4. Бүх зөв шударга хүмүүсийг цуглуулаад (1 Тессалоник 4:17-18, Матай 25:34-40, 24:30, 31), Өөрийн аварсан хүмүүсээ диваажинд аваачна. (Иохан 14:1-3, 17:24, 1 Тессалоник 4:16-18). 5. Есүс амьд байгаа гэм нүгэлт хүмүүсийг Өөрийн агуу гэрэл гэгээгээр устгана. (Лук 17:26-30, 2 Тессалоник 2:8). 6. Тэрээр Сатаныг дэлхий дээр 1000 жилийн турш хүлнэ. (Илчлэлт 20:2- 3).

4. Мянган жилийн турш дэлхий эзгүй, хоосон байна. (Илчлэлт 20:3, Иеремиа 4:23- 26, Исаиа 24:1,3). Гэмт хүмүүс үхсэн байна. (2 Тессалоник 2:8). Ямар ч хүн үлдэхгүй. (Исаиа 24:20-22, Иеремиа 4:25, 26, 25:31-33). Сатан эзгүй дэлхий дээр хүлэгдэнэ. (Илчлэлт 20:1-3). Зөв шударга хүмүүс диваажинд очно. (Илчлэлт 20:4, 6, Даниел 7:22), шүүдлийн ажилд оролцоно. (Илчлэлт 20:4, 1 Коринт 6:1- 3, Үйлс 24:25, Иуда 6).

5. Мянган жилийн төгсгөлөөр, Ариун Хот тэнгэрээс буун ирнэ. (Илчлэлт 20:9, 21:1- 5, Зехариа 14:4, 9) гэм нүгэлт хүмүүс □хоёр дахь амилалтаар□ амилна. (Илчлэлт 20:5, эхний хэсэг). Сатан болон гэмт хүмүүс Ариун хотыг эзлэхээр бүслэнэ. (Илчлэлт 20:8- 9). Бүх гэмт хүмүүс сөнөнө (Илчлэлт 20: 9), дэлхий шинээр бүтээгдэнэ. (Илчлэлт 21:1- 5, 2 Петр 3:10- 14).

харахад, үзэгтүн, арвин жимстэй газар нь цөл бөгөөд бүх хотууд нь ЭЗЭНий өмнө, Түүний ширүүн уур хилэнгийн өмнө нураагдсан байв. Учир нь ЭЗЭН ингэж тунхаглаж байна. ‘Бүхэл газар нутаг хоосрох боловч Би бүрмөсөн устгахгүй.’”

Иеремиа 4:23-27

Шинэ Гэрээний зөгнөлд:

“Долоо дахь нь аягатайгаа агаарт асгав. Сүм дотроос сэнтийнээс, ‘Энэ дууслаа’ гэх чанга дуу гарав. Цахилгаан гялбаж, дуу гарч, аянга бууж, газар асар хүчтэй хөдлөв. Хүнийг дэлхий дээр байх болсноос хойш болж байгаагүй тийм хүчтэй, тийм агуу газар хөдлөлт болов... үндэстнүүдийн хотууд нурав... Арал бүр зугтаж, уулс олдсонгүй.”

Илчлэлт 16:17-20

1000 жилийн туршид Сатанд юу тохиолдох вэ?

“Гартаа ёроолгүй гүний түлхүүр, асар том гинжтэй тэнгэр элч тэнгэрээс бууж ирэхийг би харав. Тэрээр диавол ба Сатан болох эртний могой буюу лууг бариад, түүнийг хүлж, мянган жилийн турш ёроолгүй гүнд хаяжээ. Тэгээд мянган жилийг нь дуустал үндэстнүүдийг цаашид мэхлүүлэхгүйн тулд түүнийг түгжээд лацдав. Үүний дараа тэр ахархан хугацаанд суллагдах ёстой аж.”

Илчлэлт 20:1-3

Тайлбар: Сатан Бурханы Хуулийн эсрэг тэрсэлсний үр дүнд хоосорсон дэлхий дээгүүр цааш нааш тэнүүчлэх болно. Энэ үеийн туршид түүний зовлон бэрхшээл дэндүү их байх болно. Гэм нүгэл хийснээс хойш эхэлсэн түүний завгүй үйл ажиллагаа Үмар ч нөлөөгүй болж, түүний хүч чадал үгүй болж, анх диваажинд тэрслүү загнасан

ЭСЭРГҮҮЦЛЭЭ ОРХИЖ ХИЙСЭН БҮХ БУЗАР ЗҮЙЛИЙНХЭЭ ТӨЛӨӨ ЗОВЖ ШАНАЛАХ БОЛНО ГЭДГЭЭ ХАРНА. АГУУ МЭТГЭЛЦЭЭН 660-Р ХУУДАС.

(Гэм нүгэлт хүмүүст зориулагдсан) Хоёр дахь дахин амилалт хэзээ болох вэ?

“Үхэгсдээс үлдсэн нь мянган жилийг дуустал амилсангүй. Энэ бол анхны амилалт юм.”

Илчлэлт 20:5

Сатан шоронгоосоо хэзээ суллагдах вэ?

“Мянган жил төгсөх үед Сатан шоронгоосоо суллагдана.”

Илчлэлт 20:7

Сатан суллагдах үед, Бурханыг эсэргүүцэн тэмцэх сэтгэл нь өөрчлөгдөөгүй болохыг бид түүний ямар үйлдлээс нь мэдэж болох вэ?

“Мянган жил төгсөх үед Сатан шоронгоосоо суллагдан, дэлхийн дөрвөн өнцөгт буй үндэстнүүдийг, Гог болон Магогийг мэхлэн, тэднийг дайнд хамтад нь цуглуулахын тулд гарч ирнэ. Тэдний тоо тэнгисийн эргийн элс шиг аж.”

Илчлэлт 20:7,8

Сатан болон дахин амилсан гэм нүгэлт, бузар дагалдагч нар Бурханы Хотыг эзлэхийг оролдох үед юу тохиолдох вэ?

“Тэд газрын энгээр нэг тарж, ариун хүмүүсийн хуаран, хайрлагдсан хотыг бүсэлжээ. Тэнгэрээс гал бууж тэднийг залгив... Тэгээд үхэл ба Үхэгсдийн орон галт нуурт хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой. Хэрэв хэн нэгний нар амийн номд бичигдсэн нь олдохгүй бол тэр хүн галт нуурт хаягдсан байна.”

Илчлэлт 20:9,14,15

Бурханаас гарах гал бүхнийг цэвэрлэнэ, Бурхан өөрийн аварсан хүмүүстээ юу гэж амласан бэ?

“Харин Түүний амлалтын дагуу бид зөвт байдал оршдог шинэ тэнгэр, шинэ газрыг хүлээн байна.”

2 Петр 3:13

Шинээр бүтээсэн дэлхий дээр хэн амьдрах вэ?

“Дөлгөөн хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд тайвшрал авах болно.”

Матай 5:5

Бодож цэгнэх амлалт:

“Сэнтийнээс чанга дуу гарахыг би сонсов, Харагтун, Бурханы асар хүмүүсийн дунд байна. Тэр тэдний дунд нутаглах болно. Тэд Түүний ард түмэн болж, Бурхан Өөрөө тэдний дунд байж тэдний Бурхан нь болно. Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо. Сэнтийд залрагч, ‘Харагтун, Би бүх юмсыг шинэ болгож байна’ гээд, ‘Бичигтүн, эдгээр үгс итгэмжит бөгөөд үнэн’ гэв.”

Илчлэлт 21:3-5

ТАМ ГЭЖ ЮУ БОЛОХ ХААНА БАЙДАГ ТУХАЙ

Гэм нүгэлт, зөв шударга хүмүүсийг хооронд нь салгах буюу “ургац хураах” үе хэзээ болох вэ?

“Тэдгээрийг тарьсан дайсан нь диавол, ургац нь энэ үеийн төгсгөл, тариа хадагсад нь тэнгэр элч нар юм. Тиймээс зэрлэг өвсийг зулгааж шатаах адил энэ үеийн төгсгөл тийнхүү байх болно.”

Матай 13:39,40

Есүсийн Хоёр дахь ирэлтээс өмнө ямар ч гэмт, зөв шударга хүн шагнал, шийтгэл аваагүй гэдэгт итгэлтэй байж болох уу?

“Учир нь Хүний Хүү тэнгэр элч нарын хамт Эцэгийнхээ алдрын дотор ирж, хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө.”

Матай 16:27

Тайлбар: Шүүлт, гэм нүгэлт хүмүүсийн шийтгэл болон зөв шударга хүмүүсийн мөнхийн шагналын тухай олон ишлэл Библид бичигдсэн байдаг. Эдгээр ишлэл гэм буруутай хүмүүс одоо “шатаж буй тамын галд” шатаж, эсвэл зөв шударга хүмүүс шагналаа хүлээн авсан гэж тодорхой бичсэн! Доорхи Библийн ишлэлүүдийг анхааран үзнэ үү?

“Бурханлаг хүмүүсийг сорилтоос яаж ангижруулахыг болон зөвт бус хүмүүсийг шүүлтгийн өдрийг хүртэл шийтгэлийн доор яаж барьж байхаа Эзэн мэддэг.”

2 Петр 2:9

“Харагтун, Би удахгүй ирнэ. Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөхийн тулд Миний шагнал Надтай хамт байгаа.”

Илчлэлт 22:12

Бурхан гэмт хүмүүсийн үхлээр зугаа хийх хүсэлтэй байдаг юм болов уу?

“Тэдэнд өгүүл. ‘Би Өөрийн амьд буйгаар тангараглая.’ гэж Эзэн БУРХАН тунхаглаж байна. ‘Би хорон муу хүний үхэлд огтхон ч баярлахгүй. Харин хорон муу хүн замаасаа эргэж, амьдрахад Би баярлах болно. Өөрийн муу замаасаа буцагтун, буцагтун! Тэгвэл та нар юунд үхэх вэ, Израилийн гэр ээ?’”
Езекиел 33:11

Хүмүүсийг эрэгтэй, эмэгтэй гэлгүй үхүүлэх нь Бурханы төлөвлөгөө мөн үү?

“Эзэн удаашралыг тооцдог зарим хүмүүсийн боддог шиг Өөрийнхөө амлалтад хойрго биш билээ. Харин ч Тэр хэнийг ч мөхүүлэхийг хүсэлгүй, бүгдийг гэмшилд ирээсэй хэмээн хүсэн та нарт тэвчээртэй ханддаг.”
2 Петр 3:9

Шүүлтийн эцсийн галыг Бурхан хэнд зориулан бэлдсэн бэ?

Шинэ Гэрээ номын зөгнөлд:

“Тэгээд Тэр Өөрийн зүүнтэйд байгсдад хандан ‘Хараагдагсад аа, Надаас зайл. Дявол болоод түүний тэнгэр элч нар нь бэлтгэсэн мөнх галд ор.’”
Матай 25:41

Хуучин Гэрээ номын зөгнөлд:

“Өөрийн тоо томшгүй хууль бус явдал ба зөв бус наймаагаар чи ариун газруудаа бузарлав. Тиймээс Би чиний дотроос гал гаргаж, тэр нь чамайг шатаасан. Чамайг харагч бүхний нүдэн дээр Би чамайг газрын үнс болгов.”
Езекиел 28:18

Аврал авахаас татгалзсан гэмт хүмүүс, Сатаны сүйрэл хэр удаан үргэлжлэх вэ?

Сатаных:

“Ард түмнүүдийн дунд чамайг мэддэг бүгд чамаас болж чичрэв. Чи айдаст автаж, хойшид байхгүй болно.”
Езекиел 28:19

Гэмт хүмүүсээс:

“Учир нь харагтун, зуух мэт шатаж буй өдөр ирж байна. Омог бардам бүх хүмүүс болон мууг үйлдэгч бүр тохуурхагдана. Ирж буй өдөр тэднийг түймэрдэх болно. Тиймээс тэдэнд үндэс ч, мөчир ч үлдэхгүй,” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна.”
Малахи 4:1

Тайлбар: Гэмт хүмүүсийн сүйрэл үтэр түргэн болж өнгөрөх тухай Библид тодорхой бичсэнийг ажиглана уу?

- а. “ЭЗЭН Өөрийг нь хайрладаг бүгдийг сахин хамгаалдаг, Харин бүх хорон муу хүнийг Тэр устгана.”
Дуулал 145:20
- б. “Харин хорон муу хүн мөхнө. ЭЗЭНий дайснууд бэлчээрийн цэцгүүд мэт болж, утаа мэт замхардаг.”
Дуулал 37:20
- в. “ЭЗЭН өөрийн уур хилэн дотроо тэднийг залгиж, Гал тэднийг шатаана.”
Дуулал 21:9
- г. “Тэд ууж, залгиж, урьд хэзээ ч оршиж байгаагүй мэт болох болно.”
Обадиа 16

Гэм нүгэлт хүмүүсийн сүйрэл, шийтгэл дуусах үед гал ассаар үлдэх үү?

“Үзэгтүн, тэд сүрэл мэт болж, галд шатна. Тэд өөрсдийгөө галын дөлнөөс аварч чадахгүй.

Дулаацах нүүрсгүй, өмнө нь суух гал ч байхгүй болно.”
Исаиа 47:14

Гэмт хүмүүсийн эцсийн шийтгэл болох үхлийг Библид юу гэж нэрлэсэн бэ?

“Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна.”
Илчлэлт 21:8

“Хоёр дахь үхэл”- ийн шүүлтээр гэмт хүмүүсийн бие махбодь, амин амьсгал, сүнсийг хоёуланг нь устгана гэдэг талаар Есүс тодорхой зүйл хэлсэн үү?

“Биеийг хөнөөх хүмүүсээс бүү ай. Учир нь тэд сэтгэлийг хөнөөж үл чадна. Харин махан бие болоод сэтгэлийг, хоёуланг нь тамд устгаж чадах Түүнээс айгтун.”
Матай 10:28

Тайлбар: “Там” гэсэн үг нь Библийн эх хэлний “булш” гэсэн үгнээс орчуулагдсан үг юм. Зарим итгэгчид хүний сүнс үхэж эсвэл сүйрэлд ордоггүй гэж итгэдэг. Харин Библид “Нуглийг үйлдэгч сэтгэл (сүнс) нь үхэх болно.” гэж бичсэн байдаг. Езекиел 18:4

Гэмт дэлхийг нэг мөсөн цэвэрлэхийн тулд Бурхан ямар гал ашиглах вэ?

“Үүнчлэн Содом, Гоморра болоод эргэн тойрных нь хотууд эдгээрийн нэгэн адил завхайралд автагдан, өөр гаж махан биеийн араас явсан тул мөнхийн галын шийтгэлд өртөхийн жишээ болдог юм.”
Иуда 7

Тайлбар: Энэхүү “мөнхийн гал” өнөөдрийг хүртэл ассан хэвээр биш. Энэ уг нь гал өөрөө мөнхөд шатах биш, харин мөнхийн гал нь мөнхийн үхлийг авчрах тухай хэлсэн байсан юм.

Библид “шатаж дуусахгүй,” “мөнхөд шатах” галын талаар өөр ишлэл бий юу?

“Харин амралтын өдөр ачаа өргөхгүй, Иерусалимын хаалгаар орж ирэхгүйгээр амралтын өдрийг ариунаар сахихаар та нар Намайг эс сонсвол, Би хаалган дээр нь гал ноцоох бөгөөд тэр нь Иерусалимын ордуудыг залгиж, унтраагдахгүй.”

Иеремиа 17:27

Тайлбар: Эртний Иерусалим хот унтраахын аргагүй галд шатсан юм (Иеремиа 52:12,13). Энэ гал нь хотыг газрын хөрстэй тэгшилсэн боловч, өнөөдрийг хүртэл ассаар байгаа бишээ!

Библийн үгс өөр хоорондоо зөрчилдөөд байгаа юм биш үү? Библид мөнхийн мөнхөд шатах Шүүлтийн үеийн гал гэж бичсэн байдаг биш бил үү?

“Тэднийг мэхэлсэн диавол хүхэр бүхий галт нуурт хаягдлаа. Тэнд ч мөн араатан болоод хуурамч эш үзүүлэгч байгаа аж. Тэд өдөр шөнөгүй үеийн үед тарчилна.”

Илчлэлт 20:10

Тайлбар: Өнгөцхөн харвал Библийн үг зөрчилдөж байгаа юм шиг санагдана. Гэвч Библийн үгсийг сайтар ойлгохын тулд бусад ишлэлүүдтэй харьцуулж үзэх хэрэгтэй. Жишээ нь: Өмнөх ишлэл болох Илчлэлт 20:9.

“Тэд газрын энгээр нэг тарж, ариун хүмүүсийн хуаран, хайрлагдсан хотыг бүсэлжээ. Тэнгэрээс гал бууж тэднийг залгив.” Илчлэлт 20:9

Тайлбар: “Тэнгэрээс гал бууж тэднийг залгив!” Хүмүүс дэлхий дээр 60, 70, 80 жил гэм нүгэлтэй амьдарсны хариуд Бурхан тэднийг саёсаёжилийн туршид шийтгэдэггүй. Энэ нь Бурханы хайр, эсвэл Библид бичигдсэн Бурханы зан чанартай нийцдэггүй юм. Гал өөрөө мөнхийн мөнхөд шатдаг биш, харин галаас гарах үр дагавар мөнхийн үхэл авирах юм.

Энэ асуудлыг ойлгоход тус болох өөр

“мөнхийн мөнхөд” гэсэн ишлэл

Библид бичигдсэн байдаг уу?

а. “Эзэн нь түүний чихийг шөвгөөр цоолж, тэр насан турш (мөнхийн мөнхөд) эзэндээ үйлчлэх ёстой.” Египетээс гарсан нь 21:6

Тайлбар: “Мөнхийн мөнх” гэсэн утга нь зарц нь насан туршийн боол гэсэн утгыг илэрхийл байсан.

б. “Харин Ханна нөхөртөө, “Энэ хөвгүүнийг хөхнөөс гарах хүртэл би тийшээ явахгүй. Дараа нь би түүнийг дагуулан явж, ЭЗЭНий өмнө аваачиж, тэнд үүрд үлдээнэ хэмээн өгүүлээд явсангүй... Энэ хөвгүүний төлөө би залбирсан юм. Өөрөөс нь гуйсан миний гуйлтыг ЭЗЭН биелүүлж өгсөн билээ. Тиймээс би ч мөн энэ хөвгүүнийг нэгэнт ЭЗЭНд зориулсан юм. Энэ хөвгүүн амьд байх цагтаа ЭЗЭНд зориулагдав.”

1 Самуел 1:22,27,28

Зөв шударга хүмүүст зориулсан амлалт:

“Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, үйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо.”

Илчлэлт 21:4

БИБЛИ БА ЭРҮҮЛ МЭНД

Бурхан хүмүүсийн төлөө юу хүсэж байдаг вэ?

“Хайрт минь, сэтгэл тань амжилттай байгаагийн адил аливаа үйлс тань амжилт олж, эрүүл энх байгаасай хэмээн би залбирч байна.” 3 Иохан 2

Түүний хүмүүс Үгийг нь сахивал Бурхан юу хийж өгнө гэж амласан бэ?

“Чи өөрийн Бурхан ЭЗЭНд үйлчил. Тэгвэл Тэр чиний талх, усыг ерөөх болно. Би та нарын дундаас өвчин эмгэгийг зайлуулна.”

Египетээс гарсан нь 23:25

Биднийг бүтээсний хувьд Бурхан юуг Өөрийн өмч гэж тунхагласан бэ?

“Та нарын бие бол Бурханы та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу? Та нар өөрсдийнх биш гэдгээ мэддэггүй юм уу? Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханыг алдаршуулагтун.” 1 Коринт 6:19,20

Бие хамгаалж явах талаар Бурхан ямар сануулга, заавар өгсөн бэ?

“Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юм уу? Хэрэв хэн нэг нь Бурханы сүмийг устгавал Бурхан тэр хүнийг устгана. Учир нь Бурханы сүм бол ариун бөгөөд энэ нь та нар мөн.”

1 Коринт 3:16,17

ТАЙЛБАР: Христэд итгэгчид бүх төрлийн хордуулагч бодисоос хол байх ёстой. Тамхи нь никотин хэмээх үхэл

АВЧРАГЧ ХОРЫГ АГУУЛДАГ. Сүүлийн үеийн судалгаагаар тамхи хэрэглэх нь хүний амьдралыг гуравны нэг хувиар хорогдуулдаг гэсэн тооцоо гарсан. Ийм үйлдэл нь (ЕГИПЕТЭЭС ГАРСАН НЬ 20:13) Бурханы Хуулийн “хүн бүү ал” гэсэн хуулийг зөрчиж байгаа гэсэн үг. Хүн бүр тамхины хорын талаар мэддэг, харин тэгвэл хорт зуршил төрүүлэгч ундаануудын талаар хэр сайн мэддэг билээ? “Судалгаанаас үзэхэд кофены каффейн нь хүний биед муу нөлөөтэй болох нь нотлогдсон... Кофе уух, эсвэл каффейны донтой болох зуршлыг бусад хорт бодистой нэг түвшинд авч үзэж болно. Опиат, спирт, барбитурайт, никотин... Хамгийн алдартай кола ундаанууд нь каффейн агуулсан учир ийнхүү нэрлэгдэх болсон билээ. Тиймээс каффейны зуршил бусад хорт зуршилтай адил тооцогдохгүй гэж үү? Цайнд донтсон хүмүүс ч гэж бас байдаг.” NEW ENGLAND MEDICAL JOURNAL, MAY 13, 1954.

Хүн Бурханыг хэрхэн дээдлэн хүндэлж болох вэ?

“Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл нь мөн.” Ром 12:1

Тайлбар: Бурхан биднийг эруул саруул байлгахыг хүсдэг. Библиэс Бурханы аз жаргалтай, эруул амьдрах зааврыг олж авах боломжтой юм. Бурхан Өөрийн зааврыг хүчээр дагуулахыг хүсэхгүй, Түүний зааврыг дагаагүйгээс бидний эруул мэнд хохирох болно. Түүний амлалтанд, “Хэрэв та нар өөрсдийн Бурхан ЭЗЭНий дуу хоолойг анхааралтай сонсож, Түүний мэлмийд зөвийг үйлдэж, Түүний тушаалуудыг чих тавьж, Түүний бүх тогтоолуудыг сахивал, Би Египетчүүдэд буулгасан өвчнүүдээс нэгийг нь ч та нарт буулгахгүй. Учир нь ЭЗЭН Би бол та нарыг эдгээгч билээ.” Египетээс гарсан нь 15:26

Библид согтууруулах ундааг хэрэглэж болохгүй гэж зөвлөсөн байдаг уу?

- а. “Дарс бол басамжлагч, сархад бол агсамнагч, эдгээрт согтуурсан хэн боловч мэргэн биш.”
Сургаалт үгс 20:1
- б. “Улаан байхад нь, Аяган дотор хөөсрөн шуугиж байхад нь, Доошоо зөөлөн урсаж байхад нь, Дарс уруу бүү хар. Эцэст нь тэр хорт могой шиг хатгах болно.”
Сургаалт үгс 23:31,32
- в. “Хулгайч нар ч, шуналтангууд ч, архичид ч, хараалчид ч, дээрэмчид ч Бурханы хаанчлалыг өвлөхгүй.”
1 Коринт 6:10

Хүнд зориулан хүнс болгон өгсөн бэ?

“Газар дэлхий дээрх үрт ургамал, үрт жимсний мод бүгдийг би та нарт өгнө. Тэр бүхэн та нарын хоол хүнс болно.”
Эхлэл 1:29

Тайлбар: Бурхан эхнээсээ хүмүүст үрт ургамал, самар, жимс, эмийн ургамал, хүнсний ногоог хоол болгон өгсөн. Дэлхий дээр усан галав юулсний дараа хүнийг мах идэж болно гэж зөвшөөрсөн. Хүн махыг хоол хүнс болгон хэрэглэж эхлэсэн цагаас хүний наслалт эрс буурсан!

Бурхан Ноагийн завинд амьтдыг оруулахдаа амьтдыг хэрхэн ангилсан бэ?

“Чи бүх цэвэр амьтны төрөл бүрээс долоо долоог эр эмээр нь, бузар амьтны төрөл бүрээс хоёр хоёрыг эр эмээр нь өөртөө ав.”
Эхлэл 7:2

Бурхан «цэвэр» амьтан гэж яагаад ялгасан юм бол?

“ЭЗЭН дахин Мосе, Аарон нарт айлдан, Израилийн хөвгүүдтэй ярин ийн хэлэгтүн: ‘Газар

дээрх бүх амьтдаас та нарын идэж болох амьтад нь эдгээр болой. Амьтдын дундаас туурай нь салаатай буюу ац туурайтан болон сэвсээ хивдэг амьтдыг та нар идэж болно.” Левит 11:1-3

Бурхан ямар амьтдыг “бузар” хэмээн нэрлэж хоол хүнсэнд зохицохгүй гэж хэлсэн юм бэ?

“Харин хивдэг, эсвэл ац туурайтай амьтдын дотроос та нарын идэж болохгүй амьтан бол тэмээ, туулай, хадны дорго. Эдгээр амьтад хивдэг боловч салаа туурайгүй учир та нарт бузар бөгөөд гахай бол ац туурайтан боловч хивдэггүй учир та нарт бузар болно. Та нар эдгээрийн махыг нь идэж болохгүй, хүүрт нь ч хүрч болохгүй.”

Дэд хууль 14:7,8

ТАЙЛБАР: ӨӨРӨӨР ХЭЛБЭЛ, ТАЛЫН АМЬТДЫГ ХОЁР ШАЛГУУРААР ХУВААДАГ. ЭНЭХҮҮ ХОЁР ШАЛГУУРЫГ ДАВЖ ЧАДАХГҮЙ АМЬТНЫ МАХ ХҮНИЙ ХҮНСЭНД ТОХИРОХГҮЙ ГЭДЭГ НЬ МЭДЭГДСЭН. БУРХАН БИД НАРААС МЭДЭЭЖ САЙН ЗҮЙЛЭЭ ХАРАМЛААД, ХОРИГЛОСОН БИШ ЮМ. “ТЭРЭЭР ШУЛУУН ШУДАРГААР ЁВАГЧДААС ЁМАР Ч САЙН ЮМЫГ НУУН ДАРАГДУУЛДАГГҮЙ.” ДУУЛАЛ 84:11

Далайн амьтад, загасны талаар юу гэж бичсэн байдаг вэ?

“Усанд байдаг буюу далайд байдаг, голд байдаг сэрвээтэй, хайрстай болгоныг та нар идэж болно. Усанд байдаг энэ бүхнийг та нар идэж болно. Харин усанд сэлэгчдийн дундаас, мөн усан дахь бүх амьтдаас далайд ч бай, голд ч бай сэрвээгүй, хайрсгүй алив бүхэн нь та нарт жигшүүрт зүйлс мөн.” Левит 11:9,10

Шувуудын хувьд “цэвэр” ба “бузар” гэсэн ялгаа байдаг уу?

“Аливаа цэвэр шувууг та нар идэж болно. Харин идэж болохгүй шувууд гэвэл бүргэд, тас, хар тас, улаан шонхор, элээ, шонхорын төрөл, хэрээний төрөл, тэмээн хяруул, шар шувуу, цахлай, харцагын төрөл, ууль, цагаан хүзүүт тас, цагаан ууль, хотон, хүрэн шувуу, хар галуу, өрөвтас, хөх дэглийн төрөл, өвөөлж, сарьсан багваахай юм.”

Дэд хууль 14:11-18

Петр Христэд итгэгч болоод олон жил болсны дараа, Бурхан нэгэн эш үзүүллэг үзүүлсэн билээ. Энэ эш үзүүллэгт маш том даавуутай бузар амьтад тэнгэрээс бууж ирэх үед тэнгэрээс, “Петр ээ! Бос, нядлаад ид.” гэх дуу гарчээ. Петр тэр үед ямар хоол иддэг гэж хэлсэн бэ?

“Эзээн, яасан ч үгүй. Учир нь би хэзээ ч ариун бус, бузар юм идэж байгаагүй гэлээ.” Үйлс 10:14

ТАЙЛБАР: ПЕТР ХРИСТЭД ИТГЭГЧ БОЛООД БУЗАР ХООЛ ИДДЭГ БОЛООГҮЙ. ТЭРЭЭР ХУУЧИН ГЭРЭЭНД БИЧИГДСЭН ЗААВРЫГ САХИСАН ХЭВЭЭР БАЙСАН.

Энэхүү хачирхалтай эш үзүүллэгийн дараа Петрд юу ойлгомжгүй санагдаж байсан бэ?

“Үзсэн үзэгдэл нь ямар утгатай болохыг Петр ойлгож ядан байх зуур.” Үйлс 10:17

Хоёр хоногийн дараа, Петр тэрхүү хачирхалтай эш үзүүллэгийн хэрхэн ойлгосон бэ?

“Гэвч ямар ч хүнийг бузар, эсвэл цэвэр бус гэж нэрлэх ёсгүйг Бурхан надад харууллаа.” Үйлс 10:28

Тайлбар: Иудейчүүдийн хувьд, харь үндэстнүүд (бусад үндэстнүүд) бузар гэж тооцогддог байжээ. Тиймээс Иудейчүүд бусад үндэстэнтэй харилцаж болдоггүй байв. Энэ нь Бурхан харь үндэстнүүдэд хаанчлалын сайн мэдээг түгээх цаг болсон гэдэг тухай ПЕТРТ үзүүлсэн эш үзүүлэлэг байлаа.

Зарим нэгэн Христэд итгэгчид Үйлс 10-р бүлгийг, Үйлангуяа 15-р ишлэлийг ашиглан, “Бурханы цэвэр болгосон юуг ч ариун бус гэж бүү үзэгтүн” хэмээн бузар амьтдын махыг ч идэж болно гэж хэлдэг. Ямар ч байсан, ПЕТРТ үзүүлсэн эш үзүүлэгийг сайтар уншиж үзвэл Бурхан Үймар ч хүнийг бузар гэж бүү үз гэсэн сургамж байсан юм. Иудей ч байсан харь үндэстэн ч байсан хамаагүй хүн бүрийн ходоод ижилхэн. Бурханы эрүүл мэндийн дүрэм ч өөрчлөгдөөгүй!

Эрүүл амьдрах Бурханы зарчмыг товчлон авч үзье.

1. **Тогтсон цагт завсарлагатай хооллож, тогтоосон цагаас гадуур хооллохгүй байх.** “зохистой цагт согтуурахын төлөө бус, харин хүч сэлбэхийн тулд иддэг газар нутаг ивээлтэй ээ!”

Номлогчийн үгс 10:17

2. **Идэхийн тулд бүү ид, харин амьдрахын тулд ид.** “Зооглох их хүслэн байгаа бол хоолойндоо хутга тулга.”

Сургаалт үгс 23:2

3. **Бурханы төлөвлөгөөний дагуу амар.** “Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, бүх ажлаа хий. Харин долоо дахь өдөр бол чиний Бурхан ЭЗЭНий амралт тул чи болон чиний хүү, чиний охин,

чиний зарц, шивэгчин, чиний мал, танайд байгаа зочин ямар ч ажил хийж болохгүй.”

Египетээс гарсан нь 20:9,10

“Жаахан амар.”

Марк 6:31

“Та нарын хувьд эрт босон, орой болтол унтахгүй байж, зүтгэж олсон талхыг идэх нь дэмий хоосон юм. Учир нь Тэр Өөрийн хайрладаг хүндээ нойрыг өгдөг билээ.”

Дуулал 127: 2

4. **Биеэ цэвэр байлга.** “Махан биеийн ба сүнсний бүх л бузар булайгаас цэвэрлэе.”

1 Коринт 7:1

“Өөрсдийгөө ариусгагтун!”

Исаиа 52:11

5. **Өөрийгөө захир.** “Тэмцээнд өрсөлдөгч хүн бүр бүх талаараа биеэ барих чадварт өөрийгөө дасгалжуулдаг аж.”

1 Коринт 9:25

“Та нарын тэвчээр бүх хүмүүст мэдэгдэг.”

Филиппой 4:5

6. **Баяр баясгалантай бай.** “Баяр хөөртэй зүрх бол сайн эм.”

Сургаалт үгс 17:22

7. **Амьтны ямар ч төрлийн өөх тос, цусыг бүү хэрэглэ.** “Энэ нь үеийн үед, амьдрах газар бүрд чинь улиран үргэлжлэх зарлиг болой. Та наравливаа өөх болон аливаа цус бүү ид.”

Левит 3:17

8. **Хэрэгцээтэй хүнд тусал.** “Нүгэл хилэнцийн хүлгийг мултлан, буулганы оосрыг тайлан... өлсгөлөн нэгэнтэй талхаа хуваан, орон гэргүй ядуусыг гэртээ оруулан, нүцгэн нэгнийг хараад хувцасла... тэгвэл чиний гэрэл үүрийн гэгээ шиг цацарч, чиний эдгэрэлт үтэр түргэн болно.”

Исаиа 58:6-8

9. **Бурханд итгэж, дага.** “Хүү минь, миний үгэнд анхаарлаа хандуул. Үгсийг маань чих тавин сонс. Учир нь гэвэл миний үгс бол тэдгээрийг олсон нэгэнд амь бөгөөд Тэр хүний бүх биенд эрүүл мэнд юм.”
Сургаалт үгс 4:20,22
10. **Юу ч хийсэн үргэлж Бурханыг алдаршуул.** “Иймээс та нар идэж, уухдаа, эсвэл юу ч хийсэн Бурханы алдрын төлөө бүхнийг хий.”
1 Коринт 10:31

Библид мөнгөний ТАЛААР ЮУ ГЭЖ ХЭЛСЭН БАЙДАГ ВЭ?

**Дэлхий болон түүн дээрх бүхнийг эзэмших
эрхтэй нэг нь хэн бэ?**

“Дэлхий болон түүнийг дүүргэдэг бүхэн, ертөнц
хийгээд түүнд оршигчид ЭЗЭНийх юм.”

Дуулал 24:1

Өөр юуг Бурхан Өөрийнх гэж хэлсэн бэ?

“Учир нь ойн амьтан бүр, мянган толгодоод
бэлчдэг мал сүрэг Минийх юм.”

Дуулал 50:10

“Мөнгө Минийх, алт Минийх гэж түмэн цэргийн
ЭЗЭН тунхаглаж байна.”

Хаггаи 2:8

**Эд хөрөнг тэй болох боломжийг хэн
бидэнд өгдөг вэ?**

“Харин өвөг дээдэст чинь тангарагласан
Өөрийнхөө гэрээг өнөөдрийнх шиг батлахын тулд
Тэр чамд хөрөнгө чинээ олгох хүч чадлыг өгдөг
учраас чи өөрийн Бурхан ЭЗЭНийг санагтун.”

Дэд хууль 8:18

**Эд зүйлс арвижих үед бид ямар дутагдлаас
болгоомжлох хэрэгтэй вэ?**

“Өнөөдөр миний чамд тушааж буй Түүний
тушаал, хууль, зарлигийг сахилгүй, өөрийн Бурхан
ЭЗЭНийг мартахаас болгоомжлоорой. Чиний идэж
цадаад, сайхан байшин барьж, тэндээ амьдран, мал
сүрэг чинь үржин олширч, алт мөнгө чинь арвижиж,

чамд байгаа бүхэн чинь өсөн нэмэгдэх үед чиний зүрх бардам болж, өөрийн Бурхан ЭЗЭНийг мартуузай. ‘Би хүч тэнхээ, гарынхаа чадлаар энэ хөрөнгө чинээг өөртөө бий болгосон юм.’ гэж чи зүрхэндээ хэлүүзэй.” Дэд хууль 8:11-17

“Учир нь мөнгөний хайр бол бүх төрлийн бузар муугийн үндэс мөн.” 1 Тимот 6:10

Бурхан бидэнд амжилт хайрладаг учир бид ямар бодол тээж явах ёстой вэ?

“Надад өгсөн бүх ашиг тусынх нь төлөө Би ЭЗЭНд юугаар хариулах вэ?” Дуулал 116:12

Бурхан бидэнд энэ дэлхийн эд зүйлсийг даалган хариуцуулсан билээ. Хариуцуулсан бүхний аль хэсгийг Бурхан ариун болгож, Өөрийнх хэмээсэн бэ?

“Газрын, эсвэл газрын үрийн эсвэл модны үр жимсний бүх арван хувь нь ЭЗЭНийх бөгөөд энэ нь ЭЗЭНд ариун билээ.” Левит 27:30

Тайлбар: Энд маш сонирхолтой санаа гарч байна. Бурхан бидэнд даалгасан долоо хоногийн нэг өдрийг, бүх орлогын арван хувийг Өөрт нь зориулах ёстой гэж хэлсэн. Арван хувь гэдэг нь арав хуваасны нэг юм. Бурханд бидний өмч хөрөнгө хэрэггүй. Тэрээр бүхнийг эзэмшдэг. Ямар ч байсан Тэрээр бидэнтэй Өөрийн өмч хөрөнгийг хуваалцдаг. Бид Түүнд ноогдох бүхнийг буцаан өгснөөр бид хувиа хичээх зангаас ангижирч, Түүнд талархалтай ханддаг болдог. Хэрэв бид бүхнийг өөртөө авч байдаг бол бид шуналд автаж, үүнийхээ муу үр дүнг амсаж эхэлдэг.

Бурханы хүмүүс орлогынхоо “арван хувь”- ийг эрт дээр цагаас өгч байсан.

Абрахамын талаар Библид:

“Абрам түүнд бүх юмны аравны нэгийг өгчээ.”

Эхлэл 14:20

Иаков Бурханд хандан тангараг өргөхдөө:

“Таны надад өгсөн бүх зүйлийн аравны нэгийг би заавал Танд өргөнө.”

Эхлэл 28:22

Бурхан “арван хувь”-ийн өргөлийг хэрхэн хуваарилдаг вэ?

“Харагтун, Левийн хөвгүүдэд Би Израиль дахь бүх арван хувийг өв болгон тэдний гүйцэтгэдэг үйлчлэл болох хурлын майхны үйлчлэлийн хариуд өгөв.”

Тооллого 18:21

Тайлбар: Леви аймгийнхан тэр үед бүх насаараа Бурханы үйлчлэлд ажилладаг хүмүүс байсан.

Арван хувь төлөх зарчим Шинэ Гэрээний үед ч хүчин төгөлдөр байсан уу?

“Ариун үйлчлэлийг гүйцэтгэгчид сүмээс хооллодгийг болон тахил өргөхөд оролцогчид тахилын ширээн дээрхээс хувиа хүртдэгийг та нар мэдэхгүй гэж үү? Түүнчлэн сайн мэдээг тунхаглагчид сайн мэдээгээр амь зуухыг Эзэн тогтоосон ажээ.”

1 Коринт 9:13,14

Итгэлтэйгээр арван хувийн өргөлөө төлж байгаа хүнд Бурхан ямар онцгой амлалт өгсөн бэ?

“Миний өргөөнд хоол хүнс байхын тулд бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг

хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга... Би та нарын төлөө цөлмөгчийг зэмлэх болно. Тэгвэл тэр газрын үр жимсийг устгахгүй, талбай дахь усан үзмийн мод чинь жимснүүдээ унагахгүй байх юм.” Малахи 3:10,11

Арван хувийн өргөлөө өөртөө авч үлдэж, завшдаг хүмүүст ямар сануулга өгсөн байдаг вэ?

“Хүн Бурханыг луйвардах уу? Гэсэн ч та нар Намайг луйвардаж байна! Гэвч та нар «Бид Таныг яаж луйвардсан юм бэ?» гэдэг. Аравны нэгээр ба өргөлөөр. Танай үндэстэн бүхэлдээ Намайг луйвардаж байгаа тул та нар хараалаар хараагдсан!” Малахи 3:8,9

Тайлбар: Бидний орлогын арван хувь бол Бурханы өмч. Энэ нь Түүний ариун арван хувь ба Христийн бафт мэдээ түгээх ажил, Бурханы үйлчлэлд ажиллаж байгаа хүмүүст зориулагдах ёстой билээ. Бурханд итгэлтэйгээр арван хувийн өргөл өргөсөн хүмүүс жирийн өргөл өргөсөн гэсэн үг биш. Бидний арван хувиас гадуур өгч байгаа өргөл нь хандив, Бурханд өгч байгаа бэлэг юм.

Бодож цэгнэнэ үү?

Зарим нэгэн хүмүүс “Би амьжиргааны төлбөрөө төлж чадахгүй байхад, яаж Бурханд арван хувь, өргөл өргөх вэ?” гэж шалтаг хэлж байдаг. Бурханд итгэж, Түүнийг бүхнээс илүүд тавьсан хүмүүст Библи онцгой амлалт өгсөн байдаг!

а. “Та нар юунд хувцас хунарт санаа зовно вэ? Талын сараана цэцэг хэрхэн ургаж буйг ажиглаач. Тэд ажил хийдэггүй, утас ч ээрдэггүй.

Гэвч Би та нарт хэлье. Соломон хаан ч сүр жавхлантай байхдаа эдгээр цэцэгсийн аль нэг шиг хувцаслаагүй юм. Өнөөдөр ургаж, маргааш зууханд хаягдах хээрийн өвсийг Бурхан ийнхүү гоёдог бол, та нарын төлөө Тэр түүнээс хавьгүй илүүг хийхгүй гэж үү, итгэл багатай хүмүүс ээ? Тиймээс ‘Бид юу идэх билээ?’ ‘Юу уух билээ?’ эсвэл ‘Юу өмсөх билээ’ гэж бүү санаа зов. Харь үндэстнүүд энэ бүхэн хэрэгтэйг мэддэг юм. Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно.” Матай 6:28-33

б. “Бүх бүтээгдэхүүнийхээ дээжээр болон эд хөрөнгөөрөө ЭЗЭНийг дээдэл. Тэгвэл агуулах чинь пиг дүүрч, торхнууд чинь шинэ дарсаар бялхана.” Сургаалт үгс 3:9,10

в. “Өгөгтүн, тэгвэл чамд өгөгдөх болно. Тэгэхдээ шахагдсан, чигжсэн мөн бялхсан хэмжээтэйгээр хормой дээр чинь асгарах болно. Учир нь өөрсдийхөө хэмжүүрийн жишгээр та нар хариуд нь хэмжигдэх болно гэлээ.” Лук 6:38

г. “Би залуугаасаа хөгширтлөө зөв шударга хүн хаягдахыг, үр удам нь талх гуйж байхыг үзээгүй.” Дуулал 37:25

ХРИСТЭД ИТГЭГЧДИЙН АМЖИЛТ

Бурханы Үгээр хооллох

**Христэд итгэх итгэлээ хадгалж үлдэхийн тулд
Есүс, Петрийн хэлснээр ямар сүнслэг хоолыг
“идэх” хэрэгтэй вэ?**

“Гэвч Есүс, ‘Хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдарна’ гэж бичигдсэн байдаг гэж хэлэв.” Матай 4:4

“Нялх хүүхдүүд шиг үгийн цэвэр сүүг хүс. Ингэснээр та нар үүгээр авралд өсөх юм.”

1 Петр 2:2

**Библийн судрыг яагаад, хэрхэн судлах
ёстой вэ?**

“Чи өөрийгөө ичих явдалгүй ажилчин, үнэний үгийг зөв заагч гэж Бурханд сайшаалган харуулахыг хичээгтүн.” 2 Тимот 2:15

Амьдралыг минь удирдаач гэж

Бурханаас гуйх

**Залбирсан хүмүүс юунд итгэлтэй байж
болох вэ?**

“Хэрэв бид Түүний хүслийн дагуу юуг ч гуйвал, Тэр биднийг сонсдог гэдэг нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм. Бид юуг ч гуйсан, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гуйснаа авсан болохыг мэднэ.” 1 Иохан 5:14,15

Библийн сударт Давид хаан, эш үзүүлэгч Даниел, Есүсийн хэрхэн залбирал үйлддэг байсан талаар юу гэж бичсэн байсан бэ?

Давид:

“Үдэш, өглөө болон үд дунд ч би гомдоллон, үглэх бөгөөд Тэрээр дууг минь сонсоно.” Дуулал 55: 17

Даниел:

“Тэрхүү албан бичигт гарын үсэг зурсныг Даниел мэдсэн үед гэртээ ороод, (дээд давхрын өрөөндөө тэрээр Иерусалимын зүг уруу харсан онгорхой цонхтой байлаа) урьд хийж байсан ёсоор өдөр бүр гурван удаа өвдөг сөгдөн, Бурханыхаа өмнө залбиран, талархал өргөж байлаа.” Даниел 6:10

Есүс:

“Өглөө эрт харанхуй байхад, Тэр босоод гадагш гарч зэлүүд газарт очин, тэндээ залбирч байв.”

Марк 1:35

“Тэдгээр өдрүүдэд Есүс залбирахаар ууланд гарч, бүхэл шөнийг Бурханд залбирсаар өнгөрөөв.”

Лук 6:12

Тэнгэрийн Эцэг бидний залбирал мөргөлд ямар нөхцөлтэйгөөр хариулдаг вэ?

1. **Тэвчээртэйгээр залбирах үед.** “Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлтаар залбир.”
Ефес 6:18
2. **Итгэлтэйгээр.** “Харин тэр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг.”
Иаков 1:6
3. **Бусдыг уучлах хэрэгтэй.** “Эхлээд ах дүүтэйгээ эвлэр, дараа нь ирж өргөлөө өргө.” Матай 5:24

4. **Бидний амьдралд гэмшээгүй гэм нүгэл байх ёсгүй.** “Хэрэв Би зүрхэндээ хорон мууг хүндэтгэсэн бол Эзэн сонсохгүй.” Дуулал 66:18
5. **Бид Бурханы Хуулийг сахих хэрэгтэй.** “Хуулийг үл сонсдог хүний залбирал нь ч хүртэл жигшүүртэй.” Сургаалт үгс 28:9
6. **Бурханы хүслийн дагуу залбир.** “Хэрэв бид Түүний хүслийн дагуу юуг ч гуйвал, Тэр биднийг сонсдог.” 1 Иохан 5:14

Бурханы өмч хөрөнгийг хүндлэх хэрэгтэй

Ялангуяа Түүний өгсөн цаг хугацааг

“Амралтын өдрийг ариунаар сахихын тулд санагтун. Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, бүх ажлаа хий. Харин долоо дахь өдөр бол чиний Бурхан ЭЗЭНий амралт тул чи болон чиний хүү, чиний охин, чиний зарц, шивэгчин, чиний мал, танайд байгаа зочин ямар ч ажил хийж болохгүй. Учир нь ЭЗЭН тэнгэр, газар, далай болон тэдгээрийн дотор байгч бүгдийг зургаан өдөрт бүтээж, долоо дахь өдөрт амарсан. Тиймээс ЭЗЭН Амралтын өдрийг ерөөн, тэр өдрийг ариун болгосон юм.”

Египетээс гарсан нь 20:8-11

Ялангуяа Түүний Арван хувийг

“Хүн Бурханыг луйвардах уу? Гэсэн ч та нар Намайг луйвардаж байна! Гэвч та нар «Бид Таныг яаж луйвардсан юм бэ?» гэдэг. Аравны нэгээр ба өргөлөөр. Миний өргөөнд хоол хүнс байхын тулд бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын

төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга.” Малахи 3:8,10

Бусдыг өөрөөсөө илүүд тавь

Есүс хэлэхдээ: “Тиймээс та нар хүмүүсийг өөрсөддөө хэрхэн хандаасай гэж хүссэнээрээ л өөрсдөө ч тийнхүү тэдэнд ханд. Энэ бол Хууль болоод Эш үзүүлэгчид мөн.” Матай 7:12

Дагалдагч Паул хэлэхдээ: “Юуг ч өрсөлдөх сэтгэлээр, эсвэл бардам зангаар бүү хий. Харин даруухнаар бие биенийгээ өөрөөсөө дээр гэж үзэж хүн бүр зөвхөн хувийн ашиг сонирхлыг бус, харин бусдын ашиг сонирхлыг хар.” Филиппой 2:3,4

Өөрийн хийж буй бүхэндээ цэвэр ариун байх

Бодол санаагаараа

“Эцэст нь, ах дүү нар аа, юу нь үнэн, юу нь хүндэтгэлтэй, юу нь сайхан, юу нь сайшаалтай байна, хэрэв аливаа сайн үйл байгаа бол, хэрэв магтууштай ямар нэгэн юм байгаа бол тэдгээр юмсыг бодож санацгаа.” Филиппой 4:8

Үг яриагаараа

“Хэрэв энэ бүхэн тийн устгагдах аваас ариун байдал ба бурханлаг байдал дотор та нар ямар төрлийн хүмүүс байх ёстой вэ?” 2 Петр 3:11

Өөрийн зан байдлаараа

“Түүний дотор оршдог гэж ярьдаг нэгэн Түүний хэрхэн явсанчлан өөрөө бас тийн явдаг байх ёстой...”

Түүнд ийнхүү найдаж байгаа аливаа хүн өөрийгөө цэвэршүүлдэг. Учир нь Тэр цэвэр ажээ.”

1 Иохан 2:6 ба 3:3

Өөрийн биеэрээ

“Та нарын бие бол Бурханы та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу? Та нар өөрсдийнх биш гэдгээ мэддэггүй юм уу?... Хэрэв хэн нэг нь Бурханы сүмийг устгавал Бурхан тэр хүнийг устгана. Учир нь Бурханы сүм бол ариун бөгөөд энэ нь та нар мөн... Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханыг алдаршуулагтун.”

1 Коринт 6:19, 3:17, 6:20

“Чи бол ЭЗЭН Бурханыхаа ариун ард түмэн. ЭЗЭН дэлхий дээр байгаа бүх ард түмнүүдийн дотроос чамайг Өөрийнхөө өв, ард түмэн болгохоор сонгосон билээ. Чи жигшмээр муухай юуг ч бүү ид.”

Дэд хууль 14:2,3

Гоёл чимэглэл, хувцаслалтаараа

“Иаков гэрийнхэн болон хамт байгаа бүх хүмүүстээ хандаж, Та нар өөрсөддөө байгаа харийн бурхдаа хаяж, биесээ ариусган, хувцсаа сольцгоо! Тэд гартаа байсан хамаг харийн бурхад, чихэндээ байсан ээмгүүдээ Иаковд өгчээ. Иаков тэдгээрийг нь Шехемийн ойролцоох царс модны доор булав.”

Эхлэл 35:2,4

“Үүний адилаар эмэгтэйчүүд зохистой хувцаслан өөрсдийгөө даруу, түвшин байдлаар чимэн, сүлжсэн үс, алт, сувдаар, эсвэл үнэтэй хувцсаар биш, харин Бурханаас эмээгч эмэгтэйд зохистой сайн үйлсээр чимэгтүн.”

1 Тимот 2:9

“Та нарын үс сүлжилт, алтан эдлэл зүүх, эсвэл хувцаслалт гэх мэт чимэглэл чинь зөвхөн гадна талын үзэмж бүү байг. Харин Бурханы өмнө асар үнэтэй болох дөлгөөн болон даруу сүнсний мөхөшгүй чанараар чимсэн зүрхний нуугдмал хүн нь та нарын чимэглэл байг.” 1 Петр 3:3,4

Мөнгөндөө хямгач байх

“Нэг нэгэндээ хайртай байхаас өөр хэнд ч ямар ч өргүй бай. Учир нь бусдыг хайрладаг хүн хуулийг биелүүлсэн хэрэг.” Ром 13:8

Итгэгч анд нөхөдтэйгөө нөхөрлөх хэрэгтэй

“Хайр болон сайн үйлсэд бие биенийгээ хэрхэн хөхүүлэн урамшуулахыг бодоцгооё. Ингэхдээ зарим хүмүүсийн зуршил шиг хамтран цуглахаа умарталгүй, харин тэр өдрийг ойртох тусам нэг нэгнээ зоригжуулья.” Еврей 10:24,25

Бүхнээ Христэд даатган өг

“Тэр тэдэнд бүгдэд нь хандаж, ‘Хэрэв хэн нэгэн Миний араас явахыг хүсвэл, тэр хүн өөрийгөө үгүйсгэж, өдөр бүр загалмайгаа үүрч Намайг дага’.” Лук 9:23

“Тэгтэл Петр Түүнд, ‘Хараач, бид бүх зүйлсийг орхиод Таныг дагасан. Тэгвэл бидэнд юу байх вэ?’ гэхэд... Миний нэрийн төлөө өөрийн гэр орноо, ах дүүсээ, эгч дүүсээ, эсвэл эцэг эхээ, хүүхдүүдээ, эсвэл эдлэн газраа орхисон хүн бүр зуу дахин ихийг хүртэх бөгөөд мөнх амийг өвлөх болно.” Матай 19:27,29

Бусадтай Христийг хуваалцах

“Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав.” Матай 28:19,20

Бурханы Хуулийг сахин биелүүлэх

“Амийн мод уруу очих эрхтэй болохын тулд болон хаалгаар хот уруу орохын тулд дээлээ угаагчид нь ерөөлтэй ээ!” Илчлэлт 22:14

“Энэ бүхнийг сонордоод, дүгнэхэд Бурханаас эмээж, Түүний тушаалыг дагагтун. Энэ нь хүн бүхэнд хамаарна. Бурхан сайн, муу гэж ялгалгүй нууцлагдсан юмс бүрийг, бүх үйлсийг шүүлтэд аваачих болно.” Номлогчийн үгс 12:13,14

Стресс таныг тарчилган зовоож байна уу...

Боловсронгуй хөгжсөн гэх өнөөгийн амьдралын хэв маяг нь амар тайвныг биднээс шаардаж байдаг. Салж сарнисан гэр бүл, сэтгэлийн шаналал, ажил төрөлтэй холбоотой янз бүрийн бухимдал стресс нь мянга мянган хүнийг тамлан зовоож байна.

Бидэнтэй өдөр тутам нүүр тулж байдаг бэрхшээлээс гарах арга замыг зааж өгөх, уншихад хялбар энэхүү ном нь 100 гаруй хэлээр орчуулагдсан.

Энэ номоос сая сая уншигчид юу нээж олсныг та өөрөө олж мэднэ үү. Дотоод Сэтгэлийн Амар Тайвныг Олохуй ном хүн бүхэнд тустай ном.

Та Монгол хэлээр орчуулагдсан ном зохиолоос уншихыг х?сэж байна уу?

Үе үеийн хүслэн

АНУ-ын Номын Сангуудын Нэгдсэн Холбооноос Есүс Христийн амьдралын тухай хамгийн сайн бичигдсэн ном гэсэн үнэлгээ авсан.

Шинэ гараа

Амьдралынхаа хэв маягийг өөрчлөх ба эрүүл саруул аж төрөх тухай мэдээллүүдийг унших боломжтой.

240 хуудас Үнэ 3500 ₮

Үхэвч үл үрэгдэх нэгэн

Хятадын соёлын хувьсгалын үед тохиолдсон итгэл, эр зоригийн санаанд багтамгүй явдал.

224 хуудас Үнэ 2500 ₮

Залуусын цагаан ном

Амьдралын олон сонирхолтой үйл явдлуудыг өгүүлсэн энэ эмхтгэл Америк дахь Христэд итгэгч залуусын чин сэтгэлийнх нь дуу хоолой юм.

136 хуудас Үнэ 1500 ₮

Христэд х?рэх зам

1892 онд анх хэвлэгдсэн уг ном өдгөө дэлхийн 150 гаруй хэлээр орчуулагдсан. Жил бүр олон хувь хэвлэгддэг эрэлт ихтэй ном. Христ бол хүний хамгийн итгэлт анд найз, туслагч хийгээд цорын ганц Аврагч болохыг энэ ном өгүүлдэг.

117 хуудас Үнэ 1200 ₮

Уйлах ч газар олдохгүй

Хүүхэд ахуйдаа бие сэтгэлийн хүчирхийлэлд өртөж, бэлгийн доромжлолыг насан туршдаа мартаж чадахгүй шаналж яваа хүмүүст сэтгэлийн дэм итгэлийн гэгээ өгөх гэж энэхүү ном зохиогджээ.

104 хуудас Үнэ 1500 ₮

Эцгийн гашуун бэлэг

Архичин эцгийн архичин хүү хэрхэн Христэд итгэгч болж амьдрал нь өөрчлөгдсөн тухай энэ номноос унших болно.

73 хуудас Үнэ 600 ₮

Эдгээр номуудыг доорх хаягаар захиалан авч уншиж болно:

Улаанбаатар хот – 13

Төв шуудан

Ш\х 1006

Утас: 688031